

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ  
СТРАТЕГИ СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ EDITOR'S BOARD

**Дарга** Chairman  
Баянхүүгийн БАТТӨР Bayankhuu BATTUR

**Нарийн бичгийн дарга** Secretary  
Сэсээрийн БУЯНХИШИГ Seseer BUYANKHISHIG

**Гишүүд** Members  
Др. Эрдэнэ-Очирын ЭНХМАА Erdene-Ochir ENKHMAA Ph.D  
Др. Баянхигийн ОТГОНСҮРЭН Buyankhishig OTGONSUREN Ph.D  
Чулуунбатын ЦЭЦЭГМАА Chuluunbat TSETSEGMAA

**Редакцын хаяг:** Board Address:  
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын-11, 8 давхар  
8th floor, Government Building-11,  
Sambuu Str. 11

**Утас:** (976-51)264000 Tel: (976-51)264000  
**Факс:** (976-11)324055 Fax: (976-11)324055

**Шуудангийн хаяг:** Postal Address:  
Монгол Улс, Улаанбаатар Төв шуудан-870  
Central Post Office 870 Ulaanbaatar

**Захиалгын индекс:** Subscription index:  
200952 200952

Цахим хуудас: [www.iss.gov.mn](http://www.iss.gov.mn)

## АГУУЛГА

## CONTENT

<b>Др.дэд проф Б.Энхбайгаль</b> Улсын бүрэн эрх: тусгаар тогтнолын баталгаа	3	<b>B.Enkhbaigali (Ph.D, Associate Professor)</b> State Sovereignty: Independence Guarantee
<b>Б.Баттөр</b> Гадаад өрийн удирдлагыг боловсронгуй болгох асуудал	19	<b>B.Battur (M.A)</b> Improving External Debt Management of Mongolia
<b>Д.Батмөнх</b> Эдийн засгийн өнөөгийн байдал болон цаашдын чиг хандлага: коронавирусын Монгол Улсад үзүүлэх нөлөө	31	<b>D.Batmunkh (M.A)</b> Current Economic Situation and Future Trends: COVID-19 Impact on Mongolia
<b>Ч.Цэцэгмаа</b> Тарифын хөнгөлөлтийн системийг ашиглан Монгол Улсын экспортыг нэмэгдүүлэх боломж	41	<b>Ch.Tsetsegmaa (M.A)</b> Export Opportunity of Mongolia under the Preferential Tariff Treatment
<b>Б.Пүрэвсүрэн, Т.Энхзаяа,</b> Банкны салбарын эдийн засаг дахь үүрэг оролцоог сайжруулах зарим асуудал /Ковид-19 цар тахлын жишээн дээр/	50	<b>B.Purevsuren, T.Enkhzaya</b> The Role of Mongolian Banking Sector in the Economy during COVID-19 Pandemic
<b>Др. проф Д.Уламбаяр</b> COVID-19 цар тахлын дараах дэлхийн шинэ дэг журмын дүр төрхийн тухайд зарим төсөөлөл	65	<b>D.Ulambayar ( Ph.D, Professor)</b> Some Thought on the Shape of the New World Order Post-COVID-19 Pandemic
<b>Т.Батцэцэг</b> ОХУ, БНХАУ-ын хамтран дэвшүүлсэн Ази, Номхон далайн аюулгүй байдлын шинэ механизм бий болгох санаачилгын хэрэгжилтийн явцын тухай	81	<b>T.Battsetseg (M.A)</b> Implementation Strategy for Joint Initiative by Russia and China to Build a New Regional Security Mechanism in the Asia-Pacific
<b>Др. проф Л.Дамдинсүрэн</b> Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын төлөв байдал	93	<b>L.Damdinsuren (Sc.D, Professor)</b> Status of Mongolian Food Security
<b>Др Э.Энхмаа</b> Хүнсний импортын хяналт ба сорилтын лабораториудын чадавхын өнөөгийн түвшин	102	<b>E.Enkhmaa (Ph.D)</b> Current Capability Level of Food Import Control and Testing Laboratories
<b>Э.Энхтайван</b> Хил орчмын нутаг дэвсгэрийн эдийн засгийн хөгжил	116	<b>E.Enkhtaivan (M.A)</b> Economic Development in Border Areas of Mongolia
<b>Зохиогчид</b>	134	<b>Authors</b>



Б.ЭНХБАЙГАЛЬ (Ph.D. Associate Professor)

## УЛСЫН БҮРЭН ЭРХ: ТУСГААР ТОГТНОЛЫН БАТАЛГАА<sup>1</sup>

Тунхагласан тусгаар тогтнолыг зөвхөн нийт ард түмний төлөө улсын хариуцах үүргийг буюу “УЛСЫН БҮРЭН ЭРХ”-ийг гүйцэлдүүлснээр л баталгаажуулдаг. Бүрэн эрхийг алдвал тусгаар тогтнолыг алдана. Тусгаар тогтнолыг алдвал улс мөхөж, хуулиар хамгаалагддаг ардчилал, хувь хүний эрх эрх чөлөө үгүй болно. Ардчилал үгүй бол ард түмний хяналт, ард түмний эрхийн тухай ярих боломжгүй.

Тусгаар тогтнолынхоо төлөө улс орон өөрөө л зүтгэж хамгаалдаг. Өөр гадны хэн нэгэн хамгаалдаггүй. Иймийн тул “улсын бүрэн эрхийн чанар”-ын асуудлыг хөндөж байна. Болгоомж, сэрэмж илүүдэхгүйн зэрэгцээ энэ нь мөн улс орны, ард иргэдийнхээ сайн сайхныг баталгаажуулах арга хэрэгсэл билээ.

<sup>1</sup> Уг өгүүллийг анх 2017 онд бичсэн боловч өдийг хүртэл эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдээгүй.

Улс бүхэн эдийн засгийн хүч чадал (I), шинжлэх ухаан технологийн чадавх (II), үзэл суртал, улс төр, шашин, өөрийн гэсэн өвөрмөц соёл (III), батлан хамгаалахын чадавх (IV), төрт ёс, төрийн тогтолцооны чадавх (V), гадаад харилцааны нэр хүнд (VI)-ээр дамжуулан бүрэн эрхээ бататгаж, чанаржуулахыг зорьдог.

“Улсын бүрэн эрх” нь орчин үед улсын зүгээс хариуцах үндсэн хоёр төрлийн хариуцлага юм. Эдгээр нь:

**нэгдүгээрт**, ард иргэдийнхээ заяагдмал эрх, эрх чөлөө, амьдрах орчныг хамгаалах,

**хоёрдугаарт**, гадаад харилцаанд бусад бүх улс оронтой эн тэгш, ижил эрхтэйгээр харилцах чадавхтай байх явдал юм.

Улс энхтайван, аюулгүй байдлыг сахих, хүмүүний заяагдмал эрхийг хамгаалж,

хүмүүнлэг энэрэнгүй нийгэм байгуулах үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх нь суурь шаардлага юм. Эдгээр нь:

- дотоодын хямрал, зөрчлөөс **урьдчилан сэргийлэх** үүрэг хариуцлага,
- хүч хэрэглэсний улмаас хүний заяагдмал эрх зөрчигдөх нөхцөлд **хариу арга хэмжээ авч, иргэнээ хамгаалах** үүрэг хариуцлага,
- **иргэдээ хэвийн аж төрөх нөхцөлөөр хангах**, гамшгийн дараа сэргээх, сэргээн босгох, хор хөнөөлийн шалтгааныг арилгах үүрэг хариуцлагыг биелүүлэх замаар хэрэгжинэ.

Улс бүхэн ижил тэгш бүрэн эрхтэй байх, дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцсон тохиолдолд хамгаалах эрхтэй<sup>2</sup> байх зохицуулалт нь улс хоорондын харилцааны хэм хэмжээ, олон улсын харилцааны суурь болдог<sup>3</sup>. Энэ нь улсын бүрэн эрх шууд бүрэн баталгаажна гэсэн үг биш.

Улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох цөөн боловч тохиолдол бий. Зөрчил, дайны шалтгаанаар, эсвэл улсын бүрэн эрхийг олтгойрч эмх замбараагаа алдан хуулиа уландаа гишгэж, хүчирхийллийг өөгшүүлснээс, эдийн шуналд автан улс орноо дааж давшгүй өрийн хүлээсэнд оруулсны улмаас газар нутаг, баялгаа, эрхээ алдаж, улс орон мөхөж байгаа бодит жишээнүүд байсаар байна.

Улс үгүй болбол хүн ам<sup>4</sup>, нутаг дэвсгэр,

<sup>2</sup> Мөн Тунхаглалын 51 дэх заалт.

<sup>3</sup> Уэстфалийн концепциор анх хуулийн этгээдийн хувьд Улсын бүрэн эрхийн асуудлыг авч үзсэн бөгөөд, улмаар Нэгдсэн үндэстний тунхаглалын 2.1-д “аль ч улсын дотоод асуудалд хөндлөнгөөс оролцохыг үл зөвшөөрнө” хэмээн баталгаажуулсан.

<sup>4</sup> Улсын бүрэн эрх, иргэний эрхийн асуудал нь өөр хоорондоо зөрчилдөх үндэсгүй бөгөөд улсын бүрэн эрх нь иргэний эрх, эрх чөлөөний суурь юм. Энэ хоёр асуудлыг сөргүүлэн тавьж, хэт туйлшран улсын үүрэг рилийг үгүйсгэх нь мөн чанартаа хүмүүний эрхийг

байгалийн баялаг бусдын эрхшээлд автдаг. Нэг нь нөлөөгөө тэлж, нөгөө нь бусад улс оронд автах, эрхшээлд орох нь өдгөө ч байсаар байгаа үзэгдэл ажээ.

Үүнээс сэргийлэх цорын ганц арга зам нь аюулгүй байдлаа хангаж, бүрэн эрхээ чанаржуулах явдал билээ. Тунхагласан, эсвэл олон улсаар зөвшөөрүүлсэн төдийгөөр улсын бүрэн эрх баталгаажихгүй.

Улсын дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцох эрх хэдийд бий болдог вэ? Хүн зон нь зовлон зүдгүүртэй, дотоодын хямрал зөрчилдөөнтэй, хууль хэрэгжихгүй, хүмүүний эрх зөрчигддөг, улс нь дотоод асуудлаа зохицуулах чадваргүй, байдлыг өөрчлөх хүсэлгүй үед дотоод хэрэгт үл оролцох зарчим мөрдөгдөхгүй бөгөөд хөндлөнгөөс оролцох эрх олон улсын мэдэлд шилждэг. 1992-1993 оны Сомали, 1995 оны Руанда, 1995 онд Босниа, 1999 онд Косовод болсон үйл явдлууд үүний тод жишээ юм.

“State failure” буюу улсын чадавх үгүй болох нь (бүрэн эрхт улс үүрэг хариуцлагаа гүйцэтгэж чадахгүй болох, ард иргэдийн амьдралын чанар буурах, үндэстэн доройтох) дараах нийтлэг шинжтэй. Үүнд:

- Газар нутгийнхаа бүрэн бүтэн байдлыг хянах, хүч хэрэглэн зохицуулах хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх чадавхаа алдах,
- Хамтын хүчээр асуудал шийдвэрлэх хууль ёсны эрхээ алдах,
- Төр нь иргэддээ үйлчилж чадахгүй болох,
- Бусад улс оронг олон улсын харилцааны бүрэн эрхтэй гишүүний хувьд харилцах чадамжгүй болох.

хамгаалах боломж, чадавхыг үгүй хийж, улмаар олны эрхийг уландаа гишгэхэд хүрнэ. Улс тусгаар байж, бүрэн эрхээ хадгалсан нөхцөлд л “Улсын иргэн”-ий эрхийн тухай ярих боломжтой бөгөөд хэн нэгэн хүмүүний заяагдмал эрхийг зөрчиж байгаа бол улс үүргээ биелүүлээгүй байна.

Төр засаг сулран доройтож, татварынхаа хувь хэмжээг өөрчлөх, эдийн засагт зохицуулалт хийх чадваргүй болох, газар нутгаа бүрэн хянах чадвар бодитоор суларч, төрийн үйлчилгээг хүргэх чадваргүй болсон нөхцөлд улс доройтлоо гэж үзнэ. Ийм үед авлига, гэмт хэрэг түгээмэл болж, улсаас бусад тоглогчид (олигархиуд, авлигалчид, гэмт хэрэгтнүүд, үндэстэн дамнасан авлигын сүлжээ, бусад улс орны ашиг сонирхлыг төлөөлсөн аж ахуйн нэгжүүд) хүч түрж, эдийн засаг огцом уналтад орж, иргэдийн хүсээгүй шилжилт хөдөлгөөн ихэсдэг.

2018 оны Энхтайвны сангийн “Fragile State Index” үнэлгээгээр Монгол Улс 178 орноос 130 дугаарт жагсч, сүүлийн 12 жилд улсын хүч чадал зогсолтгүй буурсаар (2018 онд 54,1 үнэлгээтэй) байна.

Энэ судалгаагаар Монгол Улсын бүрэн эрхийн эмзэг байдлын асуудлыг эдийн засгийн бодлого, зохицуулалтын жишээгээр авч үзэн эрхэм уншигч танаа хүргэж байна. Үүгээр бид Улсын бодлогыг хэрэгжүүлэх механизм (“Төр”)-ийн асуудлыг биш, харин нийт иргэд, газар нутгийг хамарсан, нэгдмэл эрх зүйт, гадаад харилцааны эрх бүхий “Улсын бүрэн эрх”-ийн асуудлыг эдийн засгийн үүднээс авч үзэж байгаа юм.

Улсаас эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт авах, өр нэмэх, төсөв батлахдаа улсын бүрэн эрхийг нэн тэргүүнд анхаарч, баталгаажуулах чиглэлд дорвитой арга хэмжээ авч, тодорхой алхам хийхгүй бол Монгол Улсын эдийн засаг ихээхэн эрсдэл өндөртэй, эмзэг байдалд байгааг онцлон тэмдэглэж байна.

Цаашид өр нэмэх, одоогийн бодлогыг хэвээр үргэлжлүүлэх нь эдийн засгийн нэгэнт алдагдсан тэнцвэрийг улам дордуулж, ихээхэн өндөр эрсдлийг дагуулна. Эдийн засагт бодлогын реформ хийх нь тулгамдсан асуудал болжээ.

Өдгөө дэлхий дээр оршин байгаа улс

гүрнүүдийн нас хэдэн мянган жилээр тоологдох бөгөөд улсын эрх ашиг буюу нийт иргэдийнхээ, ард түмний, хойч ирээдүйнхээ эрх ашгийг хамгаалах нь аль нэг улс төрийн нам, засгийн газрын дөрвөн жилийн мөрийн хөтөлбөрийн амлалтын савалгаагаар шийдэх асуудал огтхон ч биш билээ. Чухам үүнд л монгол төрийн бодлого оршдог.

### НЭГ. УЛСЫН БҮРЭН ЭРХИЙГ ЧАНАРЖУУЛАХ НЬ МӨНХИЙН АШИГ СОНИРХОЛ

Улс орнуудын мөнхийн ашиг сонирхол нь өөрийн бүрэн эрхийг чанаржуулан баталгаажуулах явдал юм. Энэ ашиг сонирхлоо гүйцэлдүүлж чадсан нь хөгжин цэцэглэж, чадаагүй нь бууран доройтдог учир бүрэн эрхийн асуудал байнга анхаарлын төвд байдаг.

1933 оны 12 дугаар сарын 26-ны улсын эрх, үүрэг хариуцлагын тухай “Montevideo Convention”-ны 1 дэх заалтад:

“Олон улсын харилцаанд хуулийн этгээд болох улс нь

1. Байнгын хүн ам,
2. Тодорхойлсон хил хязгаар, газар нутаг
3. Засаг (төр),
4. Бусад улс орнуудтай харилцах чадавх гэсэн дөрвөн шаардлагыг биелүүлсэн байна” гэсэн нь бий.

Түүнчлэн тус конвенцийн 3 дахь заалтад ингэж заажээ. “Улс нь нэгдмэл байдал, тусгаар тогтнолоо хамгаалах, дотоод аюулгүй байдлаа сахин хамгаалж хөгжих, өөрийн зохимжтой гэж үзсэнээр зохион байгуулах, өөрийн эрх ашигт нийцсэн эрх зүйтэй байх, үйлчилгээг хүргэх, шүүх эрх мэдэл, шүүхийн чадавхыг бүрдүүлэх *эрхтэй*. Олон улсын хуулиар эдгээр эрхийн хэрэгжилтэд бусад орныхоос ялгаатай ямар ч хязгаарлалт үйлчлэхгүй”. Энэ нь дэлхий

нийтээр оршин тогтнохын зайлшгүй нөхцөл юм.

5 дахь заалтад “Улсын суурь эрхэд ямар ч аргаар нөлөөлж, эсвэл өөрчилж болохгүй” гэсэн нь бий. (Изм ба төрийн оролцоо, 2014).

Европын улс орнуудын зарим судлаач Европын холбооны асуудалд “улс орны бүрэн эрхийг сулруулж, сөргөөр нөлөөлсөн” хэмээн үзэж, шүүмжлэлтэй ханддаг. Аж үйлдвэржиж эдийн засаг нь бэхжсэн улс орнуудын хувьд ч бас бүрэн эрхийн асуудал амин чухал байсаар байна.

*Бүрэн эрхийг алдана гэдэг бол улсаа алдана гэсэн үг.* Африк, Азийн улс оронд ч бас бүрэн эрхээ алдаж бусдын эрхшээлд орсон тохиолдол цөөнгүй бөгөөд энэ нь өнгөрсөн зуунд л тохиож байсан үйл явдал биш, орчин үед ч бас ийм жишээ хангалттай олон.

176 орноос Транспаренси Интернэйшнлийн үнэлгээгээр авлига ихтэй орны тоонд орж 151-д бичигдэж, 2006 оноос

авсан их хэмжээний өр зээлээ төлж дийлэхээ байгаад 2011 оны нэгдүгээр сард 1000 км<sup>2</sup> нутгаа Хятадад алдсан Тажикстаны жишээ анхаарал татах нь зүй юм (Bustunkala, 2011), (Tajikistan Cededs Land to China, 2011).

Памирын уулсын хормой дахь энэ нутгийн шууд залгаа хэсэг буюу Вакханы зурвас хоолой (16-64 км өргөн, 225 км урт) геостратегийн ач холбогдолтой. Тажикстаны энэ нутгийг эзэмшсэнээр Таджикстан, БНХАУ-ын Шинжаан, Кашмирийн дундах энэ зурвас руу чөлөөтэй нэвтрэх боломжтой болох бөгөөд байгалийн баялгаас гадна үүнд л гол учир байсан гэж үзэж болох юм.

Торгоны замын нэгэн чухал хэсэг болох энэ коридорын 4.9 км өндөр, жилийн ихэнх үед хаалттай байдаг Вахжирын гарцыг чөлөөтэй нэвтрэхийн тулд уулын нүхэн гарц барихад хөрөнгө оруулах, улмаар Пакистанаар дамжихгүйгээр шууд Афганистан болон Ирантай харилцах, эдийн засгийн хувьд нөлөөллөө тэлэх нь БНХАУ-ын хувьд стратегийн чухал алхам болж байна.



Тажикстаны хувьд газар нутгийнхаа багагүй хэсгийг ийнхүү өрөнд өгснөөр бүс нутагт гүйцэтгэж болох байсан үүрэг роль,

худалдааны замд нөлөөлөх боломжоо ч бас алдаж байна.

Шри-Ланк улс Хамбантога далайн боомтыг барихад зээлсэн 1.6 тэрбум ам.долларын өрөө буцаан төлж чадаагүй тул боомтыг Хятадын төрийн өмчит Чайна Мерчантс Порт Холдингс-д 70 хувийг нь эзэмшүүлсэн. 99 жилээр боомтыг түрээслэх

гэрээг 2017 оны долоодугаар сарын 31-нд багалсан. Зарим судлаачид энэ нь Шри-Ланкийн улсын төсвөөс өрийг буцаан төлснөөс илүү их алдагдалтай гэрээ хэмээн үзэж байна (Schultz, 2017).



*Шри-Ланкийн зүүн эрэг дэх Хамбантога боомт*



БНХАУ-ын зүгээс энэ тухайд “Нэг бүс нэг зам төсөл”-ийг хэрэгжүүлэхийн тулд Хятадыг далайн замаар баруунтай холбох зорилготой гэж тайлбарладаг ч Энэтхэгийн зүгээс үүнийг Энэтхэгийг тойрон хүрээлэх БНХАУ-ын бодлого хэмээн үзэж, аюулгүй байдалд нь сөргөөр нөлөөлж байна хэмээн болгоомжилдог ажээ.

Сүүлийн үед Пакистан, Непал, Мьянмар улс нийт 20 тэрбум ам.долларын өртөг бүхий БНХАУ-ын зээлээр усан цахилгаан станц барих төслүүдээ цуцалж, зарим нь хойшлууллаа. Нэг бүс нэг зам төсөлд Азийн зарим улс оронд болгоомжлонгуй хандаж байна (Times, 2017). Зээл тусламж, өрийн дарамт нь улс орны бүрэн эрхт байдалд нөлөөтэй юу?

Бүрэн эрхээ алдсан улс орны тоо тоочиж барахааргүй их<sup>5</sup>, үүнийг түүхийн үзмэр гэж ойлгох хэрэггүй юм. XIX зуунд бүрэн эрхтэй байсан улсын тоо 214, XX

<sup>5</sup> Invalid source specified., Invalid source specified.

зуунд бүрэн эрхтэй байсан улсын тоо 140 байжээ. XXI зуунд ч ямар нэг хэмжээгээр бүрэн эрхээ алдсан (Таджикстан, Украин, Крым), хуваагдаж задарсан улс орон (Серб ба Мотенегро, хуучин Югослав буюу ХБНСЮУ) ч бий. Цаашид ч ийм эрсдэл байсаар байх болно.

Хүчтэй нь хүчгүйгээ эзлэн авах арга хэлбэр урьд өмнөхөөс ч илүүтэйгээр улам олшрон төрөлжиж байна. Хөрөнгийн саадгүй урсгал, ажиллах хүчний шилжилт хөдөлгөөн, мэдээлэл, технологийн харьцангуй байдал буюу даяаршлын зарим элементүүд үүнийг улам бүр өөгшүүлж байгаа билээ.

Улсын бүрэн эрхийг чанаржуулах нь улс орон бүхний амин чухал эрх ашиг бөгөөд олон улсын харилцаанд байр сууриа хадгалах, бэхжүүлэх нэг чухал хэрэгсэл байсаар байх болно<sup>6</sup>.

<sup>6</sup> Бүрэн эрхийг харилцан хүндэтгэх зарчим: Энэ зарчмыг баталгаажуулсан, дэлхий нийтээр дагаж мөрддөг гол баримт бичгүүд нь

### Хүснэгт 1. Бүрэн эрхэд нөлөөтэй асуудлууд (зээл тусламж, өр)

	БҮРЭН ЭРХЭД НӨЛӨӨТЭЙ АСУУДЛУУД (Бие даасан, тусгаар улс хяналтаа өөрийн мэдэлд байлгаж, бодлогын сонголтын хувьд гаднаас хараат биш эрх чөлөөтэй байх үед тулгамддаг, сэргийлэх асуудлууд)				БҮРЭН ЭРХЭЭ БҮРЭН АЛДАХ ТОХИОЛДОЛ
	Дотоод дахь үйл явц	Глобалчлалын нөлөө	Гаднаас шууд ирэх нөлөөлөл	Гаднаас шууд улсын дотоод хэрэгт оролцох	
Төрөл	Улсын дотоод хүч сулрах, доройтох	Нийгмийн хөгжилд соёл, эдийн засаг, нийгмийн харилцаагаар дамжуулан гаднаас нөлөөлөх	Улсын бодлогод гаднаас нөлөөлөх, ялангуяа макро эдийн засгийн бодлогыг чиглүүлэх	Тухайн улсын үндсэн хуулийн өөрчлөлтөд гаднаас нөлөөлөх	Хуулийн дагуу бүрэн эрхээ, улмаар тусгаар тогтнолоо алдах
Жинсээ	Үндэсний соёл, ухамсар доройтох, зөрчил хагарал ихсэх, авлигад автах, эдийн засаг, хууль ёс суларч доройтох	Дэлхийн зах зээлд нөлөөлөх, гадаадын хөрөнгө оруулалт, харилцаа холбооны технологи, бусад солилцооны арга хэрэгслүүд	Хоёр талт болон олон талт хэлэлцээрт, зээл тусламж өгөхдөө болзол тавих, лоббидох, авлигад автуулж, өөрт ашигтай шийдвэр гаргуулах	Хязгаарлагдмал хүрээ бүхий улсын бодлого, дайн байлдааны дараах хэлэлцээр, улсаа сэргээх оролдлого,	Цэргийн хүчээр эзэрхийлэх, колоничлох, эзлэн түрэмгийлэх, эрхийг үл тоомсорлон зөрчих



Үр нөлөө	Бүрэн эрхт байдал сулрах, дотоодын нэгдмэл байдал үгүй болох	Үндэсний соёл, хөгжлийн тухай ойлголт хүлээлт, эдийн засгийн бие даасан байдлыг алдагдуулж сулруулах	Улсын бодлогыг хараат байлгах, хянах, үр дүнг хүссэнээрээ залж чиглүүлэх	Олон улсад биш, зөвхөн дотоодод хүлээн зөвшөөрөгдсөн төр	Эрх зүй, улс төрийн хувьд бие даасан байдлаа алдах
Эзэл тусламж нөлөөлдөг үү?	Шууд бусаар, зарим тохиолдолд	Шууд бусаар	Шууд, янз бүрийн түвшинд	Зарим тохиолдолд	Шууд, зарим тохиолдолд

*Улс нь улс шиг байх нөхцөлд л улсын иргэний эрх баталгаажна.* Улс доройтвол өрийн дарамт ихэсч, улс төр самуурч, хууль ёс гажиж, авлигад автаж, өрх, иргэний амьдрал доройтон, байгалийн баялгаа хяналтгүйгээр гадагш урсгах, улмаар олз булаалдан тэмцэлдэх харь гүрний эрхшээлд их бага, янз бүрийн хэлбэрээр өртөж, газар нутгаа алдах, төрийн бодлогын бие даасан байдал алдагдаж хэлбийх, өөрийн иргэний тусын тулд биш харийн эрх ашгийн төлөө үйлчлэхэд хүрдэг нь дэлхий нийтийн гашуун сургамж юм.

## 1. УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДАЛ: ОРШИН ТОГТНОХ ГОЛ АРГА ЗАМ

Улс орон бүрэн эрхт байдлаа чанаржуулах буюу улс орны аюулгүй байдлаа сахин хамгаалж, ирээдүйгээ

баталгаажуулах нь оршин тогтнох гол арга зам гэж дэлхий нийтээр үзэж байна. Энэ нь улсын суурь эрхийг хөдөлбөргүй хадгалж, ард түмнийхээ нийтлэг эрх ашиг, сонирхлыг эн тэргүүнд тавих тухай асуудал юм. Энэ зарчмыг хэрэгжүүлэх үүргийг төр албан ёсоор хүлээдэг. Томас Хоббсын “Левиатан” (Hobbes, 1651)-д, Жон Локк (Steinert-Trelkeld, July 30, 2010), Монтескьюгийн “The Spirit of Law” (1748), Жан Жак Руссо (Jean-Jacques Rousseau)-гийн “Du contrat, ou principes du droit politique”, “Social Contract” (1762)-д өгүүлсэн нь ч “Улсын суурь эрхийг ямар ч аргаар нөлөөлж, өөрчилж болохгүй”-тэй утга нэг билээ<sup>7</sup>.

<sup>7</sup> Тэгэхдээ Жан Жак Руссогийн авч үзсэн “Хувь хүний бүрэн эрхт байдал”-ын тухай ойлголтоос нийт ард иргэдийн эрх ашиг, сонирхлыг илэрхийлсэн “Улсын бүрэн эрхт байдал” нь ямар ч нөхцөлд илүү гэж бусад чиглэлийнхэн үздэг.



Макс Хубер 1928 онд “Газар нутгийн бүрэн эрхт байдал нь улсын үйл ажиллагаа эрхлэх тусгай эрхийг хамарна”, “... газар нутгийн бүрэн эрхт байдлыг тунхаглахгүйгээр улс үүргээ гүйцэтгэж чадахгүй”<sup>8</sup> гэсэн нь бий.

*Газар нутгийн бүрэн эрхт байдал нь бусад газар нутгаас ялгаатай нэгдмэл эрх зүйн систем үйлчилж байж биеллээ олдог. Энэ нь газрын дээрх агаарын орон зай, түүний доорх газар шороо (онолын хувьд дэлхийн төв хүртэлх орон зай)-г хамарна (Malanszuk, 1970).*

“Байнгын хүн амтай байх” шалгуур нь газар нутгийн бүрэн эрхт байдалтай холбоотой бөгөөд улс оршин тогтнох бас нэг үндэс болдог. Улс нь оршин суугчдын хувьд:

1. Газар нутагт үйлчлэх хууль ёсны эрх мэдэл,
2. Гадаадад байгаа иргэдийн хувьд хувь хүнд үйлчлэх хууль ёсны эрх мэдлээ хэрэгжүүлдэг.

Улс оршин тогтнохын гурав дахь шалгуур болох **төрөөс үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлэх** (газар нутаг, хүн амын) нь олон улсын хуулиар дээрх хоёр элементийн аль алийг нь агуулдаг.

Бид Үндсэн хуулийнхаа эхний бүлэгт улсынхаа бүрэн эрхт байдлыг тунхагласан ард түмэн билээ. Монгол Улсын “Үндсэн хууль”-ийн 5-р зүйлийн дөрөвт **“Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”** гэж заасан нь тусгаар улсын бүрэн эрхт байдлын тухай дээрх үзэл баримтлалуудтай утга нэг юм.

<sup>8</sup> 1928 оны дөрөвдүгээр сарын 04-нд одоогийн Индонезийн Нануза арлын тухай АНУ болон Нидерландын маргаанд Гаагийн байнгын арбитрын шүүхэд талууд хандаж, тэр үед олон улсын эрх зүйн байнгын шүүхийн Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Макс Хуберт арбитраараар томилогдон ажиллажээ.

**Ард иргэдийнхээ ахуй амьдрал, эдийн засгийн хөгжих боломжийг хязгаарлахгүй байх, эдийн засгийн хүндрэл, хямрал тохиолдсон үед Монгол төр шаардлагатай зохицуулалтыг хийх эрхтэй байх** нь Монгол Улсын “Үндсэн хууль”-ийн 5-р зүйлийн дөрөвт заасан тэр л чиг үүрэг билээ. Энэ нь газар нутгийн бүрэн эрхт байдал, хүн амд үйлчлэх хууль ёсны эрх мэдлийн аль алиныг нь хамарсан ард иргэдийнхээ төлөө төрийн гүйцэтгэх зохицуулалт үр нөлөөтэй байх тухай асуудал юм. **Ямар ч субъект, салбар, улс төрийн нам, хувь хүн, аж ахуйн нэгжийн эрх ашиг, улсын бүрэн эрхт байдлаас илүү дээгүүрт тавигдах ёсгүй**<sup>9</sup>.

Төрийн дотоод хяналт буюу үндсэн хуульдаа нийцүүлэн эрх зүйн эмх цэгцийг бий болгох, хадгалах чадавх нь улсын бүрэн эрхт байдлын нэг гол шаардлага буюу төрийн зохицуулалт шударга, тэгш, үр нөлөөтэй байх суурь нөхцөл юм. Энэ нь улсын иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалах, аюулгүй, амгалан тайван амьдрах орчныг бүрдүүлэх эд зайлшгүй шаардлагатай нөхцөл билээ.

Төрийн чадавх нь бүрэн эрхт байдлыг чанаржуулан баталгаажуулах суурь нөхцөл бөгөөд энэ нь төрийн бүх салаа мөчир, бодлого зохицуулалтын тогтолцоог хамарна.

## **2. УЛСЫН БҮРЭН ЭРХТ БАЙДЛЫН ЧАНАР: ОРШИН ТОГТНОХУЙН СОРИЛТ**

Улс орны хувьд бүрэн эрхт байдлаа чанаржуулах нь:

1. Дотооддоо эдийн засаг, шинжлэх

<sup>9</sup> Нэгдмэл байдал, тусгаар тогтнолоо хамгаалах, дотоод аюулгүй байдлаа сахин хамгаалж хөгжих нь Монтевидеогийн тунхагт туссан улсын суурь эрх гэдгийг харгалзвал бид төрийн оролцооны тухай сая ярьж болох юм. Монтевидеогийн тунхгийг хуучин гэж зарим нь шүүмжилдэг ч сүүлийн үеийнхэн үүн дээр нэмж янз бүрийн үзэл баримтлал боловсруулсан болохоос үндсэн, суурь зарчмуудыг өөрчилж чадаагүй.

ухаан-технологи, улс төр, нийгэм соёл, гадаад харилцааны байр суурь, аюулгүй байдлын тогтолцооны хувьд нэгдмэл, цул байдлаа хадгалах, бэхжүүлэн хөгжүүлэх, чадваржих,

2. Гаднаас ирэх хатуу болон зөөлөн хүчний бодлогод хариу өгөх, нөлөөллийг тэсч гарах чадавхыг бүрдүүлэх явдал юм.

Дээрх хоёр нөхцөлийн аль аль нь зэрэг бүрдэж байж, бүрэн эрхт байдал чанаржина. Системийн талаас нь авч үзвэл энэ нь дотоод дахь цэгцрэл, шинэчлэгдэх чадавх (I), системийн өөрийгөө хамгаалах, мөн чанараа хадгалах чадавх(II)-ыг хамтад нь бий болгох тухай асуудал байдаг. Дотоод дахь ардчилал, улс төр, нийгмийн үйл явц, гадаад орчны өөрчлөлтөд хариу өгөх, гаднаас ирэх цохилт, сорилтыг даван туулах чадварын аль аль нь улс орны хувь заяаг шийдэх чухал асуудлууд юм.

**Зураг 1. Системийн хөгжил, оршин тогтнохуйн үндсэн хэмжээсүүд**



Ямар ч системийн хувьд дотоод дахь болон гадаад орчны үйл явц, өөрчлөлтөөс шалтгаалан хэлбэлзэл үүсэх нь хэвийн үзэгдэл боловч тэнцвэржилтийн төлөвөөс хэт холдох тохиолдолд сонголт эргэлт буцалтгүй юм. Иймд системийг богино хугацаанд буцаан

тэнцвэржүүлэх, тэнцвэрийг хадгалах, тэнцвэрт төлөвөөс хэт холдуулахгүй байх нь улс орны хувьд төрийн бодлогоор хэрэгжүүлдэг чиг үүрэг байсаар ирсэн билээ.

Бүрэн эрхт байдлын чанарыг тодорхойлох гол хэмжээсүүд нь дараах хүчин зүйлс гэж үзэж болох юм.

**Зураг 2. Бүрэн эрхт байдлын чанарын гол хэмжээсүүд**



Эдийн засаг, төрийн тогтолцоо, гадаад харилцаа, батлан хамгаалах, нийгэм соёлын чадавх бүрдэж чадвал улсын бүрэн эрх, улмаар тусгаар тогтнол батжиж, хүн ардынхаа сайн сайхан аж амьдрал, эрх чөлөө, ардчиллыг баталгаажуулна.

**Улс бүхэн бусдаас хараат биш, бие даасан байр суурьтай байж, өөрийн ирээдүйг чадлынхаа хэрээр улам бүр баталгаажуулахыг чармайдаг.** Энэ нь асуудал бүрэн эрхийг тунхаглах төдийгөөр хязгаарлагдахгүй, харин мөнхөд анхаарлын төвд байх үндсэн асуудал гэдгийг дэлхий нийтэд өрнөж байгаа үйл явцаас тод харж болно.

Сүүлийн мянган жилд өрнөсөн томоохон гүрнүүдийн сэргэлт, уналт, өнгөрсөн зуунд болсон дэлхийн I, II дайн, Ирак, Сири, Косово, Украйнд болон бусад бүс нутагт болж өнгөрсөн үйл явц нь хүч буурайгаа хүчтэй нь давамгайлах, өөрийн ашиг сонирхолд нийцэх талыг барих улс гүрнүүдийн ашиг сонирхол, өрсөлдөөн, зөрчлийн үр дагавар юм. Социалист, капиталист үзэл баримтлалын хоёр тусдаа лагерьт хуваагдсан дэлхий нийтийн улс орнуудын зөрчил 1990 оноос намжмал байдалд орсон хэдий ч, энэ нь түр зуурынх болох нь тодорхой харагдаж байна.

**Зураг 3. Дэлхий дахиныг түгшээсэн хямрал, зөрчлийн голомтууд**



Цаашид ч байдал намжих, энхтайван тогтох магадлал, боломж бага хэвээр байна.

Дэлхий дахины ихээхэн өөрчлөгдөж байгаа нөхцөл байдал нь бүрэн эрхт байдлыг баталгаажуулахыг улам ихээр

шаардах боллоо.

Хүчний тэнцвэрт харьцаа ихээхэн өөрчлөгдөж, дэлхийн II дайны дараа тогтсон геополитикийн архитектур шинэчлэгдэж байна. Их гүрнүүдийн нөлөөллийнхөө

бүсийг шинээр тодорхойлох, дахин хуваарилах ихээхэн төвөгтэй бөгөөд ужиг үйл явц үргэлжлэх хандлага ажиглагдаж байгаа юм. Дэлхийн II дайны дараах үеийг бодвол нөлөөллөө тогтоох арга хэрэгслүүд илүү төрөлжин боловсорсон нь өнөө үеийн онцлог юм.

Глобализмын давллагааны тухай хүлээлт эхэн үедээ ихээхэн эерэг байсан бол өдгөө дэлхий нийт үүний эерэг, сөрөг талын аль алиныг нь мэддэг болж, улмаар өөр өөрийн эрх ашгийг түлхүү хамгаалах хандлагыг баримтлах нь ихэслээ. Их гүрнүүд бодлогоо шууд ил зарлах нь олширч, улс төр, геополитикийн орчин ихээхэн өөрчлөгдөж, дэлхийн улс төрийн тавцанд шинэ тоглогчид бий болж байна.

Их гүрнүүд нөлөөгөө тэлэх гол хэрэгсэл нь дотоодын нэгдмэл цул байдал, засаглалын чадавх, технологийн түвшин, эдийн засаг, батлан хамгаалахын хүч чадал болж байна. Цэрэг–улс төрийн бодлого дангаар биш, нийгэм–эдийн засаг–шинжлэх ухаан технологийн бодлоготой нэгдмэл цул шинжтэйгээр хэрэгжиж байна.

Далд колоницлолын бодлого улс төр–эдийн засагт урьд өмнөхөөс илүү хүчтэй болж байна. Эдийн засаг–мэдээлэл–нийгмийн оюун санааны аюулгүй байдал хурцадмал болж байна.

Жон Бодан (Jean Bodin) “*Les six livres de la republique*” бүтээлдээ “Аливаа улсын бүрэн эрхт байдлын мөн чанар нь хоёр

үндсэн шаардлагыг биелүүлэх ёстой” гэж бичсэн (1576 он).

Нэг дэх шаардлага нь **үнэмлэхүй чанар** буюу “үүрэг хариуцлага, нөхцөлөөр хамгаалагдсан, хэн нэгний зөвшөөрөл шаардахгүйгээр шууд хэрэгжих, өмнөх хуулиудаар хязгаарлагдахгүй (энэ нь логикийн хувьд зөрчилтэй учраас боломжгүй), тухайн улсын өөрийн хуулиар зохицуулагдана”.

Хоёр дахь шаардлага нь “Хэрэв Улсын засаглах эрх үнэмлэхүй байгаа л бол, үүнийг хугацаагаар хязгаарлах эрх мэдэл бүхий, Улсын эрхээс дээгүүр хэн нэгэн байх боломжгүй бөгөөд энэ нь бүрэн эрхт байдал **тасралтгүй байх зарчим** болно. Энэ утгаар нь авч үзвэл бүрэн эрхт байдлыг аль ч утгаар эвдэх, үүнтэй зөрчилдөх нь аль ч улсын эрх ашигт нийцэхгүй”.

1. *Улсын бүрэн эрхийн мөн чанарт тавигдах шаардлагууд нь дараах хоёр зарчим юм. Үүнд: Үнэмлэхүй байх чанар: Үүрэг хариуцлага, нөхцөлөөр хамгаалагдсан, хэн нэгний зөвшөөрөл шаардахгүйгээр шууд хэрэгжих, өмнөх хуулиудаар хязгаарлагдахгүй, тухайн улсын өөрийн хуулиар зохицуулагдана.*
2. *Тасралтгүй байх зарчим: Улсын засаглах эрх үнэмлэхүй (засаглах эрхийг хугацаагаар хязгаарлахгүй, Улсын эрхээс хэн ч дээгүүр бус)*

## Хүснэгт 2. Бүрэн эрхт байдлыг баталгаажуулах нийтлэг арга хэрэгслүүд

Улс орнуудын бүрэн эрхт байдлаа баталгаажуулах арга хэрэгслүүд	Нийтлэг агуулгын жишээ
Эдийн засгийн хүч чадал, бие даасан байдлыг бэхжүүлэх	Эдийн засгийн хүч чадлыг бүрдүүлсэн нөхцөлд бусад нөхцөлүүд бүрдэхэд дөхөмтэй. Энэ нь алт валютын нөөц, өрийн дарамт багатай байдлаас гадна импортоос хараат бус байдал, дэлхийн зах зээл дэх экспортын үнэ цэнэ, хэмжээ, эрэлт, иргэдийн амьжиргааны түвшин, технологийн хүрсэн түвшин, бэлэн байдал зэрэг олон үзүүлэлтээс шалтгаалдаг.
Шинжлэх ухаан технологийн чадавх, давуу тал	Шинжлэх ухаан, технологийн түвшин нь <ul style="list-style-type: none"> <li>- эдийн засаг, үзэл суртал, улс төр, шашин, соёлын түрэлтэд тэсч үлдэх, дархлаатай байх нөхцөл болж,</li> <li>- эдийн засгийн хувьд үйлдвэрлэлээ хөгжүүлэх, экспортоо төрөлжүүлэх нөхцөлийг бүрдүүлэн,</li> <li>- цэрэг армийн хүчин чадлыг дэмждэг</li> </ul>
Үзэл суртал, улс төр, шашин, соёл	Үзэл суртал, улс төр, шашны хувьд нэгдмэл, соёлын хувьд хүчтэй байх нь бүрэн эрхт байдлын дархлааны үүргийг гүйцэтгэдэг. Улс төрийн хувьд нэгдмэл нэг цул байх, улс төрчид авлигад автахгүй байх, иргэдийн оролцоо хяналт, хариуцлага тооцох механизм сайн байх нь ихээхэн чухал юм. Үндэсний соёл, уламжлал, зан заншил хүчтэй байх нь ахуй амьдрал, амьдралыг үзэх үзэл, өөрийн гэсэн сэтгэлгээтэй, үндэстний оюун санааны орон зай нэгдмэл байхын үндсэн нөхцөл байдаг.
Батлан хамгаалахын чадавх	Зэвсэглэл, батлан хамгаалахын хүч чадал нь гадаад харилцаа, эдийн засаг, үзэл сурталын талд ихээхэн түшиг болдог.
Төрт ёс, төрийн тогтолцоо, бодлогын чадавх	Төрд итгэх итгэл, төрийн бодлогын чанар нь үндэсний дотоодын нөөц боломжийг үр өгөөжтэй чиглүүлэх, хүчээ нэгтгэх чадавхийг сайжруулдаг. Ажилгүйдэл, ядуурлаа бууруулах, өрийн дарамтгүй байх, засаг захиргааны нэгжүүдийг үр өгөөжтэй ажиллуулах, тодорхой салбаруудыг бодлогоор дэмжин эдийн засгийн өрсөлдөх чадвараа дээшлүүлэх нь үүний жишээ юм.
Гадаад харилцаа, аюулгүй байдлаа хангах хүчтэй бодлого, стратеги	Гадаад харилцаа, аюулгүй байдлаа хангах хүчтэй нэгдмэл бодлого нь гадны сөрөг нөлөөллөөс хамгаалах, актив буюу стратегич шинжтэй зохицуулалт хийх боломжийг олгодог. Гадаад харилцаанд улс орныг хуулийн нэг этгээд хэмээн авч үздэг. Үндэсний аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, иргэдийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх нь мөн нэг гол арга хэрэгсэл байдаг.

Эдгээр арга хэрэгслийн аль нэг нь дангаараа бүрэн баталгаа болж чадахгүй, аль нэг нь нөгөөгөө үгүйсгэхгүй, харин хоорондоо харилцан уялдаатай юм. Хэрхэн уялдуулж, бүрэн эрхээ баталгаажуулах нь тухайн улс орны стратегийн асуудал билээ.

Цаг хугацааны явцад бүрэн эрхт байдал

нь олон улсын эрх зүйд улам бүр бэхжин тусгалаа олж, улс хоорондын харилцааны суурийг бүрдүүлэх болсон. Цаашид ч бас тусгаар улсуудын харилцаа, хамтын ажиллагаанд бүрэн эрхт байдлыг хүндэтгэх зарчим нь ихээхэн чухал ач холбогдолтой, улс хоорондын харилцаанд гол түлхүүр байсаар байх болно.

### Улс орны бүрэн эрхт байдлыг баталгаажуулах арга хэрэгслүүд

Эдийн засгийн хүч чадлыг бэхжүүлэх стратеги	Улс орны эдийн засгийн хүч чадлыг бэхжүүлэхгүйгээр шинжлэх ухаан технологи, зэвсэглэл, үзэл суртал, гадаад харилцааны аль алинаар бүрэн эрхт байдлаа бэхжүүлэх боломж бүрдэхгүй. Энэ утгаараа эдийн засгийн хувьд бие даасан байдлаа бэхжүүлэх, хүчирхэгжих нь улс орны бүрэн эрхт байдлыг бэхжүүлэх суурь нөхцөл юм. Эдийг засаглахын үндэс нь үндэстэн өөрт байгаа байгалийн нөөц баялаг, бүтээх чадвар, дотоод хуримтлал, хүмүүний чадавх болон бусад нөөцийг үр ашигтайгаар зарцуулах, үүнд чиглэсэн төрийн бодлогыг хэрэгжүүлэх замаар эдийн засгийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд байдаг.
Шинжлэх ухаан технологийн чадавх, давуу талыг бэхжүүлэх бий болгох стратеги	Шинжлэх ухаан, технологийн хувьд бэхжих нь томоохон улс гүрнүүдийн хувьд цэрэг армийн зэвсэглэлээр өрсөлдөх, дотоодын үйлдвэрлэлээ бэхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх, мөн экспортын байр сууриа багатах замаар олон улсын эдийн засагт бэхжих, орлогоо нэмэгдүүлэх зорилгыг агуулдаг. Стратегийн хувьд ач холбогдол бүхий салбар, чиглэлүүдэд судалгаа, шинжилгээнд хөрөнгө оруулах замаар технологийн давуу талыг олж авах, технологийн давуу талын өндөр ашгийг олон улсын зах зээлээс хүртэхийн зэрэгцээ стратегийн зарим бүтээгдэхүүнээр өөрийгөө найдвартай хангах, импортоос хараат байдлаа бууруулан эдийн засгаа төрөлжүүлэх нь эн тэргүүний зорилт байдаг.
Төрт ёс, төрийн тогтолцоо, бодлогын чадавхыг бэхжүүлэх стратеги	Төрд итгэх итгэл, төрийн бодлогын чанар нь үндэсний дотоодын нөөц боломжийг үр өгөөжтэй чиглүүлэх, хүчээ нэгт гэх чадавхыг сайжруулдаг. Ажилгүйдэл, ядуурлаа бууруулах, өрийн дарамтгүй байх, засаг захиргааны нэгжүүдийг үр өгөөжтэй ажиллуулах, тодорхой салбаруудыг бодлогоор дэмжин эдийн засгийн өрсөлдөх чадвараа дээшлүүлэх нь үүний жишээ юм.

<p>Зэвсэглэл, батлан хамгаалахын чадавхыг бэхжүүлэх стратеги</p>	<p>Батлан хамгаалах бодлого нь улсаа батлан хамгаалахын зэрэгцээ цэргийн албан хаагчдад эх орноороо бахархах үзлийг суулгах, цэргийн алба хаах хугацаанд нь чадавхжуулан мэргэшүүлэх замаар соёлоо бататгах, хүнээ хөгжүүлэхэд чиглэж байгаа нь ихэнх орнуудын хандлага болж байна.</p> <p>Үүний зэрэгцээ олон улсын байдал тогтворгүй, эрсдэлтэй хэвээр байгаа бөгөөд энэ нь зарим улс оронд зэвсэглэлээр хөөцөлдөх явдал үргэлжилж, цэргийн зэвсэглэлийн технологи үйлдвэрлэлд оруулж буй хөрөнгийн хэмжээ нэмэгдэж байгаагаар илэрдэг. Шинжлэх ухаан, технологи, түүний дотор салбар хоорондын ололтыг цэргийн зэвсэглэлээ сайжруулахад стратегич байдлаар идэвхтэй ашиглаж байна.</p> <p>Цаашид технологийн түвшнээр давамгайлах, зэвсэглэлээр хөөцөлдөх, байгалийн баялаг, газар нутгийн төлөөх болон мэдээллийн давуу тал олж авах, банк санхүүгийн системийг эрхшээлдээ оруулах, улс орны дотоод дахь төр засгийн шийдвэрт нөлөөлөх оролдлогууд, зөөлөн хүчний бодлогоор дамжуулан шашин шүтлэг, үзэл суртал, хэрэглээ, сэтгэлгээнд нөлөөлж өөрийн дагуул хараат болгох оролдлогууд улам ихсэх төлөвтэй байна.</p> <p>Цөмийн зэвсэгтэй статусаа баталгаажуулах замаар бүрэн эрхт байдлаа чанаржуулах БНАСАУ-ын оролдлого, бүхэл бүтэн Европ тивийг 48 цагийн турш хяналтдаа байлгах чадвартай сөнөөгч онгоц зохион бүтээж, цөмийн зэвсэг турших Энэтхэгийн оролдлого, АНУ-ын аюулгүйн баталгаан дор армийн зардлаа хэмнэж, эдийн засгаа хүчирхэгжүүлэн шинжлэх ухаан, технологио дэлхийд тэргүүлэх түвшинд хүргэснийхээ дараа энэ суурин дээрээ шинээр армиа бүрдүүлж байгаа Японы жишээ улс орнуудын ийм сонирхлын бодит дүр зураг юм.</p>
<p>Үзэл суртал, улс төр, шашин, хэрэглээ, соёлын стратеги</p>	<p>Нийгэм дотооддоо хөгжлийн баримжаа, үнэт зүйл, үзлийн хувьд нэгдмэл цул, зөрчил талцал багатай байх нь улс гүрний оршин тогтнохуйн үндэс юм. Нөгөөтэйгүүр зөөлөн хүчний бодлого нь улс гүрнүүдийн нөлөөллөө тэлэх гол арга хэрэгсэл болж байгаа нь нууц биш. Кино урлаг, соёл судлал болон хэлний сургалтын төвүүд, оюутан солилцооны хөтөлбөрүүд, ажиллах хүчний солилцоо, шашны суртал ухуулга, ном хэвлэл, өөрийн орны соёлыг сурталчлах, бүтээгдэхүүнээ илүү чанартай гэж ойлгуулах, урлаг соёлын хөтөлбөрүүд гэхчилэн олон арга хэлбэрийг түгээмэл ашигладаг.</p> <p>Монгол Улс өөрийн үнэт зүйл, эх оронч сэтгэлгээ, соёл, зан заншил, үзлээ хадгалж авч үлдэх хүчтэй стратегитэй байж, түүнийгээ хэрэгжүүлэх нь л чухал юм. Мэдээллийн орон зайд хяналтаа бий болгох асуудал сүүлийн үед хурцаар тавигдах боллоо. Олон улс орон энэ асуудлаар шинэ арга зам эрэлхийлж, идэвхтэй ажиллаж байна. Фэйсбүүкийн хэрэглэгчдийн мэдээлэл алдагдаж, сонгуулийн үйл явцад нөлөөлсөн тухай шуугиан ч бас л анхаарч үзэх асуудлын нэг юм.</p>
<p>Гадаад харилцааны хүчтэй стратеги</p>	<p>Гадаад харилцаа, батлан хамгаалахын бодлогын аль аль нь хүчтэй байх нь улс орон бүрийн чухалчлан үздэг асуудал юм. Хил, гаалийн хяналт, агаарын орон зайн асуудал мөн үүнтэй холбоотой.</p> <p>Монгол Улсаас хоёр хөрштэйгөө найрсаг, өндөр түвшний харилцаатай, “Туравдагч хөрш”-ийн бодлого хэрэгжүүлж, олон улсын харилцаанд идэвхтэй байр суурь баримталдаг нь гадаад харилцааны практикын өвөрмөц бөгөөд үр нөлөөтэй хэрэгжиж буй жишээ болдог.</p>



Улсын бүрэн эрхт байдлыг баталгаажуулахын язгуур үндэс нь улсын нийт ард иргэдийн үнэлэмж, эв эе, соёл уламжлалаа хадгалж буй байдал, үзэл суртал, шашин шүтлэг, шинжлэх ухаанч сэтгэлгээ юм.

Нийгэм, улс төр, соёлын хувьд хөгжиж, өвөрмөц байдлаа хадгалж чадсан нөхцөлд хэрэглээнээсээ илүү ихийг бүтээх чадвар, өөрийн зайлшгүй хэрэгцээг бие даан хангаж, ард иргэдийнхээ амьжиргааг төвхнүүлж, мөнгөн тэмдэгтийнхээ ханшийг баталгаажуулан тогтворжуулж, олон улсын зах зээд өөрийн байр суурийг баттай эзлэх эдийн засгийн хүч чадал нь улсын бүрэн эрхт байдлыг баталгаажуулан чанаржуулахын үндэс гэж хэлж болох юм.

Нийгэм, соёлын хөгжил, эдийн засгийн хүч чадлын тусламжтайгаар төрийн тогтолцоог сайжруулах боломж нэмэгдэх нь зүйн хэрэг боловч төрийн тогтолцооны чадавч ч бас нийгэм соёл, эдийн засгаа удирдан залах үүрэгтэйг дурдах нь зөв юм. Тэгэхдээ өнөөгийн Монгол орны хувьд нэгэнт уламжилж ирсэн төрийн тогтолцоогоо сайжруулах, төрт ёсоо сэргээн хөгжүүлэхийн зэрэгцээ, нийгэм соёлоо хөгжүүлэх, монгол хүн бүр эх орноороо бахархах, үнэт зүйл, итгэл үнэмшлээ сэргээх, мөн бүтээх чадавхаа дээшлүүлэх, эдийн засгийн бие даасан байдлаа бататгах нь тулгамдсан асуудал болж байна. Иймийн тул гурвалжны суурь хоёр давхаргад нийгэм соёл, эдийн засгийг оруулан дүрсэллээ.

#### Зураг 4. Улсын бүрэн эрхт байдлыг баталгаажуулах арга хэрэгслийн эрэмбэ



Нийгэм, улс төр, соёл (I), эдийн засаг (II), төрийн тогтолцооны чадавч(III)-ыг бүрдүүлсэн нөхцөлд батлах хамгаалах,

гадаад харилцааг тэтгэх боломж бүрэн бүрдэнэ.

---

.....

## ЭХ СУРВАЛЖ

1. Б.Энхбайгаль. (2014 оны 10 10). *Изм ба төрийн оролцоо*. news.mn: <https://www.news.mn/?id=175711-ээс> Гаргасан
2. Bustonkala, R. K. (2011, 03 25). *Tajik land deal extends China's reach in Central Asia*. Retrieved from [www.reuters.com](http://www.reuters.com): <https://www.reuters.com/article/us-tajikistan-china-land/tajik-land-deal-extends-chinas-reach-in-central-asia-idUSTRE72O1RP20110325>
3. Hobbes, T. (1651). *Leviathan or The Matter, Forme and Power of a Common Wealth Ecclesiasticall and Civil*. Retrieved 2013, from <http://oregonstate.edu/instruct/phl302/texts/hobbes/leviathan-contents.html>
4. Malanszuk, P. (1970). *Akehurst's Modern Introduction to international Law* (Vol. Seventh revised edition). Routledge.
5. Schultz, K. (2017, 12 12). *Sri Lanka, Struggling With Debt, Hands a Major Port to China*. Retrieved from [www.nytimes.com](http://www.nytimes.com): <https://www.nytimes.com/2017/12/12/world/asia/sri-lanka-china-port.html>
6. Steinert-Trelkeld, S. (July 30, 2010). *Hobbes and Locke on Sovereignty*.
7. *Tajikistan Cedes Land to China*. (2011, 01 13). Retrieved from [www.bbc.com](http://www.bbc.com): <http://www.bbc.com/news/world-asia-pacific-12180567>
8. Times, F. (2017, 12 12). *China signs 99-year lease on Sri Lanka's Hambantota port: Critics denounce move as an erosion of country's sovereignty*. Retrieved from [www.ft.com](http://www.ft.com): <https://www.ft.com/content/e150ef0c-de37-11e7-a8a4-0a1e63a52f9c>



Б.БАТТӨР (М.А)

## ГАДААД ӨРИЙН УДИРДЛАГЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

*The study analyzes the impact of government debt of total external debt on Mongolian economy using the IMF's debt sustainability analysis methodology, raises issues within the legal framework, and suggests some ways to manage external debt.*

**Keywords:** *External debt management*

### УДИРТГАЛ

Дэлхий нийтийн хувьсан өөрчлөгдөж буй орчинд улс орнууд гадаад өр зээлийг хөгжил дэвшлийг хурдасгах нэг хүчин зүйл болгон ашиглаж байгаа бол нөгөө талаас эдийн засгийн өсөлт хөгжил, аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй хүчин зүйл болж байна.

Гадаад өр зээлийг өрсөлдөх чадвартай аж үйлдвэрт хөрөнгө оруулж, аливаа хямрал, хүндрэлийг даван туулах боломжтой хуримтлал үүсгэн, түүнчлэн гадаад валютын нөөцөө нэмэгдүүлж, өрийн хэмжээг эдийн засагтаа дарамт учруулахгүйгээр зохистой

түвшинд барьж, ашиглаж чадвал хөрөнгө оруулалтын нэг оновчтой хэлбэр болж эдийн засагт эерэг нөлөөлдөг байна. Харин улс орнуудын хувьд гадаад өрийн хэмжээ эргэн төлөх чадавхаас хэтэрч өрийн дарамт, хямралд орох нь нийтлэг бөгөөд өр нь эдийн засгийн аюулгүй байдал, цаашлаад бүрэн эрхт байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгодог тул өрийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх, гадаад өрийн удирдлагын асуудал нэн чухлаар тавигддаг байна.

Монгол Улсын хувьд гадаад өрийн хэмжээ сүүлийн 10 жилд дөрөв дахин

нэмэгдэж, Монголбанкны албан ёсны статистик үзүүлэлтээр 2020 оны III улирлын байдлаар 31.2 тэрбум ам.долларт хүрч, үүнээс Засгийн газрын гадаад өр 8.1 тэрбум ам.доллар болж өсчээ. Манай улсын эдийн засагт олборлох салбарын анхан шатны үйлдвэрлэл зонхилсон, түүхий эдийн олон улсын зах зээлийн үнийн хэлбэлзлээс бүрэн хараат, цөөн нэр төрлийн түүхий эдийн экспортод түшиглэсэн байдал бүтэцтэй. Эдийн засгийн дотоод нөхцөл байдлыг харгалзан гадаад улс орон, олон улсын байгууллагаас авах өр, зээлийн асуудлыг эдийн засгийн аюулгүй байдалд хохиролгүйгээр зохицуулах сорилт бидний өмнө тулгарч байгаа нь гол асуудал болоод байна.

Иймд, энэхүү судалгаагаар Монгол Улсын гадаад өр, түүний эргэн төлөлтөөс үүдэн эдийн засагт учирч буй дарамт, эрсдэл, цаашид эрсдэлийг бууруулах, гадаад өрийн удирдлагыг сайжруулах арга замын судалгаа.

### ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТӨД ГАДААД ӨРИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

Тухайн улсын гадаад өрийн эдийн засагт үзүүлэх нөлөө нь хөгжлийн өнөөгийн түвшин болон өрийн хэмжээнээс хамаарч харилцан адилгүй байдаг. Улс орнууд “Хадгаламж-Хөрөнгө оруулалт”-ын зөрүүг нөхөх зорилгоор гадаад өрийн хэмжээг нэмэгдүүлдэг<sup>1</sup> бөгөөд ялангуяа хөгжиж буй орнуудад дотоодын хуримтлал бага байдгаас санхүүжилтийн хэрэгцээгээ гадаад эх үүсвэрээс хангах шаардлага тулгардаг. Түүнчлэн хөгжиж буй орнууд эдийн засгийн хөгжлөө хурдасгах, дотоодын хөрөнгийн дутагдлаа нөхөх нэг гол эх үүсвэрээ ихэвчлэн гадаад капиталын нөөцөөр бүрдүүлдэг.<sup>2</sup> Өр, зээлийн зохистой түвшин

<sup>1</sup> Chenery, Hollis B., and Alan M. Strout. “Foreign Assistance and Economic Development.” *The American Economic Review*, vol. 56, no. 4, 1966, pp. 679–733. JSTOR, <http://www.jstor.org/stable/1813524>.

<sup>2</sup> Panizza, U. *Domestic and External Public Debt in*

нь хөгжиж буй улсуудын эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэх нөлөөтэй.<sup>3</sup> Өрийн хэмжээ зохих түвшнээс давбал эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх бөгөөд урт хугацаанд эдийн засгийн өсөлтийг сааруулж, эдийн засагт ихээхэн дарамт болсноор бодит өсөлт бий болгох боломж хумигдана. Мөн өр ихсэн төлбөрийн чадвар муудах тусам хөрөнгө оруулагчдын эргэлзээ нэмэгдэн хөрөнгөө буцаан татах эрсдэл үүсэхийн зэрэгцээ эдийн засгийн аливаа бодлого хэрэгжүүлэх орон зай хязгаарлагддаг байна.<sup>4</sup>

Өрийн дарамтад орж, эргэн төлөх боломжгүй болох нь улсыг өрийн дефолт зарлахад хүргэдэг. Улсын өрийн дефолт нь олон сувгаар дамжих бөгөөд гадаад зах зээлээс эх үүсвэр татах хүүг өсгөж, зээлжих зэрэглэлийг бууруулж, гадаад худалдааг хумьж, банкны системийг сульдуулж, үндэсний валютын ханшийг сулруулж, эцэстээ үйлдвэрлэлийн өндөр алдагдлыг бий болгодог байна.<sup>5</sup>

Иймд гадаад өрийн хэт өсөлт нь улс орны эдийн засгийн бие даасан байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд ч аюул занал учруулж болох юм.

Нгози Оконжо-Ивеала, Чарльз Чуквума Солудо, Мансур Мухтар нар улсын өрийн бодлого нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаад зээлийг багасгах, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх гадаад зээлийн хэмжээг зохистой түвшинд байлгах, өрийн дарамтгүй тогтвортой хөгжих нөхцөлийг бий болгоход чиглэх

Developing Countries. March 2008. UNCTAD Discussion Papers 188. [https://unctad.org/system/files/official-document/osgdp20083\\_en.pdf](https://unctad.org/system/files/official-document/osgdp20083_en.pdf)

<sup>3</sup> Wang, F. 2009. The Effects of Foreign Borrowing Policies on Economic Growth: Success or Failure?. *Journal of Economic Policy Reform*, 12(4), 273-284

<sup>4</sup> Энхбайгаль Б. Монгол Улсын бүрэн эрхийн эмзэг байдлын үнэлгээ. УБ.: 2018. 85х. ISBN:978-99978-2-983-2 51x

<sup>5</sup> Ган-Очир Д. Монголын хөгжлийн зам: сургамж, сорилт, боломж. УБ.: “Адмон принт” ХХК. 2020. 334х. ISBN 978-9919-23-280-1 107x

шаардлагатай<sup>6</sup> гэж үзсэн байна. Улс орнууд засгийн газрын өрийн удирдлагын бодлогыг боловсруулан хэрэгжүүлдэг ба түүний үр ашиг нь хяналт тавих тогтолцооноос хамаардаг. Зарим улс өрийн удирдлагын тухай хуулиас гадна өрийн аудитын тухай хууль, эрх зүйн зохицуулалттай байдаг.<sup>7</sup>

Өрийн хямрал үүсэх нөхцөл байдлыг ирээдүйд үүсч болох өрийн дарамтаар тодорхойлоод, өрийн дарамтыг өрийн тогтвортой байдлын шинжилгээний аргачлалаар тооцдог. Өрийн тогтвортой байдлын шинжилгээний загваруудыг авч үзвэл нийтлэг байдлаар ОУВС, Дэлхийн банкны аргачлалд тулгуурлаж байна.

Тус аргачлалаар гадаад өрийн төлбөрийн чадварын эрсдэлийг тодорхойлохдоо ДНБ, экспорт, засгийн газрын орлогын мэдээллийг тус тус ашигладаг. Аливаа улсын эдийн засгийн чадавх нь бүтээгдэхүүн үйлдвэрлэл, экспортоос хамаарах тул өрийн хэмжээ нь экспорт болон ДНБ-тэй харьцуулахад тогтвортой байх шаардлагатай юм.

### **МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨРИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

Монгол Улс 2015 онд өрийн удирдлагын бодлого, зохицуулалтын хүрээнд өрийн зохистой түвшинг хангах, дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх, Засгийн газар, орон нутаг зээллэг хийх замаар өр үүсгэх, дамжуулан зээлдүүлэх, Засгийн газрын өрийн баталгаа гаргах, тэдгээрийг бүртгэх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор “Өрийн удирдлагын тухай” хуулийг баталсан. Энэ хууль нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,

<sup>6</sup> Оюунцацрал З., Б.Мөнхзаяа болон бусад. Гадаад өрийн дарамт, эдийн засагт учирч болох эрсдэлүүд, бодлогын зөвлөмж. 799-874 х. //Монголбанк. Судалгааны ажил товхимол 10. 2015. 808 х. Дам эшлэв.

<sup>7</sup> Vieira M. Regulatory frameworks and government auditing of public debt. 213-243 p. //Public debt: the Brazilian experience. World Bank. 2010. 450 p. ISBN 978-85-87841-44-5

Төсвийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, дээр дурдсан хууль болон эдгээр нэр бүхий хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэх бөгөөд эдгээр хуулиудаар өрийн асуудлыг зохицуулахаар заажээ.

Өрийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ удирдлагын нэгдсэн тогтолцоотой байх, өрийн зохистой түвшинг хангах, өр үүсгэж бий болгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, ил тод байдлыг хангах, хариуцлагатай байх зарчмыг баримтлах ба өрийн удирдлагын харилцаанд оролцогч этгээд нь дээрх зарчмыг мөрдөж, хэрэгжүүлэх үүрэгтэй.<sup>8</sup>

Өрийн удирдлагын тухай хуулийн 6.3-т өрийн зохистой түвшинг хангах зарчмыг хэрэгжүүлэх арга замыг дараах байдлаар тусгаж өгсөн байдаг.

6.3.1. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т заасан шаардлагыг хангасан байх;

6.3.2. Засгийн газрын шинээр үүсгэх өр болон гаргах өрийн баталгаа нь энэ хуулийн 17.1-д заасан дээд хэмжээнд нийцсэн байх;

6.3.3. Засгийн газар болон орон нутгийн зээллэг, Засгийн газрын өрийн баталгаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр нөлөө нь ирээдүйд өрийн дарамт учруулахгүй байх;

6.3.4. Урт хугацаанд Засгийн газрын өрийн зохистой түвшинг хангах замаар Засгийн газрын өрийн удирдлагыг хэрэгжүүлэх.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар Засгийн газрын өрийн ӨҮЦ-ээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй байхаар, энэ зорилгод хүрэхийн

<sup>8</sup> Өрийн удирдлагын тухай хууль. 2015

тулд ӨҮЦ-ээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн үлдэгдлийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг 2015 онд 58.3, 2016 онд 55.0, 2017 онд 50.0, 2018 онд 40.0 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар хуульчилсан байдаг.

Мөн УИХ-аас 2015 оны тавдугаар сарын 21-ний өдөр баталсан Монгол

Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуульд Засгийн газрын нийт өрийн хэмжээ 2016 онд 15,174.4 тэрбум, 2017 онд 15,560.1 тэрбум, 2018 онд 14,323.6 тэрбум төгрөг байхаар, ӨҮЦ-ээр ДНБ-д эзлэх хувь 2016 онд 55.0, 2017 онд 50.0, 2018 онд 40.0 байхаар заажээ.

### Хүснэгт 1. ӨҮЦ-ээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувь хэмжээг тогтоосон хуулийн заалтын өөрчлөлт

УИХ-аар баталсан	2015	2016	2017	2018	2019	2020	2021
ТТБТХ-д 2015 оны 01 сарын 20-ны өдөр оруулсан өөрчлөлт	58.3	55	50	40	40	40	40
ТТБТХ-д 2016 оны 09 сарын 09-ний өдөр оруулсан өөрчлөлт	58.3	88	85	80	75	70	60
Гүйцэтгэл	62.3	93.1	81.6	69.0	64.8	-	-

Гэвч 2015 онд Засгийн өрийн хэмжээ төсвийн тусгай шаардлагаас хэтэрч, 2016 онд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулан батлах замаар өрийн хязгаарыг нэмэгдүүлсэн. Энэ нь өр өсөх нөхцөлийг бүрдүүлсэн. Тодруулбал, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2016 оны есдүгээр сарын 9-ний өдөр өөрчлөлт оруулан Засгийн газрын өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байхаар заасан. Энэ зорилгод хүрэхийн тулд ӨҮЦ-ээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээг 2015 оны төсвийн жилд 58.3, 2016 оны төсвийн жилд 88, 2017 оны төсвийн жилд 85, 2018 оны төсвийн жилд 80, 2019 оны төсвийн жилд 75, 2020 оны төсвийн жилд 70, 2021 оны төсвийн жилээс эхлэн 60 хувиас тус тус хэтрүүлэхгүй байхаар хуульчилснаар өрийн тусгай шаардлага 2016-2019 онд хангагдаж байна.

Ийнхүү өрийн хэмжээнд тавигдах тусгай шаардлага биелэхээргүй нөхцөл байдал үүсэх үед хуульд өөрчлөлт оруулах замаар асуудлыг шийдэж байгаа нь өрийн удирдлагыг хэрэгжүүлэх гол зорилго, зарчимд нийцэхгүй байна.

Түүнчлэн УИХ-аас Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2016 оны нэмэлт өөрчлөлтөөр тогтоосон өрийн хязгаар нь ОУВС болон Дэлхийн банкнаас тогтоосон өрийн тогтвортой байдлын үзүүлэлтээс хэтэрсэн байна. Өрийн удирдлагыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжилтэд хяналт тавих, мониторинг, үнэлгээ хийх системийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага тулгарч байна.


### МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨРИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

**Нийт гадаад өр.** Монгол Улсын нийт гадаад өрийн хэмжээ 2010 онд 7.1 тэрбум ам.доллар байсан бол сүүлийн 10 жилд 4 дахин нэмэгдэж, 2020 оны III улирлын байдлаар 31.2 тэрбум ам.долларт хүрчээ (Зураг 1). Энэ дүнгээс харахад, нийт гадаад

өр ДНБ-ий 246 хувьтай тэнцэж, жилийн экспортын орлогоос 6 дахин өндөр байна (Зураг 2). Хэдийгээр нийт гадаад өрийн хэмжээг аюулгүй байдалд нөлөөлөхөөр хэмжээнд байгаа эсэхийг хянах шалгуур

(босго) байхгүй ч дээрх харьцаанууд нь гадаад зах зээлээс хамаарал өндөр, импортын хэрэгцээ ихтэй, дотоодын хуримтлал бага эдийн засагтай улсын хувьд хэт өндөр үзүүлэлт болж байгаа юм.

**Зураг 1. Монгол Улсын нийт гадаад өр, ДНБ-ий харьцаа, тэрбум ам.доллар**



Эх сурвалж: Монгол банк болон ҮСХ-ны статистик

**Зураг 2. Гадаад өр/ДНБ, гадаад өр/экспорт**



Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Гадаад өрийн бүтцээс харахад сүүлийн 10 жилийн хугацаанд Засгийн газар, төв банк, хадгаламжийн байгууллага, бусад салбаруудын өр болон өр үүсгэх нөхцөлтэй шууд хөрөнгө оруулалтын зээл 3-7 дахин нэмэгдсэн бөгөөд 2016 оноос хойш Засгийн

газрын өр хамгийн ихээр буюу 62 хувиар өссөн байна.

Хувийн хэвшлийн өр эцсийн дүндээ Монгол Улсын үндэсний орлого, экспорт, валютын орлогоос төлөгдөнө. Үндсэн

хөрөнгийн үнэ, хөрөнгө оруулалт, зээлийн хүүгээр дамжин пүүс, компаниудын өртөг зардлыг өсгөн улмаар татвар ногдох ашгийг бууруулж, гадагшлах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлдэг гэдгийг анхаарлын төвөөс гаргаж болохгүй билээ.<sup>9</sup> Өөрөөр хэлбэл, дотоодын аж ахуйн нэгжүүдийн гадаад өр өсөх нь төсвийн орлогыг бууруулах, валютын гарах урсгалыг нэмэгдүүлэх замаар төлбөрийн тэнцлийн алдагдал, улмаар гадаад валютын нөөцийн өөрчлөлтөд нөлөө үзүүлнэ. Тиймээс нийт гадаад өр, түүний эргэн төлөлтийн хуваарьт анхааралтай мониторинг хийж байх нь төлбөрийн тэнцэл, валютын нөөцийн цаашдын төлөв, санхүүгийн болон макро эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалахад туйлын чухал болж байна. Түүнчлэн тухайн улсын зээлжих зэрэглэл, чадавх, улсын эрсдэлийн тооцоонд Монгол Улсын нийт гадаад өрийг илүүтэй харгалздаг. Иймд төрийн бодлогын хүрээнд нийт гадаад өрийн удирдлагын стратеги боловсруулан хэрэгжүүлж байх нь чухал байна.<sup>10</sup>

**Засгийн газрын гадаад өр.** 2009 онд Монгол Улс олон улсын зээлжих зэрэглэлээр бага орлоготой орноос – дундаас доогуур орлоготой орны ангилалд шилжиж Засгийн

газар олон улсад үнэт цаас гаргаж, арилжааны зээл авах боломжтой болсноор Засгийн газрын гадаад өр хурдацтай нэмэгдэж, одоогоор 8.1 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь Засгийн газрын өөрөө шууд авсан зээл гэж үзэж болно.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд Засгийн газрын өрд өөрөө шууд авсан өрөөс гадна баталгаа гаргасан өр зээлийг хамруулна гэж заасан байдаг. Засгийн газар баталгаа гаргуулагч нь гэрээнд заасан төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн өмнөөс төлж барагдуулах үүрэгтэй<sup>11</sup> тул Засгийн газрын төлж болзошгүй өр төлбөр болно.

2012-2016 оны хооронд Засгийн газар дотоодын аж ахуй нэгж байгууллагын гадаадын банк санхүүгийн байгууллага болон олон улсын зах зээлд бонд арилжиж авсан 2.29 тэрбум ам.доллар бүхий гадаад өрд баталгаа гаргасан (Хүснэгт 2). Эндээс төлөгдөөгүй байгаа Хөгжлийн банк, МИАТ ТӨХК, Эрдэнэс Монгол ХХК (нийт гадаад өрийн дүнд 26 хувийг эзэлж буй бусад салбарын ангилалд орсон)-ийн өр нь Засгийн газрын гадаад өрийн үлдэгдэлд тооцогдоно.

<sup>9</sup> Даваасамбуу Д. Зээлийг хөгжил болгоход анхаарах зарим асуудал. 2013. ННФ. 14 дүгээр тал

<sup>10</sup> Ган-Очир Д. Монголын хөгжлийн зам: сургамж, сорилт, боломж. УБ.: “Адмон принт” ХХК. 2020. 334х. ISBN 978-9919-23-280-1 107х

<sup>11</sup> Өрийн удирдлагын тухай хууль. 2015



**Хүснэгт 2. Засгийн газрын өрийн баталгаа**

	Баталгаа гаргасан он	Арилжаалсан дүн /сая ам.доллар/	Жилийн хүү, хувиар	Эргэн төлөгдөх, төлөгдсөн хугацаа	
1	Монгол Улсын Хөгжлийн банк	1,565.0			
	Евро бонд	2012	580.0	5.75	2017.03.21
	Кредит Свисс банкны зээл	2014	300.0	4.375+(LIBOR)	2019.09.05
		2016	250.0	6.25	2021.03.15
	Самурай бонд	2013	30 тэрбум иен буюу 273 сая ам.\$	1.52	2023.01.06
	БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл	2014	162.0	6	2022.09.03
2	МИАТ ТӨХК-ний Бойнг онгоц худалдан авах зээл		121.3		
	АНУ-ын Экспорт-Импорт банк	2013	77.4	2.52	2023.12.24
	ING банк	2013	23.9	5.3+(LIBOR)	2020.12.24
	ING банк	2013	20.0	9.38+(LIBOR)	2018.12.24
3	Худалдаа хөгжлийн банкны олон улсын зах зээл арилжаалсан бонд	2015	500.0	9.375	2020.05.19
4	Эрдэнэс Монгол ХХК-ний АХБ-наас авсан зээл	2016	35.0	0.6+(LIBOR)	2031.04.01
5	Хөгжлийн банкны ОХУ-ын ВТБ банкнаас авсан зээл	2016	65.4	7+(LIBOR)	2016.06.01
	Өрийн баталгааны дүн		2,286.7		

*Эх сурвалж: Сангийн яам*

Засгийн газар 2016 оны зургаадугаар сараас хойш шинээр өрийн баталгаа гаргаагүй бөгөөд гаргасан өрийн баталгаат зээллэгийн эргэн төлөлтүүд хийгдэж үлдэгдэл буурч байгаа ч гадаад үнэт цаас, зээлийн хэмжээ тогтмол өсч байна. 2020 оны III улирлын

байдлаар Засгийн газрын гадаад үнэт цаас, гадаад зээлийн үлдэгдэл 23.0 их наяд төгрөг, баталгааг оруулан тооцвол 24.1 их наяд төгрөгт хүрчээ (Хүснэгт 3). Энэ дүнд Засгийн газрын сүүлд гаргасан 600 сая ам.долларын Номад бондын зээл ороогүй болно.

## Хүснэгт 3. Засгийн газрын өрийн бүтэц

Өрийн бүтэц, өрийн хэрэгсэл		2018.12.31	2019.12.31	2020.09.30	Өөрчлөлт 2019-2020*	Дүнд эзлэх хувь
I. Засгийн газрын дотоод өр		<b>1,564.7</b>	<b>1,399.6</b>	<b>1,317.6</b>	<b>-82.0</b>	<b>5%</b>
1.1	Үнэт цаас	1,564.7	1,399.6	1,317.6	-82.0	5%
II. Засгийн газрын гадаад өр		<b>18,865.6</b>	<b>20,728.1</b>	<b>23,039.4</b>	<b>2,311.3</b>	<b>88%</b>
2.1	Үнэт цаас	7,664.5	7,927.2	8,276.8	349.6	32%
2.2	Зээл	11,201.1	12,800.9	14,762.6	1,961.7	56%
III. Засгийн газрын өрийн баталгаа		<b>1,130.7</b>	<b>1,076.3</b>	<b>1,050.2</b>	<b>-26.1</b>	<b>4%</b>
3.1	Засгийн газрын өрийн баталгаа	1,130.7	1,076.3	1,050.2	-26.1	4%
IV. Барих-шилжүүлэх төрлийн концесс		<b>806.0</b>	<b>995.7</b>	<b>860.2</b>	<b>-135.6</b>	<b>3%</b>
4.1	Концесс	806.0	995.7	860.2	-135.6	3%
Засгийн газрын нийт өр		22,367.0	24,199.7	26,267.3	2,067.6	100%
Засгийн газрын өр (ӨҮЦ)		18,955.9	20,525.6	22,138.6	1,613.0	
Хуулиар тогтоосон өрийн хязгаар		80.0%	75.0%	70.0%		
Засгийн газрын өр (ӨҮЦ) / ДНБ		58.9%	55.6%	57.2%		
Засгийн газрын өр/ДНБ		69.5%	65.6%	67.9%		
Дотоодын нийт бүтээгдэхүүн (оны үнээр)*		32,165.97	36,897.64	38,688.25		
Ам.долларын тайлант үеийн эцсийн ханш		2,642.92	2,733.52	2,854.07		

Эх сурвалж: Сангийн яам

Ихэнх хөгжиж буй оронд дотоодын хуримтлал бага байдгаас санхүүжилтийн хэрэгцээгээ гадаад эх үүсвэрээр хангах шаардлагатай болдог. Монгол Улсын хувьд татварын орлого, иргэд, хувийн хэвшлийн дотоод хуримтлал хангалтгүй байдгаас эдийн засаг, нийгмийн хөгжилд шаардагдах хөрөнгийг гадаад эх үүсвэрээр

санхүүжүүлж байна. 2020 оны III улирлын байдлаар Засгийн газрын гадаад өрийн хэмжээ ДНБ-ий 62.3 хувьтай тэнцэж байгаа нь экспортын орлогоос 1.6 дахин, төсвийн орлогоос 3.6 дахин их байна (Хүснэгт 4). Экспортын орлогыг бүхэлд нь гадаад өрийн төлбөрт төлж, төсвийн дарамт нэмэгдэх бодит эрсдэл бий болжээ.

#### Хүснэгт 4. Засгийн газрын гадаад өрийн тогтвортой байдал

Үзүүлэлтүүд	Сэрэмжлэх түвшин	2018	2019	2020.3
Засгийн газрын гадаад өр/ДНБ	40%	62%	59%	62%
Засгийн газрын гадаад өр/Экспорт	150%	108%	105%	164%
Засгийн газрын гадаад өр/Төсвийн орлого	250%	217%	202%	359%

Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Нөгөөтэйгүүр экспорт, төсвийн орлого дорвитой өсөхгүй байгаагаас гадаад өр нэмэгдэхэд өрийн тогтвортой байдлын харьцаанууд даган өсч байна.

Судлаач Антони Миллерийн “Монгол ба Казахстаны хэрэгжүүлж буй уул уурхайн татварын өнөөгийн бодлого: Улаанбаатар ба Астанагийн хөгжлийн харьцуулалт” сэдэвт судалгаанд Монгол Улс уул уурхайн 12 түүхий эдэд Казахстаны жишгээр татвар ногдуулбал улсын төсөвт жил бүр 1.3 орчим тэрбум ам.доллар нэмж орж ирэх тооцоог гаргаж, баялгаа олборлосноос зохих үр ашгийг хүртэхгүй байгаагаас улс орныг хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилтээс хоцорч байна гэж дүгнэсэнтэй<sup>12</sup> санал

<sup>12</sup> Miller, A.D. (2019). Current Mining Taxation Policy Implemented by both Mongolia and Kazakhstan:

нийлж байна.

Уул уурхайн салбар 2020 оны урьдчилсан гүйцэтгэлээр нийт төсвийн орлогын 26.2, экспортын орлогын 69.4 хувийг тус тус бүрдүүлж байгаа ба цаашид ч орлогын гол эх үүсвэр байх нь дамжиггүй. Иймд уул уурхайн татварын зөв тогтолцоог бүрдүүлэх нь гадаад өрийн асуудлыг шийдвэрлэх нэг гол гарц байх юм.

Засгийн газрын өрийн хүүгийн зардал 2019 онд төсвийн орлогын 8.3, төсвийн зарлагын 7.8 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд хүүгийн зардлын төсөвт үзүүлэх дарамт 2017 оноос буурчээ (Зураг 3). Гэсэн хэдий ч гадаад өрийн үндсэн төлбөр хийгдэх жилүүдэд өсөх эрсдэл хэвээр байна.

The Development Comparatives between Ulaanbaatar and Astana. Business Ethics and Leadership, 3(2), 39-52p. [http://doi.org/10.21272/bel.3\(2\).39-52.2019](http://doi.org/10.21272/bel.3(2).39-52.2019). 45-47p

#### Зураг 3. Хүүгийн зардлын төсөвт учруулах дарамт



Эх сурвалж: ҮСХ-ны тоон мэдээлэлд түшиглэн тооцов

Өрийн хүүгийн төлбөр урсгал тэнцлийн алдагдалд нөлөөлж энэ нь эргэн төгрөгийн ханшийг сулруулж, ханшийн зөрүүгээс гарах алдагдлыг өсгөхөд хүргэж байна.

Засгийн газар 2018 оноос хойш олон улсын зах зээлд шинээр бонд арилжаагүй байхад Засгийн газрын гадаад үнэт цаасны

зээлийн үлдэгдэл сүүлийн гурван жил дараалан нэмэгдсэн нь ханшийн өөрчлөлттэй холбоотой. 2020 оны III улиралд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 2019 оноос 4 хувиар суларснаас болж гадаад үнэт цаасны зээлийн үлдэгдэл жилийн дотор 349.6 тэрбум төгрөгөөр нэмэгджээ (Хүснэгт 5).

#### Хүснэгт 5. Засгийн газрын үнэт цаасны үлдэгдлийн ханшийн зөрүүнээс үүссэн нэмэгдэл

Гадаад үнэт цаас	Гаргасан он	Жилийн хүүгийн хувь	2019 оны байдлаар үлдэгдэл		Ханшийн өөрчлөлт /тэрбум төгрөг/	2020* оны байдлаар үлдэгдэл		Эргэн төлөх он
			сая ам.доллар	тэрбум төгрөг		сая ам.доллар	тэрбум төгрөг	
Чингис бонд	2012.12.05	5.125	1000.0	2,733.5	120.6	1000.0	2,854.1	2022.12.05
Мазаалай бонд	2016.04.06	10.875	500.0	1,366.8	60.3	500.0	1,427.0	2021.04.06
Хуралдай бонд	2017.03.09	8.75	600.0	1,640.1	72.3	600.0	1,712.4	2024.03.09
Гэрэгэ бонд	2017.11.01	5.625	800.0	2,186.8	96.4	800.0	2,283.3	2023.05.01
<b>Нийт дүн</b>			2900.0	7,927.2	349.6	2900.0	8,276.8	

*Эх сурвалж: Судлаачийн тооцоо*

Ийнхүү валютын ханшийн зөрүүнээс үүдэн Засгийн газрын гадаад өрийн хэмжээ ихээхэн нэмэгдэж байна. Монгол Улсын нийт гадаад өрийн дийлэнх хувийг ам.долларын өр зээл эзэлж байгаа ба цаашид ханшийн зөрүүгээр гадаад өрийн хэмжээ нэмэгдэж, өрийн үйлчилгээний төлбөрийн төсөвт үзүүлэх дарамт улам нэмэгдэх болно.

#### ДҮГНЭЛТ

Монгол Улсын гадаад өр сүүлийн 10 жилд 4 дахин нэмэгдэж 2020 оны III улирлын байдлаар 31.2 тэрбум ам.доллар, Засгийн газрын гадаад өр 8.1 тэрбум ам.долларт хүрч өсчээ. Нийт гадаад өр ДНБ-ий 246 хувьтай тэнцэж, жилийн экспортын орлогоос 6 дахин өндөр байгаа бол Засгийн газрын гадаад өрийн хэмжээ ДНБ-ий 62.3 хувьтай тэнцэж, экспортын орлогоос 1.6 дахин, төсвийн орлогоос 3.6 дахин их

байна. Энэ нь гадаад өрийн хэмжээ эдийн засгийн даах чадвараас давж, эдийн засгийн өсөлт, хөгжил, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөхөөр түвшинд очсоныг харуулж байгаа бөгөөд өрийн удирдлага тааруу байгаагийн илрэл юм.

Хэдийгээр өрийн удирдлагыг зохицуулах эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжилтэд хяналт тавих, мониторинг, үнэлгээ хийх системийг бүрдүүлээгүйн улмаас өрийн хэмжээнд тавигдах тусгай шаардлага биелэхээргүй нөхцөл байдал үүсэх үед хуульд өөрчлөлт оруулж, өрийн зохих түвшний хязгаарыг нэмсэн нь өрийн хэмжээг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Мөн гадаад өр зээл нь эргэн төлөлтийн баталгаа болох төсөл хөтөлбөрүүдэд оновчтой хуваарилагдахгүй байгаагаас өрийн үйлчилгээний төлбөр төсөвт ихээхэн дарамт учруулжээ. Түүнчлэн

Засгийн газар 2018 оноос хойш олон улсын зах зээлд шинээр бонд арилжаагүй байхад засгийн газрын гадаад үнэт цаасны зээлийн үлдэгдэл сүүлийн 3 жил ханшийн өөрчлөлтөөр нэмэгдсэн байна.

Олон улсад гадаад өрийн асуудлыг шийдвэрлэх шалгарсан томъёо, арга хэрэгсэл гэж байхгүй. Харин гадаад өрийн удирдлагын оновчтой стратегийг боловсруулан хэрэгжүүлэх нь эдийн засгийн өсөлт, бие даасан, аюулгүй байдлыг хангах хүчин зүйл болно. Иймд Монгол Улсад үүсээд буй гадаад өрийн асуудал, түүний сөрөг үр дагавар, эрсдэлийг бууруулахын тулд гадаад өрийн удирдлагыг сайжруулах алхмуудыг хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Үүний тулд:

- Төрийн зохих байгууллагаас эдийн засгийн аюулгүй байдалд гадаадын өрийн үзүүлэх нөлөө, эрсдэлийн шинжилгээг тогтмол хийж, эрсдэлийн менежментийг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэх,
- Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох бусад эрх зүйн актуудын хэрэгжилтэд хяналт тавих, мониторинг, үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх,
- Хууль тогтоомжоор шалгуур болгосон төсвийн зарчим, өрийн тусгай шаардлагын зохицуулалтыг тогтвортой байлгах, өрийн зохих түвшин, хязгаарыг нэмэгдүүлэхгүй байх,

- Улсын нийт гадаад өрийн урт хугацааны удирдлагын стратегийг боловсруулан хэрэгжүүлэх,
- Дотоодын үр ашигтай төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг дэмжин, бизнесийн орчныг сайжруулах замаар экспортыг нэмэгдүүлэх, улмаар төсвийн орлогыг өсгөх, өр төлөх арга замыг эрэлхийлэх. Ингэхдээ уул уурхайн татварын зөв тогтолцоог бүрдүүлэх замаар улсын орлогыг нэмэгдүүлэх, гадны санхүүжилтийн хэрэгцээг бууруулах, өр төлбөрийг барагдуулах чиглэлд түлхүү анхаарах,
- Гадаад өрийн үйлчилгээний төлбөрийг төсөвт дарамт учруулахгүйгээр барагдуулахын тулд гадаад валютын нөөцийг хангалттай хэмжээнд нэмэгдүүлэх, удирдлагаар хангах,
- Гадаад өрийн бодлогыг оновчтой, үр ашигтай байлгах үүднээс гадаадын хөрөнгө оруулалтын бодлого, стратегитай нягт уялдуулах,
- Зайлшгүй шаардлага үүссэн нөхцөлд өндөр хүүтэй, арилжааны нөхцөлтэй зээл бус олон улсын байгууллага, хандивлагч орноос хөнгөлөлттэй зээл, тусламж авч байх тал дээр анхаарч ажиллах, харилцаа холбоогоо сайжруулах зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай юм.

---

**ЭХ СУРВАЛЖ**

1. Chenery, Hollis B., and Alan M. Strout. "Foreign Assistance and Economic Development." *The American Economic Review*, vol. 56, no. 4, 1966, pp. 679–733. JSTOR, <http://www.jstor.org/stable/1813524>.
2. Panizza, U. Domestic and External Public Debt in Developing Countries. March 2008. UNCTAD Discussion Papers 188. [https://unctad.org/system/files/official-document/os-gdp20083\\_en.pdf](https://unctad.org/system/files/official-document/os-gdp20083_en.pdf)
3. Wang, F. 2009. The Effects of Foreign Borrowing Policies on Economic Growth: Success or Failure?. *Journal of Economic Policy Reform*, 12(4), 273-284
4. Энхбайгаль Б. Монгол Улсын бүрэн эрхийн эмзэг байдлын үнэлгээ. УБ.: 2018. 85х. ISBN:978-99978-2-983-2 51х
5. Ган-Очир Д. Монголын хөгжлийн зам: сургамж, сорилт, боломж. УБ.: “Адмон принт” ХХК. 2020. 334х. ISBN 978-9919-23-280-1 107х
6. Оюунцацрал З., Б.Мөнхзаяа болон бусад. Гадаад өрийн дарамт, эдийн засагт учирч болох эрсдэлүүд, бодлогын зөвлөмж. 799-874 х. //Монголбанк. Судалгааны ажил товхимол 10. 2015. 808 х.
7. Vieira M. Regulatory frameworks and government auditing of public debt. 213-243 p. // Public debt: the Brazilian experience. World Bank. 2010. 450 p. ISBN 978-85-87841-44-5
8. УИХ. (2015). Өрийн удирдлагын тухай хууль
9. Даваасамбуу Д. Зээлийг хөгжил болгоход анхаарах зарим асуудал. 2013. ННФ. 14 дүгээр тал
10. Miller, A.D. (2019). Current Mining Taxation Policy Implemented by both Mongolia and Kazakhstan: The Development Comparatives between Ulaanbaatar and Astana. *Business Ethics and Leadership*, 3(2), 39-52p. [http://doi.org/10.21272/bel.3\(2\).39-52.2019](http://doi.org/10.21272/bel.3(2).39-52.2019). 45-47p
11. УИХ. (2019). Засгийн газрын өрийн удирдлагын 2019-2022 оны стратегийн баримт бичиг
12. УИХ. (2010). Төсвийн тогвортой байдлын тухай хууль.
13. УИХ. (2011). Төсвийн тухай хууль.
14. Үндэсний Аудитын газар. (2019). “Засгийн газрын өрийн удирдлагын 2016-2018 оны стратегийн баримт бичгийн хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитын тайлан
15. Үндэсний Статистикийн хороо. (2020). Статистик.
16. IMF. (2013). Debt sustainability framework for Low-Income countries.
17. IMF. (2013). Public debt sustainability analysis in market-access countries.



Д.БАТМӨНХ (М.А)

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БОЛОН ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА: КОРОНАВИРУСЫН МОНГОЛ УЛСАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

*As 2020 approaches, the spread of a new coronavirus in China has shocked half world. The disease is spreading rapidly among the population and the number of deaths is increasing day by day. The article will discuss how current situation could affect the Mongolian economy.*

### ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2020 он гарахтай зэрэгцээд БНХАУ-д шинэ коронавирус тархсантай холбоотой улс орнуудыг цочролд орууллаа. Уг өвчлөл нь хүн амын дунд маш хурдтай тархаж амь үрэгсдийн тоо өдөр ирэх тутам нэмэгдэж байгаа тул дэлхийн олон улсад хилээ хааж, хорио цээр тавих болсноор олон улсын эдийн засагт том сорилт тулгарсан.

Эдийн засгаар тэргүүлж буй хүчирхэг хоёр гүрний худалдааны маргаантай асуудал<sup>1</sup> бүрэн биш боловч тодорхой үр


<sup>1</sup> 2020 оны нэгдүгээр сарын 15 өдөр АНУ-ын зүгээс БНХАУ-ын зарим бараанд татварын хэмжээг буулгаж харин БНХАУ-аас АНУ-ын зарим

дунд хүрсэн нь 2020 оны I улиралд олон улсын эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх хүлээлтийг бий болгоод байв. Харин шинэ Коронавирусын (Covid-19)<sup>2</sup> тархалтаас үүдэн олон улсын эдийн засаг саарч эдийн засгийн тодорхой бус байдал үүсгэсэн. Өнөөгийн нөхцөл байдал эдийн засагт үзүүлэх хохирлын хэмжээг тодорхойлоход эрт байгаа хэдий ч хөрөнгө, санхүүгийн зах зээл дээр сөрөг нөлөө үзүүлээд эхэлсэн.

бүтээгдэхүүн, үйлчилгээг авах тохиролцоонд хүрч худалдааны хэлцлийн нэгдүгээр үе шатанд гарын үзэг зурсан.

<sup>2</sup> Шинэ Коронавирус SARS вирусийн 79.5 хувийн генийг өвчлөсөн.

### Зураг 1. Балтик драй индекс (Baltic Dry) 2020 оны есдүгээр сар



Эх сурвалж: (Trading economics, 2020)


сараас сайжирсан болов ч АНУ, БНХАУ-ын худалдааны сөргөлдөөн тодорхой үр дүнд хүрч чадахгүй байгаа, коронавирусээс үүдсэн эдийн засгийн хориг арга хэмжээ бүрэн цуцлагдаагүй тул олон улсын ачаа тээвэрлэлт тогтвортой өсөлтийг үзүүлж чадахгүй байна.

Улс орнууд коронавирусын халдвар тархсанаас хойш таван сарын дараагаар

АНУ болон БНХАУ-ын худалдааны сөргөлдөөнөөс болж 2019 оны дунд үеэс далайн тээвэрлэлтийн хэмжээ буурсан нь уг тээврийн индекст сөрөг нөлөөлж 2016 оноос хойш хамгийн доод түвшинд 2020 оны хоёрдугаар сард хүрсэн. Олон улсын худалдааны тээвэрлэлтийн гол индекс 2020 оны зургаадугаар

эдийн засгийн хориг арга хэмжээг сулруулж эхэлсэн. Энэ нь олон улсын зах зээлийн индексүүд өсч эдийн засгийн идэвхжих хандлага ажиглагдаж эхэлсэн. Гэхдээ эдийн засгийн хориг арга хэмжээг өнөөг хүртэл бүрэн чөлөөлж чадаагүй. Ийм учраас судлаачдын үзэж байгаагаар уг өсөлт богино хугацааных бөгөөд цаашид коронавирусын нөлөөгөөр эдийн засагт сөрөг үр дагаврууд авчрах хүлээлтийг үүсгээд байна.

### Зураг 2. Таваарын зах зээлийн CRB индекс<sup>3</sup> 2020 оны есдүгээр сар



Эх сурвалж: (Trading economics, 2020)


Коронавирусын нөлөөгөөр олон улсад бараа бүтээгдэхүүний зах зээлийг тодорхойлогч (CRB Commodity Index) индекс мөн буурсан. Тухайлбал,

коронавирусээс хамгийн их хохирол учруулсан салбарт аялал жуулчлал, бизнес аялал болон тээврийн салбар байгаа тул үйл ажиллагаа нь бараг бүрэн зогссон.

<sup>3</sup> Thomson Reuters /Core Commodity (CRB) индекс нь таваарын фьючерсийн үнийн арифметик дунджийг сар бүр тэнцвэржүүлэлт хийж тооцдог. Индекс нь 19 нэр төрлийн таваарыг оруулдаг. Үүнд: хөнгөн цагаан, какао, кофе, мөнгө, зэс, эрдэнэ шиш, буудай, хөвөн, газрын тос, алт, мазут, гахайн мах, амьд мал, байгалийн хий, никел, жүржийн шүүс, бензин, буурцаг, элсэн чихэр.



**Зураг 3. Лондоны өнгөт металлын London Metal Exchange (LME) индекс**




Эх сурвалж: (Trading economics, 2020)

технологи боловсруулагдан цааш БНХАУ-д үйлдвэрлэгдэж олон улсад тархаж бусад

улс оронд хэрэглэгч болсон загвар ажиллахгүй юм.

**Зураг 4. Бараа бүтээгдэхүүний ашигт ажиллагааны хэмжигч (GSCI Commodity Index) индекс мөн бүрчээ**



Эх сурвалж: (Trading economics, 2020)

Сарс (SARS)<sup>4</sup> өвчний үр дагавартай ижил хэмжээнд зарим үзүүлэлтийн хувьд илүү их сөрөг үр дагавартай байна. Олон улсын шинжээчдийн үзэж байгаагаар уг өвчний улмаас Хятад улсын эдийн засаг өмнөх онд нь 11.1 хувийн өсөлттэй байсан бол 9.1 хувь болон буурчээ. Өөрөөр хэлбэл, 0.5-2.0 хувь болтол буурсан байна.

SARS өвчин гарахад гол төлөв аялал жуулчлал, үйлчилгээний салбарт сөрөг нөлөө үзүүлсэн бол шинэ коронавирус нь үүнээс гадна үйлдвэрлэлийн салбарт тодорхой нөлөө үзүүлсэн.

<sup>4</sup> Сарс (SARS) өвчин 2002 оны 11 дүгээр сард дэгдэж 2003 оны долоодугаар сар хүртэл үргэлжлэн бүтэн найман сарын дотор 8 мянга 96 хүн өвдөж 774 хүн нас баржээ.

Коронавирус олон улсын худалдаанд мөн сөрөг нөлөө үзүүлсэн. Нөгөө талаар Коронавирус орчин үеийн худалдааны загвар болох нийлүүлэлтийн сүлжээнд ямар сул тал байгааг харуулсан. Өөрөөр хэлбэл, АНУ болон өндөр хөгжилтэй улсуудад

Олон улсын эдийн засгийн өсөлтийн гуравны нэг хувийг дангаар бүрдүүлж байдаг Хятад улсын эдийн засагт их хэмжээний сөрөг үр нөлөө үзүүлэх тул олон улсын эдийн засагт мөн сөрөг нөлөө үзүүлэх нь тодорхой.


Үүнээс үзэхэд шинэ коронавирус олон улсын эдийн засагт 2002-2003 онд гарсан

Шинэ Коронавирус тархсан Ухань (Wuhan) хот нь эдийн засгийн хувьд эрчимтэй хөгжиж буй Хубей мужид байрлах бөгөөд уг мужид гадаадын хөрөнгө оруулалттай олон компани үйл ажиллагаа явуулдаг. Мөн Ухань хот нь шинжлэх ухаан, аж үйлдвэрийн томоохон төв. Ийм учраас эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг улам нэмэгдүүлсэн. Тухайлбал, АНУ-ын авто машины том үйлдвэрлэгч компаниуд Ухань хотод байрлах өөрийн салбар үйлдвэрийг тодорхойгүй хугацаагаар түр хаасан. Гадаадын хөрөнгө оруулалттай бусад компанид Стар бакс, Уолт дисней зэрэг үйлчилгээ, нийтийн хоолны газарууд 40 хувийн алдагдал хүлээж эхэлсэн. Эдийн засгийн онцгой бүс болох Макаогийн эдийн засаг мөн 8 хувиар буурчээ.

## МОНГОЛ УЛСАД ШИНЭ КОРОНАВИРУСЫН НӨЛӨӨЛӨЛ

Коронавирус тархаж эхэлсэн 2020 оны нэгдүгээр сард гадаад худалдааны нийт бараа эргэлтийн гүйцэтгэлийг авч үзэхэд өмнөх оны мөн үеэс 178.9 сая ам.доллар буюу 16 хувиар буурсан. Үүнээс БНХАУ-тай хийсэн гадаад худалдаа 52.5 сая ам.доллар буюу 8.6 хувиар буурсан.

**Зураг 5. Гадаад худалдаа 2020 оны наймдугаар сард (мянган ам.доллар)**




*Эх сурвалж: Гаалийн статистик  
2020 оны наймдугаар сарын мэдээ*

Харин коронавирус олон улсад тархсанаас хойш найман сарын дараа Монгол Улсын гадаад худалдааны нийт эргэлт 7,932.1 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 16.3 хувь буурсан байна. БНХАУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 27.7 хувь буурсан нь нэг сартай харьцуулахад эдийн засаг эрчимтэй сэргэх төлөв ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, коронавирусыг түргэн хугацаанд намжааж чадвал улс орнуудын эдийн засаг эрчимжих хандлагатай байна.

Коронавирус олон улсад тархаж эхэлсэн нэгдүгээр сард Монгол Улсын импортоор оруулж ирсэн бараа бүтээгдэхүүний ачаа

тээвэр өмнөх оны мөн үеэс 6, экспорт 24 хувиар тус тус буурчээ.


**Зураг 6. Импорт тээврийн төрлөөр 1-8 дугаар сард (сая ам.доллар)**



*Эх сурвалж: (Гаалийн статистик ,  
2020)*

Үүнээс төмөр замаар импортолсон ачааны тээвэрлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15 хувь өссөн бол авто зам 21, агаарын тээвэр 58 хувиар тус тус буурсан үзүүлэлт гарчээ. Харин 2020 оны наймдугаар сарын байдлаар төмөр зам 21, агаарын тээвэр 68 хувиар тус тус буурсан бол авто тээвэр 2.7 хувь өссөн байна.

Зураг 7. Экспортын тээврийн төрлөөр 1-8 дугаар сард (сая ам.доллар)



Эх сурвалж: (Гаалийн статистик, 2020)

Гадаад худалдаанд тээврийн хэрэгслээр экспортолсон бараа бүтээгдэхүүн коронавирус тархаж эхэлсэн нэгдүгээр сард өмнөх оны мөн үеэс 24 хувь буурсан бөгөөд төмөр зам 22 хувь өсчээ. Харин авто зам 15, агаарын тээвэр 96 хувиар буурсан бол 2020 оны наймдугаар сард төмөр зам 7.7, агаарын тээвэр 185.1 хувь тус тус өсч, авто зам 47 хувиар буурсан байна.

Харин 2020 оны наймдугаар сарын байдлаар БНХАУ-тай хийсэн экспорт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.6 хувь, импорт 6.6 хувиар тус тус буурчээ. Үүнээс Монгол

Улсын экспортын гол эрдэст бүтээгдэхүүний биет хэмжээ болон үнэ эхний найман сард буурсан байна. Тухайлбал,

- Коронавирус тархаж эхлэх үед Жоншны экспорт 2020 оны нэгдүгээр сарыг 2019 оны мөн сартай харьцуулахад биет хэмжээ 15, нийт үнийн дүн 27 хувь тус тус буурсан бөгөөд өмнөх сартай харьцуулахад биет хэмжээ 37 хувь, үнэ 28 хувиар буурчээ.

Зураг 8. Жоншны экспорт 1-8 дугаар сард




Эх сурвалж: Гаалийн статистик 2020 оны наймдугаар сар

- Коронавирус тархаад найман сарын дараа жоншны экспорт өмнөх оны мөн үеэс 1.6 хувь өссөн боловч үнэ нь 23.4 хувиар буурсан байна. Өөрөөр хэлбэл экспортын жоншны биет хэмжээ өссөн боловч борлуулалтын үнэ буурсан байна.
- Төмрийн экспортын биет хэмжээ 2020 оны нэгдүгээр сард 2019 оны нэгдүгээр сартай харьцуулахад 34 хувь, нийт үнэ нь 113 хувь өссөн бол өмнөх сартай харьцуулахад биет хэмжээ 6 хувь, үнэ нь 3 хувиар тус тус буурчээ.
- Харин найман сарын дараа төмрийн хүдрийн экспорт 8.59 сая тонн болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.6 хувь өссөн бөгөөд үнэ нь 6.3 хувиар өссөн байна. Төмрийн хүдрийн экспортод

коронавирусын нөлөө оны эхэн үед их байсан боловч наймдугаар сар гэхэд хэвийн байдалдаа орсон гэж үзэж болохоор байна.

- Олон улсын төмрийн хүдрийн зах зээл дээр 2019 оны дунд үед таван жилийн хамгийн өндөр үнэ буюу 1 тонн нь 125.52 ам.долларт хүрсэн нь Бразил улсын төмрийн хүдрийн том орд газарт үерт автсан мөн Австрали улсад үер болсноос зах зээлийн үнэ үүсэхэд хүргэсэн бол 2020 оны эхний сард тонн 92 ам.доллар байсан төмрийн хүдрийн үнэ Хятад улсын цагаан сарын дараах арилжаа эхлэнгүүт шинэ Коронавирусын нөлөөгөөр төмрийн хамгийн их хэрэглэгч улсын эрэлт буурах болгоомжоос үүдэн үнэ 83.15 ам.доллар болон буурчээ.

### Зураг 9. Төмрийн хүдрийн экспорт 1-8 дугаар сард



Эх сурвалж: Гаалийн статистик 2020 оны наймдугаар сар

- Харин 2020 оны наймдугаар сарын эцсийн байдлаар төмрийн хүдрийн үнэ олон улсын зах зээл дээр тавдугаар сараас хойш тогтмол өсч 125.18 ам.долларт хүрчээ.

- Зэсийн биет хэмжээ 2020 оны нэгдүгээр сард 2019 оны мөн үетэй харьцуулахад 13 хувь, нийт үнэ нь 27 хувь буурсан бол өмнөх сараас 8 хувь, үнэ нь 9 хувиар буурсан.

Зураг 10. Зэсийн баяжмалын экспорт 1-8 дугаар сард




Эх сурвалж: Гаалийн статистик 2020 оны наймдугаар сар

- Харин 2020 оны наймдугаар сард зэсийн эрэлт олон улсын зах зээлд дөрөвдүгээр сараас хойш тогтмол өсөлттэй байгаа бөгөөд 2020 оны наймдугаар сарын эцэст 1 тонн зэсийн үнэ 6663.69 ам.доллар хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 19 хувиар өндөр байгаа юм.
- Монгол Улсын зэсийн экспорт коронавирус тархсанаас хойш найман сарын байдлаар зэсийн экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.8 хувиар, үнэ нь 23.9 хувиар тус тус буурсан байна. Хэрвээ зэсийн олон улсын зах зээл дээр онцын өөрчлөлт гарахгүй бол 2020 оны сүүл гэхэд зэсийн экспортоос орж ирэх орлогын хэмжээ өмнөх оны орлоготой ижил хэмжээнд хүрэх боломжтой юм.
- Уг бүтээгдэхүүний гол хэрэглэгч нь БНХАУ, Япон, Энэтхэг, Өмнөд Солонгос, Герман улс байдаг.

Коронавирусын тархалтын эхэн үе буюу 2020 оны нэгдүгээр сарын сүүлээс эхэлж эдгээр улс оронд хорио цээр тавигдсаны улмаас зэсийн эрэлт буурч үнэ сүүлийн гурван жилийн хамгийн доод түвшинд хүрсэн. Харин 2020 оны гуравдугаар сарын сүүлээс эхэлж олон улсын зах зээл дээр үнэ өсч есдүгээр сар гэхэд 1 тонн зэсийн үнэ 6 мянган ам.долларын орчим хүрч тогтворжих хандлагатай байна.

- Монгол Улсын нүүрсний экспорт коронавирус гарч эхэлсэн нэгдүгээр сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад биет хэмжээ 11, үнэ 15 хувиар тус тус өссөн бол өмнөх сараас биет хэмжээ 43, үнэ 53 хувиар тус тус өсчээ.
- Харин 2020 оны наймдугаар сарын байдлаар нүүрсний экспортын биет хэмжээн өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39.1 хувь, үнэ нь 45.2 хувиар тус тус буурсан байна.

Зураг 11. Чулуун нүүрсний экспорт 1-8 дугаар сард



Эх сурвалж: Гаалийн статистик 2020 оны наймдугаар сар

Олон улсын зах зээл дээрх нүүрсний үнэ 2019 оноос хойш тогтмол буурсан. Харин коронавирус тархаж эхэлснээс хойш нүүрсний үнэ дөрөвдүгээр сараас 55 ам.доллар орчим тогтворжиж байгаад есдүгээр сараас хойш хүйтний улирлын бэлтгэл ажил болгон нүүрсний үнэ бага зэрэг өсөх хандлага ажиглагдаж 2020 оны есдүгээр сарын 21-ний өдрийн байдлаар 59.1 ам.долларт хүрсэн. Олон улсын судлаачдын үзэж байгаагаар нүүрсний үнэ оны эцэс хүртэл бага зэрэг өсөх бөгөөд 1 тонн нүүрсний үнэ 70 ам.доллараас хэтрэхгүй.

### ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

2020 оны олон улсын эдийн засаг олон хүчин зүйлээс тухайлбал Ойрх Дорнодын (олон улсын эрчим хүчний анхдагч эх үүсвэр)-ийн асуудал, brexit Европын Холбооноос Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад гарч байгаа үйл явдлаас гадна олон улсын эдийн засагт хамгийн их нөлөө үзүүлэх хоёр том хүчин зүйлийг олон улсын шинжээчид дүгнэн үзжээ.

- Нэгдүгээрт олон улсад эдийн засгаар тэргүүлж буй хоёр гүрний худалдааны маргаантай асуудлууд,
- Хоёрдугаарт олон улсад коронавирусын тархалтын байдал зэрэг нь эдийн засагт сорилт болоод байна.

2020 оны есдүгээр сараас эхэлж АНУ, Европ, Азийн улс орнуудад коронавирусын хоёр дахь давлагаа үүсэх эрсдэл өндөр болсон. Тухайлбал, Франц, Израиль улсад хөл хориогоо эргүүлэн чангаруулж эхэлсэн. Мөн БНХАУ, АНУ-ын хоорондох худалдааны маргаантай асуудал улам бүр хурцдаж байна. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн өрсөлдөөн нь Ерөнхийлөгч Трампын зүгээс эрс шийдвэрүүд гаргаж болох тул олон улсын зах зээл дээр үнийн тогтворгүй байдал үүсэх хүлээлтийг бий болгосон хэвээр.

Цаашид олон улсад коронавирусын халдвартай төстэй өвчин гарах магадлал улам бүр ихэсч байгаа тул эдийн засгийн аюулгүй байдлыг хангах асуудал улс орон бүрийн өмнө тулгараад байгаа билээ.

**Хүснэгт 1. Сүүлийн жилүүдэд гарсан халдварт өвчний статистик**

Вирус	Тогтоогдсон жил	Нийт өвчлөгчид	Нас барсан хүний тоо	Нас барагсдын хувь	Нийт тархсан улс орны тоо
Ebola	1976	33,577	13,562	40.4	9
Nipah	1998	513	398	77.6	2
SARS	2002	8,096	774	9.6	9
MERS	2012	2,494	858	34	28
2019-nCoV*	2020	43,099	1,114	2	28

*Эх сурвалж: ДЭМБ 2020 оны хоёрдугаар сарын 10-ны өдрийн байдлаар*

Шинэ коронавирус SARS өвчинтэй төстэй бөгөөд хоёр өвчлөлийг хооронд нь харьцуулж үзвэл шинэ коронавирус 30 хоног дотор 10 мянган хүн өвчилсөн бол SARS өвчин 30 хоногийн дотор мянга гаруй хүнд халдварлажээ. Шинэ коронавирусын өвчлөгчдийн 2 хувь нас барж байгаа бол SARS өвчин 9.7 хувь байсан юм.

Хугацааны хувьд шинэ Коронавирус SARS өвчинтэй ижил түвшинд байна гэж үзвэл найман сар үргэлжлэх төлөвтэй. Өөрөөр хэлбэл, эдийн засагт үзүүлэх нөлөө богино биш хугацаан үргэлжлэх төлөвтэй.

1976 оноос хойш малаас хүнд, амьтнаас хүнд халдварлаж буй вирусын тохиолдол 5 гарчээ. Дэлхийн эрүүл мэндийн байгууллага болон вирус судлаачдын үзэж байгаагаар энэ төрлийн вирус сүүлийн үед илүү хувирамтгай, хүн амд тархах цар хүрээ улам нэмэгдэж байгааг анхааруулж байна.

Энэ нь уг төрлийн вирусын гаралт ганц үүгээр бус цаашид улам ихээр нэмэгдэж илүү ноцтой үр дагаврууд авчрах төлөвтэй байгаа тул эдийн засгийн хувьд бэхжээгүй улс орнуудад илүү хүндээр тусах тул эртнээс бэлтгэлтэй байх хэрэгтэй.

**ДҮГНЭЛТ**

Шинэ Коронавирусээс үүдэн эдийн засагт 2020 оны эхний улиралд бүхэлдээ саарсан. Харин хоёрдугаар улирлаас эхэлж зарим улс оронд хөл хориогоо

сулруулж эдийн засаг сэргэх арга хэмжээ авч хэрэгжүүлсний үрд дүнд бага зэрэг сайжирсан болов ч коронавирусын хоёр дахь давлагаа үүсэх эрсдэл өндөр тул эдийн засаг бүрэн сэргэсэн гэж үзэхэд эрт байна.

2002 онд гарсан SARS өвчний үед аялал жуулчлалын салбар илүү эмзэг туссан тул өвчлөлийн дараа эргээд эдийн засаг амархан сэргэх боломж бүрдсэн. Харин энэ удаа аялал жуулчлалаас гадна, тээвэр, аж үйлдвэрийн салбарт илүү эмзэг туссан бөгөөд хугацааны хувьд урт байгаа нь эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөө урьд өмнөхөөс илүү их байна.

БНХАУ коронавирусыг халдварыг бүрэн хяналтанд авсан болов ч олон улсад уг вирусын тархалт зогсоогүй байна. Хэдийгээр БНХАУ-ын эдийн засаг өөрийн ердийн үйл ажиллагааг хангах болсон ч олон улсын нөхцөл байдлаас үүдэн эдийн засгийн өсөлт нь урьд өмнө таамаглаж байсан хэмжээнээс хамаагүй бага байна. Дэлхийн банкны судлаачдын үзэж байгаагаар олон улсын эдийн засаг 2020 оны эцэст 2.6 хувиар агших бөгөөд БНХАУ-ын эдийн засаг 2-3 хувийн өсөлттэй байх төлөвтэй.

Монгол Улсын нийт гадаад худалдааны 55 хувийг дангаар эзэлдэг Хятад улсын эдийн засаг буурч байгаа нь манай улсын эдийн засагт олон сөрөг үр дагаврыг бий болгоно. Тухайлбал, Монгол Улсын экспортын гол эрдэст бүтээгдэхүүний борлуулалт буурч

төсвийн орлого тасалдахад хүрч төсвийн алдагдал өснө. Мөн Хятад улсад уг төрлийн вирусын хоёр дахь удаагаа тохиож байгаа бөгөөд цаашид ийм төрлийн өвчний тоо, давтамж, хугацаа улам ойртож байгаа тул эдийн засгийн хувьд хэт хамааралтай байдлыг багасгах хэрэгтэй байна.

Иймээс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын тодорхой заалтуудыг байгууллага бүрт анхааран ажиллах шаардлагатай байгааг уг үйл явц харуулж байна. Үүнд: Үндэсний аюулгүй байдлын

үзэл баримтлалын 3.4.1.4. Өргөн тархалттай, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчний тандалт судалгааг өргөжүүлж, халдварыг эрт илрүүлэх, тархалтаас сэргийлэх арга хэмжээ авах, 3.4.1.5. Халдварт өвчний нийтийг хамарсан тархалт, гамшгийн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангаж, урьдчилан сэргийлэх эм, тарилга, вакцин, био бэлдмэлийн улсын нөөцийг бүрдүүлэх зэрэг арга хэмжээг жил болгоны төсөвт хөрөнгө мөнгийг хангалттай тусгаж бэлэн байдлыг хангаж ажиллах хэрэгтэй байна.

---

## ЭХ СУРВАЛЖ

1. Trading economics. (2020, Feb 10). Retrieved from Trading economics: <https://tradingeconomics.com/commodity/gsci>
2. Гаалийн статистик . (2020, Feb 10). Retrieved from Гаалийн статистик : <http://www.customs.gov.mn/>
3. <https://www.who.int/emergencies/diseases/>
4. <http://www.bp.com/energyoutlook 2020>
5. <https://www.imf.org/external/datamapper/datasets/WEO>
6. <https://www.worldbank.org/en/region/>





---

Ч.ЦЭЦЭГМАА(М.А)

## ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТИЙН СИСТЕМИЙГ АШИГЛАН МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖ

*Mongolia is benefiting customs tariff preferences under the Generalized System of Preferences of 37 developed countries since 1971. But preference utilization is still insufficient. This article discusses customs tariff preferences, which is one of the favorable treatments for Mongolian export products, and its importance and utilisation, the resources and opportunities to increase its effectiveness.*

**Keywords:** foreign trade, export, Generalized System of Preferences, utilization,

---

### ОРШИЛ

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эдийн засгийн аюулгүй байдлыг хангах нэг нөхцөл нь гадаад худалдаа, интеграцын оновчтой бодлого баримтлах хэмээн тусгасан байна. Энэ хүрээнд эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулах,

бүс нутгийн болон олон улсын интеграцад нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлэх тухай дурдсан билээ.

Монгол Улс хөрш орнууд болон бүс нутгийн улс орнуудтай эдийн засгийн үйл ажиллагааны бодлого зохицуулалтын хүрээнд идэвхтэй хамтран ажиллаж байгаа

боловч эдийн засгийн хамтын ажиллагааны түвшин хангалттай бус, экспортын бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл төдийлөн нэмэгдэхгүй, экспортын зах зээл цөөн хэдэн орноос хамааралтай хэвээр байна. Тухайлбал, дэлхийн өндөр хөгжилтэй 37 орноос Монгол Улсаас

гарал үүсэлтэй экспортын бараа бүтээгдэхүүнд Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (ХЕС)-ийн хүрээнд гаалийн татварын хөнгөлөлт олгож байгаа боловч энэхүү хөнгөлөлтийг бүрэн ашиглаж чадахгүй байна.

Энэхүү нийтлэлд Монгол Улсын гадаад худалдааны таатай нөхцөлүүдийн нэг болох гаалийн тарифын хөнгөлөлтийн тухай, тэдгээрийн ач холбогдол, ашиглалтын тухай, үр нөлөөг нэмэгдүүлэх нөөц, боломжийн тухай өгүүлэхийг зорилгоо.

### ХӨНГӨЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ СИСТЕМ, ТАРИФЫН ХӨНГӨЛӨЛТ

1963 оны тавдугаар сард болсон

Тариф Худалдааны Ерөнхий Хэлэлцээр (ГАТТ)-ийн Сайд нарын хурлаас тарифын хөнгөлөлтийг дэлхийн хөгжиж буй бүх орнуудад хамааруулах нь зүйтэй гэсэн санаачлага гарч 1968 онд Шинэ Делид болсон НҮБ-ын Худалдаа Хөгжлийн Бага Хурал (ЮНКТАД)-ын хурлаас

1970 оноос эхлэн гишүүн бүх орнууд дэмжиж шийдвэр гаргажээ. Ийнхүү ЮНКТАД-ын дэргэд Хөнгөлөлтийн Тусгай Хороо байгуулагдаж, ГАТТ-ын хэлэлцээрийн 1 дүгээр заалт /хэлэлцэн тохиролцогч талууд бие биеийг ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг тодорхойлсон/ -ын дагуу зарим өндөр хөгжилтэй орнууд хөгжиж буй улс орнуудад 10 жилийн хугацаанд тарифын хөнгөлөлт эдлүүлэхээр тохирсон байна.<sup>1</sup>

ГАТТ-ын Токиогийн хэлэлцээрийн үр дүнд Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (ХЕС)-ийн үйлчлэх цаг хугацааны хязгаарыг хүчингүй болгожээ.

<sup>1</sup> <https://unctad.org/>

#### Хүснэгт 1. ХЕС-ийн хэрэгжүүлэгч орнууд, UNCTAD, 2018

№	Улс	Хөнгөлөлтийн хэлбэр	Хөнгөлөлт олгож эхэлсэн хугацаа	Монгол Улсын хамрагдсан байдал
1	Австраль	ХЕС	1974	+
2	Беларус			+
3	Канад	ХЕС	1974	+
4	Европын холбоо (28 улс)	ХЕС, нэн буурай хөгжилтэй орнуудад зориулсан зэвсгээс бусад бүх төрлийн бараанд олгох ХЕС, ХЕС+	1971, 2005	ХЕС+

5	Исланд	ХЕС	2002	+
6	Япон	ХЕС	1971	+
7	Казахстан	ХЕС	2010	+
8	Шинэ Зеланд	ХЕС	1972	+
9	Норвеги	ХЕС, ХЕС+	1971	ХЕС+
10	ОХУ	ХЕС	1992	+
11	Швейцари	ХЕС	1972	+
12	Турк	ХЕС	2002	+
13	АНУ	ХЕС, AGOA	1976	+

Эх сурвалж: НУБ-ын Худалдаа Хөгжлийн Бага Хурал

Мөн түүнчлэн БНСУ (2000 он), Энэтхэг (2008 он), Хятад (2010 он) зэрэг орон нэн буурай хөгжилтэй орнуудыг дэмжих зорилгоор тусгайлсан тарифын хөнгөлөлтийг хэрэгжүүлж эхлээд байна.

ХЕС-ийн хүрээнд хөнгөлөлт олгож буй барааны нэр төрлийг судлан үзэхэд хөдөө аж

ахуйн бус бараанд илүү хөнгөлөлт олгосон байна. Энэ нь өндөр хөгжилтэй орнууд хөдөө аж ахуйн салбараа илүү хамгаалсан байдал ажиглагдаж байна (Хүснэгт 2). Энэ нь хүнсний аюулгүй байдал, хүний эрүүл мэнд, дотоодын зах зээл үйлдвэрлэлээ хамгаалсан бодлого юм.

## Хүснэгт 2. ХЕС-ийн бүтээгдэхүүний нэр төрөл

	ХЕС хэрэгжүүлэгч орон		Нийт хамрагдсан барааны нэр төрөл	ХАА-н барааны нэр төрөл	ХАА-н бус барааны нэр төрөл
1	Австраль	Хөнгөлөлттэй тарифтай	854	129	725
		0 тарифтай	198	29	169
2	Беларус	Хөнгөлөлттэй тарифтай			
		0 тарифтай			
3	Канад	Хөнгөлөлттэй тарифтай	1188	193	995
		0 тарифтай	413	56	357
4	Европын холбоо	Хөнгөлөлттэй тарифтай	6220	921	5299
		0 тарифтай	6027	736	5291
5	Исланд	Хөнгөлөлттэй тарифтай	323	204	119
		0 тарифтай	220	101	119
6	Япон	Хөнгөлөлттэй тарифтай	3032	352	2680
		0 тарифтай	1645	158	1487
7	Казахстан	Хөнгөлөлттэй тарифтай	2417	1454	963
		0 тарифтай	0	0	0

8	Шинэ Зеланд	Хөнгөлөлттэй тарифтай	473	140	333
		0 тарифтай	140	16	124
9	Норвеги	Хөнгөлөлттэй тарифтай	974	713	261
		0 тарифтай	383	127	256
10	ОХУ	Хөнгөлөлттэй тарифтай	75%		
		0 тарифтай			
11	Швейцари	Хөнгөлөлттэй тарифтай	5609	654	4955
		0 тарифтай	4333	372	3961
12	Турк	Хөнгөлөлттэй тарифтай	9387	245	9142
		0 тарифтай	5300	62	5238
13	АНУ	Хөнгөлөлттэй тарифтай	2985	446	2539
		0 тарифтай	2985	446	2539


Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа Хөгжлийн Бага Хурал

2019 онд АНУ-ын ХЕС-ийн импортын ихэнх хувийг Тайланд Улс эзэлсэн байна (Зураг 1).<sup>2</sup> Харин хамгийн ихээр импортлосон бүтээгдэхүүнээр алтан гоёл

чимэглэл (453 сая ам.доллар), хиймэл утсаар үйлдвэрлсэн спортын болон аялалын цүнх (444 сая ам.доллар), резинэн бээлий (321 сая ам.доллар) зэрэг шалгарсан байна (Зураг 2).


<sup>2</sup> <https://fas.org/sgp/crs/misc/RL33663.pdf>

Зураг 1. АНУ-ын ХЕС-ийн ашиглалт, эхний 10 улс, 2019, тэрбум ам.доллар



Эх сурвалж: Congressional Research Service

Зураг 2. АНУ-ын ХЕС-ийн бүтээгдэхүүн, 2019, сая ам.доллар



Эх сурвалж: Congressional Research Service

Их Британи улсын Засгийн газраас ЕХ-оос тусгаарласантай холбогдуулан 2021 оны нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн өргөжүүлсэн ХЕС-ийг бие даан хэрэгжүүлж эхэлсэн байна. Энэхүү хөнгөлөлтөд Монгол Улс хамрагдсан бөгөөд сайн засаглал, хүний эрх, байгаль орчныг хамгаалах тухай олон улсын 27 конвенцийг хэрэгжүүлэх ёстой юм.

### МОНГОЛ УЛСЫН ХЕС-ИЙН АШИГЛАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Хэдийгээр тарифын хөнгөлөлт эдэлж байгаа боловч тарифын бус саад тотгорууд болох эрүүл ахуй хорио цээр, чанар стандарт болон худалдаатай холбоотой дүрэм журмын шаардлагууд, далайд гарцгүй

орны тээвэрлэлтийн хүндрэл, дэд бүтцийн сул хөгжил, ажиллах хүчний болон түүхий эдийн хомсдол, санхүүгийн бэрхшээлүүдээс хамааран тухайн орнуудын зах зээлд экспортлох бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл төдийлөн нэмэгдэхгүй байна.

Тухайлбал, 2020 оны байдлаар ЕХ-ны зүгээс 414 тарифын бус арга хэмжээг Монгол Улсын бараа бүтээгдэхүүнд хэрэгжүүлж байгаагаас эрүүл ахуй хорио цээрийн шаардлага 97, худалдаатай холбоотой журмын шаардлага 272 байна (Хүснэгт 3). Өөрөөр хэлбэл, тухайн орнуудын зүгээс зах зээл, хэрэглэгч, байгаль орчныг хамгаалсан худалдааны хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлж байна.

## Хүснэгт 3.Тарифын бус зохицуулалт, 2020

Үйлчлэх хүрээ	Зохицуулалтын нэр	Тоо
Бүх гишүүн орнууд	Экспортын зохицуулалт	2
	Бусад зохицуулалт	2
	Ачилтын өмнөх хяналт шалгалт	5
	Тоо хэмжээний хяналт	35
	Эрүүл ахуй хорио цээрийн зохицуулалт	97
	Худалдаан дахь техникийн саад тотгор	272
Хоёр талт	Ачилтын өмнөх хяналт шалгалт	2


Эх сурвалж: НҮБ-ын Худалдаа Хөгжлийн Бага Хурал

ЕХ-ноос 2020 онд хийсэн судалгааны дүнгээс харахад Монгол Улсаас ЕХ-ны зах зээлд экспортолсон экспортын хэмжээ 2016-2019 онд 30 хувь өссөн бөгөөд ХЕС-ийн

ашиглалт дунджаар 86 хувь байна (Зураг 1)<sup>3</sup>. Нийт экспортын 27 хувь нь ХЕС-д хамрагдсан байна.

<sup>3</sup> [https://trade.ec.europa.eu/doclib/docs/2018/january/tradoc\\_156536.pdf](https://trade.ec.europa.eu/doclib/docs/2018/january/tradoc_156536.pdf)

## Зураг 3. Экспортын хэмжээ (Монгол Улс ба ЕХ), 2016-2019, сая евро



Эх сурвалж: <https://trade.ec.europa.eu/>

Нийт импортын 13 хувь нь тарифын хөнгөлөлт эдлээгүй байна. Энэ нь тухайн барааны баримт бичгийн бүрдэл дутуу, гарын үсэг, тамга дарагдаагүй болон гарал үүслийн холбогдох шаардлага хангаагүйтэй холбоотой юм. Иймд ашиглалтын хэмжээг 100 хувьд хүргэхэд анхаарах шаардлагатай юм.

Монгол Улсаас ЕХ-ны зах зээлд экспортолсон уламжлалт бараа бүтээгдэхүүнүүд болох ноос ноолууран сүлжмэл бүтээгдэхүүн, хагас боловсруулсан арьс шир, самнасан ноолуур, эсгий гар урлалын бүтээгдэхүүний импортын хувьд хөнгөлөлтийн ашиглалтын хувь 83-84 хувьтай гарсан байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний 44 хувь нь нэн тааламжтай тариф, 15 хувь нь ХЕС-ийн тарифын хөнгөлөлт эдэлсэн байна. Бүтээгдэхүүний нэр төрлийн хувьд

- Уул уурхайн бүтээгдэхүүн- 100%
- Оёмол бүтээгдэхүүн- 96%
- Арьс шир, үслэг эдлэл- 94%
- Сүлжмэл бүтээгдэхүүн- 92%
- Гутал, гутлын эд анги- 85%
- Хагас боловсруулсан арьс шир- 74.5 хувь хөнгөлөлттэй тарифаар нэвтэрсэн байна.

Самнасан ноолуур (HS 5105.30)-ын хувьд ХЕС-ийн хөнгөлөлтөд хамрагдаагүй боловч тэг гаалийн тарифаар нэвтэрсэн байна.

ХЕС нь ихэнх бараанд 9.6-12 хувийн хөнгөлөлтийн зөрүүг Монгол Улсаас гарал үүсэлтэй экспортын бараанд олгож байна (Хүснэгт 3). Тухайлбал, Монгол Улсад үйлдвэрлэсэн ноолууран цамц бусад улсынхаас 9.6-12 хувийн тарифын хямд нэвтрэх болмжтой юм.

#### Хүснэгт 4. ЕХ-ны ХЕС-ийн тарифын харьцуулалт

Барааны нэр	Нэн тааламжтай нөхцөлийн тарифын хэмжээ - MFN	ХЕС-ийн ердийн тарифын хэмжээ- ХЕС	Шинэчилсэн ХЕС-ийн хөнгөлөлттэй тарифын хэмжээ ХЕС+
Эмэгтэй болон охид хувцас, хослол, хүрэм, гоёлын хувцас, өмд, богино өмд, өмдөн юбка, усны хувцас г.м	12%	9,6%	татваргүй
Ноосон цамц, хантааз, сүлжмэл, ямааны ноолууран бүтээгдэхүүн	12%	9,6%	татваргүй
Элдсэн савхи, илгэн арьс, сарлагийн ноолууран бүтээгдэхүүн	6.5 %	3%	татваргүй

Эх үүсвэр: <https://trade.ec.europa.eu/>

АНУ-ын ХЕС-ийн хувьд Монгол Улс зэрэг нийт 118 оронд 3500 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнд гаалийн тарифын хөнгөлөлт олгож байна. Гэвч Монгол Улсын хувьд АНУ-ын зах зээлд сүлжмэл бүтээгдэхүүн, эсгий гар урлалын бүтээгдэхүүн,

вольфрамын баяжмал зэрэг цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн экспортлож байгаа нь хөнгөлөлтийн ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна. Ноос ноолууран сүлжмэл бүтээгдэхүүний хувьд цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн хамрагдсан байна. Тухайлбал

HS6111 барааны код бүхий ноолууран сүлжмэл цамц хамрагдаагүй байна. Гэвч ноолуурыг торго, спандекс зэрэг химийн хольцтой утастай холин үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд хамрагдсан байгаа нь энэ төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн тарифын хөнгөлөлтийн доор экспортлох боломжтой юм.

### ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын экспортын бүтээгдэхүүний хувьд дараах тарифын сонголтууд байгаа бөгөөд эдгээрээс алийг хэрэглэн тухайн зах зээлд нэвтрэх нь экспортлогчийн сонголт юм. Үүнд:

- Ердийн гаалийн тариф
- Дэлхийн худалдааны байгууллагын нэн тааламжтай нөхцөлийн тариф
- Хөнгөлөлтийн Ерөнхий Системийн хөнгөлөлттэй тариф
- Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хөнгөлөлттэй тариф (зөвхөн Япон Улсын зах зээлд)
- Ази номхон далайн худалдааны хэлэлцээрийн хөнгөлөлттэй тариф (Азийн 8 улс).

Эдгээрээс өндөр хөгжилтэй орнуудаас олгож буй ХЕС-ийн тарифын хөнгөлөлтийг ашиглан Монгол Улсын экспортыг нэмэгдүүлэх бүрэн боломжтой юм. Энэхүү гаалийн тарифын хөнгөлөлтүүд нь нэг талын хөнгөлөлт бөгөөд Монгол Улс хариу арга хэмжээ болгон тарифаа буулгах шаардлагагүй гэдгээрээ чөлөөт худалдааны хэлэлцээрүүдээс давуу талтай юм. ХЕС нь Монгол Улсын экспортын бүтээгдэхүүнийг тухайн зах зээлд ижил төрлийн бүтээгдэхүүнээс хямд өртгөөр нэвтрэх давуу талыг үүсгэж байгаа нь тухайн бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн үйлдвэрлэлийг дэмжиж байна.

ХЕС-ийн ашиглалтыг сайжруулахын үүднээс гол шаардлагууд болох гарал

үүслийн шаардлага, тээвэрлэлтийн нөхцөл, баримт бичгийн баталгаажуулалтын шаардлагуудыг хангах ёстой юм. Тухайлбал, гарал үүслийн дүрмийг ашиглан бүтээгдэхүүнийг бүхэлд нь болон хэсэгчлэн үйлдвэрлэн, нэмүү үнэ цэнийг бүтээн тарифын хөнгөлөлтийн дагуу экспортлох боломжтой юм. Энэ нь мөн гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллах таатай боломжийн нэг юм.

Гарал үүслийн дүрэм нь дараах байдлаар ангилагддаг байна. Үүнд:

- Бүрэн гарал үүсэлтэй бүтээгдэхүүний шаардлага
- Нэмүү өртгийн дүрэм
- Бүтээгдэхүүний тусгайлсан дүрэм
- Донор орны оролцооны дүрэм
- Нийлмэл гарал үүслийн дүрэм (өргөжүүлсэн)

Гарал үүслийн дүрмийн дагуу тухайн бүтээгдэхүүнийг импортын түүхий эд ашиглан үйлдвэрлэх, зохих нэмүү өртөг бүтээн үйлдвэрлэх, донор оронтой хамтран үйлдвэрлэх зэрэг өргөн боломжууд байна. Өөрөөр хэлбэл тухайн бүтээгдэхүүнийг 100 хувь Монгол Улсад үйлдвэрлэнэ гэсэн хатуу байр суурьнаас татгалзах хэрэгтэй юм.

Нөгөө талаас хэдийгээр тарифын хөнгөлөлт эдэлж байгаа боловч тарифын бус хориг саадаас хамааран ашиглалт туйлын хангалтгүй байгааг анхаарах нь зүйтэй юм. Тарифын бус саад тотгорууд болох эрүүл ахуй хорио цээр, чанар стандарт болон худалдаатай холбоотой дүрэм журмын шаардлагууд, далайд гарцгүй орны тээвэрлэлтийн хүндрэл, дэд бүтцийн сул хөгжил, ажиллах хүчний болон түүхий эдийн хомсдол, санхүүгийн бэрхшээлүүдээс хамааран тухайн орнуудын зах зээлд экспортлох бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрөл төдийлөн нэмэгдэхгүй байна. Өнөөг хүртэл Монгол Улсад олон улсад баталгаажсан лаборатори байхгүй байгаа



бөгөөд энэ асуудал сүүлийн 20 жил яриад шийдэгдээгүй хэвээр байна. Экспортын гол бүтээгдэхүүн болох самнасан ноолуурын чанарын гэрчилгээг Өвөр Монголын Ордос, Казахстаны олон улсад баталгаажсан лабораториас авсан хэвээр байна.

Экспортын чиглэлийн үйлдвэрүүдийг кластер хэлбэрээр үндэсний болон олон улсын түвшинд хөгжүүлэх, энэ чиглэлээр олон улсын төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн ХЕС-д дурдсан олон улсын 27 конвенцуудын хэрэгжилтийг сайжруулах тал дээр анхаарч ажиллах шаардлагатай юм. Тухайлбал, 2019 оны сүүлээс дэлхий нийтэд тархсан Covid-19 вирусын цар тахлын улмаас хүний эрх зөрчигдөх тохиолдлууд үүсч болзошгүй бөгөөд энэ нь холбогдох конвенцийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөн улмаар тарифын хөнгөлөлтөөс хасагдах нэг

нөхцөл болж болзошгүй юм.

АНУ зэрэг орны ХЕС-д оёмол сүлжмэл бүтээгдэхүүний нэр төрлийг нэмж хамруулах өргөдлийг тухайн улсын худалдааны газарт өгөх боломжтой байдаг. МҮХАҮТ-аас 2001 онд АНУ-ын ХЕС-ийн асуудал хариуцсан ажилтанд Монгол Улсад үйлдвэрлэсэн 60 орчим нэр төрлийн оёмол сүлжмэл бүтээгдэхүүнийг хамруулах хүсэлт тавьсан боловч шийдэгдээгүй байна. Иймд энэхүү асуудлыг дахин судлан үзэх шаардлагатай юм.

ХЕС-ийн тарифын хөнгөлөлтийг үр дүнтэй ашиглахад гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтран ажиллаж экспортын үйлдвэрлэлийн улс дамнасан экспортын кластерийг хөгжүүлэн, АНУ, ЕХ, Япон, Канад гэх мэт тарифын хөнгөлөлт олгогч орны зах зээлд экспортлох бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх бүрэн боломж байна.

## ЭХ СУРВАЛЖ

1. <https://trade.ec.europa.eu/>
2. JOINT REPORT TO THE EUROPEAN PARLIAMENT AND THE COUNCIL [https://trade.ec.europa.eu/doclib/docs/2018/january/tradoc\\_156536.pdf](https://trade.ec.europa.eu/doclib/docs/2018/january/tradoc_156536.pdf)
3. The global database on non-tariff measures <https://trains.unctad.org/Forms/TableView.aspx?mode=modify&action=search>
4. UNCTAD, Generalized System of Preferences and Market Access, [https://unctad.org/publications-search?f\[0\]=product%3A494](https://unctad.org/publications-search?f[0]=product%3A494)
5. Report on the Generalised Scheme of Preferences covering the period 2018 – 2019, <https://ec.europa.eu/transparency/regdoc/?fuseaction=list&coteId=10101&year=2020&number=3&language=EN>
6. EU DG Trade, GSP statistics, [https://trade.ec.europa.eu/doclib/docs/2020/february/tradoc\\_158640.pdf](https://trade.ec.europa.eu/doclib/docs/2020/february/tradoc_158640.pdf)
7. <https://ustr.gov/issue-areas/trade-development/preference-programs/generalized-system-preference-gsp>
8. Office of the United States Trade Representative (USTR), <https://ustr.gov/issue-areas/trade-development/preference-programs/generalized-system-preference-gsp>
9. Generalized System of Preferences (GSP): Overview and Issues for Congress <https://fas.org/sgp/crs/misc/RL33663.pdf>



Б.ПҮРЭВСҮРЭН, Т.ЭНХЗАЯА

## БАНКНЫ САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ҮҮРЭГ ОРОЛЦООГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ /Ковид-19 цар тахлын жишээн дээр/

*In this paper, the impact of the Covid-19 pandemic in the Mongolian banking sector is compared with the basic indicators using financial stability indicators and suggests some policy approaches to the Government in field of economic recovery through banks.*

***Keywords: COVID-19, banking sector, financial stability indicator***

### УДИРТГАЛ

Дэлхий дахинд сүүлийн 50 жилд гарсан эдийн засгийн уналт, хямралуудын дийлэнх нь санхүүгийн системээс үүдэлтэй байв. Харин энэ удаагийн хямрал нь дэлхий нийтийг хамарсан цар тахал, засгийн газар, нийгмийн зүгээс түүнд үзүүлэх хариу арга хэмжээ, үүнээс үүдэлтэй эрэлт, нийлүүлэлтийн шокоос үүссэнээрээ ялгаатай.

Хэдий хямрал үүссэн шалтгаан өөр ч Ковид-19 цар тахал өмнөх санхүү, эдийн засгийн хямралуудын үетэй адил, түүнээс ч илүүгээр банк, санхүүгийн салбарт сөргөөр

нөлөөлж, цаашдын тодорхой бус байдал эрсдэлийг улам нэмэгдүүлж байна.

Зарим судлаачдын зүгээс энэ нөхцөл байдалд Европ, АНУ-ын банкны системүүд эдийн засгийг хэвийн байдалд нь оруулахад чухал үүрэг гүйцэтгэж байна гэж үзэж байгаа юм. Банкны дэмжлэгтэйгээр эдийн засаг хямралын дараа богино хугацаанд сэргэх эсэх нь банкуудын тогтвортой байдлаас ихээхэн хамаарна. Нөгөө талаас төрөөс банкаар дамжуулан бодит эдийн засагт үзүүлэх дэмжлэг хэр оновчтой байхаас шалтгаалж байна.

Монгол Улсын банкны систем санхүүгийн салбарын 90 хувийг эзэлж буйн хувьд эрүүл, тогтвортой байх нь санхүүгийн тогтвортой байдал, цаашлаад эдийн засагт нөөцийн үр ашигтай хуваарилалтад чухал ач холбогдолтой.


Иймд, энэхүү ажилд Ковид-19 цар тахлын банкны салбарт үзүүлж буй нөлөөлөл, тогтвортой байдалд учирч болзошгүй эрсдэлийг шинжилж, төрөөс банкаар дамжуулан эдийн засагт дэмжлэг үзүүлэх боломжит зарим арга замын талаар өгүүлэхийг зорилоо.

### БАНКНЫ САЛБАРЫН СУУРЬ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын санхүүгийн системийн 95.3 хувийг банкны системийн үйл ажиллагаа бүрдүүлдэг ба банкны салбарт нийт 13 арилжааны банк<sup>1</sup> үйл ажиллагаа явуулж байна. Монголбанкны тодорхойлсноор банкны системд нөлөө бүхий банкинд ХААН, ХХБ, Голомт, Хас, Төрийн гэсэн таван банк багтдаг. Эдгээр банк нь санхүүгийн системийн 90-ээс дээш хувийг бүрдүүлж буй юм.

<sup>1</sup> Худалдаа хөгжлийн банк (Улаанбаатар хотын банк Худалдаа хөгжлийн банктэй нэгдсэн), ХААН банк, Голомт банк, Төрийн банк, Тээвэр хөгжлийн банк, Ариг банк, Кредит банк, Капитрон банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Хас банк, Чингис хаан банк, Богд банк

Зураг 1. Арилжааны банкуудын салбарт эзлэх хувь, активаар, 2020 оны I улирал



Эх сурвалж: ЭЗБӨЧСТ, Банкуудын өрсөлдөөний тойм

Монгол Улс банк давамгайлсан санхүүгийн системтэй тул олон улсад ашигладаг санхүүгийн тогтвортой байдлын

шалгуур үзүүлэлтүүдээр банкны салбарын суурь нөхцөл байдлыг дүгнэх боломжтой.

### Хүснэгт 1. Санхүүгийн голлох үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Томоохон банкууд	Жижиг банкууд
Банкуудын тоо	6	7
Зах зээлд эзлэх нийт хувь	92%	8%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа	17.2%	25.6%
Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь	8.5%	7.0%
Өөрийн хөрөнгийн өгөөж (RoE)	11.4%	7.8%
Цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR)	133.0%	124.2%

Эх сурвалж: Дэлхийн банк (2020), Эдийн засгийн эрчтэй сэргэлт, түүний хүртээмжийг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн институцийн болон бүтцийн бодлогын реформууд /Томоохон банк<sup>2</sup>, Жижиг банк<sup>3</sup>/

<sup>2</sup> Хаан, Голомт, ХХБ, Хас, Төрийн банк, Улаанбаатар хотын банк


<sup>3</sup> Тээвэр хөгжлийн банк, Ариг банк, Кредит банк, Капитрон банк, Үндэсний хөрөнгө оруулалтын банк, Чингис хаан банк, Богд банк

Дээрх хүснэгтээс харахад, 2019 оны байдлаар банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээний шалгуур үзүүлэлтүүд байвал зохих хамгийн бага түвшнээс өндөр, ашигт ажиллагаа эерэг, хөрвөх чадвар сайн байжээ.

### ЦАР ТАХЛЫН БАНКНЫ САЛБАРТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ, ЭРСДЭЛ

Цар тахлын нөлөөгөөр банкны салбарын нийт актив, пассивын өсөлт саарч, эдийн засагт санхүүгийн зуучлалын үйл

#### Зураг 2. Банкны салбарын актив, зээлийн өсөлт



ажиллагааны идэвхжил суларч байна. Нийт активын өсөлт саарахад зээл, пассивын өсөлт саарахад харилцах дансны үлдэгдэл голлон нөлөө үзүүлжээ. Тодруулбал, 2020 оны III улирлын байдлаар нийт активын 45.2 хувийг бүрдүүлж буй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 4.5 хувиар буурч 16 их наяд төгрөг, пассивын 15 хувийг бүрдүүлж буй аж ахуйн нэгж иргэдийн харилцах дансны үлдэгдэл 19.9 хувиар буурч 4.8 их наяд төгрөгт хүрсэн байна.

#### Зураг 3. Банкны салбарын пассив, харилцах дансны өсөлт



Эх сурвалж: Монголбанкны тоо мэдээлэлд түшиглэн тооцов

**Зээлийн чанаргүйдлийн эрсдэл.** Хэдийгээр Монголбанкнаас зээлийн нөхцөл өөрчлөх, ангилал бууруулахгүй байх журмын өөрчлөлтийг банкуудад мөрдүүлж байгаа<sup>4</sup> ч банк санхүүгийн салбарын

<sup>4</sup> Ковид-19 вирусын тархалттай холбоотойгоор Монгол Улсын эдийн засагт хүндрэл учирч, банкны салбарын зээлийн эргэн төлөлтөд доголдол үүсч байгаатай холбогдуулан Монголбанк активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журамд түр хугацааны өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн. Энэхүү зохицуулалтын хүрээнд 3.7 их наяд төгрөгийн зээлд бүтцийн өөрчлөлт хийсэн бөгөөд 2.2 их наяд төгрөгийн бизнесийн зээл, 1.5 их наяд төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт орсон байна. Мөн ипотека, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зээл хэлбэрээр иргэнд олгосон зээлд тогтоох хугацааны ангиллыг “Хэвийн” зээлийн хувьд 15 хүртэлх хоног байсныг 90 хүртэлх хоног болгож, “Анхаарал

**Зураг 4. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)**



2020 оны III улирлын байдлаар банкны системд 1.78 их наяд төгрөгийн зээлийн эрсдэлийн сан байгуулжээ. Энэ нь нийт

эрсдэлийг тодорхойлдог хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн үлдэгдэл 2020 оны III улирлын эцэст 6.2 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 111 хувиар өссөн нь нийт активын хэмжээнд эрсдэл учруулах магадлалтай болгож байна (Зураг 1). Энэ дүнгээс харахад хугацаа хэтэрсэн болон нийт зээлд эзлэх хувь хэмжээ 18.1 хувьд хүрсэн ба бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, хатуу хөл хорио тогтоосонтой холбоотойгоор цаашид ч өсөх дарамт өндөр байгаа нь салбарын эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна.


хандуулах” зээлийн хувьд 91-120 хүртэлх хоног, “Чанаргүй” зээлийн хувьд 121-ээс дээш хоног байхаар тус тус өөрчлөлт оруулсан.

**Зураг 5. Хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь**



*Эх сурвалж: Монголбанкны тоо мэдээлэлд түшиглэн тооцов*

албан ёсоор ангилагдсан чанаргүй зээлийн 45 хувь, чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээлийн 29 хувьтай тэнцэж байгаа юм.

Зураг 6. Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ<sup>5</sup>

Эх сурвалж: Монголбанкны тоо мэдээлэлд түшиглэн тооцов

<sup>5</sup> Эрсдэлийн сангийн хүрэлцээ нь чанаргүй зээлтэй холбоотой эрсдэлээс хамгаалах чадамжийг илэрхийлнэ

**Хөрвөх чадварын эрсдэл.** Арилжааны банкуудын балансын пассивын бүтцэд зохистой хэмжээнээс давсан гадаад валют төвлөрсөн үед хөрвөх чадварын эрсдэл бий болдог. Тухайлбал, тухайн орны болон банкны системийн эрсдэл нэмэгдэж байгаа үед хадгаламж эзэмшигчид болон зээлдүүлэгч нар өөрсдийн хадгаламж болон зээлийн эх үүсвэрээ гадаад валютад хөрвүүлэх, татаж авах, эсвэл гадаадад байршуулж эхэлдэг. Энэ үед банкуудын хувьд валютын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар муудаж, цаашлаад Төв банкны гадаад валютын нөөцөөс худалдаж авах шаардлага тулгарна.<sup>6</sup>

2020 оны III улирлын байдлаар банкны салбарын нийт харилцах дансны үлдэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 20, үүнээс төгрөгийн харилцах 12, гадаад валютын харилцах 29 хувиар тус тус буураад байна. Мөн банкны салбарын эх үүсвэрийн 14 орчим хувийг бүрдүүлдэг гадаад эх үүсвэр 18.1 хувиар буурсан бол 50 орчим хувийг бүрдүүлдэг иргэд, аж ахуйн нэгжүүдийн хадгаламжийн


<sup>6</sup> Монголбанк, Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлын тайлан, 2020 оны зургаадугаар сар

хэмжээ 27 хувиар, үүнээс гадаад валютын хугацаагүй хадгаламж хамгийн ихээр өсчээ. Ийнхүү банкны салбарын богино хугацаатай эх үүсвэрүүд агшиж, хадгаламж гадаад валютад, хугацаагүй хэлбэрээр илүүтэй төвлөрсөн нь нийт системийн хөрвөх чадварт эрсдэл учруулж байна.

Нөгөөтэйгүүр актив талд банкны нөөцийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 6 хувиар буурсан ч хөрвөх чадвартай актив<sup>7</sup> нийт пассивын харьцаа доод шалгуур үзүүлэлтээс өндөр байна. Үүнд банкууд хөрвөх чадварын эрсдэлд орохгүйн тулд татан төвлөрүүлсэн эх үүсвэрээ хөрвөх чадвар өндөр, эрсдэл багатай Төв банкны болон Засгийн газрын богино хугацаат үнэт цаасанд хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулсан нь голлон нөлөөлжээ. Өөрөөр хэлбэл, банкны салбарын хөрвөх чадварыг илтгэх нэг үзүүлэлт болох төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа зохистой байдлын шалгуураас өндөр байгаа нь төгрөгийн илүүдэл их байгааг харуулж байна.

<sup>7</sup> Банкны нөөц, төв банкны үнэт цаас, засгийн газрын богино хугацаат бондын нийлбэр

**Зураг 7. Банкны салбарт нөлөө бүхий банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар**



Эх сурвалж: Монголын банкны холбоо, Банкны салбарын тойм 2020 оны III улирал


**Өөрийн хөрөнгийн эрсдэл.** Банкны салбарын эрсдэл даах чадварыг харуулдаг өөр нэг үзүүлэлтийг авч үзэхэд, 2020 оны зургаадугаар сарын байдлаар нийт өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа 15.6 хувь байгаа нь Монголбанкнаас тогтоосон шалгуур үзүүлэлтээс 3.6 нэгж хувиар өндөр байна. Монголбанк Ковид-19 цар тахлаас шалтгаалан зээл олголт болон эргэн төлөлтүүд тасалдан хойшлогдох, Ковид-19-т өртсөн зарим зээлдэгчийн хувьд цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болох буюу эрсдэлийн сангийн зардлыг нэмэгдүүлэх зэрэг хувилбараар банкны

системд стресс тестийн шинжилгээ хийхэд үр дүнд нь банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт алдагдахааргүй байна гэсэн дүгнэлтэд хүрчээ.<sup>8</sup>

Монголын банкны холбооны тайлангаас харахад 2020 оны III улирлын байдлаар салбарын нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай хэмжээнд байгаа нь дээрх дүгнэлтээс зөрөхгүй байна.

<sup>8</sup> Монголбанк, Санхүүгийн тогтвортой байдлын тайлан, 2020 оны зургаадугаар сар

**Зураг 8. Банкны салбарт нөлөө бүхий банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ**



Эх сурвалж: Монголын банкны холбоо, Банкны салбарын тойм 2020 оны III улирал

Гэсэн хэдий ч ОУВС, Дэлхийн банк хямралаас өмнө Монгол Улсын зарим томоохон банкыг өөрийн хөрөнгийн нэлээд дутагдалтай байж болзошгүй гэж дүгнэсэн байна.<sup>9</sup>

Банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай ч зарим нэр бүхий банкны хувьд өөрийн хөрөнгийн нөөц бололцоо нь харьцангуй нимгэн байгаа ба дотоодод вирус тархсантай холбоотойгоор байдал улам хүндэрч, олон улсын байгууллагууд, зээлжих зэрэглэл тогтоогч агентлагууд, хөрөнгө оруулагчдад сөрөг дохио болж, улмаар эдийн засгийн ойрын болон дунд хугацааны төлөвт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

2020 оны зургаадугаар сараас өмнө буюу дотоодод вирусын халдвар тархаагүй үед олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Фитч агентлаг коронавирусын шокоос хамааралтай нөхцөл байдал түр хугацаанд үргэлжлэн 2021 оноос эдийн засаг огцом сэргэж, гадаадын хөрөнгө оруулагч, зээлдүүлэгчдээс орж ирэх санхүүжилтийн урсгал нэмэгдэх хүлээлттэй байгаа тул Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг В буюу тогтвортой төлөвт хэвээр үлдээхээр шийдвэрлэсэн ч цаашид эрсдэл өндөр байгааг онцолжээ.<sup>10</sup> Мүүдис агентлаг шокын нөлөөгөөр гадаад санхүүжилт

<sup>9</sup> Дэлхийн банк, Монголын эдийн засгийн тойм: Эдийн засгийн тогтвортой байдал, банкны зээлийн өсөлт, 2020 оны 01 дүгээр сар, 26 дугаар тал

<sup>10</sup> Fitch Affirms Mongolia at 'B'; Outlook Stable. Fitch Ratings. May 28, 2020. <https://www.fitchratings.com/research/sovereigns/fitch-affirms-mongolia-at-b-outlook-stable-28-05-2020>

авах боломж тодорхойгүй, эрсдэл өндөр гэсэн шалтгаанаар үнэлгээний төлөвийг “тогтвортой”-гоос “сөрөг” болгож бууруулсан.<sup>11</sup> Мөн 2020 оны III улирлын байдлаар банкуудын гадаад эх үүсвэр жилийн 18.1 хувиар буурсан зэргээс харахад эрсдэл ойрхон байгаагийн илрэл юм.

Дээрх эрсдэл нь банкуудыг өөрийн хөрөнгийн хүрэлцээг хангах, хөрвөх чадвараа тогтвортой хадгалахын тулд зээлийн багцаа бууруулах сонголтод хүргэнэ. 2020 оны есдүгээр сарын байдлаар банкуудын шинээр олгосон зээлийн хэмжээнд огцом бууралт ажиглагдахгүй байгаа (Зураг 9) нь Монголбанкны гаргасан банкуудын төгрөгийн заавал байлгах нөөц хэмжээг бууруулах шийдвэртэй холбоотой гэж үзэж болох юм.<sup>12</sup>


Банкны чөлөөт хөрөнгө нь нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө ба заавал байлгах нөөцийн зөрүүгээр тодорхойлогддог. Иймд банкуудын төгрөгийн заавал байлгах нөөц хэмжээг бууруулснаар банкны төгрөгөөрх чөлөөт эх үүсвэрийг нэмэгдүүлээд зогсохгүй эх үүсвэрийн зардлыг бууруулж, эдийн засагт зээлийн тасалдал үүсгэхгүй байхад эерэг нөлөө үзүүлжээ.

<sup>11</sup> Rating Action: Moody's changes Mongolia's outlook to negative from stable; affirms B3 rating. Moody's Investors Service. May 08, 2020. [https://www.moody.com/research/Moodys-changes-Mongolias-outlook-to-negative-from-stable-affirms-B3--PR\\_423017](https://www.moody.com/research/Moodys-changes-Mongolias-outlook-to-negative-from-stable-affirms-B3--PR_423017)

<sup>12</sup> Мөнгөний бодлогын хорооны 2020 оны гуравдугаар сарын 11-ний өдрийн хуралдааны тогтоолоор төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг 2 нэгж хувиар бууруулж, 8.5 хувь байхаар шийдвэрлэсэн. Ингэснээр системийн хэмжээнд банкуудын 324 тэрбум төгрөг заавал байлгах нөөцөөс чөлөөлөгдсөн билээ.



**Зураг 9. Банкуудын шинээр олгосон зээлийн хэмжээ, их наяд төгрөг**



Эх сурвалж: Монголбанк


Зээл олголтыг бүтцээр нь харвал, 2020 оны III улирлын байдлаар иргэдийн зээл жилийн 30 хувиар, бизнесийн зээл 12 хувиар тус тус өссөн (Зураг 10, 11). Иргэдийн зээл олголтын өсөлтөд цалин, тэтгэврийн зээлийн өсөлт голлон нөлөө үзүүлсэн бол уул уурхайн экспорт сэргэснээр тус салбарын зээл олголт 126 хувиар өссөн нь

**Зураг 10. Иргэдийн зээл**



бизнесийн зээлийн өсөлтөд нөлөөлжээ. Уул уурхайгаас бусад цар тахлын нөлөөнд өртсөн стратегийн ач холбогдолтой салбаруудын зээл олголт буурсан бөгөөд хатуу хөл хориотой холбоотой үргэлжлэн буурахаар байна. Эндээс зээлийн өсөлт эдийн засгийг төрөлжүүлэх чиглэлтэй уялдахгүй байгааг цаашид анхаарууштай.

**Зураг 11. Бизнесийн зээл**



Эх сурвалж: Монголын банкны холбоо, Банкны салбарын тойм 2020 оны III улирал

Ийнхүү цар тахлын нөлөөгөөр банкны салбарын тогтвортой байдалд олон эрсдэл тулгарч байна. Улс орнууд санхүүгийн тогтвортой байдалд ихээхэн анхаарал хандуулж, эдийн засагт дэмжлэг үзүүлэх замаар санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсээр байна. Монголбанкнаас

авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд ч гадаад улс орнуудын туршлагатай зарим талаар нийцтэй байгаа ба хөл хорио, хязгаарлалт удаан хугацаанд үргэлжилбэл Ковид-19 цар тахал Монгол Улсын банкны салбарт онолын хувьд дараах сувгаар нөлөөлөх магадлалтай (Хүснэгт 2).

### Хүснэгт 2. Ковид-19 цар тахлын банкны салбарт үзүүлж болзошгүй нөлөө

Эерэг нөлөө	Сөрөг нөлөө
<p>Монгол банкнаас “Төлбөр тооцоогоо цахимаар хийе” уриалга гаргасан.</p> <ul style="list-style-type: none"> <li>Банкуудын онлайн үйлчилгээ болон бусад төрлийн хэрэгслүүд хөгжиж эхлэх буюу харилцагчдад илүү олон төрлийн үйлчилгээг үзүүлэх боломж үүснэ.</li> <li>Банкнаас гадуурх бэлэн мөнгө харилцах данс руу шилжихийн хэрээр банкны сектор эдийн засаг дахь нийт мөнгийг хянах боломж үүснэ.</li> </ul>	<p>Зээлийн төлбөрийн хуваарийг хойшлуулсан тул арилжааны банкуудын мөнгөний орох урсгал саарч, гарах урсгал нэмэгдэх.</p> <ul style="list-style-type: none"> <li>Төлбөрийн хуваарийг хойшлуулсантай холбоотой шинээр зээл гаргах процесс доголдолд орох эрсдэл гарах магадлалтай.</li> <li>Банкны салбарын ашигт ажиллагаа муудах, өөрийн хөрөнгийн хүрэлцээ багасах, хөрвөх чадвар муудах зэргээр банкны системийн зохистой харьцааны үзүүлэлтүүд доошилж, улмаар зээлжих зэрэглэл буурч эх үүсвэр татах зардал өснө</li> </ul>
<p>Мөнгөний нийлүүлэлтийг өсгөхийн тулд төв банкнаас заавал байлгах нөөцийн хувийг бууруулав.</p> <ul style="list-style-type: none"> <li>Банкны төгрөгөөрх чөлөөт эх үүсвэрийг нэмэгдүүлээд зогсохгүй эх үүсвэрийн зардлыг бууруулж байна.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>8 хувийн ипотекийн зээлийн төлбөрийг чөлөөлж байгаатай холбогдуулан эргэн төлөлтөөс нь зээл санхүүжүүлэх боломж багасах.</li> </ul>
	<p>Эдийн засгийн үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлөх</p> <ul style="list-style-type: none"> <li>Төгрөгийн бусад валюттай харьцах ханш сулрах.</li> <li>Хэрэв төгрөгийн бусад валюттай харьцах нэрлэсэн ханш суларна гэж төсөөлбөл худалдан авах чадвараар тодорхойлогдох төгрөгийн бодит ханш суларна.</li> <li>Хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлнө.</li> </ul>
	<p>Харилцагч орнуудтай хил хаасны үр дүнд урт хугацаанд нийлүүлэлтээс хамаарсан инфляци нэмэгдэх</p>

Банкны салбарт цар тахлын үзүүлэх бодит нөлөөг тодорхойлоход шаардлагатай олон хүчин зүйл тодорхойгүй байгаа үед хямралын нөлөөллийг бууруулахын тулд Ковид-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнгээс шалтгаалан үүсэх эрсдэлийн хувилбаруудаар богино хугацаанд олон давтамжтай стресс тест хийх замаар эрсдэлийг тодорхойлж байх нь чухал болоод байна.

### **ЦАР ТАХЛЫН БОДИТ ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ НӨЛӨӨЛӨЛ, БАНКНЫ САЛБАРЫН ДЭМЖЛЭГ**

Энэ удаагийн хямрал өмнө нь гарч байсан олон улсын банк, санхүү, эдийн засгийн хямралуудаас илүү өргөн хүрээг хамарч дотоодын дийлэнх жижиг дунд аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа зогсож, орлого тасалдаж байна. Улмаар бизнесээ явуулах эргэлтийн хөрөнгөгүй, урсгал болон тогтмол зардлуудыг төлөх бэлэн мөнгөгүй, зээлийн санхүүжилтгүй байгаагаас олон аж ахуйн нэгж дампуурах эрсдэлтэй тулгараад байгаа юм. Энэ нөхцөлд үүсэх үр дагавар нь зардлаа бууруулах буюу ажлын байрыг цомхотгох сонголт руу оруулдаг. Тухайлбал, Худалдаа аж үйлдвэрийн танхимын 2020 оны 11 дүгээр сарын 23-25-ны өдөр 3530 аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийг хамруулсан түүвэр судалгааны дүнд аж ахуйн нэгжийн 63 хувь нь сар хүрэлцэхгүй хугацааны мөнгөний нөөцтэй байгаа ба эдгээр аж ахуйн нэгжийн 72 хувь нь бизнесийн зээлтэй гэжээ. Судалгаанд оролцогчдын 54 хувийнх нь борлуулалтын орлого 91-ээс дээш хувиар багасч, 25 хувь нь ажлын байрны тоогоо бууруулсан буюу 7645 ажлын байр цөөлжээ<sup>13</sup>.

Монгол Улсын хувьд зээлийн өсөлт болон эдийн засгийн өсөлт нь ихэнх

<sup>13</sup> Судалгааны тайлан: Хатуу хөл хорионы үеийн хувиараа бизнес эрхлэгчдийн нөхцөл байдал, Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим, 2020 оны 11 дүгээр сарын 26

тохиолдолд аль алиныхаа мөчлөгийн хэлбэлзлийг нэмэгдүүлдэг. Өөрөөр хэлбэл, эдийн засаг тогтвортой, эерэг хүлээлттэй үед банкууд хөрвөх чадвараа сайжруулсны үндсэн дээр иргэд, аж ахуйн нэгжид олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх байдлаар ДНБ-ий өсөлтөд эергээр нөлөөлдөг бол энэ нөлөө нь эргээд банкны салбар өсөх хүчин зүйл болдог. Энэ үүднээс цар тахал эдийн засагт хямрал учруулж байгаа нь банкны салбарт мөн сөргөөр нөлөөлнө гэсэн хүлээлтийг үүсгэж, банкууд шинээр зээл олголтын хэмжээг бууруулах тактик баримтлахад хүргэж байна. Улмаар банкууд эрсдэлд орохгүйн тулд эдийн засагт шаардлагатай зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг эрсдэл багатай хөрөнгөнд байршуулж байгаа нь эргээд эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан Монголбанк банкуудын зээлийн нийлүүлэлтийг дэмжих, ажлын байрыг хадгалах, цаашид эдийн засгийг төрөлжүүлэх ач холбогдолтой гэж үзэж жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортыг дэмжихэд зориулсан урт хугацаат санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлж, ашиглаж эхэлсэн<sup>14</sup> нь бизнес эрхлэгчдийн хөрвөх чадварт бодит дэмжлэг үзүүлэхүйц арга хэмжээ болж байна.

Олон улсад цар тахлын банкуудад үзүүлсэн сөрөг нөлөө нь бусад санхүүгийн зуучлагч байгууллагатай харьцуулахад илүү хүчтэй бөгөөд удаан үргэлжилж

<sup>14</sup> Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны тогтоолоор жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарыг дэмжихэд зориулан Төв банкны репо арилжааны нөхцөлд өөрчлөлт оруулж, төгрөгийн хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас барьцаалан 2 хүртэл жилийн хугацаатай санхүүжилт олгох боломжийг бүрдүүллээ. Улмаар 2020 оны 4 дүгээр улиралд 230 тэрбум төгрөгийн санхүүжилт, 2021 оны 1 дүгээр улиралд нэмж 250 тэрбум төгрөгийн санхүүжилт банкуудад олгохоор шийдвэрлээд байна. Уг арга хэмжээ нь тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн эх үүсвэрийн зардлыг 10.5 хувь болгон, зах зээлийн хүүнээс 6-7 нэгж хувиар бууруулж, хугацааг уртасгах, зээлдэгчийн хүсэлтээр үндсэн төлбөрөөс эхний 6 сард чөлөөлөгдөх боломжийг олгож байна.

байгаа билээ. Улмаар банкууд санхүүгийн зуучлалын үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж хумигдаж, бизнес эрхлэгчдийн хөрвөх чадвар муудсантай холбоотой үүсч буй зээлийн хэрэгцээ, шаардлага нь банкны системд ихээхэн дарамт учруулж байна.

Дэлхийн нийтээр төв банкууд бодлогын хүүгээ түүхэн бага түвшинд хүргэх замаар мөнгө зээлийн дэмжлэгийг идэвхжүүлж, нээлттэй захын үйл ажиллагаа эрхлэх замаар нөөц нийлүүлж банкны системийн дарамтыг бууруулахаар ажиллаж байна. Хөгжиж буй орнуудын төв банкууд бодлогын хүүг бууруулах арга хэмжээг авч эхэлсэн бөгөөд эдгээр арга хэмжээ нь итгэлийг сэргээх замаар системд үүссэн сөрөг шокийг хязгаарлахад эерэгээр нөлөөлж байгаа билээ. Үүний сацуу хэд хэдэн төв банк своп хэлцлийн үндсэн дээр зээлийн сувгийн механизмуудыг ашиглан ам.долларын нөөц нийлүүлж байна. Мөн төв банкууд 2008-2009 оны арга хэмжээг, тухайлбал компанийн бонд зэрэг эрсдэлтэй активыг худалдаж авах арга хэмжээг авав.

Төв банкуудаас гадна засгийн газрууд хөрвөх чадварыг дээшлүүлэх, зээлийн урсгалыг дэмжих зорилгоор олон төрлийн арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Эдгээр мөчлөгийн эсрэг хэрэгжүүлэх зээлийн бодлогын хүлээгдэж буй гол үр дүн нь банкны системийн ирээдүйн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлж, цар тахлын шокийг эрсдэл багатайгаар даван туулах боломжийг олгох явдал юм.


ОУВС-ийн “Төсвийн арга хэмжээ” тайланд дурдсанаар дэлхийн улс орнууд Ковид-19 цар тахал болон түүнтэй холбоотой хөл хорионоос үүдэн есдүгээр сарын 11-ний байдлаар энэ онд нийт 11.7 их наяд ам.доллар буюу дэлхийн нийт ДНБ-ий 12 хувьтай тэнцэхүйц төсвийн багц арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна. Үүний тал хувь нь зээл, баталгаа, хөрөнгө оруулалт зэрэг бизнес эрхлэгчдийн хөрвөх чадварыг дэмжих арга хэмжээнд зарцуулагджээ. Эдгээр арга хэмжээ нь төсвийн алдагдал, Засгийн газрын өрийн хэмжээг нэмэгдүүлэхэд хүргэж байгаа ч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа улам дордох, цаашлаад дампуурах, олон мянган ажлын байр алдагдах эрсдэлээс сэргийлж чадсан гэж үзэж байна.

Гэхдээ аж ахуйн нэгжүүдийн хөрвөх чадварыг дэмжих арга хэмжээний хэлбэр, нөхцөлөөс хамааран үр дүн нь харилцан адилгүй байжээ. Аж ахуйн нэгжүүдийг бүхэлд нь хамруулах нөхцөлтэй хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийг голчлон цар тахлын нөлөөнд бага өртсөн аж ахуйн нэгжүүд авч зорилтот бүлгүүд, ялангуяа жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд үзүүлэх дэмжлэгийн нөлөөг сааруулахад хүргэсэн байна. Харин Евро бүсэд засгийн газрын зээлийн баталгаа нь жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүжилтийн таатай нөхцөлийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэжээ.

#### Европын Төв банкны сайн туршлага

Евро бүсийн ихэнх улсын Засгийн газрууд бизнес эрхлэгчдэд зориулж банкны зээл авах боломжийг хадгалж үлдэхийн тулд улсын зээлийн баталгааны томоохон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү арга хэмжээ нь зээлийн чанаргүйдлийн эрсдэл, түүнээс үүдэх алдагдлыг банкуудаас Засгийн газарт шилжүүлж, улмаар банкуудын зардлыг бууруулах замаар тус салбарт цар тахлаас үүдэх эрсдэлийг бууруулах эерэг нөлөөг үзүүлж байна. Нөгөөтэйгүүр аж ахуйн нэгжүүдийг хөрвөх чадваргүй болохоос урьдчилан сэргийлэх, ажлын байрыг хамгаалж үлдэх сайн туршлага болж байна. Мөн Европын Төв банк цар тахлаас болж хямраад буй эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд банкуудад илүү хямд санхүүжилт олгох зорилгоор бонд худалдан авалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Зураг 12. Бизнес эрхлэгчдэд хөрвөх чадварын дэмжлэг үзүүлэх схем




Эх сурвалж: Phakawa Jeasakul (2020). Considerations for designing temporary liquidity support to businesses, IMF

Монгол Улс Европын сайн туршлагад нийцүүлэн банкны салбарын зээлийн эрсдэлийг бууруулах, урт хугацааны эдийн засгийн уналтаас сэргийлж, ажлын байрыг хадгалж үлдэхийн тулд зээлийн батлан даалтын хэрэгслийг ашиглан банкуудын төгрөгийн илүүдэл нөөцийг бизнес эрхлэгчдийн хөрвөх

чадварыг дэмжихэд зарцуулах боломжтой. Ингэхдээ аж ахуйн нэгжүүдийг бүхэлд нь хамруулах нөхцөлтэйгөөр бус эдийн засгийг төрөлжүүлэх стратегийн чиглэлтэй уялдуулан цар тахлын нөлөөнд өртсөн зорилтот салбаруудыг оновчтой сонгох нь чухал байна.

**Зураг 13. ДНБ-ий өсөлт, 2020 оны III улирал, салбараар**



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо тоо мэдээнд үндэслэж тооцов.

Монгол Улсын эдийн засгийн үйл ажиллагааны ихэнх салбарууд Ковид-19 цар тахлын нөлөөнд өртсөн. Ялангуяа

уул уурхай, худалдаа, тээвэр агуулахын салбарын өсөлт өмнөх оны мөн үеэс 7.6, 8.5, 17.8 хувиар тус тус буурчээ. (Зураг 13).

**Зураг 14. Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр) 2020 оны есдүгээр сарын байдлаар, нийт хугацаа хэтэрсэн зээлд эзлэх хувь, жилийн өсөлт**



Эх сурвалж: Монгол банкны тоо мэдээнд түшиглэн тооцов.

**Зураг 15. Эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудын чанаргүй зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөгөөр) 2020 оны есдүгээр сарын байдлаар, нийт чанаргүй зээлд эзлэх хувь, жилийн өсөлт**




Эх сурвалж: Монгол банкны тоо мэдээнд түшиглэн тооцов.

2020 оны есдүгээр сарын байдлаар уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарт хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл бусад салбараас харьцангуй их хэмжээгээр өссөн ба үүнээс боловсруулах үйлдвэрлэлийн салбарын хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл хамгийн ихээр буюу өмнөх оны мөн үеэс 7 дахин их өссөн байна (Зураг 14, 15). Түүнчлэн ядуурал,

ажилгүйдлийг бууруулахад чухал нөлөөтэй жижиг дунд үйлдвэрлэлийн зээл жилийн 12 хувиар буурсан бөгөөд үүнд боловсруулах үйлдвэрлэлийн зээл 27 хувиар буурсан нь голчлон нөлөөлжээ (Зураг 16). Эндээс цар тахлын нөлөөнд боловсруулах үйлдвэрлэлийн салбарын аж ахуйн нэгжүүд хамгийн ихээр өртсөн гэж дүгнэж болохоор байна.

**Зураг 16. Жижиг дунд бизнес эрхлэгчдийн зээлийн өсөлт**



Эх сурвалж: Монголбанкны тоо мэдээлэлд түшиглэн тооцов

Манай улсын уул уурхайгаас бусад салбарын бизнесүүд гадаадын бараа, үйлчилгээний импортоос хамааралтай буюу олгогдсон зээлүүд бараа үйлчилгээний импортыг нэмэгдүүлж энэ нь урсгал тэнцлийн алдагдлыг өсгөх хандлагатай байдаг. Харин импортыг орлох, экспортыг дэмжих боловсруулах үйлдвэрлэлд олгосон зээл нь урсгал тэнцлийн алдагдлыг өсгөх бус бууруулах нөлөө үзүүлдэг. Иймд Засгийн газрын зүгээс цар тахлын нөлөөнд ихээхэн өртсөн боловсруулах үйлдвэрлэл, ялангуяа бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлд батлан даалт гаргах, зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатай байна.

### ДҮГНЭЛТ

Ковид-19 цар тахлын улмаас банкны салбарт зээлийн чанар муудах, өөрийн

хөрөнгө буурах, хөрвөх чадвар сулрах зэргээр банкны салбар, цаашлаад санхүүгийн салбарын тогтвортой байдал алдагдах эрсдэл өндөр байна. Цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, богино хугацаанд хэвийн байдалд оруулахад засгийн газрын зүгээс цар тахлын нөлөөнд ихээхэн өртсөн боловсруулах үйлдвэрлэл, ялангуяа бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн зээлд батлан даалт гаргах, зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарах шаардлагатай. Ингэхдээ Засгийн газар олон улсын сайн туршлагад нийцүүлэн аж ахуйн нэгжүүдийг бүхэлд нь хамруулах нөхцөлтэйгөөр бус эдийн засгийг төрөлжүүлэх стратегийн чиглэлтэй уялдуулан цар тахлын нөлөөнд өртсөн зорилтот салбаруудын зээлд батлан даалт гаргах хэрэгслийг ашиглан хөрвөх чадварыг дэмжих нь илүү үр ашигтай юм.

---

**ЭХ СУРВАЛЖ**

1. Дэлхийн банк (2020). Монголын эдийн засгийн тойм: Эдийн засгийн тогтвортой байдал, банкны зээлийн өсөлт
2. Дэлхийн банк (2020). Эдийн засгийн эрчтэй сэргэлт, түүний хүртээмжийг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн институцийн болон бүтцийн бодлогын реформууд
3. Монголбанк (2020). Санхүүгийн тогтвортой байдлын тайлан
4. Монголын банкны холбоо. Банкны салбарын тойм, 2020 оны 3 дугаар улирал
5. Anderson, J., F. Papadia, and N. Vйron. (2020). “Government-Guaranteed Bank Lending in Europe: Beyond the Headline Numbers.” Realtime Economic Issues Watch (blog), Peterson Institute for International Economics, July 21. <https://www.piie.com/blogs/realtime-economic-issues-watch/government-guaranteed-bank-lending-europe-beyond-headline>
6. European Central Bank (6/2020). Economic and Monetary developments: Public loan guarantees and bank lending in the COVID-19 period, Economic Bulletin,
7. IMF (2020). Fiscal monitor: policies for the recovery
8. Phakawa Jeasakul (2020). Considerations for designing temporary liquidity support to businesses, IMF
9. UNDP (2018). Development Finance Assessment for Mongolia: diversifying finance for sustainable development
10. World Bank (2020). COVID-19: The Regulatory and Supervisory Implications for the Banking Sector
11. Монголбанкны статистик
12. Үндэсний статистикийн хорооны статистик
13. <https://www.imf.org/>
14. <https://www.fitchratings.com>
15. <https://www.moody.com>





Д.УЛАМБАЯР (Ph.D, Professor)

## COVID-19 ЦАР ТАХЛЫН ДАРААХ ДЭЛХИЙН ШИНЭ ДЭГ ЖУРМЫН ДҮР ТӨРХИЙН ТУХАЙД ЗАРИМ ТӨСӨӨЛӨЛ

*This article talks about the Post-COVID-19 pandemic, which will forever alter the shape of the world order.*

*The Humanity needs to have some time-out. As a core apparatus of international relations the world order based on balance of power aims to upgrade and update itself to shape a more secure new world order based on cooperation and solidarity.*

*The understandings of new world order, cooperation of states and security have been changed in Post-covid-19, trade and economy, governance, politics, and human mentality, way of living, health and education sector, the readiness during state of emergency are all going to follow the new rules of game. The new issue has raised on the openness of state borders and the possibility of free movement of people across the globe like before.*

*The decline of reputation of neoliberal thought, in this context the spread of socialist democratic idea (left-wing politics), the nationalism and populism against hyper globalization are going to be intensified.*

*There are coming changes in relation between USA and its close allies. The controversies between USA and China are in center. The way of living of humanity will be changed fundamentally. And the results of USA presidential elections are seems to change things in large.*

**Keywords:** *coronavirus, pandemic, shape of the new world order, international relations, all mankind, great power, herd immunity, quarantine, lockdown, isolation, emergency, vaccine, etc.,*

2019 оны 12 дугаар сарын эхээр Хятадын Хубэй мужийн төв Ухань хотод эхэлсэн коронавирусууд гаралтай амьсгалын замын хам шинж өвчний дэгдэлт дэлхий

нийтийг хамарсан цар тахлын хэмжээнд хүрч, халдвар авсан хүний тоо аль хэдийн 37.4 саяын босгыг давж, нэгдүгээр сарын 22-нд 17 хүн нас барж байсан бол түүнээс

хойш есөн сарын хугацаанд 1.077,459 хүн амь насаа алдаж<sup>1</sup> зөвхөн наймдугаар сарын 5-ны байдлаар Reuters агентлагийн мэдээгээр 15 секундэд 1 хүн нас барж,<sup>2</sup> хүн төрөлхтөн асар өндөр үнэ төлж байна.<sup>3</sup> Энэ тоо цаашид тасралтгүй, гэхдээ хурдацтай нэмэгдэх нь тодорхой болов. Гэхдээ 28.1 сая хүн эмчлүүлж эдгээрэд байгаа юм.<sup>4</sup> Дэлхийн 214 улс орон (НҮБ-ын гишүүн 193 улсын 189, ажиглагч Гэгээн ширээт улс, Палестинд бүртгэгдэж, одоогоор Хойд Солонгос баталгаажуулаагүй тохиолдолтой, Туркменистан, Өмнөд Номхон далайн арлын 2 улс албан ёсоор бүртгэгдээгүй байна), нутаг дэвсгэрийг хамарч, дэлхийн нийт хүн амын талаас илүү хувь нь хөл хорионы дэглэмд орсон билээ. *Коронавирусын анхны тохиолдол Хятадад нэгдүгээр сард бүртгэгдсэнээс хойш гурван сарын хугацаанд нийт халдвар авагсдын тоо нэг саяд хүрч байжээ.* Харин 2020 оны долоодугаар сарын 13-нд нийт халдвар авсан хүний тоо 13 саяд хүрч

<sup>1</sup> <https://www.worldometers.info/coronavirus/> October 11, 2020

<sup>2</sup> COVID-19 deaths: 1 person dies every 15 seconds globally; death toll crosses 7-lakh mark. <https://www.financialexpress.com/lifestyle/health/covid-19-deaths-1-person-dies-every-15-seconds-globally-death-toll-crosses-7-lakh-mark/2045327/>

<https://www.worldometers.info/coronavirus/> August 23, 2020

<sup>3</sup> 2019.12.31-нд Ухань хотын Эрүүл мэндийн зөвлөл цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд зарлав. 2020.01.05-нд ДЭМБ-аас гишүүн орнуудад болон олон нийтэд хандаж анхны мэдээллийг гаргав. 2020.01.08-нд Wall Street сэтгүүлд шинэ коронавирусын халдварын талаар нийтлэв. 2020.01.13-нд Тайланд улсын ЭМЯ-ны холбогдох албан тушаалтнууд хэвлэлийн бага хурал хийж Ухань хотоос ирсэн хүнд шинэ коронавирусын халдвар илэрсэн болохыг мэдээлсэн. 2020.01.20-нд Хятадын эрх баригчид халдвар хүнээс хүнд дамжиж байгааг мэдэгдэв. 2020.01.23-нд Ухань хотод онц байдал зарлаж, нисэх онгоц, төмөр зам, авто замын орох, гарах бүх гарцыг хаав. ДЭМБ 2020 оны гуравдугаар сарын 11-нд 128 улсад бүртгэгдсэний дараа pandemic буюу цар тахал гэж зарлав. Монгол Улс 3 дугаар сарын 10-нд 120 дахь улс болж бүртгэгдэв.

<sup>4</sup> <https://www.worldometers.info/coronavirus/> October 11, 2020

*байсан бол ердөө дөрөв хоногийн дотор нэг саяар нэмэгдэж 14 саяд хүрсэн байна.*<sup>5</sup> Энэ статистик буурахгүй, харин ч цаашдаа үргэлжилсээр байна.

*ДЭМБ коронавирус хүнээс хүнд халдаж буйг баталсны дараа 2020 оны нэгдүгээр сарын 30-нд онц байдал зарлаж, гуравдугаар сарын 11-нд COVID-19-ыг pandemic буюу цар тахал хэмээн зарласан юм.*

ДЭМБ COVID-19 цар тахал хэмээх нүдэнд үл үзэгдэгч дайсантай дайн зарласан боловч энэхүү өвчний дэгдэлт хэзээ нэг мөр зогсох тухайд тоймтой хариулж чадахгүй байна. Түүгээр ч зогсохгүй коронавирусын хоёр дахь, гурав дахь давалгаа эхэлсэн байж болзошгүй ба ДОХ, улаан бурхан (measles) шиг хэзээ ч устахгүй байж магадгүй, цаашлаад энэ вирус endemic (улирлын шинж төлөв) төлөвт шилжих боломжтой тухай мэдэгдэх болов. Хүн төрөлхтөн дижитал оюун ухаанд суурилсан аж үйлдвэрийн IV хувьсгалд алхаж орсон боловч, коронавирусын өмнө хүчин мөхөстсөөр байна. 2020 оны нэгдүгээр сарын 12-нд коронавирусын генийн дарааллыг уншиж тайлсан боловч эмчилгээний найдвартай вакцин гарган авч хэрэглээнд оруулах хүртэл доод тал нь нэг жилээс наашгүй гэж үзэж буй ажээ. Нөгөө талд коронавирус мутацид орж генийн дараалал нь өөрчлөгдөх, энэ нь өндөр магадлалтай байгаа нь вакцин гарган авах ажилд хүндрэл учруулахаар байна.

Сүүлийн үед коронавирус мутацид орж, улам аюултай болсон тохиолдол хэд хэдэн оронд бүртгэгдэж энэ нь хүмүүсийн санааг ихээр зовоож, айдас түгшүүрт автуулж байгаа ч зарим эрдэмтдийн үзэж буйгаар коронавирус илүү халдвартай болсноор үхлийн аюул нь багасч магадгүй байгаа ажээ. Коронавирус эрчимтэй хувьсах нь магадгүй сайн зүйл хэмээн Сингапурын Үндэсний их сургуулийн ахлах зөвлөх эрдэмтэн, олон улсын халдварт өвчний

<sup>5</sup> <https://www.worldometers.info/coronavirus/> July 17, 2020

нийгэмлэгийн ерөнхийлөгчөөр сонгогдсон Пол Тамбья (Paul Tambyah) хэлжээ. Тэрбээр вирусүүд байгалийн жамаар хувьсахдаа аль болох удаан амьд байхын тулд хор хөнөөл нь улам багассаар байдаг хэмээн онцолж, учир нь вирус тээгчээ түргэн устгачихвал өөрөө ч төд удалгүй үхдэг гэжээ. “Вирус бол аль болох илүү олон хүн, амьтанд халдварлах зорилготой болохоос биш амь насыг нь хөнөөхдөө гол нь биш юм. Учир нь вирус өөрийн тээгчээ хоргодож байр, хүнсний эх үүсвэр болгон ашигладаг” хэмээн Тамбья тайлбарласан байна.<sup>6</sup>

Улс орнуудад сүргийн дархлаа (herd immunity) тогтоох оролдлого бүтэл муутай байгаа ажээ. “COVID-19” цар тахал хэзээ зогсохыг тодорхой хэлж мэдэхгүй ч хүн төрөлхтөн энэ өвчнийг хоёр жилийн дотор хяналтдаа авч чадна гэж ДЭМБ-ын тэргүүн мэдэгдэв.<sup>7</sup>

Германы Макс Планкын Хүрээлэн, Францын Пастьор (Pasteur) Хүрээлэнгийн эрдэмтдийн хамтарсан судалгааны үр дүнд ханиад томуу нь коронавирусны тархалтыг хамгийн багадаа хоёр дахин нэмэгдүүлдгийг тогтоожээ. Эрдэмтдийн судалгааны тайлан 2020 оны есдүгээр сарын 10-ны Лхагва гаригт анагаах ухааны medrxiv.org цахим хуудсанд нийтлэгдсэн байна.<sup>8</sup> Өнгөрсөн 8 дугаар сард АНУ-ын халдварт өвчин судлалын гол мэргэжилтэн, доктор Энтони Фаучи (Anthony Fauci) Америкийн Анагаах ухааны нийгэмлэгийн сэтгүүл JAMA-д

<sup>6</sup> Infectious COVID-19 mutation may be ‘a good thing’, says Paul Tambyah. 18 Aug 2020

<https://www.channelnewsasia.com/news/singapore/infectious-covid-19-mutation-may-be-good-thing-paul-tambyah-13030116>

<sup>7</sup> Coronavirus pandemic could be over within two years-WHO head. <https://www.businessinsider.com/coronavirus-pandemic-could-be-over-within-two-years-who-director-2020-8-22>

<sup>8</sup> Stephen Chen. Coronavirus: scientists find collision of pandemic and flu doubles Covid-19 transmission. 11 Sept. 2020. <https://www.scmp.com/news/china/science/article/3101048/coronavirus-scientists-find-collision-pandemic-and-flu-doubles>

ярилцлага өгөхдөө: “Энэ намар юу болохыг хэн ч хэлж мэдэхгүй байна” гэж байжээ.<sup>9</sup> Хамгийн сэтгэл түгшээж буй асуудал нь ирэх өвлийн шинэ дэгдэлт ажгуу.

Харин Канадын эмч нар шинэ төрлийн коронавирусны эсрэг биетүүд халдвар аваад эдгэрсэн хүмүүсийн цус, биеэс эдгэрснээс нь хойш гурван сар орчмын дараа алга болж эхэлдэг болохыг тогтоожээ. Тэдний ажиглалтын үр дүнг “Blood” шинжлэх ухааны сэтгүүлд нийтэлсэн байна.<sup>10</sup>

Хүн ам олноороо вакцинжуулалтад хамрагдсанаар бус, харин вирустэй зохицон амьдарч сурснаараа бид коронавирусыг ялна гэж ДЭМБ-ын Европын бүсийн товчооны захирал доктор Ханс Клюге (Hans Kluge) мэдэгджээ.<sup>11</sup>

Харин коронавирусын эсрэг вакцин гаргаж авах асуудал их гүрнүүдийн геополитикийн сөргөлдөөн болж хувирав. Хамгийн гол нь вакциныг дэлхий нийтийн хэмжээнд тэгш, хүртээмжтэй хуваарилах тухай асуудал нэн чухал болов.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антони Гутерреш коронавирусны цар тахал дэлхийн II дайнаас хойш хүн төрөлхтөнд тохиолдсон хамгийн том хямрал боллоо гэж хэдийн дүгнэсэн билээ. 2020 оны гуравдугаар сарын 27-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблей 188 орны санаачилгаар “*Коронавирусын цар тахлын эсрэг тэмцэлд даян дэлхийн эв нэгдлийг бэхжүүлэхийн төлөө*” А74/L52 тоот тогтоолын төслийг

<sup>9</sup> Ibid,

<sup>10</sup> Coronavirus antibodies may disappear 2 to 3 months after people recover. 10.02.2020

<https://www.businessinsider.in/science/news/coronavirus-antibodies-may-disappear-2-to-3-months-after-people-recover-a-new-study-found/articleshow/76454989.cms>

<sup>11</sup> Europe can live with COVID-19 with local lockdowns: WHO regional director. Sept. 1, 2020

<https://www.reuters.com/article/us-health-coronavirus-who-sky/europe-can-live-with-covid-19-with-local-lockdowns-who-regional-director-idUSKBN25S43U>

батлав.<sup>12</sup> Түүнд: Мянганы хөгжлийн зорилгод төсөөлж байгаагүй сорилт тулгарч байна. Ялгаварлан гадуурхах үзлийг таягдан хаях, шинжлэх ухааны мэдлэгээ харилцан хуваалцах, олон талт хамтын ажиллагааг шинэчлэх, галын шугам дээр ажиллаж буй эмнэлгийн болон онцгой байдлын ажилчдын хөдөлмөрийг үнэлэх, ДЭМБ-ыг чадавхжуулах, хэзээ, хэзээнээс илүү эв нэгдэлтэй байхын чухлыг тэмдэглэв.

COVID-19 цар тахал бол НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хэлэлцэх асуудал биш хэмээн маргалдсаны эцэст 2020 оны дөрөвдүгээр сарын 9-нд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийг даргалж буй Доминиканы Бүгд Найрамдах Улсын байнгын төлөөлөгч элчин сайд Жозе Сингер (Jose Singer)-ийн саналаар Аюулгүйн Зөвлөлийн видео бага хурлыг зохион байгуулж “Impact of Covid 19 on the issues that fall under the Council’s mandate” болон Ерөнхий нарийн бичгийн дарга Антони Гутеррешийн илгээлтийг хэлэлцсэн юм.<sup>13</sup>

ДЭМБ-ын Ерөнхий захирал Тедрос Аданом Гебрейесус улс гүрнүүд эв нэгдлээ бэхжүүлэх, асуудлыг улс төржүүлэхгүй байхыг уриалж, хөл хорионы арга хэмжээнүүдээ эрт цуцалбал халдвар асар хурдан нэмэгдэж болзошгүйг анхааруулав. Харин Дональд Трамп ДЭМБ-ыг дан ганц Хятадын талд үйлчилсэнд буруутган, коронавирусны цар тахлын талаар үнэн зөв мэдээллээр хангаж чадаагүй хэмээн хурцаар шүүмжилж, Тедрос А.Гебрейесусийг огцрохыг шаардаж, 30 хоногийн ultimatum тулгаж, тус байгууллагаас харилцаагаа тасалж, түр зогсоогоод байсан санхүүжилтээ дэлхий нийтийн эрүүл мэндийн бусад асуудалд зарцуулахаа мэдэгдэв. Мөн АНУ-

<sup>12</sup> 74/270. Resolution adopted by the General Assembly on 2 April 2020. Global solidarity to fight the coronavirus disease 2019 (COVID-19) <https://undocs.org/en/A/RES/74/270>

<sup>13</sup> UN Security Council Press Elements on COVID-19. 09.04.2020. <https://new-york-un.diplo.de/un-en/news-corner/200409-uncs-covid19/2332088>

ын зарим улс төрчид ийм алхам нь ДЭМБ-д Хятад улсын нөлөөг улам нэмэгдүүлнэ гэж болгоомжилж байгаа билээ. “Хэрвээ Хятадын нөлөө ДЭМБ-д өндөр байна гэж үзэж байгаа бол ДЭМБ-ыг Хятадын гарт бүрэн оруулах алхам хийх ёсгүй юм” гэж Сенатын Гадаад бодлогын байнгын хорооны гишүүн, Ардчилсан Намын улс төрч Крис Мурфи мэдэгджээ.

АНУ-ын засаг захиргаа ДЭМБ-д жил бүр 400 сая ам.долларыг төлдөг нь тус байгууллагын төсвийн 14 орчим хувийг бүрдүүлдэг байна.

ДЭМБ-ын тэргүүн доктор Тедрос А. Гебрейесус: “Найзууд минь, алдаа гаргах хэрэггүй. Бидэнд тулгараад байгаа хамгийн том асуудал коронавирус биш юм байна. Бидний гол асуудал бол муу удирдлага, нэгдэж чаддаггүй байдал юм. Өвчнөөс болж хоорондоо хагаралдах, олон хүний амь насыг аварч чадахгүй байх нь эмгэнэл. Бид тархай бутархай байдалтайгаар энэ тахлыг дарж чадахгүй” хэмээн Женевт хийсэн мэдээлэлдээ дурджээ.<sup>14</sup>

Доктор.Тедрос А. Гебрейесус Вашингтонд төвтэй Аспен институтын Аюулгүй байдлын цахим форумд оролцож үг хэлэхдээ дэлхий нийтээрээ вакцинд бүрэн хамрагдсан тохиолдолд л эдийн засгийн сэргэлт бүрэн утгаараа хэрэгжихийг анхааруулсан байна.<sup>15</sup>

Тийнхүү харилцан хамааралтай дэлхий нийтийн хэмжээнд бүх хөдөлгөөн зогсонги байдалд, зарим салбар тэг зогсолт хийв. Хэвийн явагдаж байсан 87.2 их наяд

<sup>14</sup> WHO chief blasts ‘lack of leadership’ and calls for global unity as coronavirus cases mount worldwide. July 10, 2020, <https://edition.cnn.com/2020/07/10/world/who-tedros-adhanom-unity-plea-intl-scli/index.html>

<sup>15</sup> World Health Organization Director-General & Other WHO Leaders Will Address Aspen Security Forum

*WHO experts will discuss global response to the COVID-19 pandemic* August 3, 2020

<https://www.aspeninstitute.org/news/press-release/who-aspen-security-forum/>

ам.доллараар үнэлэгдэх дэлхийн ДНБ<sup>16</sup> огцом унаж, эхний ээлжид 5 их наяд ам.долларын хохирол учрах төлөвтэй байгааг Bloomberg L.P өнгөрсөн дөрөвдүгээр сарын эхээр мэдээлж байсан бол нэг сар хагасын дараа АХБ-ны урьдчилсан дүгнэлтээр 9 их наяд ам.долларын хохирол үзүүлэхээр байгаа ажээ. Энэ бол зөвхөн оны эхний хагасын дэлхийн эдийн засгийн хохирлын тойм үзүүлэлт ажгуу. Газрын тосны брент маркийн нэг баррелийн үнэ огцом унаж 30 ам.доллараас доош орж, эргээд 40 ам.доллар орчимд хэлбэлзэж байна. Унц алтны үнэ өсч 2000 ам.долларыг давсан ч, ойрмогхон яльгүй буурч, аялал жуулчлал, агаарын тээвэр ноцтой сорилттой тулгарав. Зөвхөн сүүлийн 6 сарын хугацаанд аялал жуулчлалын салбар 460 тэрбум ам.долларын алдагдал хүлээснийг НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллага мэдэгдэв.<sup>17</sup> Үүнийг 2009 оны дэлхийн эдийн засгийн хямралын үеийн нөхцөл байдалтай харьцуулахад 5 дахин илүү үзүүлэлт юм” хэмээн мэдэгдэл дурджээ.<sup>18</sup>

Энэ бол глобал эдийн засгийн хямрал биш юм. Харин жамаараа явж байсан дэлхийн эдийн засаг коронавирусны улмаас огцом уналтад орсон хэрэг байв.

Мөн энэ бол *force majeure* буюу “давагдашгүй хүчин зүйл” ч биш юм. Учир нь “давагдашгүй хүчин зүйл”-ийн үед импортлогч, эсвэл экспортлогч талын аль нэг нь эрсдэл хүлээдэг бол коронавирусны үед импортлогч, экспортлогчийн аль аль тал нь эрсдэл хүлээж байгаад оршино.

ОУВС-гийн гүйцэтгэх захирал Кристалина Георгиева 1930 оны их хямралаас хойших хамгийн том хямралтай нүүр тулж байна, цар тахал зогсоход дэлхийн 7,8 тэрбум хүн амын тэн хагас

<sup>16</sup> 2019 Global GDP. IMF. <https://www.worldometers.info/gdp/>

<sup>17</sup> Tourism industry loses \$460 billion in six months. [https://www3.nhk.or.jp/nhkworld/en/news/20200916\\_25/](https://www3.nhk.or.jp/nhkworld/en/news/20200916_25/)

<sup>18</sup> Ibid,

нь ядуу ангилалд орсон байх магадлалтай гэдгийг анхааруулж, доройтсон эдийн засгийг сэргээхэд олон жил шаардагдахаар байна гэж өнгөрсөн дөрөвдүгээр сард мэдэгдэж байв.

НҮБ-ын дөрөвдүгээр сарын эхээр гаргасан судалгааны тайланд дурдсанаар дэлхийн нийт ажиллах хүч болох 3,3 тэрбум хүний 81 хувь нь коронавирусны дэгдэлтээс болж ажлын байраа бүрэн болон хэсэгчлэн алдах эрсдэлтэй тулгарч байна. АНУ-д л гэхэд есдүгээр сарын 1-ний байдлаар бараг 80 сая хүн ажилгүй болсны улмаас мөнгөн тэтгэмж авахаар бүртгүүлсэн байна. Covid-19 цар тахал дэлхийн хөрөнгийн зах зээлд учруулсан хохирлын улмаас нийт 267 хүн тэрбумтны жагсаалтаас хасагдсан тухай Форбс сэтгүүлийн 2020 оны дөрөвдүгээр сарын эхээр гаргасан тайланд тэмдэглэжээ.

АНУ-д халдвар авсан хүний тоо 7.9 саяыг хэдийн өнгөрч, хүн амын 52 хувь буюу 200 сая хүн гэрийн хорионд орж байсан хэдий боловч, нас барсан хүний тоо 219.2 мянгыг давлаа.<sup>19</sup> Зөвхөн Нью-Йорк муж улсын халдварын тоо Өрнөд Европын орнуудыг нийлүүлснээс давж гарав.

АНУ-д коронавирусын халдварын улмаас нас барсан хүний тоо АНУ-Вьетнамын дайны үеэр амь үрэгдсэн америк цэргүүдийн тоог давсныг Жонс Хопкинсийн нэрэмжит их сургуулийн тоон үзүүлэлтүүд харуулжээ. АНУ-д халдвараар нас барсан хүний тоо Вьетнамын дайны үед амь үрэгдсэн цэргүүдийн тоог 2020 оны дөрөвдүгээр сарын 30-ны байдлаар гурав хүрэхгүй сарын хугацаанд давсан нь энэ юм.<sup>20</sup> 1955-1975 он хүртэл 20 жил үргэлжилсэн Вьетнамын дайнд Америкийн 58,209 цэрэг амь үрэгджээ. Жонс Хопкинсийн нэрэмжит их сургуулийн

<sup>19</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/us/> October 11, 2020

<sup>20</sup> Coronavirus: COVID-19 has killed more Americans than the Vietnam War. <https://www.euronews.com/2020/04/29/covid-19-kills-more-americans-than-the-vietnam-war>

мэдээллээр АНУ-д халдварын улмаас нас барсан хүний тоо 82 өдрийн дотор 58,365-д хүрчээ. Тэгвэл тавдугаар сарын 15-ны байдлаар АНУ-д COVID-19 цар тахлаар нас барсан хүний тоо Сувдан эрэг, Солонгос, Вьетнам, Персийн булан, 2001/9/11-ний халдлага, Афганистан, Иракийн дайнд амь үрэгдсэн цэргийн нийлбэрээс давсан байна.<sup>21</sup>

Тус улсад халдвараар нас барсан анхны тохиолдол 2020 оны хоёрдугаар сарын 6-нд бүртгэгдсэн юм. АНУ-д халдварын анхны тохиолдол өнгөрсөн нэгдүгээр сарын 21-нд илэрсэн бөгөөд түүнээс хойш 99 хоногийн дараа халдвар авсан хүний тоо нэг саяд хүрсэн байна. Харин халдварын тохиолдлын тоо 2 саяд хүрэхэд 43-хан хоног зарцуулагджээ. Түүнээс хойш 28 хоногийн дараа буюу долоодугаар сарын 8-нд халдварын 3 сая дахь тохиолдол бүртгэгдсэн бол хоёр долоо хоногийн дотор буюу долоодугаар сарын 23-ны байдлаар халдвар авсан хүний тоо 4.1 саяд хүрч байлаа.<sup>22</sup>

АНУ-ын Конгресс онцгой нөхцөл байдлын энэ үед эдийн засгийг дэмжих, иргэдийг орлогыг хадгалах үүднээс Bretton Woods-ийн систем тогтносноос хойш анх удаа 2 их наяд ам. долларын санхүүжилт баталсан нь ОХУ-ын нэг жилийн ДНБ-ээс давсан үзүүлэлт байв.

Дональд Трампын Засаг захиргаа агшсан эдийн засгаа яаралтай сэргээхээр хүчлэн зүтгэж, халдварын тархалт, нас баралт тууштай буураагүй байхад хорио цээрийн дэглэмийг аажмаар сулруулж эхэлсэн нь асуудалтай дахин тулгарч байна. Конгрессын Төлөөлөгчдийн танхим

<sup>21</sup> The coronavirus has now killed more Americans than the Vietnam War Gulf War Afghanistan War and Iraq War combined. 2020.05.15. <https://fortune.com/2020/05/15/coronavirus-deaths-us-covid-19-death-rate-covid-19-more-than-korean-vietnam-gulf-afghanistan-iraq-wars-combined/>

<sup>22</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/us/> July 23, 2020

дахин эдийн засгийг дэмжих 3 их наяд ам.долларын нэмэлт санхүүжилтийн багцыг Сенатын танхимд санал болгов.

“Бид дэлхий даяар вакцины тусламж үзүүлнэ гэж найдаж байна» хэмээн Америкийн удирдагч хэлсэн байна. Оксфордын их сургуулийн эрдэмтэдтэй хамтран вакцин боловсруулж буй Их Британи-Шведийн эмийн үйлдвэрийн “AstraZeneca” компанид АНУ-ын эрх баригчид 1.2 тэрбум ам.доллар олгожээ. Үүнээс гадна, Америкийн биотехнологийн “Moderna” компанид 486 сая ам.доллар, “Johnson & Johnson” компанид 456 сая ам.доллар хуваарилсан байна. АНУ-д мөн “Merck” болон “Pfizer” компаниуд коронавирусын вакциныг бүтээж байгаа юм. Вашингтоны засаг захиргаа эдгээр төсөлд нийтдээ 12 тэрбум ам.долларын хөрөнгө оруулсан гэж Цагаан ордноос мэдээлжээ.<sup>23</sup>

“Америк нэгдүгээрт” лоозон ганхаж, Хятад мөрөөдөл, БНХАУ-ын үсрэнгүй хөгжлийн тухай үзэл баримтлалд ч засвар оруулах шаардлагатай болов. COVID-19 цар тахал Дональд Трампын байр суурийг сулруулж, 2020 оны ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнд ноцтой нөлөөлөхөөр байна.

2020 оны тавдугаар сарын 22-нд ажлаа эхэлсэн Бүх Хятадын Ардын төлөөлөгчдийн их хурлын 13 дахь удаагийн сонгуулийн III чуулганд тавьсан Засгийн газрын илтгэлд коронавирусууд шалтгаалан эдийн засаг 2020 оны эхний улиралд 6,8 хувиар агшсанаас шалтгаалан энэ онд ДНБ-ий өсөлтийн зорилт дэвшүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн байна.<sup>24</sup>

<sup>23</sup> <https://www.hhs.gov/about/news/2020/09/16/trump-administration-releases-covid-19-vaccine-distribution-strategy.html>

<sup>24</sup> China decides not to set a GDP target for 2020 as coronavirus batters the economy.

<https://www.cnn.com/2020/05/22/china-will-not-set-gdp-target-for-2020-as-coronavirus-batters-economy.html>

ОХУ-ын Төрийн Думын депутат, Олон улсын асуудал эрхэлсэн хорооны орлогч дарга Наталья В.Поклонская “БНХАУ эдийн засаг, технологийн хувьд асар хурдтай хөгжиж байгаа нь дэлхийд ноёрхох сонирхолтой нэгэнд нь таалагдаагүй байх магадлалтай...үхлийн аюулт коронавирус нь Хятадын эсрэг хэрэглэж буй биологийн зэвсэг байж магад...Өнгөт хувьсгалын боловсруулсан стандартаар нийтийг хамарсан эмх замбараагүй байдал зохион байгуулж байсан... Энэ зүгээр санамсаргүй нөхцөл байдал уу? Миний бодлоор дэлхийн хүчирхэг хэсгээс хэтэрхий их тоглоом хийж байна”<sup>25</sup> хэмээн 2020 оны нэгдүгээр сарын сүүлчээр АНУ-ыг битүүхнээр буруушаан мэдэгдэж байсан юм. Түүнчлэн НҮБ-ын Биологийн зэвсгийн комиссын гишүүн асан Игорь Никулин “2019-нCoV” шинэ төрлийн коронавирус нь Америкийн эрдэмтдийн “бүтээл” бөгөөд Хятадуудын эсрэг биологийн зэвсэг юм” гэж хэлснийг Ura.ru цахим хуудаст нэгдүгээр сарын төгсгөлөөр мэдээлж байв.<sup>26</sup>

Гэтэл хойд хөрш ОХУ коронавирусын цар тахлын халдвараар дэлхийд АНУ, Энэтхэг, Бразилын дараа дөрөвт эрэмбэлэгдэж, Оросын бүх 85 бүгд найрамдах улс, муж, тойрогт бүртгэгдсэн халдвар 1.2 саяыг хэдийн өнгөрч, 22.4 мянган хүн нас бараад байгаа юм.<sup>27</sup>

Энэтхэгт халдварын тоо 7.0 саяд хүрч, Бразилын өмнө хэдийн гарч, нас барагсдын тоо 108.3 мянгаар хэмжигдэж байна.<sup>28</sup> Бразилд коронавирусээр халдварласан

<sup>25</sup> Поклонская раскрыла происхождение китайского коронавируса. 25.01.2020

<https://www.mk.ru/politics/2020/01/25/poklonskaya-raskryla-proiskhozhdenie-kitayskogo-koronavirusa.html>

<sup>26</sup> Новый коронавирус “сбежал” из лаборатории? В России разработана секретная программа. 27 января 2020. <https://www.vshouz.ru/news/analitika/7937/>

<sup>27</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/russia/> October 11, 2020

<sup>28</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/russia/> October 11, 2020

иргэдийн тоо, нас барагсдын тоо хурдтай өссөөр нийт тохиолдол 5.0 сая, нас барагсдын тоо 150.2 мянга давлаа. Энэ ноцтой мэдээлэл Бразилд анхны иргэн нас барснаас зургаан сарын хугацаанд бүртгэгдсэн тоо болж байна.<sup>29</sup>

АНУ, Бразилын удирдагчид коронавирусын цар тахлыг “хамрын ханиад” хэмээн басамжилж, амны хаалтад төдийлөн ач холбогдол өгөөгүй юм. Ер нь Өрнөдөд амны хаалтыг зөвхөн өвчтэй хүн зүүх ёстой гэсэн тэс өмнөө ойлголттой байсан нь халдварын даамжралтад голлон нөлөөлжээ. Тэгвэл Дональд Трамп, тэргүүн хадагтай нар коронавирусын халдвар авсан тул АНУ-ын БХЯ-ны харьяа Walter Reed Эрүүл мэндийн Төвд хэвтүүлсэн тухай Цагаан ордон мэдээлжээ. “Болзошгүй эрсдэлээс сэргийлэх үүднээс эмч мэргэжилтнүүдийн зөвлөсний дагуу ерөнхийлөгч ойрын өдрүүдэд Уолтер Рид эмнэлгийн өрөөнөөс ажлаа явуулах болно” гэж Цагаан ордны мэдэгдэлд өгүүлсэн байна.

Тийнхүү өнөөгийн дэлхийн дэг журмын дүр төрх өөрчлөгдөж, гүн гүнзгий хямралд орлоо. АНУ-ын нэрт олон улсын харилцаа судлаач 97 настай Хенри Киссинжер Wall Street Journal-д нийтлүүлсэн өгүүлэлдээ: “Нэгэнт тогтсон дэлхийн дэг журамд эргэлт буцалтгүй өөрчлөлт орж байна”<sup>30</sup> гэжээ.

Хамгийн хүчирхэг батлан хамгаалах хүчин чадавхтай улс гүрэн ч өөрийнхөө аюулгүй байдлыг дангаараа хангах боломжгүйг 2001 оны есдүгээр сарын 11-ний террорист халдлага харуулсан бөгөөд тийнхүү АНУ-ын тэргүүлэх оройлолтой олон улсын харилцааны нэг туйлт (unipolarity) дэг журам төгсгөл болох үе шат эхэлсэн тухай судлаачид тэмдэглэж

<sup>29</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/russia/> October 11, 2020

<sup>30</sup> Henry A.Kissinger. “The Coronavirus Pandemic Will Forever Alter the World Order” April 3, 2020 Wall Street Journal. <https://www.wsj.com/articles/the-coronavirus-pandemic-will-forever-alter-the-world-order-11585953005>

эхэлсэн хийгээд хамгийн хүчирхэг эдийн засгийн чадавхтай улс гүрэн ч өөрийн хөгжил дэвшлийг дангаар хөглөн авч явах бололцоогүйг моргейжийн зээлээс үүдэлтэй 2008 оны дэлхийн санхүү-эдийн засгийн хямрал харуулж, дурдсан асуудлыг хэлэлцэхээр 2009 онд 20-ийн бүлгийн анхны дээд түвшний уулзалт Вашингтон хотноо зохион байгуулагдаж байсан юм.

Их 20-ийн бүлгийн дээд түвшний ээлжит бус уулзалт өнгөрсөн гуравдугаар сард Саудын Арабын Рияд хотоос анх удаа цахимаар явагдав. Вашингтоны ойролцоо орших Мэриленд дэх Кэмп Дэвидийн эдлэнд зургаадугаар сард болох байсан Долоогийн бүлгийн саммит, долоодугаар сарын сүүлчээр Санкт-Петербургт зохиогдох байсан ШХАБ, БРИКС-ийн саммит тус тус хойшлогдож, цаашлаад НҮБ-ын Ерөнхий Ассамблейн намрын чуулганд коронавирусын цар тахлаас болж улс орнуудын төр, засгийн тэргүүн нарыг Нью-Йорк хотноо хүлээн авах боломжгүй гэдгийг Ерөнхий Ассамблейн Ерөнхийлөгч Тижжани Мухаммед-Банде (Tijjani Muhammad-Bande) мэдэгдэж,<sup>31</sup> тийнхүү video болон online хэлбэрээр зохион байгуулагдав.

COVID-19 цар тахал ЕХ-ны хувьд маш хүнд тусав. “European Union: Global Security Actor or Paper Tiger?”<sup>32</sup> хэмээх асуудлыг сөхөн тавьж, ЗХУ-ын задралын дараах том сорилт тулгарч байна гэж үзэх болов. Хамгийн сайн эрүүл мэндийн үйлчилгээтэй гэж тооцогдож байсан улс орнуудад нас баралт хэдэн зуугаараа бүртгэгдэв.

2020 оны долоодугаар сарын 21-нд ЕХ өөрийн түүхэнд байгаагүй хамгийн их

<sup>31</sup> World Leaders Won't Gather for the U.N. General Assembly for First Time in Its 75-Year History. June 8, 2020 <https://time.com/5850391/un-general-assembly-first-time-75-years-coronavirus/>

<sup>32</sup> European Union: Global Security Actor or Paper Tiger?

<https://www.worldpoliticsreview.com/articles/5246/european-union-global-security-actor-or-paper-tiger>

хэмжээний зээлийн багцыг батлав. Үүнийг ЕХ-ны Ерөнхийлөгч Шарль Мишель, Европын хувьд маш чухал үйл явдал болов гэж мэдэгдсэн бөгөөд тохиролцооны дагуу цар тахалд хамгийн их нэрвэгдсэн гишүүн орнуудад 390 тэрбум еврогийн тэтгэмжийг олгох агаад үүнд Итали, Испани зэрэг орнууд багтах ажээ. Түүнчлэн 360 тэрбум еврогийн бага хүүтэй зээлийн багцыг гишүүн орнуудад санал болгох ажээ. Дөрвөн өдөр үргэлжилсэн энэхүү дээд түвшний уулзалт нь 2000 онд Францын Ницца хотноо болсон таван өдрийн уулзалтаас хойших хамгийн удаан өрнөсөн уулзалт болжээ.<sup>33</sup>

Хүмүүс албан томилолт, амралт зугаалгаар зорчихоо больж, 14 их наяд еврогийн багтаамжтай (АНУ-ын дараа орох) ЕХ-ны эдийн засаг энэ онд 8 хувиар агшиж, 1 их наяд еврогийн алдагдалд оржээ. 2-6 дугаар сар хүртэл үргэлжилсэн цар тахлын эхний давалгааны үед үйлчилгээний салбарын орлого 16,4 хувиар буурсан бол аялал жуулчлалын салбар шууд 75 хувиар унажээ. Харин зуны дунд сарын дундуур зоогийн газруудын үйл ажиллагаа бага зэрэг идэвхэжсэн боловч эргэлт нь ердөө 50 хувиар л сэргэжээ. Агаарын тээврийн салбар ба зочид буудлууд гүнзгий хямралд орж, орлого нь ковидын өмнөх үеэс 70 хувиар буурсан байна.<sup>34</sup>

Эрүүл мэндийн салбар, иргэд, бизнес эрхлэгчид бүгд “коронавирустэй цуг амьдрахад” аажмаар дасан зохицож, амны хаалтаа зүүж, хоорондын зайгаа барьж, гэрээсээ ажлаа хийцгээж байна. “Хөл хорио нь маш их сөрөг нөлөөтэй учраас улс орны амьдралыг зогсоох эрх бидэнд байхгүй, тэгээд ч нийгэмд учрах эрсдэлийг 0 болгоно гэдэг бол боломжгүй зүйл” гэж Э.Макрон Paris Match сэтгүүлд ярилцлага өгөхдөө

<sup>33</sup> EU summit: Leaders reach landmark €1.82 trillion COVID-19 recovery deal and budget

<https://www.euronews.com/2020/07/21/eu-summit-deadlock-see-talks-stretch-into-sunday>

<sup>34</sup> CNN International. Sept. 9, 2020



хэлсэн байна.<sup>35</sup>

Цар тахлын дараа анх удаагаа авч хэрэгжүүлж буй хорио цээр (quarantine), хөл хорио (lockdown), тусгаарлалт (isolation), өндөржүүлсэн бэлэн байдал (heightened state of readiness), хилээ хаах, онц байдал зарлах (emergency) зэрэг дэлхий нийтийг хамарсан арга хэмжээнүүд нийт хүн төрөлхтний хамтын үнэт зүйлс болсон ардчилал, хүний эрх, эрх чөлөө, зах зээлийн эдийн засгийн харилцаанд ноцтой аюул учруулж эхлэв.

Үйл явдлын сорилт боловсролын салбарын чанарыг шалгаж, улс гүрнүүд технологид суурилсан боловсролыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч байгаа ч явц тийм ч таатай биш байна.

**Hyber-globalization** түүний илрэл эдийн засаг, соёл, улс төрийн даяаршлаас татгалзах тухай онцлох болов. Хорио цээрийн дэглэмийн улмаас хүмүүс анх удаагаа гэр бүлээрээ удаан хугацаанд нэг дор байх боломжтой болсон байна. Консерватив, неолиберализм болон бусад үеэ өнгөрөөсөн уламжлал, тухайлбал, гар барьж мэндлэх ёсыг мартаж цаашид үүнээс татгалзах тухай мэргэжилтнүүд тэмдэглэх болжээ.

Цар тахал улс орнуудын улс төрийн бодлогыг шалгаж байна. Популист хандлага, үндэсний амиа хичээх үзэл газар авч, эрх мэдэл төвлөрөх хандлага ажиглагдаж байна. Төлөвлөгдөж байсан олон улсын олон арга хэмжээ, зуны XXXII Олимпын тоглолт ч жилээр хойшлогдов. Харин саяхан Олон улсын олимпын хорооны дэд ерөнхийлөгч Жон Коутс (John Coates) мэдэгдэхдээ: “коронавирусын цар тахлын нөхцөл байдал хэрхэхээс үл хамааран Токио-2020 олимпын наадам хугацаандаа болно” гэжээ.<sup>36</sup>

<sup>35</sup> <https://www.parismatch.com/Actu/Politique/Emmanuel-Macron-la-gauche-et-2022-Lionel-Jospin-livres-reflexions-1701137>

<sup>36</sup> Tokyo Olympics ‘will take place with or without COVID,’ senior IOC official says

<https://www.japantimes.co.jp/sports/2020/09/07/olympics/summer-olympics/tokyo-olympics-ioc-john-coates-coronavirus/>

COVID-19 цар тахлын улмаас ӨАБНУ, Тунис, Нигери, Зимбабви, Замби, Кени, Канадын хот, дүүргийн сонгууль, Аргентин, Колумби, Бразил, Боливиын орон нутаг, Чилийн Үндсэн хуулийн санал асуулга, Уругвай, Парагвай, Мексикийн орон нутгийн сонгууль, АНУ-ын 15 муж улсын сонгууль, Энэтхэг, Пакистан, Мальдив, Киргиз, Индонези, Австри, Франц, Чех, Германы Испани, Латви, Их Британи, Серб, Кипр, Румын, Австрали, Соломоны арал, Швейцарийн орон нутгийн, Этиоп, Сири, Шри-Ланка, Хойд Македон, Польшийн парламентын сонгууль, Фолклэнд арлын санал асуулга, Армений Үндсэн хуулийн шүүхийн өөрчлөлтийн санал асуулга, ОХУ-ын Үндсэн хуулийн өөрчлөлтийн асуудлаарх санал асуулга зэрэг томоохон арга хэмжээнүүд тус тус хойшлогдсон юм.

Дэлхийн дэг журам (тогтолцоо) хэмээх категори нь улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцаа, геополитикийн үндсэн ухагдахуунуудын нэг юм. Энэхүү нэр томъёоны гарал үүсэл нь 1776 онд “Тусгаар тогтнолын Тунхаглал”-ыг батлах үеэр хийгдсэн АНУ-ын Төрийн Их тамганы дардас дээр латин хэлээр «ANNUIT COERTIS: NOVUS ORDO SECLORUM» буюу “ЭРИН ҮЕИЙН ШИНЭ ДЭГ ЖУРМЫГ ЗАРЛАН ТУНХАГЛАХ НЬ” гэж бичсэнээс үүдэлтэй. 1935 онд анх гүйлгээнд гарсан АНУ-ын нэг долларын шинэ дэвсгэртний ар талын нүүрэнд дээрх Тамгын дардас хэвлэгдэн гарснаас хойш үргэлжлэн хэвлэгдсээр өнөөг хүрч иржээ.

XX зууны түүхийн огцом өөрчлөлтүүд, түүнтэй гүн гүнзгий холбоотой улс төрийн сэтгэлгээ болон орчин үеийн олон улсын харилцааны онолын хөгжилтэй уялдан “дэлхийн дэг журам” хэмээх нэр томъёо олон улсын харилцааны үзэл баримтлалын шинжтэй цогц ойлголт болон гарч иржээ. Дурдсан ухагдахууны мөн чанар нь эмх замбараагүй, хуваагдмал, олон янз,

[coates-coronavirus/](https://www.japantimes.co.jp/sports/2020/09/07/olympics/summer-olympics/tokyo-olympics-ioc-john-coates-coronavirus/)

үндэсний явцуу үзэл баримтлал, үзэл сурталд суурилсан хуучин олон улсын харилцааг хүний эрх, эрх чөлөө, ардчилал, зах зээлийн эдийн засаг, олон улсын эрхзүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээнд тулгуурлан илүү зохистой засаглалаар илбэн тохинуулах замаар өнөөгийн дэлхий ертөнцийг өөрчлөн байгуулах тухай асуудал юм. Тиймээс дэлхий ертөнц ямар байна гэхээсээ илүүтэй ямар байвал зохистой вэ? гэдэгт илүү анхаарч **“Одоогийн бодит байдал гэдэг нь цорын ганц боломжит байдал биш”** гэж үзэх болжээ.

Эдүгээ **нэгд**, Харилцан шалтгаалцал, даяаршлын үйл явц нийгмийн бүхий л хүрээг хамарч, гадаад, дотоод бодлогын зааг ялгаа багасч, орон зай, орчин маш хурдан өөрчлөгдөж, тиймээс ойрх ирээдүйн төлөв байдлыг ч урьдчилан төсөөлөх боломж тун бүрхэг байгаа нь өнөөгийн олон улсын харилцааны үндсэн шинж болов.

**Хоёрт**, Олон улсын харилцаа, геополитикийн орчинд урьдчилан таамаглаж болохуйц тогтвортой нөхцөл байдлыг урт хугацаанд хадгалах явдал тулгамдсан асуудал болсоор байна.

**Гуравт**, Хүчний тэнцвэрийг барихаас гадна ашиг сонирхлын тэнцвэрийг барих гэдэг маш чухал болов. Тэнцвэрийн хүчийг олно гэдэг нь өөрөө ухаалаг хүч юм.

**Дөрөвт**, Төв рүү тэмүүлэх, төвөөс зугтаах хүчний аль аль нь үйлчилж буй даяаршлын эрин үед олон улсын харилцааны шинэ дэг журам төлөвших үйл явцын төгсгөлийг төсөөлөх боломж тун бүрхэг байгаа зэрэг санал, дүгнэлтүүд юм. Арабын хавар, Сирийн иргэний дайн, ОХУ Крымын хойгийг Киевын оролцоогүй өөртөө нэгтгэсэн үйл явц, үүнээс улбаатай эдийн засгийн хориг, АНУ-ын ерөнхийлөгчийн гадаад, дотоод бодлогын шинэ параметр, Brexit, Европын интеграцийн сорилт, ШХАБ-ын өргөжилт, ЕврАзийн эдийн засгийн холбооны тэлэлт,

Хятад-Америкийн худалдааны дайн, “Нэг бүслүүр, нэг зам” санаачилга, Хойд Солонгос, Ираны цөмийн болон баллистик пуужингийн хөтөлбөр, тэгээд COVID-19 цар тахал үүний тод илрэл юм.

**Тавд**, Хувьсан өөрчлөгдсөөр буй аюул, сорилтод шийдвэртэй, тогтвортой хариу барих арга барилаа олох, өөрчлөлтөд бэлэн байх, дасан зохицох төдийгүй, цохилт даах, хүнд нөхцөл байдлаас нэр төртэй гаргах, шинэчлэл хийх чадавхтай байх явдал шийдвэрлэгч нөлөөтэй.

**Зургаад**, Социализм нуран унаснаас хойш АНУ дэлхий дээр жолоодогчийн үүрэг гүйцэтгэх тухай үзэл санаа бодлогын шинж чанартай болж байгаад ОХУ, лалын ертөнц ихээхэн эгдүүцэж, дээрхийг Хятад зэрэг гүрэн ганцаараа жанжлах гэсэн эрмэлзэл гэж ч шүүмжилж эхэлсэн. Хүйтэн дайнд ялалт байгуулсандаа эрэмшсэн АНУ, түүний холбоотнууд дэлхий дахинд хүний эрх, эрх чөлөө, ардчиллыг сэргээн баталгаажуулах, чөлөөт зах зээлийн эдийн засгийн харилцааг түгээн дэлгэрүүлэх тухай зааж сургаж байв.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин бүр 2014 оны 10 дугаар сард “Дэлхийн дэг тогтолцоо: Шинэ зүй зохицол уу, эсвэл дүрэмгүй тоглоом уу?” сэдвийн дор *зохиогдсон* “Валдай” олон улсын мэтгэлцээний клубын төгсгөлийн хуралдаанд оролцож үг хэлэхдээ: АНУ-ыг хүйтэн дайны дараа дэлхий дахинд тогтсон дэг журмыг эвдсэнд буруутгаж, дэлхий ертөнцийг эмхлэн тохинуулах шинэ тогтолцоог буй болгохгүй бол бүхэлдээ анархи, эмх замбараагүй байдалд орж болзошгүйг сануулж, Орос, АНУ хоёр болсон үйл явдлыг хамтран дүгнэж, томоохон эдийн засагтай бусад оронтой хамтран олон туйлт ертөнцийн үзэл баримтлалын дагуу дэлхийг удирдах нэгдсэн шинэ дэг тогтолцоог цогцлоон бүтээхийг уриалсан юм. Орос-Америкийн харилцаа нь стратегийн тогтвортой байдал, олон улсын аюулгүй байдлын чухал хүчин зүйл хэвээр байна гэж тэрбээр үзэж байсан

билээ.<sup>37</sup>

ОХУ, БНХАУ-аар тэргүүлсэн олон улсын харилцааны олон туйлт төв төлөвших хандлага идэвхэжсэн нь хүйтэн дайн дууссанаас хойш тогтсоор ирсэн олон улсын дэг журам, аюулгүй байдлын системд ноцтой нөлөө үзүүлж эхэлсэн хэмээн судлаачид үзсээр байгаа юм. Дээрхтэй холбоотойгоор хүчний шилжилт хөдөлгөөн эрчимжиж, дахин хуваарилалт явагдаж байна. Тиймээс хүйтэн дайн дууссаны дараах үе төгсгөл болж, шинэ хүйтэн дайны үе эхэллээ хэмээн тэмдэглэж байсан. Тэгвэл дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахлыг дэлхийн III дайнтай зүйрлэх болжээ.

АНУ коронавирусын Ухань дахь Вирус судлалын лабораториос алдсан, тоо баримтыг нуун дарагдуулсан, дэгдэлтийг хяналтандаа барьж чадаагүй дэлхийд тараасан хэмээн Хятадыг буруутгасан бол БНХАУ ДОХ/ХДХВ-ийг дэлхийд тараасан, 2008-2009 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямралд АНУ-ыг буруутгаж эхлэв. Америк-Хятадын худалдааны дайн шинэ үе шатанд шилжиж магадгүй бололтой.

Коронавирусын халдвар анх дэгдсэн Ухань хотын эрх баригчид эхэндээ халдварын тархалтын бодит цар хүрээг нуухыг оролдсон гэж уг вирустэй холбоотой асуудал хариуцсан БНХАУ-ын Засгийн газрын тэргүүлэх зөвлөх доктор Жон Наншань (Dr. Zhong Nanshan) “CNN” телевизэд өгсөн ярилцлагадаа илэн далангүй мэдэгдсэн юм.<sup>38</sup>

Хятадын ШУА-ийн Хубэй мужийн Ухань хот дахь Вирус судлалын хүрээлэнд 2002-2003 онд SARS-ын дэгдэлт гарсны

<sup>37</sup> В.Путин принял участие в итоговой пленарной сессии XI заседания **Международного дискуссионного клуба «Валдай»**. Тема заседания- «Мировой порядок: новые правила или игра без правил?». 24 октября 2014 года. Сочи.

<sup>38</sup> Exclusive: Lack of immunity means China is vulnerable to another wave of coronavirus, top adviser warns. May 17, 2020 <https://edition.cnn.com/2020/05/16/asia/zhong-nanshan-coronavirus-intl-hnk/index.html>

дараа 2015 онд Био аюулгүй байдлын хамгийн өндөр IV түвшний лаборатори (biosafety level 4 (BSL-4) laboratory) байгуулах шийдвэр гарч, 300 сая юань буюу 44 сая ам. долларын санхүүжилтээр Францын Засгийн газрын Лион хот дахь Микробиологийн олон улсын судалгааны төвтэй хамтран ажиллаж эхэлжээ.<sup>39</sup> Цаашлаад тус лаборатори АНУ-ын Техасын их сургуулийн Галвестоны үндэсний лаборатори, Канадын Микробиологийн үндэсний лабораторитой маш нягт хамтран ажилладаг байжээ. Ухань дахь лабораторийг нээгдэх үед олон улсын эрдэмтэд уг байгууллагаас үхлийн вирус “гадагшлах” аюултайг анхааруулж байжээ. Ухань дахь лабораторийн туршилтууд бүтэлгүйтсэн, эсвэл аль нэг ажилтан алдаа гаргаж, аюулт “тахал” тарсан байж магад” гэж өрнөдийн шинжээчид болгоомжлох болжээ.<sup>40</sup>

Үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь тасралтгүй үргэлжлэх үйл явц мөн бөгөөд үүн лүгээ үндэсний аюулгүй байдлын судалгаа, дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ ч тасралтгүй хийгдэж байх учиртай ажгуу. Аюулгүй байдлын онол, үзэл баримтлал, аргазүйд томоохон өөрчлөлт гарч, аюулгүй байдлыг хангах үндсэн үйл ажиллагаа бол аюулгүй байдалд нөлөөлж буй аюулын чиг хандлагын судалгаа, дүн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийгээд төр, иргэн, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа юм. Коронавирусын цар тахал бол уламжлалт бус аюул мөн.

Олон улсын харилцаанд түншлэлийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлж нийт хүн төрөлхтөнд нийтлэг нүүрлэж буй даяар асуудал, аюул, сорилт, өөрчлөлтүүдийг шийдвэрлэх, даван туулахад оролцоогоо илүү идэвхжүүлж, тэнцвэртэй, тогтвортой,

<sup>39</sup> <https://www.nature.com/news/inside-the-chinese-lab-poised-to-study-world-s-most-dangerous-pathogens-1.21487>

<sup>40</sup> <https://news.cgtn.com/news/2020-05-03/U-S-researcher-who-worked-in-Wuhan-lab-calls-COVID-19-leak-unlikely--QbHBgluE5a/index.html>

хүртэмжтэй, нээлттэй, инновацитай, харилцан ашигтай, харилцан суралцахуй чухал болов.

Хүн төрөлхтөн нэг удаа time out авах шаардлагатай болжээ. Зөрчил маргаанаа зогсоож, нүсэр үйлдвэрлэл, хэт хэрэглээгээ бууруулах, эцэс төгсгөлгүй ажлаа түр зогсоож, халуун ам бүлээрээ сууж, хүрээлэн буй байгаль дэлхийгээ ухаарах, үүний тухайд тунгаан бодох боломжийг бид бүхэнд тийнхүү олгож байгаа бололтой. Цар тахал дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлтийн эсрэг байгаль эхийн хариу үйлдэл байж магадгүй гэж үзэх болжээ.

Хүн төрөлхтөн өөрсдөө зохиомлоор буй болгосон асар их ачааллаа хөнгөлж, ажлын дөрвөн өдөрт шилжих, гэр бүл, эрүүл мэнддээ анхаарал тавьж, өөрийгөө хөгжүүлэхэд илүү их цаг зав гаргах шаардлагатай болов.

Хөгжлийн төлөө цэргийн зардлыг үлэмж хэмжээгээр хорогдуулж, чөлөөлөгдсөн их хөрөнгийг боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухаанд зарцуулах, худалдааны дайныг зогсоож, эдийн засгийн хориг арга хэмжээг цуцлах, сайн засаглалыг бэхжүүлэх, амьдралын чанарыг сайжруулах, хувь хүний аюулгүй байдалд онцгой анхаарах хэрэгтэй байна.

Олон улсын харилцааны гол тулгуур аппаратур болсон хүчний тэнцвэрт суурилсан дэлхийн дэг журамд update хийх үндсэн дээр хамтын ажиллагаа, эв нэгдэлд суурилсан илүү аюулгүй дэлхийн шинэ дэг тогтолцоог цогцлоох нь хойшлуулагүй зорилт мөн.

Олон талт хамтын ажиллагаанд шинэчлэл хийх, НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүдийг өргөжүүлэх, ДЭМБ-ын үүрэг, чадавхыг хүчирхэгжүүлэхийн зайлшгүйг болж буй

үйл явдал харуулж байна.

Богино хугацаанд хуримтлагдсан сургамж бол улс гүрнүүд НҮБ-ын “Уур амьсгалын өөрчлөлтийн талаар Парисын суурь хэлэлцээр”-ийг хэрэгжүүлэхэд илүү их хүчин чармайлт гаргаж, хамтран ажиллахыг анхааруулав. Байгаль дэлхий унаган төрхөмдөө бууж, уул ус цэвэршиж, ан амьтад хөдөлгөөнд орж, Энэтхэгт хөл хорио тогтоосны дараа агаарын бохирдол огцом буурч, үүнтэй холбоотойгоор Пенжаб мужийн оршин суугчдад 160 гаруй километрийн тэртээд орших Хималайн нуруу тод харагдаж, Венец хотын онгон төрх эргэн сэргэж эхэлжээ.

COVID-19 цар тахлын дараа дэлхийн шинэ дэг журам, улс орнуудын хамтын ажиллагаа, аюулгүй байдлын талаарх ойлголт өөрчлөгдөж, худалдаа-эдийн засаг, засаглал, улс төрчид болон хүмүүсийн сэтгэлгээ, аж төрөх ёс, эрүүл мэнд, боловсролын салбар, онцгой байдлын үеийн шуурхай, бэлэн байдал тоглоомын шинэ дүрмээр явахаар болж байна. Дэлхийн улс гүрнүүд өмнөх шигээ хилээ нээж, иргэд чөлөөтэй харилцан зорчдог байх уу, үгүй юу гэдэг цоо шинэ асуудалтай тулгарч эхэллээ.

Неолибераль үзлийн нэр хүнд унаж, үүнтэй уялдан зүүн төвийн үзэл газар авч, хайбер глобалчлалын эсрэг үндсэрхэх үзэл, популизм ч эрчимжиж байна.

АНУ, ЕХ, АНУ, НАТО-гийн хоорондын харилцаанд ан цав гарч, америкчууд Европыг алдаж магадгүй. Ер нь АНУ түүний хамгийн ойр холбоотнуудын харилцаанд өөрчлөлт орно. АНУ, Хятадын харилцаа сөргөлдөөний үндсэн төв болох магадлалтай байна. Хүн төрөлхтний амьдралын хэв маяг ч өөрчлөгдөнө. АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүн олон зүйлийг өөрчлөх төлөвтэй.



## ҮНЭЛГЭЭ

Нэгт, Хайбер-глобачлал, дижиталчлалын үед хамгийн хүчирхэг батлан хамгаалах чадавхтай, хамгийн хүчирхэг эдийн засагтай улс гүрэн ч өөрийн аюулгүй байдал, хөгжил дэвшлийг дангаараа хангаж хөтлөн авч явах бололцоогүй болжээ. Энэ дүгнэлт АНУ, БНХАУ-ын аль алинд нь хамаарна.

Хоёрт, Глобалчлалаас бүх улс адил ашиг хүртэнэ гэдэг нь тийм ч үнэмшилтэй биш болов. Даяаршлын үйл явц улс орнуудын хөгжил, дэвшлийн өмнө өргөн боломж нээж байгаа нь үнэн боловч, хайбер глобалчлалаас том, жижиг улс орнуудын өмнө мөнхүү томоохон эрсдэлтэй асуудлуудыг тулган тавьж байна.

Гуравт, Чөлөөт худалдаа нь эдийн засгийн өсөлтөд гол нөлөө үзүүлнэ гэдэг ч бодит амьдралтай олон талаараа зөрчилдөж байна.

Дөрөвт, Хайбер даяаршил, чөлөөт зах зээл, дижиталчлалыг зөв залж жолоодох буюу манипуляци хийх явдал зайлшгүй чухал болж байна. Даяаршлын үйл явцад

улс орны бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Ийм түүхэн үед улс хоорондын харилцаанд эрх тэгш байх, шударга байх, олон хэлбэртэй байх, хамтын хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмын ач холбогдол өсч байна. Даяаршлын боломж бол хамтран ажиллаж, хамтаар хожих, хамтдаа ашиг хүртэх явдал мөн.

Тавд, Эдийн засгийн интеграц цорын ганц боломж биш гэдэг нь тодорхой болж байна. Харилцан хамаарал бүхий интеграцад бүх зүйл нэгдмэл байх ёстой гэсэн үзэл баримтлалд өөрчлөлт гарч байна.

Зургаад, COVID-19 цар тахлын бууралтын дараа хөрөнгө оруулалт татахын төлөө улс орнуудын өрсөлдөөн ширүүснэ.

Долоод, Төрийн зохицуулалттай зах зээлийн эдийн засгийн тогтолцоо эрчимтэй хөгжинө.

Наймд, Дижитал шилжилт эрчимжинэ.

Ест, Сансарт эрх мэдлээ өргөжүүлэх их гүрнүүдийн өрсөлдөөн ширүүснэ.

Эцэст нь, өнөөгийн олон улсын харилцааны бодит хэрэгцээ нь нэгд, урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа (*preventive diplomacy*), хоёрт, онцгой байдал, хямралын үеийн бэлэн байдал, шуурхай удирдлага (*crisis management*), оновчтой шийдвэр, гуравт, аюулгүйжуулах бодлого явуулах арга барилыг чадварлаг эзэмшиж, үйл ажиллагаагаа эрчимжүүлэхийг шаардаж байна.

Дэлхий дахин, хил залгаа бүс нутагт

COVID-19 цар тахлын дэгдэлт, нас баралт тууштай буурахгүй, харин ч зогсолтгүй хурдацтай өсч буй үед Монгол Улсын Засгийн газар дотооддоо цар тахлын нэг ч тохиолдол гаргалгүй бүрэн хянаж, ганц ч хүний эндэгдэлгүй байж, олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн өөрийн үүрэг, хариуцлагаа гүнээ ухамсарлаж, нэр хүнд, байр сууриа нэр төртэйгээр өргөж явааг зөөлөн хүчний бодлоготой холбогдуулан онцлон тэмдэглэмээр байна.

## ЭХ СУРВАЛЖ

1. <https://www.worldometers.info/coronavirus/> October 5, 2020
2. COVID-19 deaths: 1 person dies every 15 seconds globally; death toll crosses 7-lakh mark. <https://www.financialexpress.com/lifestyle/health/covid-19-deaths-1-person-dies-every-15-seconds-globally-death-toll-crosses-7-lakh-mark/2045327/> <https://www.worldometers.info/coronavirus/> August 23, 2020
3. 2019.12.31-нд Ухань хотын Эрүүл мэндийн зөвлөл цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд зарлав. 2020.01.05-нд ДЭМБ-аас гишүүн орнуудад болон олон нийтэд хандаж анхны мэдээллийг гаргав. 2020.01.08-нд Wall Street сэтгүүлд шинэ коронавирүсийн халдварын талаар нийтлэв. 2020.01.13-нд Тайланд улсын ЭМЯ-ны холбогдох албан тушаалтнууд хэвлэлийн бага хурал хийж Ухань хотоос ирсэн хүнд шинэ коронавирүсийн халдвар илэрсэн болохыг мэдээлсэн. 2020.01.20-нд Хятадын эрх баригчид халдвар хүнээс хүнд дамжиж байгааг мэдэгдэв. 2020.01.23-нд Ухань хотод онц байдал зарлаж, нисэх онгоц, төмөр зам, авто замын орох, гарах бүх гарцыг хаав. ДЭМБ 2020 оны гуравдугаар сарын 11-нд 128 улсад бүртгэгдсэний дараа pandemic буюу цар тахал гэж зарлав. Монгол Улс 3 дугаар сарын 10-нд 120 улс болж бүртгэгдэв.
4. <https://www.worldometers.info/coronavirus/> October 5, 2020
5. <https://www.worldometers.info/coronavirus/> July 17, 2020
6. Infectious COVID-19 mutation may be ‘a good thing’, says Paul Tambyah. 18 Aug 2020 <https://www.channelnewsasia.com/news/singapore/infectious-covid-19-mutation-may-be-good-thing-paul-tambyah-13030116>
7. Coronavirus pandemic could be over within two years-WHO head. <https://www.businessinsider.com/coronavirus-pandemic-could-be-over-within-two-years-who-director-2020-8-22>
8. Stephen Chen. Coronavirus: scientists find collision of pandemic and flu doubles Covid-19

- transmission. 11 Sept. 2020. <https://www.scmp.com/news/china/science/article/3101048/coronavirus-scientists-find-collision-pandemic-and-flu-doubles>
9. Ibid,
  10. Coronavirus antibodies may disappear 2 to 3 months after people recover. 10.02.2020 [HTTPS://WWW.BUSINESSINSIDER.IN/SCIENCE/NEWS/CORONAVIRUS-ANTIBODIES-MAY-DISAPPEAR-2-TO-3-MONTHS-AFTER-PEOPLE-RECOVER-A-NEW-STUDY-FOUND/ARTICLESHOW/76454989.CMS](https://www.businessinsider.in/science/news/coronavirus-antibodies-may-disappear-2-to-3-months-after-people-recover-a-new-study-found/articleshow/76454989.cms)
  11. Europe can live with COVID-19 with local lockdowns: WHO regional director. Sept. 1, 2020 <https://www.reuters.com/article/us-health-coronavirus-who-sky/europe-can-live-with-covid-19-with-local-lockdowns-who-regional-director-idUSKBN25S43U>
  12. 74/270. Resolution adopted by the General Assembly on 2 April 2020. Global solidarity to fight the coronavirus disease 2019 (COVID-19) <https://undocs.org/en/A/RES/74/270>
  13. UN Security Council Press Elements on COVID-19. 09.04.2020. <https://new-york-un.diplo.de/un-en/news-corner/200409-unsc-covid19/2332088>
  14. WHO chief blasts 'lack of leadership' and calls for global unity as coronavirus cases mount worldwide. July 10, 2020, <https://edition.cnn.com/2020/07/10/world/who-tedros-adhanom-unity-plea-intl-scli/index.html>
  15. World Health Organization Director-General & Other WHO Leaders Will Address Aspen Security Forum WHO experts will discuss global response to the COVID-19 pandemic August 3, 2020 <https://www.aspeninstitute.org/news/press-release/who-aspen-security-forum/>
  16. 2019 Global GDP. IMF. <https://www.worldometers.info/gdp/>
  17. Tourism industry loses \$460 billion in six months. [https://www3.nhk.or.jp/nhkworld/en/news/20200916\\_25/](https://www3.nhk.or.jp/nhkworld/en/news/20200916_25/)
  18. Ibid,
  19. <https://www.worldometers.info/coronavirus/country/us/> October 5, 2020
  20. Coronavirus: COVID-19 has killed more Americans than the Vietnam War. <https://www.euronews.com/2020/04/29/covid-19-kills-more-americans-than-the-vietnam-war>
  21. The coronavirus has now killed more Americans than the Vietnam War Gulf War Afghanistan War and Iraq War combined. 2020.05.15. <https://fortune.com/2020/05/15/coronavirus-deaths-us-covid-19-death-rate-covid-19-more-than-korean-vietnam-gulf-afghanistan-iraq-wars-combined/>
  22. <https://www.worldometers.info/coronavirus/country/us/> July 23, 2020
  23. <https://www.hhs.gov/about/news/2020/09/16/trump-administration-releases-covid-19-vaccine-distribution-strategy.html>
  24. China decides not to set a GDP target for 2020 as coronavirus batters the economy. <https://www.cnbc.com/2020/05/22/china-will-not-set-gdp-target-for-2020-as-coronavirus-batters-economy.html>

25. Поклонская раскрыла происхождение китайского коронавируса. 25.01.2020 <https://www.mk.ru/politics/2020/01/25/poklonskaya-raskryla-proiskhozhdenie-kitayskogo-koronavirusa.html>
26. Новый коронавирус “сбежал” из лаборатории? В России разработана секретная программа. 27 января 2020. <https://www.vshouz.ru/news/analitika/7937/>
27. <https://www.worldometers.info/coronavirus/country/russia/> October 5, 2020
28. <https://www.worldometers.info/coronavirus/country/russia/> October 5, 2020
29. <https://www.worldometers.info/coronavirus/country/russia/> October 5, 2020
30. Henry A. Kissinger. “The Coronavirus Pandemic Will Forever Alter the World Order” April 3, 2020 Wall Street Journal. <https://www.wsj.com/articles/the-coronavirus-pandemic-will-forever-alter-the-world-order-11585953005>
31. World Leaders Won’t Gather for the U.N. General Assembly for First Time in Its 75-Year History. June 8, 2020 <https://time.com/5850391/un-general-assembly-first-time-75-years-coronavirus/>
32. European Union: Global Security Actor or Paper Tiger? <https://www.worldpoliticsreview.com/articles/5246/european-union-global-security-actor-or-paper-tiger>
33. EU summit: Leaders reach landmark €1.82 trillion COVID-19 recovery deal and budget <https://www.euronews.com/2020/07/21/eu-summit-deadlock-see-talks-stretch-into-sunday>
34. CNN International. Sept. 9, 2020
35. <https://www.parismatch.com/Actu/Politique/Emmanuel-Macron-la-gauche-et-2022-Lionel-Jospin-livre-ses-reflexions-1701137>
36. Tokyo Olympics ‘will take place with or without COVID,’ senior IOC official says <https://www.japantimes.co.jp/sports/2020/09/07/olympics/summer-olympics/tokyo-olympics-ioc-john-coates-coronavirus/>
37. В.Путин принял участие в итоговой пленарной сессии XI заседания Международного дискуссионного клуба «Валдай». Тема заседания-«Мировой порядок: новые правила или игра без правил?». 24 октября 2014 года. Сочи.
38. Exclusive: Lack of immunity means China is vulnerable to another wave of coronavirus, top adviser warns. May 17, 2020 <https://edition.cnn.com/2020/05/16/asia/zhong-nanshan-coronavirus-intl-hnk/index.html>
39. <https://www.nature.com/news/inside-the-chinese-lab-poised-to-study-world-s-most-dangerous-pathogens-1.21487>
40. <https://news.cgtn.com/news/2020-05-03/U-S-researcher-who-worked-in-Wuhan-lab-calls-COVID-19-leak-unlikely--QbHBgluE5a/index.html>





Т.БАТЦЭЦЭГ(М.А)

## ОХУ, БНХАУ-ЫН ХАМТРАН ДЭВШҮҮЛСЭН АЗИ, НОМХОН ДАЛАЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ШИНЭ МЕХАНИЗМ БИЙ БОЛГОХ САНААЧИЛГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТУХАЙ

*The Asia-Pacific region lacks an all-inclusive and comprehensive security platform. China and Russia have long considered the existing security mechanisms in the region as ineffective in dealing with increasingly complicated and complex security challenges the region faces. Therefore, in 2010, the two countries jointly put forward an initiative to build a new regional security framework. The envisaged is an open, transparent, inclusive framework based on internationally recognized norms and principles, and incorporates new concepts of indivisible, common and sustainable security. The new framework is envisaged to be built by evolving and improving the existing security mechanisms. Though both China and Russia exerted considerable efforts, the initiative did not get the full support of all regional countries and currently is not actively promoted. This article firstly makes a general summary of the efforts China and Russia made. Then it will analyze the positions of other regional countries. Additionally, it will suggest an option for Mongolia's position on the matter. It will conclude that though China and Russia did not achieve that much in promoting the new idea for regional security architecture, analyzing their efforts will be useful for any future efforts to establish a new security architecture in the region.*

**Түлхүүр үгс:** Ази, Номхон далайн аюулгүй байдал, шинэ аюулгүй байдлын ойлголт, Орос-Хятадын стратегийн түншлэл, бүс нутгийн аюулгүй байдлын орчин, Монгол Улсын бүс нутгийн хамтын ажиллагааны бодлого

### ОРШИЛ

Ази, Номхон далайн бүс нутаг нь сүүлийн 30 гаруй жилийн турш эдийн засгийн хөгжлийн хурдцаар дэлхийд тэргүүлж, эдийн засгийн ерөнхий хүчин

чадал нь мэдэгдэхүйц дээшилсний дүнд дэлхийн хөгжлийг хөдөлгөгч гол төв гэж хүлээн зөвшөөрөгдөх болсон билээ. Тус бүс нутгийн аюулгүй байдал бүхэлдээ

тогтвортой байж ирсэн нь бүс нутгийн орнууд эдийн засаг, нийгмээ эрчимтэй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж ирсэн. Гэхдээ тус бүс нутаг нь аюулгүй байдлын эрсдэл үүсэх өндөр магадлалтай бүс нутаг гэдгийг мөн тэмдэглэх хэрэгтэй. Хүйтэн дайны үеэс шийдвэрлэгдээгүй үлдсэн, тус бүс нутгийн аюулгүй байдалд ноцтой заналхийлэл учруулах боломжтой ужиг асуудлууд цөөнгүй байдаг. Түүнчлэн тус бүс нутаг нь цэргийн хүч хамгийн их төвлөрсөн, цэргийн хээрийн сургууль хамгийн өндөр давтамжтай болдог, бүс нутгийн орнуудын цэргийн зардал байнга нэмэгдсээр ирсэн, зэвсэглэлээр хөөцөлдөх явдал нэмэгдэх хандлагатай бүс нутаг юм. Дэлхийн бусад бүс нутагтай харьцуулахад бүс нутгийн бүх орныг хамарсан, аюулгүй байдлын асуудлыг иж бүрнээр хэлэлцэх ерөнхий механизм<sup>1</sup> байдаггүй нь Ази, Номхон далайн бүс нутгийн бас нэг онцлог юм.

Эдүгээ Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын асуудлаарх яриа хэлэлцээ, хамтын ажиллагааны дараах механизм, бүтцүүд байна. Үүнд: нэгдүгээрт, бүс нутгийн болон дэд бүс нутгийн шинжтэй механизмууд (Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх зөвлөгөөн (АХАИБЗ), Өмнөд Азийн бүс нутгийн хамтын ажиллагааны холбоо, АСЕАН, Шанхайн хамтын ажиллагааны байгууллага (ШХАБ), АРФ, Зүүн Азийн дээд түвшний уулзалт (ЗАДТУ), АСЕАН+1, АСЕАН+3 гэх мэт), хоёрдугаарт, хоёр талын болон олон талт холбоотны харилцаанд тулгуурласан механизмууд (АНУ-ын бүс нутгийн орнуудтай байгуулсан холбоотны харилцаа гэх мэт), гуравдугаарт, тусгайлсан асуудлаарх механизм (Умард Солонгосын цөмийн асуудлаарх зургаан талт хэлэлцээ гэх мэт), дөрөвдүгээрт, 2 дугаар болон 1.5 дугаар сувгийн механизмууд (Ази, Номхон далайн аюулгүй байдлын хамтын ажиллагааны зөвлөл, Шангрила-гийн яриа хэлэлцээ, Улаанбаатарын яриа хэлэлцээ,

<sup>1</sup> Security framework, architecture

Сяншань форум зэрэг) байна.

ОХУ, БНХАУ нь Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдал, худалдаа, эдийн засгийн харилцаанд чухал нөлөө бүхий гүрнүүд билээ. Энэ хоёр орны бүс нутгийн үйл хэрэгт гүйцэтгэж ирсэн үүрэг, жин нөлөө ялгаатай ч цөөнгүй асуудал дээр тэдгээрийн эрх ашиг нийлдэг. Аливаа бусад улсын адилаар бүс нутгийн байдал тогтвортой байх нь ОХУ, БНХАУ нийгэм, эдийн засгаа хөгжүүлэх гадаад таатай орчныг бүрдүүлдэг. Тийм ч учраас хоёр улс бүс нутгийн аюулгүй, тогтвортой байдлыг хангах чиглэлээр идэвхтэй бодлого явуулж, хамтран ажиллаж ирсэн. Түүнчлэн хүйтэн дайны дараагаар бий болсон ганц туйлт дэлхийн дэг журмыг өөрчлөх, Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын баталгааг хангаж ирсэн АНУ-ын нөлөөг сулруулах нь тус хоёр улсын нийтлэг сонирхол юм.

ОХУ, БНХАУ 1996 онд стратегийн түншлэлийн харилцаа тогтоосноос хойш НҮБ болон олон улс, бүс нутгийн хамтын ажиллагааны бусад байгууллага, механизмын хүрээнд байр суурь, үйл ажиллагаагаа идэвхтэй уялдуулах болсон. Хоёр улсын бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаарх ойр, уялдаатай хамтын ажиллагаа нь хоёр талын харилцааны хүрээнээс давсан, бүс нутгийн стратегийн ерөнхий байдал, хүчний харьцаанд нөлөөхүйц үр нөлөөтэй гэж үздэг.

Бүс нутгийн энэ ерөнхий байдал дор ОХУ, БНХАУ Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдал, хамтын ажиллагааны шинэ ерөнхий механизм байгуулах тухай санаачилгыг 2010 онд хамтран дэвшүүлсэн билээ.

Энэхүү өгүүлэлд ОХУ, БНХАУ-ын хамтран дэвшүүлсэн санаачилгын мөн чанар, зорилгыг тодорхойлж, санаачилгыг урагшлуулах чиглэлээр хоёр улсын зүгээс хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар болон бүс нутгийн орнуудын байр

суурийн талаар судлахыг зорьсон бөгөөд эцэст нь санаачилгын тухайд манай улсаас баримтлах байр суурийн талаарх саналаа дэвшүүлсэн болно.

### **ШИНЭ САНААЧИЛГА ДЭВШҮҮЛЭХ БОЛСОН ШАЛТГААН, ЗОРИЛГЫН ТУХАЙ**

Хоёр улсын тухайн үеийн төрийн тэргүүн Д.А.Медведев, Ху Жиньтао нар 2010 оны зургаадугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурсан “ОХУ, БНХАУ-ын түншлэл, стратегийн харилцан ажиллагааг бүх талаар гүнзгийрүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл”-д “талууд олон улсын эрх зүйн хэм хэмжээ болон эвсэлд үл нэгдэх, бүх талуудын хууль ёсны эрх ашгийг харгалзах зарчимд тулгуурласан нээлттэй, ил тод, эрх тэгш аюулгүй байдал, хамтын ажиллагааны ерөнхий механизмыг Ази, Номхон далайн бүс нутагт байгуулахыг зорино. Бүс нутгийн бүх орнууд сөргөлдөхөөс зайлсхийж, гуравдагч орны эсрэг чиглэсэн хамтын ажиллагаа явуулахгүй байхын чухлыг онцлон тэмдэглэж байна. Талууд бүс нутгийн бүх орон аюулгүй байдлын салбарт хоёр талт болон олон талт хамтын ажиллагаа хөгжүүлэхдээ олон улсын харилцааны нийтээр хүлээн зөвшөөрсөн дараах зарчмуудыг:

- Бие биеийн бүрэн эрх, тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх, дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх,
- Тэгш, үл хуваагдах аюулгүй байдлын зарчмыг тууштай баримтлахаа нотлох,
- Хамгаалалтын шинжтэй батлан хамгаалах бодлого явуулахаа нотлох,
- Хүч үл хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэхгүй байх,
- Бусад улсын засгийн газрыг түлхэн унагаах, нийгмийн тогтвортой

байдлыг бусниулахад чиглэсэн аливаа үйл ажиллагааг явуулахгүй, дэмжихгүй байх,

- Санал зөрүүтэй асуудлыг харилцан ойлголцох, зохистой байдлаар шийдвэрлэх зарчмыг баримтлан улс төр, дипломатын аргаар, энхийн замаар шийдвэрлэх,
- Уламжлалт бус аюулгүй байдлын чиглэлд хамтын ажиллагаагаа бэхжүүлэх,
- Хоёр талт болон олон талт цэргийн хамтын ажиллагааг гуравдагч орны эсрэг чиглүүлэхгүй байх,
- Хилийн бүс нутгийн хамтын ажиллагаа, иргэд зорчих явдлыг хөгжүүлэх гэсэн зарчмуудыг баримтлахыг уриалж байна” гэжээ<sup>2</sup>.

Санаачилгыг дэвшүүлсэн нь ОХУ, БНХАУ-ын сонирхол оршил хэсэгт дурдсанчлан хэд хэдэн чиглэлээр нэгдмэл байдагтай холбоотой гэж үзэж болно. Эдүгээ бүс нутагт бий болсон АНУ-ын хоёр талын холбоотны харилцаанд тулгуурласан аюулгүй байдлын тогтолцоо нь үеэ өнгөрөөсөн бөгөөд бүс нутгийн хурдацтай өөрчлөгдөж буй нөхцөл байдлын шаардлагыг хангаж чадахгүй байгаа нь аюулгүй байдлын ерөнхий механизмыг шинэчлэх шаардлагыг бий болгож байна гэж хоёр улсын аль аль нь үздэг<sup>3</sup>. 2010 оны үеэс АНУ-ын зүгээс Ази, Номхон далайн бүс нутагт “Дахин тэнцвэржүүлэх” стратеги хэрэгжүүлэх болсноор бүс нутаг дахь их гүрнүүдийн сөргөлдөөн ширүүсч, бүс нутгийн зарим орны хооронд газар нутгийн маргаан хурцадсан зэргээр бүс нутгийн

<sup>2</sup>[http://www.gov.cn/ldhd/2010-09/28/content\\_1712072.htm](http://www.gov.cn/ldhd/2010-09/28/content_1712072.htm)

<sup>3</sup> Alexander Lukin, “Russia’s Approach to Security Architecture in the Asia Pacific,” CSCAP Regional Security Outlook 2020:23-26, <http://www.cscap.org/uploads/cscap%202020%20v3.pdf>, Zhang Zhixin, “China’s Pursuit of a New Asia-Pacific Architecture,” China Quarterly of International Strategic Studies, Vol.1, No.4(2015):578.

аюулгүй байдлын орчин бүхэлдээ түвэгтэй болоход аюулгүй байдлын өнөөгийн тогтолцоо эдгээр олон янзын түвэгтэй сорилтыг шийдвэрлэх улам бүр чадамжгүй болж байна гэж талууд дүгнэжээ.

Ялангуяа, АНУ голлох үүрэгтэй бүс нутгийн механизмуудад Хятад оролцдоггүйн зэрэгцээ тэдгээрийн гол зорилго нь Хятадын өсөн нэмэгдэж ирсэн нөлөөг тэнцвэржүүлэхэд чиглэсэн байдаг тул энэ байдлыг бүхэлд нь өөрчилж, цоо шинэ тогтолцоо бий болгохыг Хятад улс зорих нь ойлгомжтой билээ. Тийм ч учраас тус улс 1990-ээд оны сүүлчээр “Шинэ аюулгүй байдал”-ын ойлголтыг томъёолон гаргаж, АРФ зэрэг бүс нутгийн механизмын хүрээнд дэвшүүлж байсан байна.<sup>4</sup>

Хятадын бүс нутгийн бодлогын гол анхаарал эдийн засгийн талбарт төвлөрч байснаа аажмаар аюулгүй байдал, улс төрийн сонирхол тэргүүлэх чиглэл болон өөрчлөгдөж буйг энэ санаачилга мөн харуулсан гэж зарим ажиглагч дүгнэсэн байна. Түүнчлэн шинэ ерөнхий механизм байгуулахаар ажиллах явцад бүс нутгийн үйл хэрэг дэх Хятадын үүрэг нөлөөг улам нэмэгдүүлэх, “Хятадын аюул” гэх ойлголтыг саармагжуулах, бүс нутгийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэм хэмжээг тогтооход Хятадын дуу хоолойг илүү хүргэх, илүү идэвхтэй оролцох боломжийг нээх зэрэг давуу талыг бий болгоно гэж хятадууд үзэж байсан байна<sup>5</sup>.

Ийм санаачилга хамтран дэвшүүлэх саналыг оросын талаас анх тавьж, хятадын тал дэмжжээ. Үүнээс өмнөхөн буюу 2009 онд ОХУ-ын зүгээс бүх Европыг хамарсан аюулгүй байдлын нэгдсэн орон зайг бий

<sup>4</sup> Zhang Zhixin, “China’s Pursuit of a New Asia-Pacific Architecture,” 577.

<sup>5</sup> Ван Зисы, “Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын ерөнхий механизм: Зорилго, нөхцөл, үзэл баримтлал”, Олон улсын аюулгүй байдал судлал, 2016, 6, <http://www.iiss.pku.edu.cn/specialist/science/2016/1791.html>

болгож, Европын аюулгүй байдлын гэрээ байгуулах санал дэвшүүлсэн байсны үргэлжлэл болгон Ази, Номхон далайн бүс нутагт ийм санаачилга дэвшүүлсэн байх талтай юм. Европын аюулгүй байдлын шинэ ерөнхий механизм бий болгоход чиглэсэн Оросын санал нь ч “үл хуваагдах аюулгүй байдал”-ын ойлголт буюу өөр улсын аюулгүй байдлыг золиослох замаар өөрийн улсын аюулгүй байдлыг хангаж болохгүй гэсэн ойлголтод тулгуурласан байжээ<sup>6</sup>.

Хятадын хүчирхэгжилт Ази, Номхон далайн бүс нутгийн хүчний тэнцвэрт ихээхэн өөрчлөлт авчирж, АНУ өөрийн тэргүүлэх байр сууриа алдахгүйг зорьж буй үед ОХУ ч Ази, Номхон далайн бүс нутаг дахь өөрийн байр суурийг бэхжүүлж, тус бүс нутгийн их гүрэн гэдэг статусаа ахин бий болгохыг зорих болсон билээ. Тус улс бүс нутгийн халуун цэгийн асуудлуудыг шийдвэрлэхэд шууд оролцох сонирхолгүй ч аюулгүй байдлын аливаа асуудлыг шийдэхэд байр сууриа илэрхийлэх боломжийг нээлттэй үлдээхэд байнга анхаарч ирсэн бөгөөд бүс нутгийн голлох бүх механизмын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн. ОХУ өөрийн улс төр, дипломат үйл ажиллагааны нөлөөг харуулах зорилгоор улс төрийн шинжтэй санаачилгууд цөөнгүй гаргадгийн нэг нь гэж энэхүү санаачилгыг зарим ажиглагчид дүгнэжээ<sup>7</sup>. Ази тивд илүү ач холбогдол өгөх Оросын бодлого нь түүнчлэн өөрийн Сибирь, Алс Дорнодын бүс нутгийн эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэх замаар экспортын зах зээлээ тэлэх гэсэн эдийн засгийн сонирхолтой нь ч холбоотой байжээ.

ОХУ-ын санал Хятадын бүс нутаг

<sup>6</sup> <http://en.kremlin.ru/events/president/news/6152>

<sup>7</sup> Василий Кашин, “Российский подход к проблемам региональной безопасности в АТР”, 2016, <https://carnegie.ru/2016/06/17/ru-pub-63832>

дахь том амбицтай бүрэн нийцэж байсны зэрэгцээ ОХУ-ын улс төр, дипломатын арвин туршлага нь уг санаачилгыг бусад орнуудаар дэмжүүлэхэд тустай гэж хятадын тал үзсэн байна. ОХУ нь бүс нутаг дахь улс төр, аюулгүй байдлын ноцтой маргаанд оролцогч тал биш байдаг нь мөн тус улсын харьцангуй давуу тал юм.

### **САНААЧИЛГЫГ УРАГШЛУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЖ ИРСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Хамтран дэвшүүлсэн санаачилгын үндсэн агуулга, санааг хоёр улс өөрийн гадаад бодлогын чиглэлээрх баримт бичгүүд болон хоёр талын харилцааны улс төрийн баримт бичгүүдэд тусгахын зэрэгцээ ЗАДТУ, АХАИБЗ, ШХАБ зэрэг олон талт механизмын хүрээнд дэмжлэг авахаар идэвхтэй ажилласан байна.

ОХУ-ын хувьд 2012 онд гаргасан “Гадаад бодлогын үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлигт уг санаачилгыг урагшлуулах тухай заалт оруулсан бол 2016 онд баталсан “Гадаад бодлогын үзэл баримтлал”-даа “Ази, Номхон далайн бүс нутагт найдвартай, орчин үеийн бодит байдалд нийцсэн, тэгш, үл хуваагдах аюулгүй байдлын тогтолцоо байгуулахыг чухал зорилт гэж үзнэ” хэмээн тусгажээ.

2010 оноос хойш хэрэгжүүлсэн хоёр улсын төрийн тэргүүн нарын харилцан айлчлалын үеэр гаргасан улс төрийн баримт бичгүүдэд, тухайлбал 2012, 2013, 2016 оны Хамтарсан мэдэгдлүүдэд 2010 онд дэвшүүлсэн санаачилгын ерөнхий үзэл санааг нотолж, санаачилгыг урагшлуулах тухай агуулгыг тогтмол оруулж ирсэн.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, БНХАУ-ын дарга Ши Жиньпин нарын 2017 оны долоодугаар сарын 5-ны өдөр гарын үсэг зурсан “Өнөөгийн дэлхий дахины байдал, олон улсын харилцааны томоохон асуудлуудын талаарх ОХУ, БНХАУ-

ын Хамтарсан мэдэгдэл”-д “АХАИБЗ, ЗАДТУ, АРФ, АСЕАН+ орнуудын Батлан хамгаалахын сайд нарын уулзалт, АСЕМ зэрэг бүс нутгийн байгууллагын хүрээнд хамтран ажиллаж, нийтийн, цогц, хамтын ажиллагааны, тогтвортой, тэгш, үл хуваагдах аюулгүй байдал болон маргааныг энхийн замаар шийдвэрлэх, хүч үл хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэхгүй байх зарчимд тулгуурласан, нээлттэй, иж бүрэн, ил тод аюулгүй байдал, хамтын ажиллагааны ерөнхий механизмыг Ази, Номхон далайн бүс нутагт байгуулахыг урагшлуулна”<sup>8</sup> гэж тусгасан. 2019 оны зургаадугаар сарын 5-ны өдөр гаргасан “Шинэ эрин үед ОХУ, БНХАУ-ын иж бүрэн түншлэл, стратегийн харилцан ажиллагааг хөгжүүлэх тухай Хамтарсан мэдэгдэл”-д “ЗАДТУ-ын хүрээнд Ази, Номхон далайн бүс нутагт нээлттэй, хүртээмжтэй, ил тод аюулгүй байдал, хамтын ажиллагааны ерөнхий механизмыг байгуулах санаачилгыг урагшлуулна”<sup>9</sup> гэж тусгажээ.

ШХАБ-ын хүрээнд гаргасан улс төрийн баримт бичгүүдэд Орос, Хятадын дэвшүүлсэн санаачилга гэж онцлоогүй хэдий ч хамтарсан санаачилгын гол агуулгыг тусгаж байжээ. Тухайлбал, 2011 оны Астанагийн тунхаглалд “ШХАБ нь Ази, Номхон далайн бүс нутагт нээлттэй, ил тод, тэгш аюулгүй байдал, хамтын ажиллагааны ерөнхий механизм бий болгохыг дэмжинэ”, 2012 онд гаргасан “Энхтайван, хамтын хөгжил цэцэглэлтийн бүс нутаг байгуулах тухай Хамтарсан тунхаглал”-д “аюулгүй байдлын асуудалд харилцан итгэх, харилцан ашигтай байх, эрх тэгш байх, хамтран ажиллах зарчмын үүднээс хандаж, бүх улсын эрх ашгийг харгалзсан үл

<sup>8</sup><http://www.chinanews.com/gn/2017/07-05/8269110.shtml>

<sup>9</sup> Совместное заявление Российской Федерации и Китайской Народной Республики о развитии отношений всеобъемлющего партнерства и стратегического взаимодействия, вступающих в новую эпоху, <http://kremlin.ru/supplement/5413>

хуваагдах аюулгүй байдлын орон зайг бий болгох ёстой, өөр улсын аюулгүй байдлыг золиослох замаар өөрийн улсын аюулгүй байдлыг хангаж болохгүй”, “ШХАБ-ыг 2025 он хүртэл хөгжүүлэх стратеги”-д “өөр улсын аюулгүй байдлыг золиослох замаар өөрийн улсын аюулгүй байдлыг хангаж болохгүй, бүх улс тэгш, үл хуваагдах аюулгүй байдлын зарчмыг баримтлах нь чухал, бүс нутгуудад үл хуваагдах аюулгүй байдлын орон зайг бий болгох хэрэгтэй” гэж тусгажээ.

Бүс нутгийн үйл хэрэгт нөлөө бүхий орнууд хамрагддаг ЗАДТУ-ын хүрээнд өөрсдийн санаачилгыг дэмжүүлэхэд илүү анхаарч ажилласан байна. ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров “ЗАДТУ-ын хүрээнд болдог стратегийн шинжтэй яриа хэлэлцээг бүс нутгийн аюулгүй байдлын ерөнхий механизмыг боловсронгуй болгох асуудлуудад төвлөрүүлэх хэрэгтэй, ЗАДТУ нь хүртээмжтэй, үл хуваагдах аюулгүй байдлын тухай зарчмуудыг хэлэлцэх боломжтой” гэж хэлж байжээ<sup>10</sup>. Санаачилгыг ЗАДТУ-ын гишүүн орнуудаар дэмжүүлэх чиглэлээр ажиллаж Брунейн талтай хамтран 2013 онд тус улсад болсон Дээд түвшний уулзалтын Даргын мэдэгдэлд санаачилгыг гишүүн орнууд сайшааж, цаашид үргэлжлүүлэн хэлэлцэх тухай агуулгыг тусгуулсан байна<sup>11</sup>. Үүний дараагаар бүс нутгийн аюулгүй байдлын механизмын асуудлаарх семинарыг ЗАДТУ-ын хүрээнд 2014 онд гурав, 2016, 2017 онд тус бүр нэг удаа зохион байгуулжээ.

БНХАУ-ын Ерөнхий сайд Ли Кэчян 2013 оны ЗАДТУ-д оролцох үеэрээ “бүс нутгийн бодит байдалд нийцэх, бүх талуудын хэрэгцээг хангахуйц бүс нутгийн аюулгүй байдлын ерөнхий механизм байгуулах шаардлагатай байна” гэж тэмдэглэжээ.

<sup>10</sup> Выступление С.В.Лаврова на пленарном заседании 6-го Восточноазиатского саммита, 19 ноября 2011 года, <https://interaffairs.ru/news/show/8055>

<sup>11</sup> Зүүн Азийн дээд түвшний 8 дахь удаагийн уулзалтын Даргын мэдэгдэл, <https://www.asean.org>

Үүний дараагаар БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2014 онд Шанхай хотод болсон АХАИБЗ-ний Дээд түвшний уулзалтад хэлсэн үгэндээ оросын талтай хамтран дэвшүүлсэн санаачилга “бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хамгаалан бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна” гэж дүгнээд санаачилгын талаар илүү дэлгэрэнгүй тайлбарлан ярьжээ. Тухайлбал, “нийтийн<sup>12</sup>, цогц<sup>13</sup>, хамтын ажиллагааны<sup>14</sup>, тогтвортой<sup>15</sup> аюулгүй байдлын ойлголтыг бий болгож, бүс нутагт аюулгүй байдал, хамтын ажиллагааны шинэ ерөнхий механизм байгуулахыг идэвхтэй урагшлуулах шаардлагатай. Нийтийн аюулгүй байдал гэдэг нь улс бүрийн аюулгүй байдлыг хүндэтгэж, хангах ёстой гэсэн үг юм. Аюулгүй байдал нийтлэг байх ёстой, нэг улс буюу хэсэг бүлэг улсын аюулгүй байдал хангагдсанаар бусад улс аюулгүй биш байж болохгүй, өөр улсын аюулгүй байдлыг золиослох замаар өөрийн улсын “үнэмлэхүй аюулгүй байдал”-ыг хангахыг зорьж болохгүй. Аюулгүй байдал тэгш байх ёстой. Бүх улс орон бүс нутгийн аюулгүй байдлын үйл хэрэгт тэгш оролцох эрхтэй, мөн бүс нутгийн аюулгүй байдлыг хамгаалах үүрэг хүлээдэг. Аливаа улс бүс нутгийн аюулгүй байдлын үйл хэрэгт монополчлохыг зорьж, бусад орны зүй ёсны эрхийг хохироож болохгүй. Аюулгүй байдал хүртээмжтэй байх ёстой. Ази тивийн олон янзын байдал, зөрүүтэй байдлыг бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааг урагшлуулах хөдөлгөх хүч болгох ёстой. Гуравдагч орны эсрэг чиглэсэн цэргийн эвслийг бэхжүүлэх нь бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад тусгүй юм. Аюулгүй байдал цогц байх ёстой, өөрөөр хэлбэл уламжлалт болон уламжлалт бус аюулгүй байдлын асуудлыг цогцоор харж аюулгүй байдлыг хамгаалах ёстой. Тогтвортой аюулгүй байдал гэдэг нь хөгжил, аюулгүй байдлыг хослууль чадвал

<sup>12</sup> Common security

<sup>13</sup> Comprehensive security

<sup>14</sup> Cooperative security

<sup>15</sup> Sustainable security

өнө мөнхийн аюулгүй байдлыг тогтооно гэсэн үг. Хөгжил бол аюулгүй байдлын үндэс суурь бөгөөд аюулгүй байдал нь хөгжлийн нөхцөл болдог<sup>16</sup> гэжээ.

ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 2014 оны АХАИБЗ-ний Дээд түвшний уулзалтад хэлсэн үгэндээ ОХУ нь Азид болон Ази, Номхон далайн бүс нутагт орчин үеийн бодит байдалд нийцэх олон улсын харилцааны ерөнхий механизм байгуулахын төлөө байна, энэ механизм нь үл хуваагдах аюулгүй байдлын ойлголтод суурилах ёстой бөгөөд хоёр талын болон олон талт механизмуудын тэнцвэр дээр тулгуурлах ёстой, хаалттай механизм болон эвслийг хамруулах ёсгүй<sup>17</sup> гэж онцлон тэмдэглэсэн бол 2019 оны АХАИБЗ-ний Дээд түвшний уулзалтад хэлсэн үгэндээ Азид тэгш, нийтлэг, үл хуваагдах аюулгүй байдлын ерөнхий механизм бий болгоход чиглэсэн хамтын хүч чармайлтыг идэвхжүүлэхийн төлөө байна<sup>18</sup> гэж тэмдэглэжээ.

АХАИБЗ-ний 2014 оны Дээд түвшний уулзалтаас гаргасан “Шанхайн тунхаглал”-д гишүүн орнууд “нийтийн, цогц, хамтын ажиллагааны, тогтвортой аюулгүй байдлыг бий болгохыг зорино” гэж тусгасан бол АХАИБЗ-ний 2019 оны Дээд түвшний уулзалтаас гаргасан “Душанбегийн тунхаглал”-д гишүүн орнууд “нийтийн, цогц, хамтын ажиллагааны, тогтвортой, тэгш, үл хуваагдах аюулгүй байдлын ач холбогдлыг нотолж, бүс нутагт нээлттэй, ил тод, хүртээмжтэй аюулгүй байдлын

<sup>16</sup> Ши Жиньпин: Азийн аюулгүй байдлын ойлголтыг идэвхтэй төлөвшүүлж, аюулгүй байдлын хамтын ажиллагааны шинэ нөхцөл байдлыг хамтран бий болгоё, 2014, [http://www.xinhuanet.com/world/2014-05/21/c\\_126528981.htm](http://www.xinhuanet.com/world/2014-05/21/c_126528981.htm)

<sup>17</sup> Выступление В.Путина на саммите Совещания по взаимодействию и мерам доверия в Азии, 21 мая 2014 года, Шанхай. <http://kremlin.ru/events/president/news/21058>

<sup>18</sup> Выступление В.Путина на саммите Совещания по взаимодействию и мерам доверия в Азии, 15 июня 2019 года, Душанбе. <http://kremlin.ru/events/president/news/60756>

ерөнхий механизм байгуулах яриа хэлэлцээ явуулах шаардлагатайг онцолж байна” гэж тусгасан байна.

Ази, Номхон далайн аюулгүй байдлын чиглэлээр гаргасан шинэ санал, ойлголтуудаа илүү тодорхой тайлбарлах үүднээс БНХАУ-ын Төрийн зөвлөлөөс 2017 оны нэгдүгээр сард “Хятадын Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны бодлого” хэмээх Цагаан номыг гаргажээ. Уг баримт бичигт “нийтийн, цогц, хамтын ажиллагааны, тогтвортой аюулгүй байдлын ойлголтыг бүс нутагт төлөвшүүлж, ирээдүй рүү хандсан, бүс нутгийн бодит байдалд нийцэх, бүх талын хэрэгцээг хангахуйц аюулгүй байдлын ерөнхий механизм байгуулахыг зорихоо илэрхийлж, энэ зорилт нь өмнө дэвшүүлж байсан аюулгүй байдлын хамтын ажиллагааны ойлголтуудын үргэлжлэл болохын зэрэгцээ зарим шинэ агуулгатай болохыг тэмдэглэжээ. Хамтын ажиллагааны аюулгүй байдал нь хамтын аюулгүй байдлаас<sup>19</sup> өөр ойлголт, хамтын ажиллагааны аюулгүй байдал гэдэг ойлголтын хамгийн онцлог шинж нь нээлттэй, хүртээмжтэй байдал юм гэж тайлбарлажээ<sup>20</sup>.

Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлын шинэ ерөнхий механизм байгуулах шаардлагыг БНХАУ-ын Гадаад хэргийн дэд сайд Лю Жэньминь тайлбарлахдаа: “эдүгээ Ази, Номхон далайн бүс нутагт АНУ-ын тэргүүлж буй холбоотны тогтолцоо зэрэг янз бүрийн хамтын ажиллагааны механизм байгаа хэдий ч тэдгээрийн зарим нь Хүйтэн дайнаас үлдсэн, зарим дэд бүс нутгийн механизм хооронд уялдаа байхгүй, мөн аюулгүй байдлын талаарх ойлголт ижил бус байна. Бүс нутгийн эдийн засаг хурдацтай хөгжиж буй нөхцөлд аюулгүй байдлын механизм байгуулах асуудал хоцрогдолтой байгаа тул түвэгтэй, олон янзын аюулгүй

<sup>19</sup> Collective security

<sup>20</sup> Ван Зисы, “Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын ерөнхий механизм: Зорилго, нөхцөл, үзэл баримтлал”, 7.

байдлын сорилтуудыг үр дүнтэй даван туулахад хүндрэлтэй болж байна. Аюулгүй байдлын механизм боловсронгуй бус байгаа нь улс хооронд үл итгэлцэл бий болоход нөлөөлж байна. Хэрэв ерөнхий механизм боловсронгуй болбол тэр механизмын хүрээнд улс хоорондын маргаантай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх боломжтой болно<sup>21</sup> гэжээ.

Хоёр улсын дотоодын бодлогын баримт бичиг, хоёр талын гаргасан тунхаглалууд, бүс нутгийн хамтын ажиллагааны механизмын хүрээнд гаргасан баримт бичгүүдийн агуулга болон ОХУ, БНХАУ-ын удирдагчид, ГХЯ-ны удирдлагын хэлсэн үгийн агуулгаас харахад хоёр улсын байгуулахыг зорьж буй механизм нь бүс нутгийн бүх орныг хамарсан, шийдвэрийг нийтийн зөвшилцлөөр гаргадаг, улс орнууд эрх тэгш байх үндсэн дээр улс төрийн яриа хэлэлцээ өрнүүлдэг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагатай төстэй байхаар байна. Талуудын аль аль нь цоо шинэ механизм байгуулах биш өнөөг хүртэл байгуулагдсан механизм, бүтцүүдэд тулгуурлан, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах замаар хэрэгжүүлнэ гэж анхнаасаа үзэж байжээ. Тухайлбал, ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.Лавров: “Ази, Номхон далайн бүс нутагт аюулгүй байдал, хамтын ажиллагааны бүх механизмыг нэгтгэсэн ерөнхий механизм байгуулж эхлэх тухай манай санаачилга өргөн дэмжлэгийг авсан” гэж онцолж байжээ<sup>22</sup>. “Хятадын Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны бодлого”-д ч бүс нутгийн аюулгүй байдлын ерөнхий механизм байгуулахдаа бүгдийг эхнээс нь эхлэхгүй, өнөөг хүртэл бий болсон

<sup>21</sup> Лю Жэньминь “Хятадын Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны бодлого” Цагаан номыг танилцуулах хурал дээр сэтгүүлчдийн асуултад хариулсан хариултын бичвэр, <http://asean.chinamission.org.cn/chn/zgsy/t1430085.htm>

<sup>22</sup> Лавров: идея РФ и Китая о безопасности в АТР получила поддержку на ВАС, 2013, <https://ria.ru/20131010/968957198.html>

механизмуудыг шинэчлэх, сайжруулах замаар бий болгохыг зорьж байна” гэж тодорхой илэрхийлсэн байна. Хятадын хувьд аюулгүй байдлын асуудлыг эдийн засгийн асуудлаас ангид шийдвэрлэх боломжгүй гэж үздэг уламжлалт бодлогынхоо хүрээнд бүс нутгийн аюулгүй байдлын ерөнхий механизм байгуулах явцыг бүс нутгийн эдийн засгийн ерөнхий механизм байгуулах явцтай хамт урагшлуулах ёстой гэсэн санааг мөн онцолж байгааг тэмдэглэх нь зүйтэй юм.

### БУСАД ОРНЫ БАЙР СУУРЬ

Орос, Хятадын санаачилга нь АНУ-ын бүс нутгийн аюулгүй байдалд гүйцэтгэх үүргийг бууруулах, АНУ-ын өөрийн холбоотон орнуудтай байгуулсан аюулгүй байдлын сүлжээг сулруулах далд зорилготой гэж АНУ, Японы ажиглагчид үзэж иржээ<sup>23</sup>. Ялангуяа БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2014 онд хэлсэн үгэндээ “Азийн асуудлыг ази хүмүүс өөрсдөө шийдэх ёстой” гэсэн санаа хэлсэн нь энэ таамаглалыг нь лавшруулжээ. Тиймээс АНУ-тай холбоотны харилцаатай орнууд санаачилгад болгоомжтой хандсан байна<sup>24</sup>.

Гэхдээ энэ санаачилгад бүх улсыг хамруулна гэж байгаа тул АНУ-ын оролцоог хязгаарлах гэсэн санаагүй, харин бүс нутагт их гүрнүүдийн гүйцэтгэж буй үүргийг харилцан зөвшөөрч байна гэсэн агуулгатай. Их гүрнүүд бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад хамтын үүрэг хүлээхүйц, хамтын аюулгүй байдлын механизм байх юм. Хятад нь АНУ-ын үүргийг бууруулахыг зорьж буй биш, харин бүс нутгийн үйл хэрэгт Хятадын үүрэг адил чухал гэдгийг АНУ-аар

<sup>23</sup> Jae Jeok Park, “China’s Rhetorical Challenge to the US-led Order in the Asia-Pacific and the Response of Regional States,” *The Korean Journal of International Studies*, Vol. 16, No.2 (2018):215.

<sup>24</sup> Dmitry Streltsov, Anna Kireeva, and Ilya Dyachkov, “Russia’s View on the International Security in Northeast Asia,” *The Korean Journal of Defense Analysis* Vol. 30, No. 1 (2018): 117, [https://mgimo.ru/upload/iblock/7bd/Streltsov-Kireeva-Dyachkov\\_2018.pdf](https://mgimo.ru/upload/iblock/7bd/Streltsov-Kireeva-Dyachkov_2018.pdf)



хүлээн зөвшөөрүүлэхийг хүсэж байгаа гэж Хятадын эрдэмтэд тайлбарлажээ<sup>25</sup>.

Орос, Хятадын санаачилгад тусгасан ерөнхий агуулгыг бүс нутгийн бусад орон зарчмын хувьд дэмжиж байна гэж үзэх боломжтой. Учир нь АХАИБЗ, ЗАДТУ, ШХАБ-д бүс нутгийн дийлэнх орон гишүүн бөгөөд эдгээр байгууллага, механизмын шугамаар гаргасан улс төрийн баримт бичгүүдийг дэмжсэн байна.

Гэхдээ санаачилгад дэвшүүлсэн санаа, зарчмууд нь Хятадын бодит үйл ажиллагаанаас зөрж байна гэсэн санааг Зүүн Өмнөд Азийн орнуудын судлаачид илэрхийлж байгаа нь анхаарал татаж байна. Санаачилгад “аюулгүй байдал тэгш, нийтлэг байх ёстой” гэж тунхаглан “нэг улс буюу хэсэг бүлэг улсын аюулгүй байдал хангагдсанаар бусад улс аюулгүй биш байж болохгүй, өөр улсын аюулгүй байдлыг золиослох замаар өөрийн улсын “үнэмлэхүй аюулгүй байдал”-ыг хангахыг зорьж болохгүй” зэрэг жижиг, дунд орнуудын эрх ашигт нийцэхүйц санааг дэвшүүлж ирсэн ч бодит байдал дээр Хятадын үйл ажиллагаа, тухайлбал Өмнөд Хятадын тэнгис дэх газар нутгийн маргаантай асуудлаар явуулж буй үйл ажиллагаа нь бүс нутгийн орнуудын эргэлзээг төрүүлж байна гэж Сингапурын судлаач тэмдэглэсэн байна.<sup>26</sup>

### **МОНГОЛ УЛСЫН БАРИМТЛАХ БАЙР СУУРИЙН ТАЛААРХ САНАЛ**

Орос, Хятадын хамтран дэвшүүлж, урагшлуулах чиглэлээр олон жилийн турш, багагүй хүч чармайлт гарган ажиллаж буй дээрх санаачилгын талаар албаны хүмүүс болон судлаачдын зүгээс байр сууриа илэрхийлсэн тухай мэдээлэл олдохгүй байгаагаас үзэхэд энэ санаачилгыг манай

<sup>25</sup> Zhang Zhexin, “China’s Pursuit of a New Asia-Pacific Architecture,” 580, 581

<sup>26</sup> Daljij Singh, “China’s Paper on Security Cooperation in the Asia-Pacific Region and Chinese Grand Strategy,” Yusof Ishak Institute Paper, (2017), [https://www.iseas.edu.sg/images/pdf/ISEAS\\_Perspective\\_2017\\_22.pdf](https://www.iseas.edu.sg/images/pdf/ISEAS_Perspective_2017_22.pdf)

улс төдийлөн анхаарахгүй явж иржээ.

Манай улс гишүүн нь байдаг АХАИБЗ-өөс гаргасан баримт бичгүүдийг хэлэлцэх явцад тэдгээрт тусгасан холбогдох агуулгыг манай улс дэмжсэн нь тодорхой. Гэхдээ холбогдох агуулга нь Орос, Хятадын зүгээс баримталж ирсэн бодлого, дэвшүүлсэн тодорхой саналтай холбоотой байсныг анзаараагүй байх талтай юм.

Санаачилгын ерөнхий агуулга нь бүхэлдээ олон улсын харилцааны нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмууд, олон улсын хэмжээнд хэвшмэл болж буй ойлголтуудыг тусгасны зэрэгцээ манай улс бүс нутгийн хамтын ажиллагаа, түүний дотор аюулгүй байдлын асуудлаарх яриа хэлэлцээний механизмд хамрагдахыг зорьж, тодорхой санаачилга дэвшүүлж байсны хувьд, мөн хөрш орнуудтай хөгжүүлж буй Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны үзэл санааг харгалзан хоёр хөршийн зүгээс хамтран дэвшүүлсэн санаачилгыг цаашид дэмжих, улмаар шинэ механизмыг байгуулах явцад эхнээс нь оролцохыг зорих нь зүйтэй болов уу гэсэн саналтай байна.

Гэхдээ уг санаачилгын агуулгад цаг хугацааны явцад зарим өөрчлөлт орж, шинэ агуулгаар баяжиж буйг анхаарч, манай улсын бодлогын баримт бичгүүдэд тэр бүр тусгагдаагүй, хэвшмэл болоогүй ойлголтуудыг нарийвчлан судлах, хэрэглэж хэвших, мөн тэдгээрийг монгол хэл рүү орчуулах томъёоллыг ч жигдлэх нь зүйтэй болов уу.

### **ДҮГНЭЛТ**

Бүс нутгийн бүх орныг хамарсан аюулгүй байдлын асуудлыг иж бүрнээр хэлэлцэх ерөнхий механизм байгуулах санаачилгаа урагшлуулах, бусад орноор дэмжүүлэхийн тул орос, хятадын талаас багагүй хүч чармайлт гарган ажиллаж, бүс нутгийн хамтын ажиллагааны голлох

механизмуудаас гаргасан баримт бичгүүдэд тусгаж чаджээ. Одоогоор ийм ерөнхий механизм байгуулах яриа хэлэлцээ идэвхтэй өрнөхгүй байгаа нь бүс нутгийн орнуудын харилцааны ерөнхий байдалтай холбоотой, тодруулбал нөлөө бүхий орнуудын стратегийн сонирхол зөрчилдөж буйтай холбоотой байна.

Ийм ерөнхий механизм байгуулах нь урт хугацаа, ихээхэн бэлтгэл шаардлагатай амаргүй үйл явц бөгөөд их гүрнүүдийн бүс нутаг дахь нөлөөний төлөөх сөргөлдөөн хурцадвал энэ санаачилгыг хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй гэдгийг орос, хятадын талуудын аль аль нь анхнаасаа ойлгож байжээ. Бүс нутгийн орнуудын ялгаатай байдлыг харгалзан үзвэл бүс нутгийн аюулгүй байдлын тогтолцоо байгуулах нь ойрын ирээдүйд хэрэгжүүлэх боломжгүй, бүс нутгийн аюулгүй байдлын ерөнхий механизм хувиран өөрчлөгдөж буй явцад олон механизмууд зэрэгцэн урагшилж байх нь хэвийн үзэгдэл юм” гэж тэд дүгнэж байна.<sup>27</sup>

<sup>27</sup> “Хятадын Ази, Номхон далайн бүс нутгийн

Гэхдээ санаачилгыг урагшлуулах, бусад оронд ойлгуулах чиглэлээр орос, хятадын талаас гаргасан хүч чармайлт үр дүнгүй биш, ийм яриа хэлэлцээ цаашид ч үргэлжлэх тул уг санаачилга нь ирээдүйд бүс нутгийн аюулгүй байдлын шинэ механизм бий болгох аливаа санаачилга, хүч чармайлтад тустай юм.

Орос, Хятадын хамтран дэвшүүлсэн санаачилгын ерөнхий агуулга нь бүхэлдээ олон улсын харилцааны нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмуудыг тууштай баримтлахыг онцолсны зэрэгцээ манай улсын Ази, Номхон далайн бүс нутгийн хамтын ажиллагааны бодлого, зорилттой нийцэж байгаа тул цаашдын өрнөлийг анхаарч, нарийвчлан судалсны үндсэн дээр санаачилгыг дэмжих, шинэ механизмыг байгуулах явцад эхнээс нь оролцохыг зорих нь зүйтэй гэсэн саналтай байна.


аюулгүй байдлын хамтын ажиллагааны бодлого”-д ингэж тодорхой тусгажээ.

## ЭХ СУРВАЛЖ

1. Alexander Lukin, “Russia’s Approach to Security Architecture in the Asia Pacific,” CSCAP Regional Security Outlook 2020:23-26, <http://www.cscap.org/uploads/cscap%202020%20v3.pdf>,
2. Daljij Singh, “China’s Paper on Security Cooperation in the Asia-Pacific Region and Chinese Grand Strategy,” Yusof Ishak Institute Paper, (2017), [https://www.iseas.edu.sg/images/pdf/ISEAS\\_Perspective\\_2017\\_22.pdf](https://www.iseas.edu.sg/images/pdf/ISEAS_Perspective_2017_22.pdf)
3. Dmitry Streltsov, Anna Kireeva, and Ilya Dyachkov, “Russia’s View on the International Security in Northeast Asia,” The Korean Journal of Defense Analysis Vol. 30, No. 1 (2018): 115-134, [https://mgimo.ru/upload/iblock/7bd/Streltsov-Kireeva-Dyachkov\\_2018.pdf](https://mgimo.ru/upload/iblock/7bd/Streltsov-Kireeva-Dyachkov_2018.pdf)
4. Jae Jeok Park, “China’s Rhetorical Challenge to the US-led Order in the Asia-Pacific and the Response of Regional States,” The Korean Journal of International Studies, Vol. 16, No.2 (2018):203-221, file:///C:/Users/Dell/AppData/Local/Temp/kjis016-02-03.pdf
5. Zhang Zhixin, “China’s Pursuit of a New Asia-Pacific Architecture,” China Quarterly of International Strategic Studies, Vol.1, No.4(2015):573-589, <https://www.worldscientific.com/doi/10.1142/S2377440015500323>

6. hina's Position Paper on the New Security Concept, <https://www.fmprc.gov.cn/ce/ceun/eng/xw/t27742.htm>
7. Chairman's statement of the 8<sup>th</sup> East Asia Summit 10 October 2013, <https://www.asean.org/wp-content/uploads/images/archive/23rdASEANSummit/chairmans%20statement%20-%208th%20east%20asia%20summit%20-%20final.pdf>
8. Dushanbe Declaration of the Conference on Interaction and Confidence Building Measures in Asia, <http://www.cicasummit2019.tj/dushanbe-declaration>
9. Shanghai Declaration of the Conference on Interaction and Confidence Building Measures in Asia, <https://www.sesric.org/imgs/news/Image/1031-CICADeclaration.pdf>
10. Александр Лукин, Василий Кашин, "Российско-Китайское сотрудничество и безопасность в АТР", <https://cyberleninka.ru/article/n/rossii-sko-kitai-skoe-sotrudnichestvo-i-bezopasnost-v-atr/viewer>
11. Василий Кашин, "Российский подход к проблемам региональной безопасности в АТР", <https://carnegie.ru/2016/06/17/ru-pub-63832>
12. Владимир Петровский Россия, Китай и новая архитектура международной безопасности в АТР <https://interaffairs.ru/jauthor/material/806>
13. Астанинская декларация десятилетия шанхайской организации сотрудничества, <http://rus.sectsc.org/documents/>
14. Выступление В.Путина на саммите Совещания по взаимодействию и мерам доверия в Азии, 21 мая 2014 года, <http://kremlin.ru/events/president/news/21058>
15. Выступление В.Путина на саммите Совещания по взаимодействию и мерам доверия в Азии, 15 июня 2019 года, <http://kremlin.ru/events/president/news/60756>
16. Выступление С.В.Лаврова на пленарном заседании 6-го Восточноазиатского саммита, 19 ноября 2011 года, <https://interaffairs.ru/news/show/8055>
17. Концепция внешней политики Российской Федерации, <http://kremlin.ru/acts/bank/41451>
18. Лавров: идея РФ и Китая о безопасности в АТР получила поддержку на ВАС, <https://ria.ru/20131010/968957198.html>
19. Совместное заявление Российской Федерации и Китайской Народной Республики о всестороннем углублении российско-китайских отношений партнерства и стратегического взаимодействия, 27 сентября 2010 года, <http://kremlin.ru/supplement/719>
20. Совместное заявление Российской Федерации и Китайской Народной Республики о развитии отношений всеобъемлющего партнерства и стратегического взаимодействия, вступающих в новую эпоху, 5 июня 2019 года, <http://kremlin.ru/supplement/5413>
21. Декларация глав государств-членов Шанхайской организации сотрудничества о построении региона долгосрочного мира и совместного процветания, <http://rus.sectsc.org/documents/>
22. Стратегии развития ШОС до 2025 года, <http://rus.sectsc.org/documents/>
23. Указ Президента Российской Федерации от 7 мая 2012 года № 605 «О мерах по реализации внешнеполитического курса Российской Федерации», [https://www.mid.ru/ru/foreign\\_policy/official\\_documents/-/asset\\_publisher/CptICkV6BZ29/content/id/157626](https://www.mid.ru/ru/foreign_policy/official_documents/-/asset_publisher/CptICkV6BZ29/content/id/157626)

24. Азид хамтран ажиллах, итгэлцлийг бэхжүүлэх зөвөлгөөний Дээд түвшний уулзалт: Ши Жиньпин Азийн аюулгүй байдлын шинэ дэг журам байгуулах санал дэвшүүлэв. 亚信峰会：习近平倡议亚洲新安全秩序, [https://www.bbc.com/zhongwen/simp/china/2014/05/140521\\_china\\_russia\\_summit](https://www.bbc.com/zhongwen/simp/china/2014/05/140521_china_russia_summit)
25. Лю Зянюн, “Тогтвортой аюулгүй байдлын ойлголт ба Дэлхийн аюулгүй байдлын засаглал”, Хятад ба Олон улсын харилцаа, 2019, №2, 6-18x 刘江永, “可持续安全观与全球安全治理”, 中国与国际关系学刊, 2019年第2期:6-18, <file:///C:/Users/Dell/App-Data/Local/Temp/3570-Article%20Text-12810-2-10-20191202.pdf>
26. БНХАУ-ын ГХЯ-ны дэд сайд Лю Жэньминь “Хятадын Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын хамтын ажиллагааны бодлого” Цагаан номыг танилцуулах хурал дээр сэтгүүлчдийн асуултад хариулсан хариултын бичвэр 外交部副部长刘振民出席《中国的亚太安全合作政策》白皮书发布会并回答记者提问实录, <http://asean.chinamission.org.cn/chn/zgsy/t1430085.htm>
27. Ван Зисы, “Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдлын ерөнхий механизм: Зорилго, нөхцөл, үзэл баримтлал”, Олон улсын аюулгүй байдал судлал, 2016, №1, 4-12x 王缉思, “亚太地区安全构架：目标、条件与构想”, 国际安全研究, 2016年第1期:4-12. <http://www.iiss.pku.edu.cn/specialist/science/2016/1791.html>
28. Ши Жиньпин: Азийн аюулгүй байдлын ойлголтыг идэвхтэй төлөвшүүлж, аюулгүй байдлын хамтын ажиллагааны шинэ нөхцөл байдлыг хамтран бий болгоё, 2014, 习近平：积极树立亚洲安全观 共创安全合作新局, [http://www.xinhuanet.com/world/2014-05/21/c\\_126528981.htm](http://www.xinhuanet.com/world/2014-05/21/c_126528981.htm)
29. Ши Жиньпин АХАИБЗ-ний 5 дахь удаагийн дээд түвшний уулзалтад хэлсэн үг, 2019, Душанбе 习近平在亚信第五次峰会上的讲话, 2019年, 杜尚别 [https://www.fmprc.gov.cn/web/ziliao\\_674904/zyjh\\_674906/t1672516.shtml](https://www.fmprc.gov.cn/web/ziliao_674904/zyjh_674906/t1672516.shtml)
30. Ван Шяочюань, “Шинэ эрин үе дэх Хятад, Оросын стратегийн харилцан ажиллагаа, түншлэлийн хамтын ажиллагааны түүхэн логик ба стратегийн хандлага”, Орос судлал, 2020, №2 王晓泉, “新时代中俄全面战略协作伙伴关系”的历史逻辑与战略走势”, 俄罗斯学学刊, 2020年第2期 [http://www.cssn.cn/gjgxx/gj\\_ttxw/202004/t20200429\\_5120276.shtml](http://www.cssn.cn/gjgxx/gj_ttxw/202004/t20200429_5120276.shtml)
31. Лун Дапөн, “Шинэ эрин үе дэх Хятад, Оросын харилцаа: Шинэ нөхцөл байдал, шинэ агуулга”, Дэлхийн мэдлэг, 2019, №14 龙大鵬, “新时代的中俄关系：新背景与新内涵”, 世界知识, 2019年第14期 <http://www.chinareform.net/index.php?m=content&c=index&a=show&catid=57&id=32668>
32. “Эрх тэгш, харилцан итгэлцсэн Хятад, Оросын иж бүрэн стратегийн харилцан ажиллагаа, түншлэлийн харилцааг улам бүр гүнзгийрүүлэх тухай БНХАУ, ОХУ-ын Хамтарсан мэдэгдэл”, 2012 中华人民共和国和俄罗斯联邦关于进一步深化平等信任的中俄全面战略协作伙伴关系的联合声明2012-06-06, [https://www.fmprc.gov.cn/web/gjhdq676201/gj\\_676203/oz\\_678770/1206\\_679110/1207\\_679122/t938682.shtml](https://www.fmprc.gov.cn/web/gjhdq676201/gj_676203/oz_678770/1206_679110/1207_679122/t938682.shtml)
33. “Хамтран ажиллаж, хамтаар хожих иж бүрэн стратегийн харилцан ажиллагаа, түншлэлийн харилцааны тухай БНХАУ, ОХУ-ын Хамтарсан мэдэгдэл”, 2013 中华人民共和国和俄罗斯联邦关于合作共赢、深化全面战略协作伙伴关系的联合声明 2013-03-22, [https://www.fmprc.gov.cn/web/gjhdq\\_676201/gj\\_676203/oz\\_678770/1206\\_679110/1207\\_679122/t1024243.shtml](https://www.fmprc.gov.cn/web/gjhdq_676201/gj_676203/oz_678770/1206_679110/1207_679122/t1024243.shtml)



Л.ДАМДИНСҮРЭН (Sc.D, Professor)

## МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

*In Mongolia, since 2010, extensive work has been intensively carried out to update the legal framework for food security in accordance with the National Security Concept and the global trend. This article examines the state of food security of the country in terms of resources and availability of food, food safety, as well as nutrition. Some considerations are proposed for the effective use of available resources, improving state and consumer control over food safety, increasing the nutritional biological value of food, as well as food education of the population.*

**Keywords:** grain, meat, milk, income, consumption, law, norm, standard

### ХҮНСНИЙ БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ЗАРЧИМ

Олон улсын байгууллага, дэлхий нийтийн ойлголтоор хүнсний аюулгүй байдал нь “хүнсний хангамж, хүртэмж”, “хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал”, “хооллолт, хүнсний шим зүй” гэсэн гурван тулгуураас бүрддэг, “хүн амьдрахын тулд хооллодог”, “зохистой, зөв хооллолт-эрүүл мэнд” гэсэн үзэл баримтлалын үндсэн

дээр хүний хүнсний эрхийг хангах үндсэн арга зам юм. Хүнсний эрх гэж хүн “зөвхөн өлсөхгүй” байхыг бус, харин өөрийн бие махбодийн хэрэгцээнд нийцсэн, чанар, аюулгүйн баталгаатай, эрүүл мэндэд ач тустай хоол, ундыг жигд, тогтвортой, хүртэмжтэй хэрэглэх боломжоор хангагдсан байх, энэ эрхээ эдлэхэд хүрэлцэхүйц

орлоготой байх зарчмыг хэлдэг<sup>1</sup>. Иргэн хүнсний эрхээ эдлэх боломж нь хүнсний зах зээл дэх бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлт, тухайн хүний орлого, боловсролоос хамааралтай учраас хүнсний аюулгүй байдлын түвшинг бүхэлд нь хүнсний нөөц, түүнээс хүн бүр хүртэх боломж, нөхцөл, бодит хэрэглээ, хүнс хоолны найрлага, шим зүйгээр үнэлдэг юм. Жич, манай хууль тогтоомжид “хүртэмж” гэж хэвшсэн боловч “хүртэмж” нь нийгмийн баялгаас хүн өөрөө олж хүртэх тухай ойлголт учраас би дээрхтэй санал нийлдэггүй юм.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (УИХ, 2010)-д хүнсний аюулгүй байдал (food security)-ын зорилтуудыг дээрх зарчимд нийцүүлэн тодорхойлжээ. Энэ үзэл баримтлалын дагуу хүнсний аюулгүй байдлын эрх зүйн орчин шинэчлэгдэн дэлхий нийтийн жишигт улам бүр ойртооор байна. Хүнсний тухай” хуулийн шинэчилсэн найруулга (2012)-д хүнсний аюулгүй байдлыг үндэсний хэмжээнд цогц агуулгаар нь хангах, “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай” хууль (2012)-д хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг сүлжээний үе шат бүрт хангах зарчмыг тогтоож, одоо тодорхой зохицуулалтын хуулиудыг шинэчлэх, шинээр батлах, дүрэм, журам, стандартуудыг хуулиудад нийцүүлэх ажил эрчимтэй өрнөж байна. Эдгээр баримт бичгийг боловсруулахад өөрийн судалгааны үндсэн дээр идэвхтэй оролцож ирсний хувьд хүнсний аюулгүй байдлын тулгуур асуудлуудаар санал, бодлоо хуваалцъя.

## **МОНГОЛ УЛСЫН ХҮНСНИЙ ХАНГАМЖ, ХҮРТЭМЖИЙН ТОЙМ**

Шинэ зууны хүнс хоолны үндсэн эх үүсвэр нь байгалийн уламжлалт бүтээгдэхүүн, найрлагыг тохируулсан бүтээгдэхүүн, хувиргасан амьд организмын

<sup>1</sup> Дамдинсүрэн Л. Хүнсний аюулгүй байдлын үндэс, 2015

гаралтай бүтээгдэхүүн гэж эрдэмтэд төсөөлж байна<sup>2</sup>. Манай улсын газар нутгийн хэмжээ, мал сүргийн тоо, байгалийн баялгийн нөөцийг тоймлон үзэхэд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр өөрийгөө хангаад зогсохгүй, мах, сүү, үр тариа, төмс, хүнсний ногооны бүтээгдэхүүн, мал, ургамлын гаралтай биологийн идэвхит бэлдмэлийн экспортоор дэлхий хүнсний зах зээлд оролцох бүрэн боломжтой. Монголын хүнсний нөөцийн давуу тал нь дэлхий дахинаар эрхэмлэх болсон байгалийн бүтээгдэхүүн, түүний эх үүсвэр нь унаган төрхөө хадгалан үлдсэн газар нутаг, бэлчээрийн мал аж ахуй маань билээ.

Монгол Улсын хөгжлийн бодлогын олон баримт бичигт энэ давуу талыг үр өгөөжтэй ашиглах стратеги, үйл ажиллагааг тодорхойлсон байдаг. Жишээлбэл, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (УИХ, 2020.08.28, тогтоол 28)-т “ХАА-н бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжинэ” гэсэн том зорилт дэвшүүлжээ.

Манайд 2007 он хүртэл буудай, гурил, төмс, хүнсний ногоо, сүү, цагаан идээний зонхилох хувийг импортоор хангаж, “хүнсний бие даасан байдал” алдагдсан ноцтой үе байлаа. Харин одоо мах, гурил, сүү, буудай, төмсний хэрэгцээ хангалтаар хүнсний баталгаат байдлын “бие даасан”, хүнсний ногоо, өндгөөр “эрсдэлтэй”, харин төрөл бүрийн будаа, чихэр, жимс, ургамлын тос, загасны хувьд импортоос хамааралтай түвшинд байна. Гаалийн статистикаас тооцоход сүүлийн 10 жилийн дунджаар манай улсын жилийн хүнсний экспорт 120 сая орчин ам.доллар, харин импорт 540 сая ам.доллар, өөрөөр хэлбэл экспорт-импортын

<sup>2</sup> Дамдинсүрэн Л. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлийн сорчилсон эмхэтгэл, 2015

харьцаа 1:5 байгаагийн дотор төрөл бүрийн боов, чихэр, цагаан идээ, зайрмаг, цөцгийн тос, пиво, давс зэрэг эх орондоо үйлдвэрлэдэг олон бараа байгаа нь нэн харамсалтай. Жилд дунджаар 500-600 гаруй мян.т амьдын жин бүхий 15-20 сая толгой бэлчээрийн малыг хүнсэнд зарцуулж, 350-400 мян.т мах бэлтгэдэг боловч үүний 95-97 хувийг хээрийн нөхцөлд, үйлдвэрлэлийн бус аргаар төхөөрч, зөвхөн жингийн хорогдлоор 14 мянган өрх буюу 56 мянган хүний хоногийн хэрэгцээний тураг мах, үүний зэрэгцээ хүнс-биологийн үнэт чанар бүхий гүзээ, сархинаг, шийр, тагалцаг, цус, бүлх, шөрмөс, ферментийн түүхий эд ихээхэн хэмжээгээр хаягддаг. Ер нь бидний баримжаалсан тооцоогоор мах бэлтгэл, үйлдвэрлэлт, худалаалалтын явцад хүнсэнд зарцуулсан малын нийт амьд жингийн 1/4 нь буюу 50 гаруй мян.т тураг махтай тэнцэх хэмжээний хүнсний нөөц алдаж байна<sup>3</sup>.

Үр тариа, төмс, хүнсний ногоо хураах, тээвэрлэх, мах, бусад бүтээгдэхүүний хадгалах, худалдахад янз бүрийн үрэгдэл, хорогдол гардаг. Үүн дээр малын зүй бусын хорогдол, төлтэй малыг саалинд хамруулдаггүй зэрэг дутагдлыг тооцвол манайд хүнсний нөөцийн асар их алдагдал байна. Ийм учраас макро түвшинд хүрсэн үр дүн, нөөц, боломжид суурилан Засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг “тооноос чанарт шилжих”, “нөөцийг үр ашигтай зарцуулах”-д чиглүүлэх нь чухал байна.

Хүнсний хангамж, хуваарилалт, түгээлтэд нэгэнт хэвшсэн “ченжийн тогтолцоо” нь бүтээгдэхүүний эрүүл ахуйн аюулгүй байдлын зөрчил, эрсдэл, хүнсний нөөцийн алдагдлын үндсэн шалтгаан болж байгааг өөрчлөн шинэчлэх цаг нэгэнт болжээ. Түүнчлэн стратегийн хүнсний

<sup>3</sup> Дамдинсүрэн Л, Сэлэнгэ Ц, Алтанцэцэг Д, “Мах үйлдвэрлэлт-нийлүүлэлтийн өртгийн сүлжээний судалгаа”, ХХААЯ, НҮ-ийн ХХААБ, GCP\_MON007\_ІТА төслийн тайлан, 2011

нөөц, хангамжийн судалгаа, тооцооны хэм хэмжээ, арга зүйд технологийн зарчим, түүхий эд, бүтээгдэхүүний логистик урсгалд нийцээгүй, эргэлзээтэй зүйл цөөнгүй байгааг ч хэлэхгүй байхын аргагүй. Бидний судалснаар (Л.Дамдинсүрэн, “Хүн ба хүнс” сэтгүүл, 2020,3) ХАА-д бэлтгэсэн махны хэмжээг нядалгааны жингээр буюу арьс, ширийг хассан жингээр, харин хүн амын хэрэгцээг ясгүй маханд суурилсан жишиг хэмжээгээр, бодит хэрэглээг ястай махаар тооцож байгаа нь махны нөөц, хангамжийн тооцоонд ойлгомжгүй байдал үүсгэж, эцэстээ махны хангамж доголдож, үнэ зохиомлоор өсөх бас нэг шалтгаан ч болох магадлалтай. Жишсэн дундаж нэг хүнд ногдох сүү, цагаан идээний хэрэглээ нь “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт” эмхэтгэл (ҮСХ, 2019)-д жишиг хэмжээнээс 1,9 л-ээр илүү, харин “Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2019”-д жишгээс 17,3 хувиар бага байна. Статистикийн үзүүлэлтүүд ийнхүү зөрүүтэй байгаа нь сүүний нийт нөөцийг зах зээлд бүрэн нийлүүлсэн мэт тооцдог, хэрэглээний жишигт сүү, тараг гэж тусад нь заасан, зарим бүтээгдэхүүн, жишээ нь цөцгий-цөцгийн тос, аарц-бяслагийг нийлүүлэн мэдээлдэг зэрэг олон шалтгаантай. Үтрэмээс буудайг үйлдвэр, нөөцийн агуулах хүртэл тээвэрлэх, эдгээр аж ахуйд буудайн чийгийг стандартад нийцүүлэх, хольцоос цэвэрлэхэд жингийн хорогдол дахин гардаг учраас буудайн нөөц, хангамжийн тооцоо нь үтрэмийн бус, харин агуулах /элеватор/-ын жинд суурилбал илүү оновчтой бөгөөд технологийн зарчим, логистикийн урсгалд нийцнэ гэж үзэж байна.

Манайд хураасан нийт үр тарианы 95-96 хувь нь буудай, дөнгөж 4-5 хувь нь арвай, овъёос байдаг (Статистик эмхэтгэл, 2019), гэтэл хөх тариа, түүний гурил, гурвалжин будаа зэрэг хүнс-биологийн өндөр ач холбогдолтой будааны олон зүйлийг жил бүр 50 мян.т орчим хэмжээгээр импортолж

байгааг ч анхаарах нь хэрэгтэй юм. Эдгээр жишээ нь хүнсний нөөц, хангамжийн төлөвлөлт, төсөөллийг аль болохоор бодитой болгоход юуны өмнө хүнс, хөдөө аж ахуйн статистикийн хөгжил нэн чухал болохыг харуулж байна.

### **ХҮНСНИЙ БОДИТ ХЭРЭГЛЭЭ, ХҮРТЭМЖ**

Статистикийн албан ёсны мэдээллээр улсын хэмжээнд жишсэн дундаж нэг хүний хоногийн хэрэглээний бүтэц сүүлийн жилүүдэд сайжирч, 2019 оны дүнгээр мах, махан бүтээгдэхүүн, сүү, цагаан идээ, гурил, гурилан бүтээгдэхүүн, төрөл бүрийн будаа, чихэр, саахарын зүйлийн зөвлөмж хэмжээ (Эрүүл мэндийн сайд, 2017, А/74)-г хангаж байна. Гэвч хот, хөдөөгийн хүн амын хүнсний хүртэмж эрс ялгаатай хэвээр байна. Тухайлбал, 2019 онд хөдөөгийн 1 хүний махны сарын хэрэглээ улсын дунджаас 2,1 кг, хотынхоос 4,0 кг-аар, сүү, цагаан идээнийх хотынхоос 8,1 кг-аар илүү, харин төмсний хэрэглээ хотынхоос 0,4 кг-аар, хүнсний ногооных бараг 1,0 кг-аар тус тус бага байна. Улсын хэмжээнд өрхийн хувийн аж ахуйгаас бэлтгэсэн хүнсний зүйл 2010 онд өрхийн нийт мөнгөн орлогын 5,6 хувь байсан бол 2019 онд 3,8 хувь болж, хотод 0,54 хувиар, хөдөөд бараг хоёр дахин буурсан нь иргэний санаачлага, төрийн дэмжлэг хэрэгтэй болсны илрэл. Өрхийн хүнсний хэрэгцээний сарын мөнгөн зарлага 2004 онд 56,7 мян.төг, 2008 онд 119,5 мян. төг байсан бол 2019 онд 275,0 мян.төг болж, 2004 оныхоос 4.8 дахин, 2008 оныхоос 2,3 дахин тус тус нэмэгджээ. Эдгээр тоо баримт бол зөвхөн макро түвшингийн буюу улсын дунджийг илэрхийлсэн үзүүлэлт, харин өрх, иргэний хүнсний хүртэмж-хэрэглээг орлогын түвшингээр судлахад эрс өөр дүр зураг гардаг юм. Жишээлбэл, зохистой хэмжээнд дүйцсэн хүнс хоол хэрэглэхэд нэг хүний сарын хүнсний зарлага 90 орчим мян.төг, өрхийнх 350 мян.төг байвал хүрэлцээтэй, харин бидний судалгаагаар

дундаж орлоготой иргэний хүнсний сарын бодит зарлага 71901,0 төг, өрхийнх 287606,0 төг, ядуу иргэн, өрхийнх үүнээс 2,2 дахин, нэн ядуугийнх бараг 3 дахин бага байна. Ийнхүү амьжиргааны түвшин, бодит орлогоос шалтгаалан хүн амын бүлгүүдийн хүнсний хэрэглээ, хүртэмж эрс ялгаатай байна.

Бидний судалгаагаар (Л.Дамдинсүрэн нар, 2009) амьжиргааны дээд түвшинд нэг хүнд ногдох махны хэрэглээ жишиг хэмжээнээс 2,6 дахин, дунд түвшинд 2 дахин тус тус илүү, харин ядуу иргэнийх 1,3 дахин, нэн ядуугийнх 1,8 дахин бага байна<sup>4</sup>. Ийм учраас амьжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой өрхийн хүнсний үндсэн хэрэглээ нь гурил, гурилан бүтээгдэхүүн, төмс төдийхнөөр хязгаарлагддаг. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн “Хоол тэжээлийн үндэсний хэмжээний Нийгмийн V судалгаа, 2017”-аар нийт өрхийн 22,7 хувьд хүнсний баталгаат байдал ноцтой түвшинд алдагдсан нь тогтоогджээ<sup>5</sup>. Мөн НҮБ-ын “Дэлхийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээлийн төлөв байдлын тайлан, 2017”<sup>6</sup>-д Монгол Улсын хүн амын 18,7 хувь нь хүнсний баталгаат байдал алдагдсан нөхцөлд байдаг гэж дүгнэжээ. Дэлхийн хүнсний хөтөлбөр (WFP)-ийн “өлсгөлөнгийн зураглал”<sup>7</sup>-д Монгол Улсыг хүн амын 15-24 хувь нь хүнс хоолны дуталтай орны хэсэгт оруулсны үндэслэл нь 2018 оны дүнгээр манайд ядуурлын хамралтын хүрээ 28,4 хувь, гүнзгийрэлт 7,7 хувь, мэдрэмж 2,7 хувь байгаатай холбоотой гэж үзэж байна (Зураг 1). Хүнсний хувьд эмзэг бүлгийн иргэн, өрхөд төрөөс мөнгөн дэмжлэг үзүүлсээр ирсэн, энэ жил гэхэд цар тахалтай холбогдуулан тусламжийг хоёр дахин нэмэгдүүлээ.

<sup>4</sup> Дамдинсүрэн Л. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллтийн сорчилсон эмхэтгэл, “Алмаз пресс”, 2015

<sup>5</sup> Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2019

<sup>6</sup> <http://www.fao.org/3/a-17695e.pdf>

<sup>7</sup> <https://www.wfp.org/publications/hunger-map> 2020



Зураг 1. Дэлхийн өлсгөлөнгийн тархац



Эх сурвалж: <https://www.wfp.org/publications/hunger-map-2020>

“Нийгмийн халамжийн тухай” хууль (шинэчилсэн найруулга, 2012), “Хүнсний тухай” хууль (шинэчилсэн найруулга, 2012)-иудын холбогдох заалтуудын дагуу эмзэг бүлгийн иргэдэд “хүнсний эрхийн бичиг” олгохын зэрэгцээ хүнсний асуудлаа бие даан шийдвэрлэх чадвартай өрх, иргэний тоог нэмэгдүүлэх талаар нутаг дэвсгэрийн бүх шатны Засаг даргын үйл ажиллагааг улам идэвхжүүлэх, иргэд, ТББ-уудын үйл ажиллагааг дэмжих шаардлага ч бодитой оршиж байна.

### ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (УИХ, 2010)-ын дагуу “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай (УИХ, 2012), Мал, амьтны эрүүл мэндийн тухай (УИХ, 2016), Тариалангийн тухай (УИХ, 2016) зэрэг хууль батлагдаж, лавлагаа болон итгэмжлэгдсэн лабораториудын техник хэрэгсэл, хүний нөөц сайжирч, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын зөрчил, дутагдлыг илрүүлэн арилгах ажилд ахиц гарч байна. Гэвч

бидний зарим судалгаа болон олдцотой мэдээллээс үзэхэд ХАА-н үйлдвэрлэл, хүнсний тээвэрлэлт, хадгалалт, худалдааны үе шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлын эрсдэл өндөр, мал эмнэлгийн ариун цэвэр, мах, сүүний аюулгүй байдал, ургамлын хорио цээрийн хяналт нь гарал үүслийн гэрчилгээ олгох төдийгөөр хязгаарлагдсан хэвээр байна<sup>8</sup>.

“Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хууль (2012)-иар хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд ХАА, үйлдвэрлэл, эрүүл ахуйн зохистой дадлууд хэвшүүлэхээр заасан боловч эрх бүхий байгууллагын заавар, зөвлөмж төдийгөөр энэ ажил хязгаарлагдаж, бэлчээрийн мал аж ахуй, жижиг тариалан, хүнсний зах, тээвэр, “ченж”-ийн тогтолцооны аюулгүй байдал, эрүүл ахуйн хэм хэмжээ өнөө хэр тодорхойгүй байгаа билээ. Монгол Улсад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн 662 стандарт хүчин төгөлдөр байгаагийн 39,6 хувь нь олон

<sup>8</sup> Дамдинсүрэн Л. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлийн сорчилсон эмхэтгэл, “Алмаз пресс”, 2015, “Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын эрх зүйн орчин” үнэлгээний тайлан, Дэлхийн банкны бүлэг, Олон улсын санхүүгийн корпораци, 2015.04, УБ

улсын түвшинд хүрсэн, 60,4 хувь нь олон улсын стандарттай уялдсан гэж холбогдох байгууллагуудаас тайлагнадаг боловч 2019 оны байдлаар тэдгээрийг мөрдөж, тохирлын тэмдгээр батлагаажуулсан аж ахуйн нэгж, бүтээгдэхүүн маш цөөн байгаа болно. Гадаад орнуудын туршлагаас үзэхэд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын үзүүлэлт, хэм хэмжээг Засгийн газрын техникийн зохицуулалтаар тогтоодог нь стандарт, техникийн зохицуулалтын хуулийн чадамжтай холбоотой.

Засгийн газраас согтууруулах ундаа, сүү, цагаан идээ, бялууны үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг 2008-2011 онд баталсан, харин түүнээс хойш энэ ажил зогсонги байдалд оржээ. Хоол хүнсээр дамжих өвчин, халдварт болон халдварт бус хордлогод хүмүүс, ялангуяа бага насны хүүхэд өртөх тохиодол тасрахгүй байгаа бөгөөд тухай бүрт эрүүл мэнд, мэргэжлийн хяналт, онцгой байдлын газар, нутаг дэвсгэрийн засаг захиргаанаас “гал унтраах” зарчмаар ажилладаг, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтийн дунд “шуугиан” дэгдээдэг боловч уг үйл явдал намжсаны дараа чимээгүй болдог, харин нэгэнт гарсан өвчин, хордлого өөр газарт дахин давтагдахгүй гэсэн итгэл, үнэмшил төрд ч, иргэнд ч байхгүй, үүнд бид дасчихаад байгаа нь эмгэнэл юм. Импортын хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын зөрчил, дутагдал тасрахгүй, илрүүлэлт нь тохиолдлын чанартай, ер нь энэ ажил зөрчилтэй бүтээгдэхүүнийг устгах төдийгээр хязгаарлагддаг. Гарал үүсэл нь тодорхойгүй, эсвэл хаяг, шошго нь бидний үл мэдэх хэл бичигтэй, тухайн орны экспортын шаардлагад нийцээгүй

учраас зөвхөн байгууллагын стандартын тэмдэглээтэй, орц, найрлагын мэдээлэл бүрэн бус зэрэг олон зөрчилтэй импортын бараа манай хүнсний зах зээлд нэн элбэг хэвээр байна. Энэ нь “Хяналт, шалгалтын тогтолцоо бүрдээгүй зах зээл рүү гадаадын зөрчилтэй хүнсний урсгал чиглэдэг” гэсэн ДХБ-ын дүгнэлтийн бодит жишээ юм. Ийм учраас импортын хүнсний бүтээгдэхүүний гарал үүсэл, аюулгүйн үзүүлэлт, стандарт, техникийн зохицуулалт, баталгааны талаар хөрш орнууд, Евразийн холбоотой Засгийн газрын түвшинд хэлэлцээр байгуулах цаг болжээ. Манайд гаалийн татвар 5 хувь, харин хоёр хөршид маань 30-аас дээш хувь байгаа нь чанаргүй барааны урсгал манайх руу үргэлжлэх бас нэг шалтгаан юм. Ер нь хүнсний бүтээгдэхүүн импортлогчийн эрх, үүргийг тодорхой болгох, ялангуяа хилийн худалдаа, бараа солилцоо, импортын зааг, ялгааг тогтоох шаардлагатай байна.


### ХҮНС ХООЛНЫ ШИМ ЗҮЙ

Улсын хэмжээнд жишсэн дундаж хүний хэрэглэсэн хүнс хоолны илчлэг, шимт чанар нь зохистой хооллолтын жишгээс 280,0 ккал илүү байна. Хотын хүний 2019 онд хэрэглэсэн хүнс хоолны илчлэг нь зөвлөмжөөс 55 ккал дутуу, уураг нь 15,1 г, өөх тос нь 7,4 г, нүүрс ус нь 11,7 г-аар тус тус бага байжээ<sup>9</sup>. Хөдөөд хүнс хоолны илчлэг болон шимт чанарын бүх үзүүлэлт нь зөвлөмж болон улсын дунджаас илүү байна (Зураг 2). Хоногт хэрэглэсэн нийт уургийн 60-аас дээш хувь нь амьтны гаралтай байгаа нь ДЭМБ-ын үнэлгээгээр “төгс хооллолт”<sup>10</sup> бөгөөд бидний бахархал юм.

<sup>9</sup> Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2019

<sup>10</sup> Innovation in Food and Nutrition Science, International Conference, UB, 2010 Northeast Asian agriculture and Food Security, International Conference, 2009

Зураг 2. Монгол хүний хүнс хоолны шим зүй, 2019



Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхэтгэл 2019, бүлэг 5

Харин өөх тос, түүний дотор амьтны гаралтайнх давамгайлж байгаа нь хүний эрүүл мэндийн хувьд сөрөг үзүүлэлт болно. Манайд цөцгийн тос бараг үйлдвэрлэхээ больсон учраас хэрэгцээг импортын цөцгийн тос орлуулагч (spread), маргаринаар хангадаг бөгөөд эдгээр нь эрүүл мэндэд сөрөг нөлөө бүхий хувирсан тосны хүчил (trans fat-транс тос) агуулдаг учраас бусад оронд импортыг тарифын болон эрүүл ахуйн шаардлагаар хязгаарладаг юм. Гэтэл манайд жил бүр 7000 орчим тонн маргарин импортолдог. “Хоол тэжээлийн үндэсний V судалгаа, 2017”-ны тайланд “...Монголд хүн амын хоол тэжээлийн талаар 2010 оноос хойш багагүй ахиц гарсан боловч бичил тэжээлийн дутал нийт хүн амын дунд түгээмэл, эрүүл мэндийн тулгамдсан асуудал болсон байна” гэж дүгнээд энэ байдал тав хүртэлх насны хүүхдийн дунд хамгийн их тархалттай. Тухайлбал, ийм насны хүүхдийн 27 хувь нь цус багадалттай, 21 хувь нь төмөр, 70 хувь нь А аминдэм, 90 хувь нь Д аминдэмийн дуталтай болохыг

тэмдэглэжээ<sup>11</sup>. Мөн нийт бүс нутгийн түвшинд илүүдэл жин, таргалалтын тархалт тахлын хэмжээнд хүрч, хүүхдийн дунд өсөн нэмэгдсээр нийгмийн эрүүл мэндэд тулгарч буй хамгийн том асуудал болсон тухай ноцтой дүгнэлт хийсэн байна. Түүнчлэн монгол хүний давсны хэрэглээ олон улсын байгууллагын зөвлөмжөөс даруй 3 дахин, чихрийн хэрэглээ 2 дахин тус тус илүү гарч, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх түвшинд хүрсэн байна. Амьдралын боломж муутай өрхөд жимс, жимсгэнэ, хүнсний ногоо, өндөг, загас зэрэг биологийн идэвхит бодисоор баялаг хүнсний хэрэглээ туйлын хангалтгүй, хот, хөдөөгийн хүний хүнсний шимт нэгдэл, бодисын хэрэглээ ч асар их зөрүүтэй байна. Тухайлбал, хотод аминдэм А, В-ийн бүлэг, аминдэм РР, кальц, фосфор, төмөр, харин хөдөөд аминдэм С, В-ийн бүлэг ихээр дутагдаж байна. Тав хүртлэх насны хүүхдийн 41 хувь нь Д аминдэмийн дуталтай, 20.8 хувь нь зулай зөөлөн, хөл нь майга, үе мөч нь хавдартай байна.

<sup>11</sup> Хоол тэжээлийн үндэсний хэмжээний Нийгмийн V судалгаа, 2017

Бидний судалгааны урьдчилсан дүнгээр хотын оршин суугчдын гэдэсний микрофлорын хэвийн тогтолцоо ч ихээхэн алдагдсан байна. Сүүлийн дөрвөн жилийн дунджаар манай оронд жил бүр 15500 хүн нас барсны шалтгааны 46.6 хувийг цусны эргэлтийн тогтолцооны болон хоол шингээх тогтолцооны өвчин эзэлж байна. Дээрх тоо баримтууд, судалгааны дүнгээс үзвэл нийгмийн эмзэг бүлгийн дунд хоол тэжээлийн дутал, харин нийт хүн амын дунд эслэг, олигосахарид, тосны ханаагүй хүчил, аминдэм, бичил эрдэс бодис, ашигтай бичил биетэн зэрэг биологийн идэвхит хүчин зүйлсийн дутал-“физиологийн өлсгөлөн” бодитой оршиж байна. Монголчуудын хувьд байгалийн унаган бүтээгдэхүүнээр зөв хооллодог уламжлалтай ч бусдыг дуурайж, чихэрлэг амт, гадаад төрх, өнгө үзэмжийг амьдралын түвшний баталгаа мэтээр төсөөлөн сүүлийн жилүүдэд “хоолоор эмчлэх” тухай дам яриа, суртачилгаанд ихээхэн өртөж байна.

### ДҮГНЭЛТ, САНАЛ

Хүнсний аюулгүй байдлын бодит түвшний үнэлгээг нэгтгэн дүгнэхэд манайд хүн амын хэрэгцээг бүрэн хангах нөөц байгаа боловч хүнсний хангамж тогтвортой муутай, хүртэмж жигд бус, түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын ноцтой зөрчлүүд дахин давтан гардаг, буруу хооллолт, шимт бодисын дутал нийтлэг болсон зэрэг олон асуудал хуримтлагджээ. Энэ бүхэн нь эцэстээ хүн амын эрүүл аж төрөх үндсэн эрхэд ноцтой нөлөөлж байна. Хүнсний аюулгүй байдлын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх ажлыг юуны өмнө хандлагын өөрчлөлтөөс эхлэх ёстой гэж үзэж байна. Тодруулбал, “хүнсний аюулгүй байдал” (food security)-ыг “бүтээгдэхүүний аюулгүй байдал” (food safety)-тай хутгалгүйгээр удирдлагын бүх шатанд болон иргэн бүр өргөн агуулгаар нь бүрэн ойлгодог болох хэрэгтэй байгаа

юм. Ингэснээр хүнсний аюулгүй байдлын асуудлуудыг удирдлагын дээд шатанд зөвхөн ХХААХҮ-ийн сайд руу, харин нийслэл, аймагт Мэргэжлийн хяналтын газар, хэлтэс рүү, салбарын яаманд Хүнсний үйлдвэрийн бодлого зохицуулалтын газар луу заачихдаг буруу зуршлаас сална.

“Хүнсний тухай” хууль (2012)-ийн 18 дугаар зүйлийн дагуу Засгийн газрын дэргэд байгуулагдсан “Хүнсний аюулгүй байдлын үндэсний зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх нь нэн чухал байна. Энэ зөвлөл нь хүн амын хүнсний бодит хэрэглээ, хангамжийн болон чанар, эрүүл ахуйн төлөв байдал, хүнсний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа, цаашид авах арга хэмжээний талаар жил бүр Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд, хүнсний аюулгүй байдлын төлөв байдлын талаарх тайланг жил бүр УИХ-д танилцуулах үүрэгтэй. Энэ үүрэг хэрэгжвэл хүнсний аюулгүй байдлын асуудлуудад төр, засгийн дээд түвшний анхаарал төвлөрөх болно. Уг зөвлөлийн ажлын албаны нэгжийг ХХААХҮЯ-нд бие даалган байгуулах, нөхцөл байдлын задлан шинжилгээ, үнэлгээ хийх судалгааны мэргэшсэн баг, хэсэг ажиллуулах зэрэг менежментийн өөрчлөлтүүд ч зайлшгүй хэрэгтэй. Үүний зэрэгцээ хүнсний аюулгүй байдлыг хангах талаар нутаг дэвсгэрийн засаг, захиргааны эрх, үүргийг оновчлох шаардлагатай.

Хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, эрүүл ахуйн зохистой дадлууд эзэмших, “ченж”-ийн тогтолцоог өртгийн сүлжээ болгон өөрчлөх, эрүүл ахуйн баталгааг олон улсын түвшинд хүргэх талаар дунд, урт хугацааны стратеги хэрэгжүүлж, бичиг цааснаас амьд ажилд, ярианаас үр дүнд шилжих цаг болжээ. Хүнсний эрхээ бүрэн эдлэх талаар иргэнийг идэвхижүүлэх, хүнсний хэрэглээний боловсролыг хүн бүрт эзэмшүүлэх, уламжлал, шинэчлэлд суурилсан эрүүл хооллолтын бодлого хэрэгжүүлэх нь чухал байна.

---

## ЭХ СУРВАЛЖ

1. Дамдинсүрэн Л. Хүнсний аюулгүй байдлын үндэс, “Сэлэнгэ пресс”, 2015
2. Дамдинсүрэн Л. Эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллийн сорчилсон эмхэтгэл, “Алмаз пресс”, 2015
3. Дамдинсүрэн Л., Сэлэнгэ Ц., Алтанцэцэг Д., бусад. “Мах үйлдвэрлэлт-нийлүүлэлтийн өртгийн сүлжээний судалгаа”, ХХААЯ, НҮ-ийн ХХААБ, GCP\_MON007\_ITA төслийн тайлан, 2011
4. “Монгол Улсын хүнсний аюулгүй байдлын эрх зүйн орчин” үнэлгээний тайлан, Дэлхийн банкны бүлэг, Олон улсын санхүүгийн корпорац, 2015.04, УБ
5. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2019
6. Хоол тэжээлийн үндэсний хэмжээний Нийгмийн V судалгаа, 2017
7. “Хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлт” эмхэтгэл (ҮСХ, 2019)
8. Innovation in Food and Nutrition Science, International Conference, UB, 2010
9. Northeast Asian agriculture and Food Security, International Conference, 2009
10. <https://www.wfp.org/publications/hunger-map> 2020



Э.ЭНХМАА (Ph.D)

## ХҮНСНИЙ ИМПОРТЫН ХЯНАЛТ БА СОРИЛТЫН ЛАБОРАТОРИУДЫН ЧАДАВХЫН ӨНӨӨГИЙН ТҮВШИН

*The main goal of this study focused on the specialized and laboratory's inspections for import food safety. We have been determined current potentiality of the National reference laboratory for food safety and Inspection laboratories for food safety which located near the Altanbulag and Zamiin-Uud border posts. It has been observed that the specialized inspections for import food based on risk classification are no effect. Also current potentiality of the main three laboratories is insufficient to do complete inspections for food safety parameters due to lack of equipments and reagents.*

**Keywords:** *food safety, food inspection laboratory, food hygiene, pesticide, phytosanitary*

### ОРШИЛ

Монгол Улсын хүн амд хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл болон хорт хавдар сүүлийн 20 гаруй жилд эрс өсч байгаа ба элэг, ходоодны хорт хавдраар өвчлөл хамгийн их байна. Ялангуяа хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл, ходоод, элэгний хорт хавдрын өсөлтийг хүнсний аюулгүй байдалтай шууд холбож

үзэх нь хамгийн бодитой юм. Бусад төрлийн хорт хавдрын ихсэлт ч мөн хүнсний аюулгүй байдалтай холбоотой байх үндэстэй. Монгол Улсад хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин сүүлийн 21 жилд (1996-2016 он) тогтмол хоёрдугаарт<sup>1</sup> бичигдэж,

<sup>1</sup>Э.Энхмаа. Монгол Улсын хүн амын нийт өвчлөлийн хорин нэгэн жилийн тархалтад хийсэн судалгаа. УБ., 2017.

элэгний хорт хавдар хамгийн ихтэй, ходоодны хорт хавдрын өвчлөлөөр БНСУ-ын дараа<sup>2</sup> хоёрт эрэмбэлэгдэж байгаа нь хоол хүнсний чанар, аюулгүй байдал дорой байгааг харуулж байна.

Нийгэм, эдийн засгийн шилжилтийн он жилүүдэд Монгол хүний хоол хүнсний бүтэц, хэв маяг ихээхэн өөрчлөгдсөний нэг илрэл нь импортын хүнс нэлээд хэрэглэдэг болсон явдал юм.

Иймд Стратеги судалгааны


<sup>2</sup> International Agency for Research on Cancer, WHO.

хүрээлэнгээс 2017-2018 онд импортын хүнсний аюулгүй байдалд холбогдох асуудлаар иж бүрэн судалгаа хийж, дараах үр дүнд хүрээд байна.

### ХҮН АМЫН ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТЭН ТОГТОЛЦООНЫ ӨВЧЛӨЛ СҮҮЛИЙН 20 ЖИЛД ЭРС ИХЭСЛЭЭ

1996 оноос хойш, 2016 оны байдлаар 10000 хүнд ногдох хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл Говьсүмбэр, Дархан-Уул, Сэлэнгэ, Хөвсгөлөөс бусад 17 аймагт **1,1-17,6** дахин ихэсчээ (Хүснэгт 1, Зураг 1).

#### Хүснэгт 1, Зураг 1. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөлийн ихсэлт, 1996-2016 он



*Эх сурвалж: ЭМЯ-ны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн өгөгдөлд түшиглэн тооцоолов.*

1996 он буюу нийгэм, эдийн засгийн шилжилтийн эхэн үетэй харьцуулахад хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчлөл 21 аймагт дунджаар **2,5** дахин, Улаанбаатарт **5,2** дахин ихэсчээ. Аймаг, орон нутагтай

харьцуулбал нийслэлийн хүн амын хүнсний хэрэглээний сагсанд импортын хоол хүнс харьцангуй их байгаа бөгөөд энэ нь өвчлөл ихсэх шалтгаан болж байх магадлал өндөр юм (Зураг 2, 3).

Зураг 2.



Зураг 3.



### ХОРТ ХАВДРААР ӨВЧЛӨЛ ЧИМЭЭГҮЙ ДАЙНЫ ТҮВШИНД БАЙНА

2016 оны байдлаар жилд 41214 хүн хоол боловсруулах эрхтэн тогтолцоо, түүний дотор дийлэнх нь элэг, ходоодны хорт хавдарт нэрвэгджээ. 2017 оны байдлаар

нийт хорт хавдрын 69,8 хувийг эзэлж буй таван төрлийн хорт хавдар (Хүснэгт 2)-аас гурав нь хоол боловсруулах эрхтэнд хамаатай төдийгүй 80-аас илүү хувь нь хэт хүндэрсэн үедээ оношлогдсон.

### Хүснэгт 2. Хорт хавдрын түгээмэл тохиолдож буй хэлбэрүүд, 2017 он

Хорт хавдрын нэр	Нийт хорт хавдрын дотор эзлэх хувь	Хорт хавдраар өвчлөгсдийн тоо, жилд	Хорт хавдраар нас барагсдын тоо, жилд	Хожуу үедээ оношлогдож байгаа хувь
Элэгний хорт хавдар	38.1	2312	1614	79.5
Ходоодны хорт хавдар	14.6	889	621	85.5
Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдар	4.0	241	157	83.1
Умайн хүзүүний хорт хавдар	5.9	356	127	52
Уушгины хорт хавдар	7.2	435	382	93.8
<b>Нийт</b>	<b>69.8</b>	<b>4233</b>	<b>2901</b>	-

Эх сурвалж: ХСҮТ-ийн Хорт хавдрын бүртгэл, тандалт, эрт илрүүлгийн албаны мэдээлэл

Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны хорт хавдар (Хүснэгт 3) болон бусад өвчлөл, үүнээс шалтгаалсан нас баралтыг бууруулахын

тулд хүнсний аюулгүй байдлыг хангаж, чанарыг сайжруулах шаардлага зайлшгүй чухал.



### Хүснэгт 3. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны хорт хавдар, 2006-2015 он (шинээр бүртгэгдсэн тохиолдол)

Хорт хавдар	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Уруул, амны хөндий, залгиурын	46	39	70	60	83	76	78	79	112	91
Улаан хоолойн	291	269	301	293	339	281	330	329	382	366
Ходоодны	512	516	641	637	619	658	665	756	882	817
Бүдүүн гэдэсний	49	55	73	69	89	73	97	135	147	137
Шулуун гэдэс, хошногоны	32	24	46	36	30	49	46	46	41	51
Элэг ба элэгн дэх цөсний сувгийн	1260	1380	1546	1674	1722	1755	1712	1967	1907	2176
Нойр булчирхайн	62	45	55	92	68	88	103	118	119	164
Хоол боловсруулах замын бусад	25	31	19	13	24	16	16	22	36	35
<b>Нийт</b>	<b>2277</b>	<b>2359</b>	<b>2751</b>	<b>2874</b>	<b>2974</b>	<b>2996</b>	<b>3047</b>	<b>3452</b>	<b>3626</b>	<b>3837</b>

Эх сурвалж: Эрүүл мэндийн яамны харьяа Эрүүл мэндийн хөгжлийн төвийн мэдээлэл

### ХҮНСНИЙ ИМПОРТЫН ХЯНАЛТ СУЛ, БАТАЛГААГҮЙ БАЙНА

Импортын хүнсний нийт 773 нэр төрлийн бүтээгдэхүүний 318 (41,1 хувь)-ыг огт шинжлэхгүй байна. Монгол Улсын хилийн 26 боомтын 22-оор жилд ойролцоогоор 270 мянган

тонн хүнс импортолдог. Энэ нь нэг Монгол хүн жилд дунджаар 90 кг импортын хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэг гэсэн үг. Импортын хүнсний бүтээгдэхүүний 99 хувь нь Алтанбулаг, Замын-Үүд, Сүхбаатар, Буянт-Ухаа боомтоор нэвтэрч байна (Хүснэгт 4).

### Хүснэгт 4. Нэг жилд импортолдог хүнсний хэмжээ

Боомтын нэр	Хэмжээ (тн)	Импортод эзлэх хувь (%)
Замын-Үүд	96,000	35,6
Сүхбаатар	89,000	33,0
Буянт-Ухаа	50,000	18,5
Алтанбулаг	32,000	11,9
Бусад	3,000	1
<b>Нийт</b>	<b>270,000</b>	<b>100</b>

### ИМПОРТЫН БАРААГ ЭРСДЭЛИЙН ГУРВАН ЗЭРЭГТ АНГИЛЖ ХЯНАХ ТОГТОЛЦОО ОНОВЧГҮЙ БАЙНА

2014 оныг хүртэл хилийн мэргэжлийн хяналт импортын бүх бараанаас дээж авч шинжилдэг байсан. Хил гаалийн үйл ажиллагааг шуурхай болгох зорилгоор Засгийн Газрын 2014 оны долоодугаар сарын 28-ны өдрийн 233

дугаар тогтоолоор импортын барааг эрсдэлийн гурван зэрэгт ангилан хянадаг болсон. Гэвч энэ тогтолцоо нь хяналтыг саармагжуулан чанаргүй хүнс хилээр нэвтрэх цоорхой бий болгожээ. Хилийн мэргэжлийн хяналтад хамрагдах ёстой 2194 нэр төрлийн бараанаас 773 нь импортын хүнс байна. Эрсдэлийн зэргийн ангилал бүрт харгалзах бүтээгдэхүүний тоо, эзлэх хувийг тооцоолон Хүснэгт 5-д үзүүлэв.

### Хүснэгт 5. Импортын хүнсний эрсдэлийн зэрэг

Эрсдэлийн зэрэг	Тоо ширхэг	Эзлэх хувь
Бага	92	11,9
Дунд	226	29,2
Их	455	58,9
<b>Нийт</b>	<b>773</b>	<b>100</b>

Эрсдэлийн гурван зэрэгт ангилсан бүтээгдэхүүнд хилийн мэргэжлийн хяналт, шалгалтыг дараах хэлбэрээр хийж байхаар журамласан (Хүснэгт 6) нь импортын хүнсний бүтээгдэхүүн бүрээс дээж авч шинжлэх нөхцөлийг хаажээ.

### Хүснэгт 6. Импортын хүнсний хилийн мэргэжлийн хяналт

Хяналт, шинжилгээний хэлбэр	Эрсдэлийн зэрэг		
	Бага эрсдэлтэй 92 бүтээгдэхүүн	Дунд эрсдэлтэй 226 бүтээгдэхүүн	Их эрсдэлтэй 455 бүтээгдэхүүн
Баримт бичгийн хяналт	√	√	√
Биет үзлэг		√	√
Лабораторийн шинжилгээ			√

Ийнхүү бага эрсдэлтэй 92, дунд эрсдэлтэй 226 нийт 318 бүтээгдэхүүнд буюу импортын хүнсний барааны 41,1 хувьд “Лабораторийн шинжилгээт хяналт” огт хийхгүй байна.

### ИМПОРТЫН ХҮНСНИЙ ШИНЖИЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ НЭГДСЭН ТОГТОЛЦОО БҮРДЭЭГҮЙ БАЙНА

Импортын хүнсний бүтээгдэхүүнд “Аюулгүйн үзүүлэлтүүд”-ийн стандарт, шаардлагын дагуу лабораторийн иж бүрэн шинжилгээ хийх үндэсний нэгдсэн тогтолцоо бүрдээгүй байна. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори (ХАБҮЛЛ) болон Замын-Үүд, Алтанбулаг боомт дахь лабораториуд импортын хүнсийг шинжилдэг. Алтанбулаг, Замын-Үүд боомт дахь хүнсний шинжилгээний лабораторийн хүчин чадал, технологи тун хангалтгүй. ХАБҮЛЛ тоног

төхөөрөмж, хүний нөөц сайтай боловч зарим багаж хэрэгсэл, урвалж бодисын хангамж дутагдалтай байдаг.

### ХҮНСНИЙ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХИМИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Хүнсний бүтээгдэхүүний химийн аюулгүйн үзүүлэлтүүдийг бичил мөөгөнцрийн ялгаруулдаг хор буюу микотоксин, химийн хорт бодис, пестицид, хүнд металл гэсэн 4 төрөлд хувааж болохоор байна<sup>3</sup> (Зураг 4).

<sup>3</sup> Эрүүл мэндийн сайдын 2014 оны 384 дүгээр тушаалаар баталсан хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн жагсаалтад химийн аюулгүйн 40 үзүүлэлт багтжээ.

### Зураг 4. Хүнсний бүтээгдэхүүний химийн аюулгүйн үзүүлэлтүүд (нийт 40)

Биет мөөгөнцрийн классуудад хор буюу микотоксин (6)	Хорт бодис (3)	Пестицид (20)	Хүнд металл (6)
<ul style="list-style-type: none"> <li>Адиглатоксин B1</li> <li>Адиглатоксин B1</li> <li>Нилбар адиглатоксин B1, B2, O1 ба O2</li> <li>Окразатоксин А</li> <li>Завралинон</li> <li>T-2</li> <li>Папулин</li> <li>Фузарион B1 ба B2 нилбар</li> <li>Эноксинвалентил</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Меланин</li> <li>Бакро-А-прин</li> <li>Испрат</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Альдрин-Дельдрин</li> <li>Гарлентар</li> <li>2, 4-Д</li> <li>Дельтаметрин</li> <li>Диванон</li> <li>Паратрин</li> <li>Ципрометрин</li> <li>Гароксифос-метил</li> <li>Малатион</li> <li>Паратрин-метил</li> <li>Эндрин</li> <li>ДДТ</li> <li>Метилформид</li> <li>Фосфан газ</li> <li>Линдан (ГХДГ)</li> <li>ДДФ</li> <li>Гексахлоран (Тендан)</li> <li>Алорцифос</li> <li>Трихлорфан</li> <li>Гексахлорциклопентан (α, β, γ) изомер (Тендан)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хар тулалга</li> <li>Цагаан тулалга</li> <li>Кадмийн</li> <li>Цинк</li> <li>Зэс</li> <li>Тангер</li> <li>Мөнгөн улс</li> <li>Хууцал</li> </ul>

Хими, хор судлалын аюулгүйн дөрвөн төрлийн 40 үзүүлэлтээс ХАБҮЛЛ 39 (97,5 хувь), Замын-Үүд боомтын лаборатори 29 (72,5 хувь) үзүүлэлтийг голдуу чанарын

аргаар<sup>4</sup>, Алтанбулаг боомтын лаборатори дөнгөж 6 (15 хувь) үзүүлэлт шинжилж байна (Хүснэгт 7-8).

<sup>4</sup> Тодорхой интервал, тоон үзүүлэлтээр биш, байгаа эсэхийг илрүүлэх төдий аргаар шинжилж байна.

### Хүснэгт 7. Хүнсний бүтээгдэхүүнд микотоксин, хорт бодис, хүнд металлын үлдэгдэл шинжилж буй өнөөгийн түвшин

№	Хүнсний сорилтын лаборатори	Микотоксин			Хорт бодис			Хүнд металл		
		Шинжилбэл зохих	Шинжилдэг:		Шинжилбэл зохих	Шинжилдэг:		Шинжилбэл зохих	Шинжилдэг:	
			Тоо	Хувь		Тоо	Хувь		Тоо	Хувь
1	ХАБУЛЛ	9	9	100	3	3	100	8	7	87,5
2	Алтанбулагийн лаборатори	9	3	33,3	3	2	66,7	8	0	0
3	Замын-Үүдийн лаборатори	9	7	77,8	3	3	100	8	0	0

**Пестицидийн шинжилгээ.** Хүнсний бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээг үндэсний стандартад заасан шинжилбэл зохих үзүүлэлт, тоо хэмжээний дөнгөж 13,6 хувьтай тэнцэх түвшинд хийж байна. Монгол Улсын үндэсний стандартад хүнсний бүтээгдэхүүнд

нийт 963 пестицидийн үлдэгдэл шинжлэхээр заасан байхад давхардсан тоогоор 131, бодит тоогоор хамгийн ихдээ 20 төрлийн пестицид шинжилж байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм (Хүснэгт 8). Энэ нь зарим талаар пестицид илрүүлэх шинжилгээний урвалжийн үнэ их, хангамж муу байгаатай холбоотой.

### Хүснэгт 8. Хүнсний бүтээгдэхүүнд пестицидийн үлдэгдэл шинжилж буй өнөөгийн түвшин

№	Хүнсний бүтээгдэхүүний:		Пестицидийн шинжилгээний тоон үзүүлэлтүүд			
	Нэр	Төрөл	Шинжилбэл зохих	Шинжилдэг	Шинжилж чадах хувь	Шинжилж чаддаггүй хувь
1	Сүү, сүүн бүтээгдэхүүн	4	98	10	10,2	89,8
2	Мах, махан бүтээгдэхүүн	7	125	14	11,2	88,8
3	Үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн	5	63	8	12,7	87,3
4	Хүнсний ногоо	12	270	44	16,3	83,7
5	Жимс, жимсгэнэ	24	359	45	12,5	87,5
6	Хүүхдийн хоол тэжээл		-	-		
7	Ус, ундаа, хүнсний бусад бүтээгдэхүүн	5	20	9	45,0	55,0
8	Ургамал, амьтны гаралтай тос	9	28	1	3,6	96,4
	<b>Нийт</b>	<b>66</b>	<b>963</b>	<b>131</b>		

Хүнсний гол нэрийн долоон төрлийн 66 бүтээгдэхүүнд шинжилбэл зохих

пестицидийн 55,0-96,4 хувийг огт шинжилж чадахгүй байна (Зураг 5).

### Зураг 5. Хүнсний бүтээгдэхүүнд пестицид шинжилж чадахгүй байгаа түвшин



Импортын хүнсний сорилтын гурван лабораторид үндэсний стандартад заасан шинжилбэл зохих пестицидийн төрлөөс:

1) **Сүү, сүүн бүтээгдэхүүн.** Дөрвөн

төрлийн бүтээгдэхүүнд 1-72 янзын, нийт 98 пестицид шинжлэхээс **10** (10,2 хувь)-ыг шинжилж, **89,8 хувийг огт шинжлэхгүй** байна (Зураг 6).


**Зураг 6. Сүү, сүүн бүтээгдэхүүнд пестицид шинжилж чадахгүй байгаа түвшин**



2) **Мах, махан бүтээгдэхүүн, өндөг.** Долоон төрлийн бүтээгдэхүүнд 2-74 янзын, нийт 125 пестицид шинжлэхээс 14

(11,2 хувь)-ийг шинжилж, **88,8 хувийг огт шинжилдэггүй** (Зураг 7).

**Зураг 7. Мах, махан бүтээгдэхүүнд пестицид шинжилж чадахгүй байгаа түвшин**



3) **Үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн.** Таван төрлийн бүтээгдэхүүнд 4-27 янзын, нийт 63 пестицид шинжлэхээс

найм (12,7 хувь)-ыг шинжилж, **87,3 хувийг огт шинжилдэггүй** (Зураг 8).


**Зураг 8. Үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүнд пестицид шинжилж чадахгүй байгаа түвшин**



4) **Хүнсний ногоо.** 12 төрлийн бүтээгдэхүүнд 2-66 янзын, нийт 270 пестицид шинжлэхээс 44 (16,3 хувь)-ийг

шинжилж, **83,7 хувийг огт шинжлэхгүй** байна (Зураг 9).

Зураг 9. Хүнсний ногоонд пестицид шинжилж чадахгүй байгаа түвшин



5) **Жимс, жимсгэнэ.** 24 төрлийн бүтээгдэхүүнд 1-60 янзын, нийт 359 пестицид шинжлэхээс 45 (12,5 хувь)-ыг

шинжилж, **87,7 хувийг огт шинжлэхгүй** байна (Зураг 10).


Зураг 10. Жимс, жимсгэнэд пестицид шинжилж чадахгүй байгаа түвшин



6) **Ус, ундаа, хүнсний бусад бүтээгдэхүүн.** Таван төрлийн бүтээгдэхүүнд 1-10 янзын, нийт 20 пестицид шинжлэхээс

ес (45,0 хувь)-ийг шинжилж, **55,0 хувийг огт шинжилдэггүй** (Зураг 11).


Зураг 11. Ус, ундаа, хүнсний бусад бүтээгдэхүүнд пестицид шинжилж чадахгүй байгаа түвшин



7) **Ургамал, амьтны гаралтай тос.** Есөн төрлийн бүтээгдэхүүнд 1-8 янзын, нийт 28

пестицид шинжлэхээс нэг (3,6 хувь)-ийг шинжилж, **96,4 хувийг огт шинжлэхгүй** байна (Зураг 12).

**Зураг 12. Ургамал, амьтны гаралтай тосонд пестицид шинжилж чадахгүй байгаа түвшин**



**Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний химийн аюулгүйн үзүүлэлтийн шинжилгээ.** Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний<sup>5</sup> химийн аюулгүй байдлын

<sup>5</sup> Хүнсний бүтээгдэхүүнд өнгө, үнэр, амт оруулах, биежүүлэх, сийрэгжүүлэх, хадгалалтыг уртасгах, технологи ажиллагааг хурдасгах зорилгоор үйлдвэрлэлийн явцад ашигладаг байгалийн ба синтетик гаралтай нэмэлтийг хүнсний нэмэлт бүтээгдэхүүн гэдэг.

**Хүснэгт 9. Хүнсний нэмэлт бүтээгдэхүүний химийн аюулгүйн үзүүлэлтийг шинжилж буй өнөөгийн түвшин<sup>7</sup>**

Химийн аюулгүйн үзүүлэлтийн нэр		Хүнсний сорилтын голлох лабораториуд		
		ХАБУЛЛ	Алтанбулагийн лаборатори	Замын-Үүдийн лаборатори
1	Ургамлын каротинууд	(-)	(-)	(-)
2	Рибофлавиноуд	(-)	(-)	(-)
3	Нүүрсхүчлийн кальцийн давс	(+)	(-)	(-)
4	Бриллиант хөх	(+)	(-)	илрүүлнэ
5	Карамель IV	(-)	(-)	(-)
6	Глицеролын диацетил дарсны болон тосны хүчлийн эфирууд	(-)	(-)	(-)
7	Полисорбатууд	(-)	(-)	(-)
8	Аскорбилын эфирууд	(-)	(-)	(-)
9	Бутилжсэн гидроксанизол	(-)	(-)	(-)
10	Аннатогийн ханд	(+)	(-)	(-)
11	Токоферолууд	(-)	(-)	(-)
12	Бензойны хүчлийн давсууд	(+)	(-)	(-)

<sup>7</sup> (+) тоон аргаар шинжилнэ, илрүүлнэ-чанарын аргаар илрүүлэх төдий шинжилнэ, (-) шинжлэхгүй

29 үзүүлэлтээс<sup>6</sup> хоёр лаборатори 13,8; 38,0 хувийг тус тус шинжилж байгаа бол Алтанбулаг боомтын лаборатори эдгээрийг **огт шинжилдэггүй** (Хүснэгт 9).

<sup>6</sup> Эрүүл мэндийн сайдын 2014 оны 384 дүгээр тушаалаар баталсан хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн жагсаалтад хүнсний нэмэлт бүтээгдэхүүний химийн аюулгүйн үзүүлэлт 29 байна.

13	Карамель III	(-)	(-)	(-)
14	Кармин	(-)	(-)	илрүүлнэ
15	Тод ногоон FCF	(+)	(-)	илрүүлнэ
16	Төмрийн ислүүд	(-)	(-)	(-)
17	Изопропилцитрат	(-)	(-)	(-)
18	Хүхэрлэг хүчлийн давсууд	(-)	(-)	(-)
19	EDTAs	(-)	(-)	(-)
20	Пропилгаллат	(-)	(-)	(-)
21	Нитрит	(+)	(-)	илрүүлнэ
22	Фосфат	(-)	(-)	(-)
23	Азодикорбанамид	(+)	(-)	(-)
24	Сорбины хүчлийн давсууд	(+)	(-)	(-)
25	Сахарин түүний натри, кали, кальцийн давсууд	(+)	(-)	(-)
26	Нимбэгний хүчлийн төмөр аммоны давс	(-)	(-)	(-)
27	Аспартам	(+)	(-)	(-)
28	Хлорфил зэсийн нэгдэл	(-)	(-)	(-)
29	Гваякийн давирхай	(-)	(-)	(-)
	<b>Нийт (тоо)</b>	<b>10</b>	<b>0</b>	<b>4</b>
	<b>Нийт (хувь)</b>	<b>34.5%</b>	<b>0%</b>	<b>13.8%</b>

**Нян судлалын аюулгүйн үзүүлэлтийн шинжилгээ.** Нян судлалын

аюулгүйн 27 үзүүлэлтийг бичил биетний (14) ба эрүүл ахуйн (13) шалгуур үзүүлэлт гэж хоёр ангилдаг.

**Хүснэгт 10. Хүнсний бүтээгдэхүүнд нян судлалын аюулгүйн үзүүлэлт шинжилж буй түвшин**

№	Хүнсний сорилтын лаборатори	Бичил биетэн			Эрүүл ахуй		
		Шинжилбэл зохих	Шинжилдэг:		Шинжилбэл зохих	Шинжилдэг:	
			Тоо	Хувь		Тоо	Хувь
1	ХАБҮЛЛ	14	11	78,6	13	13	100
2	Алтанбулагийн лаборатори	14	1	7,1	13	5	38,5
3	Замын-Үүдийн лаборатори	14	4	28,6	13	12	92,3

**Ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн аюулгүйн үзүүлэлт.** Хүнсний бүтээгдэхүүний ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн аюулгүйн 92 үзүүлэлтээс<sup>8</sup> Замын-

<sup>8</sup> Эрүүл мэндийн сайдын 2014 оны 384 дүгээр тушаалаар баталсан хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн

Үүд боомтын лаборатори **ургамлын өвчин илрүүлж чаддаггүй**, Алтанбулаг боомтын лаборатори **ургамлын өвчин болон дүгрэг хорхой илрүүлж чадахгүй байна** (Хүснэгт 11).

үзүүлэлтийн жагсаалтад ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн аюулгүйн 92 үзүүлэлт заажээ.

### Хүснэгт 11. Хүнсний бүтээгдэхүүнд ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн аюулгүйн үзүүлэлт шинжилж буй өнөөгийн түвшин<sup>9</sup>

<sup>9</sup> (+) илрүүлнэ, (-) илрүүлэхгүй

№	Үзүүлэлт	Төрөл	Хүнсний сорилтын голлох лабораториуд		
			ХАБҮЛЛ	Алтанбулагийн лаборатори	Замын-Үүдийн лаборатори
<b>1. Үр тариа</b>					
1	Хөнөөлт шавьж	12	+	+	+
2	Ургамлын өвчин	5	+	-	-
3	Хог ургамал	12	+	+	+
<b>2. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ</b>					
1	Хөнөөлт шавьж	9	+	+	+
2	Ургамлын өвчин	9	+	-	+
3	Дүгрэг хорхой	5	+	-	+
<b>3. Гурил, будаа, элсэн чихэр, цай, үрлэн кофе, тамхины түүхий эд (дүнс)</b>					
1	Хөнөөлт шавьж	14	+	+	+
<b>4. Таримал цэцэг, бут, суулгац, мод, модон бүтээгдэхүүн, хөрс, малын тэжээл</b>					
1	Хөнөөлт шавьж	6	+	+	+
2	Ургамлын өвчин	5	+	-	-
3	Дүгрэг хорхой	5	+	-	+
4	Хог ургамал	10	+	+	+
	Нийт	92	92 (100%)	63 (68,5%)	82 (89,1%)

**Цацрагийн аюулгүй байдлын үзүүлэлт.** Монгол Улсад одоогоор хүнсний бүтээгдэхүүний цацрагийн бохирдлын зөвшөөрөгдөх хэмжээг тогтоосон үндэсний стандарт байхгүй, импортын хүнсний бүтээгдэхүүн үндсэндээ цацрагийн хяналтгүй нэвтэрч байна. Цацрагтай холбогдох MNS 5069:2001, MNS 5076:2013,

MNS 5626:2006 зэрэг үндэсний стандарт нь үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ зэрэг ургамлын гаралтай бүтээгдэхүүн, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд байгалийн (U-238, Th-232, K-40) болон үүсмэл (Cs-137, Cs-134) цацраг идэвхт изотопуудын хувийн идэвхийг тодорхойлох шинжилгээний аргад хамаатай.

### Хүснэгт 12. Хүнсний бүтээгдэхүүнд агуулагдах зохиомол (байгалийн бус) цацраг идэвхт изотопын хувийн идэвхийн зөвшөөрөгдөх хэмжээ

Хүнсний бүтээгдэхүүний төрөл		Цацраг идэвхжил БК/КГ (bequerel/kg)	
		Цезий-137 (Cs-137)	Стронций -90 (Sr-90)
1	Хүүхдийн төрөл бүрийн хоол, хүнс	50	50
2	Ундны ус	10	10
3	Сүү, цагаан идээ	50	50
4	Бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүн	100	100



**Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори (ХАБҮЛЛ) нь:**

- “Цацрагийн хяналтын лаборатори”-доо гамма спектрометрийн аргаар олон улсын хэмжээнд хүнсний бүтээгдэхүүнд зайлшгүй шинжлэх ёстой гэж үздэг зохиомол цацраг идэвхт дээрх хоёр төрлийн изотопоос зөвхөн Цезий-137-гийн хувийн идэвхийг тодорхойлж, багаж төхөөрөмжгүйн улмаас Стронций-90-ийг хэмжиж чадахгүй байна.
- Төрөл бүрийн цацраг идэвхт элементүүдийн агууламж бүхий сүү, сүүн бүтээгдэхүүн, мах, хагаасан мах, загас, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, амтан, ундаа, согтууруулах ундаа, тамхи, бусад нэмэлт тэжээл зэрэг хүнсний бүтээгдэхүүний дээжинд зохиомол цацраг идэвхт Цезий-137, байгалийн цацраг идэвхт Калий-40 изотопуудын хувийн идэвх, гамма

цацрагийн нийлбэр идэвхийг тодорхойлж байна.

- Хүнсний бүтээгдэхүүнд нийлбэр альфа, бета цацрагийн нийлбэр идэвхийг тодорхойлох багаж төхөөрөмж ашиглалтад оруулсан боловч шаардлагатай урвалж бодис, туслах химийн боловсруулалтын төхөөрөмж, хэрэгслээр хангагдаагүй байна.

**ХҮНСНИЙ ИМПОРТ НЭГДМЭЛ ХЯНАЛТГҮЙ, ЗОХИЦУУЛАЛТ СУЛ БАЙНА**

Хүнсний сорилтын итгэмжлэгдсэн лабораториудын мэдээллийн нэгдмэл сан үүсээгүй. Монгол Улсад өнөөгийн байдлаар хүнсний сорилтоор итгэмжлэгдсэн 64 лаборатори (Хүснэгт 13) байгаа боловч үйл ажиллагааны уялдаа, нэгдсэн мэдээллийн сан бий болж чадаагүй байна. Ялангуяа хувийн хэвшлийн итгэмжлэгдсэн лабораториуд шинжилгээний дүнгээ ХАБҮЛЛ дахь мэдээллийн нэгдсэн санд хүргүүлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлдэггүй.

**Хүснэгт 13. Хүнсний сорилтын итгэмжлэгдсэн лабораториуд**

Итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага	Тоо	Өмчийн хэлбэр	
		Төрийн	Хувийн
Үндэсний хэмжээний үйлчилгээтэй лаборатори	4	√	
Хилийн боомтын лаборатори	3	√	
Нийслэлийн лаборатори	3	√	
Орон нутгийн лаборатори	20	√	
Хүрээлэн, дээд сургуулийн лаборатори	4	√	
ХХК-ийн лаборатори	30		√
Нийт	64	34	30

Хүнсний бүтээгдэхүүний химийн, хор судлалын аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалт дутаж байна. Монгол Улсад “Хүнсний тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай”, “Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн

хяналт, шалгалтын тухай” зэрэг хүнсний суурь хуулиуд хэрэгжиж байгаа хэдий ч гадаадын зарим улс орны адил хүнсний хими, махны хяналт, пестицидийн зохицуулалтын тухай гэх мэт тусгайлсан хуулиуд байхгүй. Хүнсний бүтээгдэхүүний химийн аюулгүйн үзүүлэлтүүд огт хуульчлагдаагүй байна. “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг

хангах тухай” хуулийн 6.4-д хүнсний хяналт хэрэгжүүлэх төрийн байгууллага нь зөвхөн эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөх, 18.1.3-т импортын болон дотоодод үйлдвэрлэсэн хүнс эрүүл ахуй, ариун цэврийн зохих шаардлага хангаж байгаа эсэхэд мөн л эрсдэлд суурилсан тандалт зохион байгуулахаар заасан.

ОХУ нь байнгын эргэлтэд буй хүнсний чанар, түүнд холбогдох мэдээлэлд системтэй анализ хийдэг ажээ. Тус улсад зарим төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг импортлохыг хориглосон бөгөөд хүнсний бүтээгдэхүүнд аюулгүй байдлын гэрчилгээ олгож, олгогдсон гэрчилгээг дахин баталгаажуулдаг тогтолцоо үйлчилдэг<sup>10</sup>. Япон Улс экспортлогч орнуудынхаа төрийн албан хаагчид болон хүнсний компаниудад мэдээлэл өгч, техникийн хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг байнга хийдэг<sup>11</sup> бол АНУ-д хүнсний бүтээгдэхүүн экспортоддог гадны орнуудын компаниуд АНУ-ын Хүнс, эмийн хяналтын агентлагт заавал бүртгэлтэй, “Эрсдэлийн шинжилгээнд суурилсан урьдчилсан хяналтын төлөвлөгөө”-нд шилжсэн байхыг хатуу шаарддаг ажээ<sup>12</sup>.

**Импортлосон хүнсний эцсийн хэрэглэгчид шуурхай хүргэх тээвэр, дэд бүтцийн стандарт, зохицуулалт**

<sup>10</sup> <http://ipipip.ru/spisok-zapreschennyh-tovarov/>

<sup>11</sup> <http://www.mhlw.go.jp/file/06-Seisakujouhou-11130500-Shokuhinzenbu/0000150035.pdf>

<sup>12</sup> <https://www.ers.usda.gov/data-products/us-food-imports/documentation.aspx>

**үгүйлэгдэж байна.** “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулиар (5.1.2. заалт) хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хариуцах үүргийг хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд хүлээлгэсэн нь импортлосон бүтээгдэхүүнтэй холбоотой ямар нэг “ноцтой асуудал” үүссэн тохиолдолд л хариуцлага яригдах “цоорхой” бий болгосон. Гарал үүслийн хувьд тодорхойгүй, оюуны өмчийг хулгайгаар ашигласан, хуурамч хүнсний бүтээгдэхүүн импортлохыг хориглосон заалт хуульд байхгүй.

*Байгаль уур амьсгал, газарзүйн байрлалын хувьд Монгол Улсаас эрс ялгаатай гадны олон улсаас хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүнээ их хэмжээгээр импортлож буй нь хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангахад харш үзэгдэл юм.*

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний 2016 оны импортын мэдээнээс<sup>13</sup> харвал дэлхийн 75 улсаас хүнсний өргөн хэрэглээний 12 нэр төрлийн, 268368.5 тонн бүтээгдэхүүн импортложээ (Хүснэгт 14). Ийм нөхцөлд хаанахын ямар хөрсөнд олон улсад хэрэглэдэг 3000 гаруй пестицидийн хэдээр нь бордож, богино болон урт хугацаанд хүн, мал, ургамлын удмын санд ямар гэмтэл, хувирал, өвчин үүсгэх бүтээгдэхүүн орж ирж байгааг хянах аргагүй.

<sup>13</sup> Гаалийн Ерөнхий газрын тайлан мэдээ

**Хүснэгт 14. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний 2016 оны импортын мэдээ**

Үзүүлэлт	Импортын хэмжээ (тонн)	Импортлосон бүтээгдэхүүний гарал үүсэл (Улсын тоо)
Мах, махан бүтээгдэхүүн	10086.9	7
Сүүн бүтээгдэхүүн	4636.9	7
Гурил	59862.6	2
Гурилан бүтээгдэхүүн	14491.8	33
Будаа	29562.3	13

Төмс	656.0	7
Хүнсний ногоо	46307.7	15
Өндөг	83.8	2
Сахар, чихрийн зүйл	40939.1	28
Жимс, жимсгэнэ	33909.2	51
Хүнсний тос	27832.2	29
<b>Нийт</b>	<b>268368.5</b>	<b>75</b>

### ДУГНЭЛТ

1. Монгол Улсын хилээр нэвтэрч буй импортын хүнсийг бүрэн, найдвартай хянаж чадахгүй байна.
2. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь Монгол Улсад анх удаа лабораторийн зориулалтаар баригдсан барилгатай, хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтүүдийг иж бүрэн шинжлэх суурь нөхцөл, боломж бүрдсэн боловч лабораторийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт, сэлбэг хэрэгслийн хангамж, урвалж бодисын зардал дутмагаас импортын хүнсийг 100 хувь шинжилж чадахгүй байна.
3. Алтанбулаг болон Замын-Үүд

боомт дахь хүнсний сорилтын лабораториудад импортын хүнсний “Лабораторийн шинжилгээт хяналт”-ыг хангалттай түвшинд хийх чадавх бүрдээгүй байна.

4. Импортлолсон хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаж эцсийн хэрэглэгчид шуурхай хүргэх тээвэр, дэд бүтцийн зохицуулалтыг бий болгох шаардлага тулгамдаж байна.
5. Хүн амын өвчлөл, ялангуяа хоол боловсруулах эрхтний өвчлөл, хорт хавдрыг эрс бууруулах нэг чухал үндэс нь импортын хүнсний чанар, аюулгүй байдал, хяналтын найдвартай тогтолцоо гэдгийг судалгааны үр дүн нотлон харууллаа.

### ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын хүнсний салбарт мөрдөж буй үндэсний стандартууд (MNS, MNS ISO, MNS CAS)
2. Эрүүл мэндийн сайдын 2014 оны 384 дүгээр тушаалаар баталсан хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийн жагсаалт
3. Хүнсний химийн аюулгүйн 126, нян судлалын аюулгүйн 27, ургамлын эрүүл ахуй хорио цээрийн 92, нийт 245 үзүүлэлтээр мэдээлэл авах зорилгоор боловсруулсан загварын дагуу импортын хүнсний шинжилгээний голлох 3 лаборатори (ХАБҮЛЛ, Алтанбулаг, Замын-Үүд)-оос ирүүлсэн мэдээ
4. МХЕГ-аас ирүүлсэн импортын хүнсний их, дунд, бага эрсдэлтэй барааны жагсаалт, “Монгол Улсын хилээр оруулж буй хүнс, хүнсний бүтээгдэхүүн” тайлан, 2015-2017.
5. Гадаад улсын импортын хүнсний зохицуулалтын тухай цахим эх сурвалжууд



### Э.ЭНХТАЙВАН (М.А)

## ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

*The inviolability of Mongolia's border is regulated by international treaties and laws, while the security of border areas is governed by the laws of Mongolia, which they are interconnected system. In this logic, the economic development of the border areas is not only the security of the territory, but also the inviolability of the border and one of the main means of ensuring the security of Mongolia's existence.*

*Түлхүүр үг: Хил, аюулгүй байдал, хөгжил, эдийн засаг*

### НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ТУЛГАМДСАН АСУУДЛУУД


#### 1.1 ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ХҮН АМ

**Хүн амын тоо.** Хилийн нийт 14 аймгийн 67 суманд 2020 оны байдлаар 324'193 хүн буюу Монгол Улсын хүн ам (3,296,866<sup>1</sup>)-ын

9,8 хувь нь байнга оршин сууж байна. 1990-2019 оны хооронд Монгол Улсын нийт хүн ам 60.8 хувь өссөн бол хилийн сумдын хүн амын тоо тус хугацаанд 5 дахин бага буюу 12.7 хувиар өсчээ.

<sup>1</sup> (ҮСХ, 2020 он)

Зураг 1. Хил орчмын нутаг дэвсгэрийн хүн амын тоо (1990-2019 он)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Хилийн 31 сумын хүн ам тоо 1000-3000, 18 сумын хүн амын тоо 3001-5000, 12 сумын хүн амын тоо 5000-10000, 2 сумын хүн амын тоо 10000-аас дээш хүн амтай байна. Эдгээрээс Говь-Алтай аймгийн 4, Баянхонгор аймгийн 2, Өмнөговь аймгийн 5, Дорноговь аймгийн 5, Увс аймгийн 3, Хөвсгөл аймгийн 3, Сэлэнгэ аймгийн 2, Дорнод аймгийн 1 хилийн сумын хүн ам 3000-аас бага хүн амтай байна.

**Хүн амын нягтрал.** Монгол Улс дэлхийн хамгийн сийрэг суурьшилтай орнуудын нэг хэвээр байгаа хэдий ч нэг квадрат километр нутаг дэвсгэрт ногдох хүний тоо 2020 онд 2.0 болж 2010 оныхоос 0.3 пунктээр өсчээ. Энэ хугацаанд хилийн сумдын хүн амын нягтрал 0.09 пунктээр буюу улсынхаас 3.3 дахин багаар өссөн байна.

Хилийн 37 сумын нягтрал 0.5 хүн/км<sup>2</sup>-ээс бага, 19 сумынх 1 хүн/км<sup>2</sup>-ээс бага, Найман сумынх 2.0 хүн/км<sup>2</sup>-ээс бага харин боомт бүхий таван сумынх 2.0 хүн/км<sup>2</sup>-ээс их байна. Хүн амын нягтрал хамгийн өндөр хилийн сумд нь Увс аймгийн Тэс, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд, Өмнөговь аймгийн Ханбогд суманд байгаа бол хамгийн бага нь Баян-Өлгий, Дорнод, Өмнөговь, Говь-Алтай аймгийн хилийн сумд байна.

**Хотжилт.** Хүн ам ихээр суурьшсан, хотжилт өндөр түвшинтэй бүсүүд нь Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хот байна. Аймгуудын хувьд Дорнод, Хөвсгөл, Баян-Өлгий, Сэлэнгэ, Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Хэнтий аймаг 30000-50000, Өмнөговь, Дорноговь, Ховд, Увс зэрэг аймаг төвд 15000-30000 хүн оршин сууж байна. Хилийн сумдаас хотжилт явагдсан гэж үзэх боломжтой сумд нь Дорнод аймгийн Халх гол сум, Сүхбаатар аймгийн Алтанбулаг, Дорноговь аймгийн Замын-Үүд, Өмнөговь аймгийн Ханбогд сумд хамаарч байна.

## 1.2 АЮУЛГҮЙ БАЙДАЛ

**Малын гоц халдварт өвчин.** Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь ямааны цэцэг өвчин хил дамжин орж ирэх тохиолдлууд манай улсад нийлээд хэд бүртгэгдсэн байна. Үүнтэй холбоотой зарим тоон мэдээллийг авч үзэхэд өвчлөлийн ихэнх хэсэг хилийн нутаг дэвсгэрт гарч байгаа нь анхаарал татсан асуудал юм. Тухайлбал, шүлхий өвчин сүүлийн 18 жилд 13 удаа Монгол Улсад дэгдсэн бөгөөд үүний зургаа нь улсын зүүн өмнөд хилийн, таван удаагийн дэгдэлт нь баруун өмнөд хилийн бүсэд гарсан байна.

**Зураг 2. Шүлхий өвчний дэгдэлт, тохиолдол 2000-2017 он**



Эх сурвалж: (ХААИС-МЭСургууль, 2017 он)

Мөн бог малын мялзан өвчин 2016 оны намар Монгол Улсын баруун хилийн ойр анх удаа гарсан (Зураг 3) бол цэцэг өвчний хувьд Улсын хилийн зүүн хэсэг Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймагт 2006, 2007, 2008, Дорноговь аймагт 2015 онд тус тус дэгдэж улмаар богино хугацаанд бусад аймгийн малд халдварлаж байсан байна.

**Зураг 3. Бог малын мялзан өвчин 2000-2017 он**



**Хилийн зөрчил, шинж чанар, төрөл, агуулга.** Хилийн зөрчил нь дан ганц Монгол Улсын биш хөрш улсуудын хилийн аюулгүй байдалд нэгэн зэрэг нөлөөлж байдгаараа олон улсын шинжтэй гэмт хэрэг, зөрчил байдаг. Хилийн зөрчлийн тоо, агуулга, гэмт байдал улам бүр нэмэгдэж байгаа нь Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг ноцтой байдалд хүргэж байна. Тухайлбал, 1967-1990 оны хоорондох 23 жилийн хугацаанд өмнөд хил дээр 3738 удаагийн хилийн

зөрчил гарч байсан бол 1990-2016 оны хоорондох 25 жилд 17261 хилийн зөрчил бүртгэгдсэн нь өмнөх үетэй харьцуулбал 4.6 дахин өссөн тоо юм.

1990 оноос өмнө гарсан хилийн зөрчлийн 51.5 хувь нь тагнах, турших, өдөөн хатгах зэрэг улс төрийн шинжтэй, 48.5 хувь нь төөрөх, ан хийх, хил давсан малаа авах, өвс ургамал түүх зэрэг ахуйн зорилготой байв. Харин 1990 оноос хойш гарч буй хилийн зөрчил нь эрдэс баялаг, түүхий эд, түүх дурсгалын үнэт олдворын хууль бус наймаа, хар тамхи, зэвсэг, хориотой бараа бүтээгдэхүүн, химийн хортой бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх зэрэг болж байна.

Хамгийн гол асуудал нь хилийн зөрчил, улсын хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгт Монгол Улсын иргэд холбогдох болсон явдал юм. 2010-2018 оны хооронд улсын хил зөрчигчдийн 36.4 хувийг ОХУ-ын иргэд, 16.4 хувийг БНХАУ-ын иргэд, 1.6 хувийг бусад улс эзэлж байхад, үлдсэн 45.6 хувийг Монгол Улсын иргэд тэр дундаа хил орчмын нутаг дэвсгэрт оршин сууж буй иргэд эзэлж байна<sup>2</sup>. Үүний дотор ахуйн шинжтэй зөрчлийн тоо буурах хандлагатай байгаа бол эсрэгээрээ зохион байгуулалттай гэмт хэргийн тоо нэмэгдэж байна.

### 1.3 ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

**Хөрөнгө оруулалт.** 2011-2019 оны хооронд орон нутагт Улсын болон Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 12 орчим их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн боловч үүний 50 орчим хувь нь Улаанбаатар хотод ногдож байгаа бол Өмнөговь аймгаас бусад аймагт нийт хөрөнгө оруулалтын 5-аас 1 хувь ногдож байна. Төсвийн төвлөрсөн байдал, хүн амын суурьшил, сонгуулийн системээс шалтгаалан хүн ам олноор оршин суудаг

<sup>2</sup> Арвай.Ш, Улсын хил, хязгаарын аюулгүй байдал, тулгамдсан асуудлууд шийдвэрлэх арга зам. УБ.,2013.17 тал

бүс нутгуудад хөрөнгө оруулалт ахиу орсон байна. Нөгөө талаас орон нутгийн төсвийн гол эх үүсвэр нь хүн амын тоотой шууд

эрэг хамраалтай Хүн амын орлогын албан татвар байгаа юм.

**Хүснэгт 1. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, аймаг, нийслэлээр (2011-2019 он)**

№	Аймаг, нийслэл	Улсын төсөв		Орон нутгийн төсөв	
		Хөрөнгө оруулалтын дүн /сая.төг/	Эзлэх хувь	Хөрөнгө оруулалтын дүн /сая.төг/	Эзлэх хувь
1	Улаанбаатар	4,072,274.20	47.6	1,889,947.88	55.0
2	Сэлэнгэ	454,045.60	5.3	55,642.12	1.6
3	Говь-Алтай	422,995.90	4.9	66,316.39	1.9
4	Өмнөговь	355,266.00	4.2	409,913.71	11.9
5	Ховд	320,004.80	3.7	47,833.40	1.4
6	Хөвсгөл	296,001.20	3.5	87,777.92	2.6
7	Дархан-Уул	232,243.30	2.7	57,412.21	1.7
8	Завхан	221,287.70	2.6	32,033.19	0.9
9	Баянхонгор	218,093.70	2.5	20,034.37	0.6
10	Хэнтий	214,702.80	2.5	45,494.81	1.3
11	Увс	207,317.10	2.4	54,637.05	1.6
12	Өвөрхангай	201,636.40	2.4	53,335.84	1.6
13	Төв	199,413.20	2.3	50,454.07	1.5
14	Архангай	158,834.90	1.9	52,712.75	1.5
15	Дорноговь	154,932.20	1.8	74,996.97	2.2
16	Дорнод	148,226.70	1.7	53,291.55	1.5
17	Сүхбаатар	134,645.80	1.6	48,302.31	1.4
18	Орхон	134,043.90	1.6	172,037.88	5.0
19	Баян-Өлгий	133,798.60	1.6	39,770.83	1.2
20	Булган	100,743.40	1.2	47,537.79	1.4
21	Дундговь	94,295.70	1.1	55,133.60	1.6
22	Говьсүмбэр	84,879.90	1.0	24,683.68	0.7
<b>Нийт</b>		<b>8,559,683.00</b>	<b>100</b>	<b>3,439,300.32</b>	<b>100</b>

2011-2019 оны хооронд Монгол Улсад нийт 29.8 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн боловч үүний 73.4 хувь нь уул уурхайн салбарт төвлөрсөн байна. Бусад хөрөнгө оруулалт

нь хүн ам олноор суурьшсан бүс нутгуудад илүү өндөр үр өгөөжтэй байдаг худалдаа, санхүү, даатгалын үйл ажиллагаа, барилга зэрэг салбарт оржээ.

**Зураг 4. Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгал, эдийн засгийн ү/а-ны салбараар, 2011-2019 он**



Өөрөөр хэлбэл, хилийн сумд, аймагт уул уурхайн томоохон орд байхгүй, хүн амын суурьшил бага байгаа нөхцөлд гадаадын хөрөнгө оруулалтыг татах боломжгүй байна. Мөн үүнтэй зэрэгцэн хөрөнгө оруулалтын өгөөжийн асуудал юм.

Дотоодын хөрөнгө оруулалт голчлон эдийн засгийн секторт бус нийгмийн болон дэд бүтцийн салбарт орж байгаа. Гадаадын хөрөнгө оруулалтын өгөөжийн гол гарц болох татвар, хураамжийн дийлэнх хэсэг нь өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд орон нутгийн төсвийн орлогод биш улсын төсөвт орж, дахин хуваарилалтаар өөр аймаг, сумдад зарцуулагдаж байна.

**Орон нутгийн төсөв, санхүү.** Хилийн аймаг, сумд гэлтгүй бүх аймаг, сумд, нийслэл,

дүүрэг нь санхүүгийн үйл ажиллагааны хувьд төвөөс хэт хараат, хязгаарлагдмал эрх зүйн орчинд үйл ажиллагаа явуулж байна. Энэ нь нутгийн өөрөө удирдах нэгжүүдийн бие даан хөгжих эдийн засгийн үндэс суурийг үгүй хийж байна.

Тухайлбал, 2019 оны байдлаар орон нутгийн тагварын орлого нэгдсэн төсвийн орлогын 24.7 хувийг эзэлж байна. Өөрөөр хэлбэл, 21 аймаг, нийслэл хот, тэдгээрийн 330 сум, 9 дүүрэг, 1600 орчим баг, 152 хороо нийлээд Улсын нэгдсэн төсвийн 30 хүрэхгүй хувиар үйл ажиллагаагаа явуулж байна. Нэгдсэн төсвийн үлдсэн хэсэг буюу Улсын төсвийн орлогыг УИХ, ЗГ төлөвлөн, зарцуулж байгаа боловч үр дүн, үр өгөөжгүйгээр зарцуулж байгаа нь хэнд ч тодорхой зүйл болоод байна.

**Зураг 5. Нэгдсэн төсвийн орлого ба орон нутгийн төсвийн орлого, түүний харьцаа, 2013-2019 он, сая төгрөгөөр**



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо



Аймгуудын төсвийн орлого бага байгаагийн бас нэг илрэл нь аймгуудын улсын төсвөөс авсан санхүүгийн дэмжлэгийн орлого юм. 2019 оны статистик мэдээллээр 21 аймгийн 15 нь орон нутгийн төсвийн суурь зарлагаа<sup>3</sup> санхүүжүүлж чадахгүй төсвийн дэмжлэгээр санхүүжүүлж байгаагийн 12 нь хилийн аймаг байна.

### **ХОЁРДУГААР ХЭСЭГ. ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ХӨГЖЛИЙН СУУРЬ НӨХЦӨЛ БОЛОХ НЬ**

Хил орчмын нутаг дэвсгэрийг хөгжүүлэх гол арга хэрэгсэл нь хөрөнгө оруулалт, төсвийн үр дүнтэй зарцуулалтын бодлого байна. Харин гадаадын болон дотоодын хувийн хөрөнгө оруулалтыг татах суурь нөхцөл нь төрөл бүрийн нөөцүүд болон дэд бүтцийн хүртээмжтэй байдал, хууль эрх зүйн таатай нөхцөл байдал байх юм.

#### **2.1 ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛЖ, ОРОН НУТГИЙН САНХҮҮГИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ**

Монгол Улсын Үндсэн хуулийн 58-р зүйлийн 1-г “Аймаг, нийслэл, сум, дүүрэг

<sup>3</sup> Орон нутгийн төсвийн суурь зарлагад аймаг, нийслэл, сум дүүргийн удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон урсгал болон хөрөнгийн зарлага, аймаг, нийслэлд нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэх, зохион байгуулах болон сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр олгодог нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээг үзүүлэх зохион байгуулах, аймаг, нийслэлийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон сум дүүргийн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбоотой зардлууд орж байна.

бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн” гэж заажээ. Энэ утгаараа зөвхөн хилийн гэлтгүй Монгол Улсын хэмжээнд бүх орон нутаг нутгийн засаг захиргаа өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх, нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэх, хөгжлийг бий болгох өөрийн орлого, хүлээсэн үүрэг, өмч хөрөнгө, төсөвтэй байх шаардлагатай. Гэтэл бодит байдалд таван аймаг, хоёр сумаас бусад бүх орон нутгийн удирдлагууд эдийн засаг, төсөв санхүүгийн дутагдалтай байна.

Хилийн 14 аймаг, түүний 67 сум нь хил орчмын нутаг дэвсгэрт хамрагдаж байгаа бөгөөд улсын макро эдийн засгийн байдал тогтворгүй, олон тулгуурт бүтэц бий болоогүй, бүсчилсэн хөгжлийн үр дүн хангалтгүй, хилийн аймаг, сумд хуримтлал, ажиллах хүчний нөөцөөр туйлын дутагдалтай, дэд бүтэц, эрчим хүчний хангамж сул байгаа үед тус нутаг дэвсгэрийн хөгжлийг дан ганц бүсчилсэн хөгжил, коридорчилсон хөгжилд найдан “эзэнгүй” орхих нь туйлын буруу юм.

Орон нутаг төсвийн суурь зарлагаа санхүүжүүлж чадахгүй байгаагийн гол шалтгаан нь татварын болон татварын бус орлогын хуваарилалтаас шалтгаалж байна. Монгол Улс нь 1990 оноос өмнө төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай байсан бөгөөд энэхүү байдал одоог хүртэл амь бөхтэй оршсоор байгаа нь татварын болон татварын бус орлогын чухал эх үүсвэрүүдийг улсын төсөвт, ач холбогдол багатай татвар, хураамжийг орон нутгийн төсөв (аймаг, сум)-т хуваарилснаар харагдаж байна (Хүснэгт 2).

## Хүснэгт 2. Татварын орлогын хуваарилалт

Хуваах Татвар	ТЗГ-ын Татвар	Аймаг, нийслэлийн Татвар	Сум, дүүргийн татвар
Ашигт малтмал ашигласны төлбөр (95:5) Дотоодын НӨАТ (75:25)	<ul style="list-style-type: none"> <li>ААНОАТ,</li> <li>Импортын бараа, үйлчилгээний НӨАТ,</li> <li>Онцгой албан татвар,</li> <li>Гаалийн албан татвар,</li> <li>Авто бензин, дизель түлшний албан татвар,</li> <li>Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр,</li> <li>Агаарын бохирдлын төлбөр,</li> <li>Тэмдэгтийн хураамж (Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2)</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Газрын төлбөр</li> <li>Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар</li> <li>Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн татвар,</li> <li>Ус ашигласны төлбөр,</li> <li>Хүн амын орлогын албан татвар (ХАОАТТХ-ийн 8.1.1)</li> <li>Өв залгамжлалын болон бэлэглэлийн албан татвар</li> <li>Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2- т зааснаас бусад тэмдэгтийн хураамж</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>ХАОАТТХ-ийн 8.1.1-д зааснаас бусад ХАОАТ,</li> <li>Бууны татвар,</li> <li>Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 11.2-т зааснаас бусад тэмдэгтийн хураамж,</li> <li>Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж,</li> <li>Ашигт малтмалаас бусад байгалийн баялаг ашигласны төлбөр,</li> <li>Байгалийн ургамал ашигласны төлбөр,</li> <li>Ойгоос хэрэглээний мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр,</li> <li>Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр, Хүн амын унд, ахуйн хэрэгцээний ус, рашаан ашигласны төлбөр, Нохойны албан татвар</li> </ul>

Орон нутгийн төсвийн орлогын гол эх үүсвэр нь Хүн амын орлогын албан татвар бөгөөд улсын эдийн засаг, нэг хүнд ногдох ДНБ-ний өсөлтөөр тогтмол өсч байгаа боловч хүн амын шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан татварын бааз суурь, татвар төлөгчдийн тоо байнга өөрчлөгдөж байна. Энд анхаарах гол асуудал нь хүн амын төвлөрөл хаана их байна тэр газрын орлого харьцангуй өндөр байна.

Гэтэл Монгол Улсын хүн амын дийлэнх нь гурван хотод, аймгуудын ихэнх хүн ам нь

аймгийн төвийн сумд оршин сууж байгаа нөхцөлд хилийн сумд ямар орлогоор наад захын үйл ажиллагаагаа санхүүжүүлэх нь туйлын ойлгомжгүй байна. Жишээлбэл:

- Сумдын хүн ам бага, үйлдвэрлэл үйлчилгээний зах зээл байхгүй тул түгээмэл тархацтай байгалийн баялгийн хэрэглээ байхгүй,
- Хувиараа бизнес эрхлэгчид маш цөөн, орон сууц байхгүй, зах зээл байхгүй зэргээс шалтгаалж


ХАОАТТХ-ийн 8.1.1-д зааснаас бусад ХАОАТ-ын орлого байхгүй,

- Хүн амын тоо бага тул бууны татварын орлого маш бага,
- Гадаадын аялал жуулчлалын маршрутын эхлэл нь Улаанбаатар хот тул ан агнуурын зөвшөөрлийг

УБ хотоос авчихдаг. Тиймээс агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлого сумдад байхгүй,

- Зүүн болон говийн бүсэд ус, рашаан, ой мод байхгүйгээс шалтгаалан тус төрлийн төлбөрийн орлого байхгүй байна.

### Зураг 6. Орон нутгийн татварын орлогын бүтэц



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Мөн олон улсад орон нутгийн төсвийн гол эх үүсвэр болдог үл хөдлөх хөрөнгийн татварын бааз суурь орон нутагт бүрэлдээгүй, мөн тус татварын эрх зүйн зохицуулалт хангалтгүй, хувь хэмжээ бага байгааг анхаарах ёстой асуудлын нэг болж байна.

Орон нутгийн төсвийн орлого бага байгаа дээр орон нутгийн төсвийн нийт зарлагын 80-90 хувийг урсгал зардал, үүний 50 орчим хувийг цалин хөлсний зардал эзэлж байгаа нь орон нутагт шаардлагатай бусад бараа үйлчилгээ, хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх боломжгүй болгож байна.

Иймд төв засгийн газраас орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор татварын болон татварын бус орлогын эх үүсвэрийн хуваарилалтыг дахин хийж, орон

нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэх, үр дүнтэй зарцуулахад шаардлагатай хяналт, мониторингийн орчныг бий болгох шаардлагатай.

Мөн үүнтэй зэрэгцэн орон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад яам, засгийн газарт хэт төвлөрөөд буй эрх мэдлүүдийг үе шаттайгаар шилжүүлэх шаардлагатай. Жишээлбэл, орон нутгийн чанартай авто зам, гүүрийн барилга, ЦДШ, цэвэр бохир ус дамжуулах шугам хоолойг барих, шинэчлэх зэрэг хот нийтийн аж ахуйн салбартай холбоотой наад захын эрх, ажлуудыг эхний ээлжинд шилжүүлж, мэргэшсэн боловсон хүчинг бэлтгэх боломжийг олгох шаардлагатай.

Орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэхийн тулд эхний ээлжинд:

- АМНАТ-ийн орлогын 50 хувь

нь улсын төсөвт, 30 хувь тухайн аймгийн төсөвт, үлдсэн 20 хувь нь ашигт малтмалаа олборлуулж буй сумдад орохоор хуваарилах;

- Дотоодын НӨАТ (уг нь олон улсад НӨАТ нь 100 хувь орон нутгийн төсвийн орлогод орж, хувь хэмжээг нь мужууд тогтоох эрхтэй байдаг)-ийн одоогийн 75:25 (улсын төсөвт 75 хувь, аймгийн төсөвт 25 хувь) хуваарилалтыг 50:30:20 болгох;
- ААНОАТ-ын орлого нь 100 хувь улсын төсөвт орж байгааг хуваалцах татвар болгон өөрчилж, 60:30:10 болгох. Тус татварын одоо үйлчилж буй татварын хөнгөлөлтийг бүс, аймаг сумдаар нарийвчилж хамгийн өндөр хөнгөлөлт, чөлөөлөлт нь хилийн аймаг суманд байхаар шаталсан хэлбэрээр зохион байгуулах;
- Газрын төлбөрийн хавтгайрсан, хөнгөлөлт чөлөөлтийг бууруулж, төвлөрөл ихтэй Дархан, Эрдэнэт, Улаанбаатар хотод эрс нэмэгдүүлэх;
- Үл хөдлөх хөрөнгийн албан татварын одоо байгаа 0-2 хувийн татварын хувь хэмжээг 10 хувь хүртэл нэмэгдүүлж, аймаг орон нутаг татварын бодлогоор өрсөлдөх боломжийг бий болгох;
- НӨАТ-ын дээд хэмжээг 10 хувь доод хэмжээг 5 хувь болгон орон нутгууд татварын бодлогоор дамжуулан бизнес эрхлэгчдийг татах ( хөдөө орон нутаг), төвлөрөл ихтэй бүс нутгууд түлхэх ( Улаанбаатар хот) бодлого явуулах боломжийг бий болгох;
- Татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөний хэтрэлт, ашиг, хэмнэлтийг тухайн орон нутгийн ирэх жилийн төсөвт дахин

хуваарилж, орон нутгуудын төсөв санхүүгээ нэмэгдүүлэх эрмэлзлийг бий болгох зэрэг арга замаар сумд, аймгуудын орлогр, хөрөнгө оруулалтын бие даасан байдлыг нэмэгдүүлэх бодлогын саналыг дэвшүүлж байна.

Ингэснээр орон нутаг нэмэлт орлогоо хөрөнгө оруулалтын ажилд зарцуулж, тухайн орон нутагт дэд бүтэц, эрчим хүч, цэвэрлэх байгууламжууд бий болж улмаар бизнес эрхлэгчид үйл ажиллагаа явуулах, иргэд амьдран суух таатай орчныг бүрдүүлэх үндэс бүрдэнэ.

Орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлэхтэй зэрэгцэн аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдийн орлого, ашигт гол нөлөө үзүүлдэг ААНОАТ, НӨАТ, Газар ашигласны төлбөр, Үл хөдлөх хөрөнгийн татварын хувь хэмжээг төвлөрөл ихтэй бүс, хот сууринд өндөр, төвөөс алслагдсан аймаг, орон нутагт бага байхаар татварын хувь хэмжээг тогтоох шаардлагатай.

Орон нутгууд бизнес эрхлэгчдийг татах, түлхэх гол арга нь хэрэгсэл нь татварын хувь хэмжээний зөрүү байх бөгөөд жишээлбэл Улаанбаатар хотод НӨАТ-ын хувь хэмжээ өндөр, дунд зэргийн хөгжилтэй аймгуудад дунд зэрэг, хөгжлийн хувьд муу аймгуудад маш бага байхаар зохицуулснаар Улаанбаатарт төвлөрөөд буй ААН-үүд аймгууд руу шилжиж, хөрөнгө оруулагчид шинэ үйлдвэр ААН-ээ хөгжил сул аймаг, сумдад байгуулах гэх мэтээр төвлөрлийг удирдах боломжтой болно.

Мөн үл хөдлөх хөрөнгийн албан татварыг Улаанбаатар хотын бүсүүдээс хамааруулан 5-10 хувь хүртэл, хөдөө орон нутагт 0-5 хувь хүртэл байхаар зохион байгуулж болно. Гэтэл өнөөгийн түвшинд бол хаана байхаас үл хамааран дээд хувь нь 2 хувь, доод хувь тэг байна. Ийм тохиолдол ААН-үүд хүн ам, дэд бүтцийн төвлөрөл их Улаанбаатар хотод төвлөрсөөр байх юм.

## 2.2 ГАДААД ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТАХ ТААТАЙ ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ НЬ

**Хил орчмын бүс нутагт бизнес, үйлдвэрлэл эрхлэх таатай орчныг бий болгох.** Монгол Улсын эдийн засгийн бүтэц дорой, уул уурхайн болон малын гаралтай түүхий эдийн экспортоос өндөр хамааралтай, хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн хөгжил сул, үүнээс шалтгаалсан төсвийн орлого бага, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт хязгаарлагдмал байгаа үед 1990 оноос өмнөхтэй адилаар<sup>4</sup> хил орчмын хөгжил дорой бүх нутгуудад өргөн хэмжээний, далайцтай хөрөнгө оруулалт хийх, үйлдвэржүүлэх боломж байхгүй.

Иймд тус нутагт богино болон дунд хугацаандаа ААН, боловсруулах үйлдвэр, цехүүд шинээр байгуулагдах, шилжих, салбар нэгжээ байгуулахыг дэмжсэн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын таатай орчинг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөөр бий болгох боломжтой. Үүний тулд:

**Нэгдүгээрт:** Бүсийн ялгамжгүй, бүх нутаг дэвсгэрийн хэмжээнд явуулж буй татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг<sup>5</sup> бүсийн ялгамжтай болгох. Одоо байгаа бүсчлэлийг нарийвчлах шаардлагатай. Ер нь албан ёсны засаг захиргааны нэгжийн хувьд Аймаг нь орон нутгийг хөгжүүлэх гол нэгж болж өгнө.

**Хоёрдугаарт:** Хил орчмын нутаг дэвсгэр, байгалийн хүнд нөхцөлтэй зарим нутаг болон эдийн засгийн онцгой ач холбогдолтой бүс нутгуудад татвар, төлбөрийн урт хугацаатай үр ашигтай хөнгөлөлт, чөлөөлөлтийг явуулах хэрэгтэй.

Тухайлбал доогийн ААНОАТ-ын тухай хуулиар:

- Нутаг дэвсгэрийн ихэнх хэсгийг

<sup>4</sup> Сангийн аж ахуй, Тэжээлийн аж ахуй байгуулах

<sup>5</sup> Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль (шинэчлэсэн найруулга)-ийн 22.1, 22.5.1

хамруулсан,

- Хил орчмын нутаг дэвсгэрийг тодотгоогүй,
- Татварын хөнгөлөлтийг үзүүлж байна.

Энэ нь ААН-ийн хуримтлагдсан өр авлагыг бууруулах, үйлдвэрлэл технологийн шинэчлэлт явуулахад дэмжлэг үзүүлэх ч бүс нутгийг тэнцвэртэйгээр хөгжүүлэх бодлого болж чадахгүй. Мөн аж ахуйн нэгж, компаниуд өөр нутаг дэвсгэрт салбар нэгж, үйлдвэрлэлээ шилжүүлэх нь урт хугацааны шийдвэр тул хил орчмын бүс нутагт үйл ажиллагаа эрхэлж буй болон эрхлэх ААН-д богино болон дунд хугацааны биш урт хугацааны давуу талыг бодлогоор бий болгох хэрэгтэй. Үүний хүрээнд:

**Эхний ээлжинд:** Хил орчмын сул хөгжилтэй суманд байршилтай байнгын үйл ажиллагаа явуулдаг, бүртгэлтэй, орон нутгийн төсөвтэй харьцдаг, гурваас доошгүй ажлын байр бий болгосон / нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөөр баталгаажсан/ ААН-ийн тус хуулийн 7.3-т заасан татварт ногдох орлогын албан татварыг үйл ажиллагаа эхлүүлснээс хойш эхний 5 ажилд 90 хувь, дараагийн 5 жилд 50 хувь, 11 дэх жилээс эхлүүлэн тогтмол 20-30 хувийн хөнгөлөлтийг үзүүлж (урт хугацаандаа болон байнга хилийн аюулгүй байдлыг хангах зорилгоор) болно. Үүнд дараах салбаруудыг хамруулахгүй.

- Ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах;
- Согтууруулах ундаа худалдах, импортлох;
- Газрын тосны бүтээгдэхүүний бөөний худалдаа эрхлэх, авто бензин, дизель түлшний худалдаа эрхлэх, импортлох;

**Хоёрдугаарт:** Хөгжил сул хил орчмын нутгуудын дэд бүтэц, инженерийн

хангамжийг сайжруулах зорилгоор тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААН-ийн тухайн сум, орон нутагт явуулсан үйл ажиллагааны орлогыг (энэхүү орлого нь тухайн бүс нутагт үзүүлсэн үйлчилгээ болон бүтээн байгуулалт байх) ААНОАТ-аас 50-90 хувь хөнгөлөх. Татварын хөнгөлөлтөд хамаарах үйл ажиллагаа ба чиглэлийн жишээ:

- Нүүрсний хайгуул хийх (эрчим хүчний нөөцийг нэмэгдүүлэх ач холбогдолтой);
- Усны хайгуул, хөв цөөрөм байгуулах үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага;
- Газрын тосны бүтээгдэхүүний тухайн бүс нутагт худалдан борлуулснаас орох орлого;
- Эрчим хүчний эх үүсвэр, шугам сүлжээ барьж байгуулах, эрчим хүч үйлдвэрлэх, борлуулах, түгээх;
- Иргэний нисэхийн үйл ажиллагаа;
- Авто зам, замын байгууламжийг барих, засварлах;
- Цэвэр усны хангамж, бохир усны шугам, цэвэрлэх байгууламж барьж байгуулах;
- Авто зам, төмөр зам, харилцаа холбооны дэд бүтэц бий болгоход оруулсан хөрөнгө;

ААН-ийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр:

- Хилийн орчмын бүс нутаг

болон хилийн аймагт экспортын зориулалттай байгуулагдсан үндэсний мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрт мах экспортлох квотыг давуу эрхтэй авах.

- Хил орчмын бүс нутагт үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүн, мах махан бүтээгдэхүүнийг НӨАТ-аас чөлөөлөх
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн “Тендерг оролцогчдод давуу эрх олгох” 10-р зүйлд хилийн зарим бүс нутагт үйлдвэрлэсэн бараа үйлчилгээнд давуу эрх олгох зэрэг зохицуулалтыг хийж зарим хөнгөн үйлдвэрлэл (сурагчийн дүрэмт хувцас, сурах бичгийн үйлдвэрлэлүүдийг г.м)-ийг дэмжих боломжтой.

**Чөлөөт бүс байгуулах.** Монгол Улсын харьцангуй давуу талтай түүхий эдэд тулгуурласан үйлдвэрлэлийн салбарт хөрөнгө оруулалт татаж, түүнийг тойрсон кластерыг хөгжүүлэх суурь нь Чөлөөт бүс байгуулах явдал юм. Хэдийгээр дотоодын дэд бүтэц, тээврийн асуудал хүндрэлтэй байгаа ч хилийн боомтууд БНХАУ-ын тээврийн дэд бүтцүүдтэй ойр байрлаж байгаа нь давуу тал болно. Өөрөөр хэлбэл дотоодын тээвэр ложистикийн салбарын хөгжлийг хүлээлгүйгээр боомтуудад чөлөөт бүс байгуулах боломжтой юм(Зураг-7).

Тус бүсүүдэд Монгол Улсын аюулгүй

### Зураг 7. БНХАУ-ын төмөр замын дэд бүтэц ба Монгол Улсын хилийн боомтууд



байдал, эрх ашиг, олон улсын дүрэм, журамд нийцсэн гадаадын хөрөнгө оруулалтын тогтвортой эрхзүйн орчныг бий болгож, үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй болгох, чөлөөт бүсэд хориглох, хязгаарлах үйлдвэрлэл, үйлчилгээг нарийн тодорхойлж, чанд мөрдүүлдэг байх шаардлагатай.

Харин ОХУ нь ой мод, эрдэс баялаг, эрчим хүчний нөөц арвинтай улс тул тус улсын түүхий эд, байгалийн баялгийг ОХУ-тай хиллэж буй хилийн сумд, аймгуудад хямд зардлаар импортлон,

дахин боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, БНХАУ болон бусад улсуудад экспортолж бүрэн боломж байна.

Монгол Улсын экспорт болон импортыг боомтоор авч үзвэл, Гашуунсухайт болон Шивээхүрэнгийн гаалийн газраар гаргасан

бараа бүтээгдэхүүн нийт экспортын 44.0 хувийг, харин Улаанбаатар дахь гаалийн газар, Замын-Үүд дэх гаалийн газраар дамжин оруулж ирсэн бараа бүтээгдэхүүн нийт импортын 66.7 хувийг эзэлж байна.

#### Хүснэгт 4. Экспорт, импортын нэвтрэлт ба гаралт, хилийн боомтоор, 2018 он

Боомтын нэр	Экспорт	Импорт
Баян-Өлгий дэх Гаалийн газар	0.0	0.7
Бичигт дэх Гаалийн хороо	2.9	0.6
Буянт-Ухаа дахь Гаалийн газар	13.2	11.0
Гаалийн ерөнхий газар	-	0.1
Гашуунсухайт дахь Гаалийн газар	36.5	6.7
Говь Алтай дахь Гаалийн хороо	1.1	0.0
Дархан уул аймаг дахь Гаалийн газар	3.2	1.5
Дорнод дахь Гаалийн газар	4.4	1.5
Завхан дахь Гаалийн хороо	-	0.0
Замын -Үүд дэх Гаалийн газар	1.2	15.5
Орхон дахь Гаалийн газар	12.9	1.9
Сайншанд дахь Гаалийн газар	7.3	2.2
Сэлэнгэ дэх Гаалийн газар	0.1	4.7
Увс дахь Гаалийн газар	0.0	0.4
Улаанбаатар дахь Гаалийн газар	8.1	51.2
Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар	0.1	1.3
Ховд аймгийн Булган дахь гаалийн газар	1.4	0.2
Хөвсгөл дэх гаалийн хороо	-	0.0
Шивээхүрэн дахь гаалийн газар	7.5	0.5
<b>Нийт</b>	<b>100</b>	<b>100</b>

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

Эдгээрээс дүгнэж үзвэл Баянхошуу, Бичигт, Замын-Үүд, Гашуунсухайт, Шивээхүрэн, Бургастай, Ярант нь гадаад худалдаанд чухал ач холбогдолтой, экспортын болон импортын барааны бөөгнөрөл ихтэй байна. Иймд эхний ээлжинд эдгээр боомтууд дээр тулгуурлан чөлөөт бүс байгуулах нь зүй юм.

#### **Замын-Үүд боомт:**

Тус боомтоор экспортолж буй барааны 70 гаруй хувийг малын гаралтай боловсруулаагүй арьс шир эзэлж байгаагаас харахад тус бүсэд арьс, нэхийний үйлдвэрийн кластер байгуулах нэг боломж харагдаж байна. Мөн тус бүсэд үйлдвэрлэсэн хувцас, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний гуравдагч орны зах зээлд худалдаалах боломжтой юм.

#### **Гашуунсухайт, Шивээхүрэнгийн боомтууд:**

Монгол Улс нүүрсийг бараг 100 хувь БНХАУ-д экспортолж байгаа бөгөөд нүүрсний экспортод Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гашуунсухайт болон Гурван тэс сумын Шивээхүрэн боомт нь чухал үүрэг гүйцэтгэж байна. Тус боомтод нүүрснээс гарган авах боломжтой бүтээгдэхүүн, үйлчилгээний кластер бүхий чөлөөт бүсийг байгуулах боломжтой.

Дээрхтэй адилаар **Дорнод аймгийн Баянхошууны боомтод**<sup>6</sup> газрын тос боловсруулах, химийн үйлдвэрлэлийн, **Говь-Алтай аймгийн Бургастай боомтод** төмрийн хүдэр боловсруулах, улмаар түүгээр бэлэн бүтээгдэхүүн хийх хар төмөрлөгийн, Ховд аймгийн Ярантын боомтоор<sup>7</sup> МАА,

<sup>6</sup> Монгол Улсын экспортын түүхий газрын тосны 90 гаруй хувь нь гардаг.

<sup>7</sup> Тус боомтоор 40 гаруй нэр төрлийн бараа экспортолодог. Голлох экспортын бүтээгдэхүүн нь чулуун нүүрс, цайрын хүдэр, баяжмал байна.

Уул уурхайн<sup>8</sup>, ХАА, аялал жуулчлалын<sup>9</sup>, мах боловсруулах чиглэлийн<sup>10</sup> зэрэг олон үйл ажиллагаатай үйлдвэрлэл бүхий чөлөөт бүсүүдийг байгуулах боломжтой юм.

Мөн энд онцгойлон авч үзэх ёстой хилийн боомт нь Бичигтийн боомт юм. Учир нь Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын тус боомт нь Монгол Улсын далайд гарах хамгийн дөт боомт юм. Тус боомтод гуравдагч орон руу гаргах экспортын баримжаатай үйлдвэрлэлийн кластер бүхий чөлөөт бүс байгуулах боломжтой.

#### **Чөлөөт бүс байгуулахад анхаарах зарим асуудлыг товчлон авч үзвэл:**

- Чөлөөт бүсэд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Монгол Улсад тарифын болон тарифын бус хөнгөлөлт үзүүлж буй АНУ, ЕХ, Япон болон ОХУ-ын зах зээлд гарах боломжийг эрэлхийлэх
- Азийн авто замын сүлжээний АН-3, АН-32 болон АН-411 чиглэлийн олон улсын хурдны авто замын төслүүдийн зангилаа хэсгүүдэд Чөлөөт бүс байгуулахыг эрмэлзэх
- Гурван улсын хилийн хамтарсан уулзвар хэсгүүдэд Чөлөөт бүс байгуулахыг эрмэлзэх
- Баруун бүс нь ОХУ, БНХАУ-тай хиллэхээс гадна Казахстан улстай хамгийн ойр байрладаг, CAREC-ийн хамгийн гол байрлалуудын нэг бөгөөд цаашлаад Төв Ази, Дундад Ази, Европт хамгийн ойрхон орших

<sup>8</sup> Баруун бүсэд 15 төрлийн ашигт малтмалын 294 орд, илэрц байгаагаас 39 нь 8 төрлийн ашигт малтмалын орд, бусад нь илрэлүүд байгаа

<sup>9</sup> Монгол Улс, ОХУ, БНХАУ, Казахстаны хосгүй үзэсгэлэнт байгаль, Алтайн уулсыг тойрсон олон улсын аялал жуулчлалын цагираг дээр байрладаг.

<sup>10</sup> Экспортлох боломжтой улсын нийт махны 1/5 хувь тус бүсэд ногдог.

<sup>11</sup> ОХУ болон БНХАУ-ыг холбох хамгийн дөт зам бол Баруун бүсийн Улаанбайшинтаас Даянгийн боомт хүртэлх 212 км зам.



Монголын баруун хязгаарын хилийн цэг тул тус чиглэлд онцгой анхаарал хандуулах. Мөн үүнтэй адилаар АН-32 чиглэлд анхаарах

- Торгоны болон Талын зам төслүүдийг уялдуулж, босоо тэнхлэгийн дагуух “хил дамнасан чөлөөт бүс”-ийг байгуулах боломжийг бий болгох.

**Авто замын сүлжээ болон төмөр замын төв зангилаа хэсгүүдэд тулгуур төвүүдийг хөгжүүлэх нь.** Монгол Улсын бүх нутаг дэвсгэрт ялангуяа алслагдсан хилийн аймаг, сумдад тэнцвэртэй эдийн засгийн хөгжил, аж үйлдвэрлэлийн төвлөрлийг дэмжихийн тулд орон нутгийн томоохон хотуудын өсөлтийг эрчимжүүлж, тулгуур төв болгон хөгжүүлэх шаардлагатай. Ялангуяа, зам тээврийн үндсэн сүлжээний босоо тэнхлэгийн дагуу байрласан хотууд (Ховд, Өлгий, Улиастай, Даланзадгад, Чойбалсан, Баруун-Урт, Дархан, Сайншанд, Замын Үүд), хэвтээ тэнхлэгийн дагуу байрласан (Ховд, Улиастай, Алтай, Баянхонгор, Баруун-Урт, Чойбалсан) хотуудыг хоёр дахь шатлалын хот болгон, бүх төрлийн худалдаа, үйлчилгээ, зах зээл, мөнгө санхүү, даатгалын үйлчилгээ, эрүүл мэнд, боловсрол, засаг захиргаа, мэдээлэл зэрэг олон төрлийн хотын функцийг сайжруулж, түүнтэй уялдуулан ажлын байр нэмэгдүүлэх хэрэгтэй. Ингэснээр өмнөх бодлоготой уялдан орон нутгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл хөгжин, орон нутаг дахь нийтийн үйлчилгээний чанар сайжирч энэ нь урт хугацаанд газар ашиглалтын тэнцвэрийг хадгалан, хүн амын нэгдсэн суурьшлын орчинг бий болгох болно.

- Олон улсын авто замын АН-3, АН-24, АН-32 чиглэлийн босоо тэнхлэгүүд дээрх гол хотууд нь Ховд, Чойбалсан, Баруун-Урт, Сайншанд, Замын-Үүд байна.
- “Төрөөс төмөр замын тээврийн

талаар баримтлах бодлого”-ын хүрээнд хийгдсэн төлөвлөлтөөр Чойбалсан, Баруун-Урт, Сайншанд, Цогтцэций, Даланзадгад, Улиастай хотод гол зангилаа цэгүүд дээр байршиж байна.

- Агаарын тээврийн төв болох боломжтой төвүүд нь хоёрдугаар зэрэглэлийн буудалтай Увс, Ховд, Баян-Өлгий, Хөвсгөл, Баянхонгор, Өмнөговь, Дорнод аймгийн буудал, III зэрэглэлийн буудалтай Завхан, Говь-Алтай, Өвөрхангай, Хэнтий, Сүхбаатар аймаг байна.

Эдгээрээс хилийн бүс болон хилийн сумдад чухал нөлөө бүхий хөгжлийн төвүүд нь Ховд, Мөрөн, Алтай, Баруун-Урт, Чойбалсан, Даланзадгад хот юм. Бүсчилсэн хил хамгаалалт болон хилийн отрядуудын өнөөгийн байршилд тулгуурлан авч үзвэл хил хамгаалалтын тулгуур хотууд нь Алтай, Ховд, Даланзадгад, Сайншанд, Баруун-Урт, Чойбалсан, Сүхбаатар, Мөрөн, Улаангом байна.

Үүнээс нэгдсэн дүгнэлт гаргавал соёл урлаг, төрийн үйлчилгээ, боловсрол, эрүүл мэнд, аж үйлдвэрийн бүрэн цогц Монгол Улсын II шатны хот нь Даланзадгад, Баруун-Урт, Чойбалсан, Сүхбаатар, Мөрөн, Ховд, Алтай байх бөгөөд эдгээрийг тэтгэгч, төвтэй холбох холбогч төв нь Улиастай, Арвайхээр, Чингис хот болох юм.

Тиймээс төлөвлөлтийн хувьд эхний ээлжинд Дархан, Улиастай, Чингис, Даланзадгад, Сайншанд гэсэн дөрвөн төвийг, түүний дараа Ховд, Өлгий, Алтай хотыг Улиастайд, Баруун Урт, Чойбалсан, хотыг Чингис хотод тулгуурлан үе шаттай хөгжүүлэх арга хэмжээг авч болно.

Стратегийн орд газруудад суурилсан аж үйлдвэрийн томоохон хот, суурийн газрыг байгуулах нь. Монгол Улсын 21 аймгийн 14 нь, 330 сумын 67 нь хилийн нутаг дэвсгэр, хилийн бүсд хамаарч байгаа бөгөөд тухайн


бүс нутагт уул уурхай, ашигт малтмалын арвин их нөөц байгаа нь хөгжлийн нэгэн гол нөөц болж өгөх юм.

Хилийн аймаг, сумдад 2007 оны хоёрдугаар сарын 6-ны өдрийн УИХ-ын “Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай” 27-р тогтоолын нэгдүгээр хавсралтад тусгагдсан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын 16 ордын 12 нь, тогтоолын

хоёрдугаар хавсралтад заасан нөөцийг нарийвчлан тогтоож, стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулж болзошгүй буюу стратегийн хоёрдугаар ээлжийн 39 ордын 22 нь хамаарч байна.

Эдгээр ордын ихэнх нь одоо эзэмшигчтэй бөгөөд дотоодын эрэлт байхгүй байгаагаас шалтгаалан нэмүү өртөг бага шингээн шууд экспортод гарч байна.

### Зураг 8. Стратегийн хоёрдугаар ээлжийн 39 ордын байрлал



Өндөр технологи хөгжсөн өнөө үед Стратегийн ач холбогдол бүхий уул уурхайн нөөцийг ашиглах явцад орон нутагт тодорхой хугацаанд барилга, хоолны газар, жижиглэнгийн худалдааны эрэлтийг нэмэгдүүлж, мөн боловсрол, эрүүл мэнд, цахилгаан, усны хангамж зэрэг дэд бүтэцтэй холбоотой бүтээн байгуулалт хийгддэг. Гэвч баялгийн нөөц дуусахад хот, суурин газар амьдрах чадваргүй болж ажиллагсад шилжин, орон нутагт үлдсэн дэд бүтэцтэй холбоотой засвар үйлчилгээ төсвийн дарамт болдог. Иймд орон нутагт уул уурхайг хөгжүүлэхтэй зэрэгцүүлэн

алсын хараатай орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийг зохиох боломжтой бөгөөд чухал ач холбогдолтой.

Уул уурхайгаас олсон ашиг, дэд бүтэц, татварын орлого зэргийг тухайн орон нутгийг нь ХАА, үйлдвэрлэл, аялал жуулчлалын нөөц болгон үр ашигтайгаар дахин хуваарилах байдлаар урт хугацаанд амьдрах чадвартай хот, суурин газрыг хөгжүүлэх шаардлагатай. Үүний тулд дээр дурдсанчлан тухайн орон нутгаас бий болгож буй татварын орлогын боломжит дээд хэмжээгээр татварын орлогыг нь орон нутагт нь үлдээх явдал юм.

Мөн тухайн орон нутагт нь буюу хилийн сум, боомтуудад боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, нэмүү өртөг шингээх ёстой. Ингэхгүйгээр зөвхөн олборлох, борлуулах байдлаар явагдвал тухайн хот, суурин газрын амьдрах хугацаа нь уурхайн нөөцийн ашиглалтын хугацаатай хамт дуусгавар болдог.

**Мал аж ахуйд суурилсан кластер хөгжүүлэх нь.** Монгол Улсын нийт нутгаар мал аж ахуйн харьцангуй тэнцвэртэй тархсан бөгөөд хилийн бус болон хилийн аймаг, сумдын малын тоо толгой ойролцоо байна. Мөн хилийн зарим сум малын тоогоор улсад тэргүүлж (Жишээлбэл, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сум 572.6 мянган малтай) байгаа зэрэг нь мал аж ахуйд суурилсан класстер хөгжлөөр дамжуулж хилийн сумдыг хөгжүүлэх боломжтойг илтгэж байна.

Тухайн улс нь өөртөө хамгийн элбэг байдаг хүчин зүйлсийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж улмаар экспорт хийх нь ашигтай байдаг. Монгол Улсын хувьд эхний ээлжид эдийн засгийн хувьд хамгийн өгөөжтэй, экспортлоход ашигтай байгаа мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх нь ач холбогдолтой юм. МАА-н гаралтай бүтээгдэхүүний ашиглалтыг сайжруулах, аж үйлдвэрийг дотооддоо хөгжүүлэхийн зэрэгцээ гадаад зах зээл дээр бүтээгдэхүүнээ борлуулснаар улс орны эдийн засгийн өсөлтөд гол нөлөө үзүүлнэ.

Казахстан, Төв Азийн улсад мах экспортлох зорилго бүхий үйлдвэрүүдийг баруун хилийн сумдад, ОХУ-руу мах экспортлох үйлдвэрүүдийг Хөвсгөл, Сэлэнгэ, Хэнтий, Дорнод аймгийн хилийн сумдад байгуулах боломжтой. Махны экспортыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтыг татахын тулд эхний ээлжинд малыг эрүүлжүүлэх, мах боловсруулах үйлдвэр, ААН-үүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг

татах, зээл, татварын бодлогоор дэмжих шаардлагатай.

Мах үйлдвэрлэлтэй зэрэгцэн малын түүхий эдийн гарц нэмэгдэх тул тухайн орон нутгуудад экспортын чиглэлийн түүхий эдийг иж бүрэн боловсруулах үйлдвэр, цехүүдийг байгуулах эсвэл тухайн орон нутгуудтай ойр байрлах дээр дурдсан тулгуур хотуудад хүртээмжтэй байдлаар байгуулах шаардлагатай. Ингэснээр хил орчмын нутаг дэвсгэрт буй малчид малын тоо хэмжээнд бус чанарт илүү анхаарах урьдчилсан суурь нөхцөлүүд бүрдэж, орлого нь сайжирна.

**Газар тариаланд суурилсан кластерыг Монгол Улсын хойд хэсэгт байгуулах нь.** Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 74 хувийг ХАА чиглэлээр ашиглах боломжтой, үүний 71 хувь нь бэлчээрийн, 3 хувь нь тариалангийн газар байна. Газар тариаланд нэн тохиромжтой бүс нутаг нь нутгийн хойд хэсэг болон зүүн хойд, зүүн бүс нутгууд буюу хилийн аймаг, сумдад харьяалагдаж байна.

Газар тариалангийн нэн тохиромжтой бүс нутгууд нь Орхон, Сэлэнгэ, Төвийн бүсээр болон, Дорнод аймгийн хилийн Дашбалбар, Баян-Уул, Баяндун, Халх гол сумын нутаг болно.

Тус бүс нутгуудад Монгол Улсын хүн амын, хүнсний ногоо, нарийн ногоо, жимс жимсгэнийн эрэлтийг хангах, импортыг орлох, экспортод чиглэсэн ХАА-д суурилсан хүнсний тариалалт, үйлдвэрлэлийг цогцолбор хэлбэрээр хөгжүүлж нийт хүн амыг хангах боломжтой.

## ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд хилийн сумдын өнөөгийн хөгжил сул дорой, иргэдийн амьжиргаа туйлын хангалтгүй, үүнээс улбаалан шилжилт хөдөлгөөнд ихээр орж хилийн бүс эзэнгүйдэж байгаа нь тогтоогдсон. Үүний үндсэн шалтгаан нь

**нэгдүгээрт**, Монгол Улсын эдийн засаг нийгмийн тогтворгүй байдал, **хоёрдугаарт**, бүс нутаг, аймгуудын тэнцвэргүй хөгжил, **гуравдугаарт**, орон нутаг буюу аймаг, сумд бие даан хөгжих боломжгүй, төвөөс хэт хараат байгаад оршиж байна. Мөн авто зам, төмөр зам, агаарын тээврийн хөгжил дорой, эрчим хүч, усны нөөцийн дутагдалтай байгаа нь хөгжлийн хоцрогдлыг улам гааруулагч хүчин зүйлс болжээ.

Гэвч хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэр нь ашигт малтмал, үржил шимт газар нутаг, мал, амьтан, эко аялал жуулчлалын арвин их нөөцтэйн сацуу гадаад зах зээлд хамгийн ойр, дөт байршиж байгаа нь хөгжлийн гол тулгуур, хөдөлгөгч хүч болж, бусад орон нутгаас ч илүү хөгжүүлэх бүрэн боломж байгааг илтгэж байна.

Монгол Улс 1992 оноос хойш улс орныг бүхэлд нь тэнцвэртэй хөгжүүлэх бодлого баримталж, энэхүү бодлого нь хангалтгүй хэрэгжсэнээс орон нутагт өнөөгийн тулгамдсан нөхцөл байдал бий болжээ. Мөн хилийн талаар баримтлах бодлогод хил орчмын нутаг дэвсгэрийг хөгжүүлэх асуудлыг бэлэг, тэмдэг төдий байдлаар оруулж, тухайлан авч үзээгүй байна. Үүний нэгэн нотолгоо нь хилийн сумдын хөгжлийг шууд аймаг, орон нутаг, эсвэл Засгийн газрын тусгай үйл ажиллагаатай уялдуулалгүйгээр бүсчилсэн хөгжлийн бодлогод найдан “хаясан” байна. Монгол Улсын Үндсэн хууль, засаг засаг захиргааны эрх, үүргийг тусгасан хууль эрх зүйн баримт бичгүүдэд багийг сумд, сумдыг аймаг хөгжүүлэх үүргийг хүлээсэн байдаг. Гэтэл хилийн сумдын хөгжлийг аймгийн хөгжилтэй уялдуулалгүйгээр, бүсчилсэн хөгжилтэй холбоотой ганцхан өгүүлбэр

төдийгөөр тодорхойлсон байна.

Цаашид хилийн аймаг, сумдыг хөгжүүлэх үндсэн бодлогын суурь нь төсвийн төвлөрлийг бууруулж, орон нутгийн төсөв, санхүү, өмчийн бие даасан байдлыг хангах нь илүү нөлөөтэй байна. Ингэхийн тулд юуны түрүүнд тухайн орон нутгийн баялгийг ашиглаж, тухайн орон нутгийн төрөл бүрийн нөөцийг ашигласны үндсэнд бий болгосон татварын орлогуудыг (АМНАТ, НӨАТ, ААНОАТ гэх мэт) улс-аймаг-сум гэсэн харилцан ашигтай, хэт төвлөрсөн бус байдлаар дахин хуваарилах шаардлагатай байна. Орлогын шилжилттэй хамт төв засгийн газарт хэт төвлөрсөн байгаа эрх мэдэл, үүрэг хариуцлагыг аймаг сумдын удирдлагад шилжүүлснээр орон нутаг бие даан хөгжих бүрэн боломж бий болно.

Мөн хилийн сумд болгоны давуу тал, нөөц, гадаад зах зээлийн боломж зэрэгт суурилан тусгай бодлого явуулах боломжтой. Үүний нэгэн хэлбэр нь хил дамнасан чөлөөт бүс юм. Хилийн сумдын дотоод зах зээлтэй холбогдох тээвэр, дэд бүтцийн асуудал хүндрэлтэй байгаа боловч гадаад зах зээл том, дэд бүтэц харьцангуй сайн, нөөц баялаг ихтэй зэрэг шалгуураар чөлөөт бүсийг Бичигт, Шивээхүрэн, Гашуунсухайт боомтын чиглэлд эхний ээлжинд байгуулах бүрэн боломж байна.

Эдийн засгийн хөгжил сул хил орчмын бүс нутгийг хөгжүүлэх төрийн бодлогын онцлог нь тухайн бүс нутагт амьдардаг иргэн болон ААН, байгууллагад татварын болон татварын бус аргаар нөлөөлж бусад бүс нутагт ажиллаж, амьдрах, үйл ажиллагаа явуулахаас давуу, уян хатан, таатай нөхцөлийг бий болгох явдал юм.

---

**ЭХ СУРВАЛЖ**

1. Ш.Арвай, 2013 он. Улсын хил, хязгаарын аюулгүй байдал, тулгамдсан асуудлууд шийдвэрлэх арга зам. УБ хот
2. Н.Наранжамц, 2012 он. Бүс нутаг-хил хамгалалтын үзэл баримтлал, УБ хот
3. Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, 2018 он.
4. Барилга хот байгуулалтын яам, 2019 он. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, УБ хот
5. БХЭШХүрээлэн, 2019 он. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал: Өнөө ба ирээдүй, УБ хот
6. Н.Наранжамц, 2007. Хил судлал. УБ хот
7. Н.Наранжамц, 2008. Хил судлал. УБ хот
8. П.Сүндэв, 2004 он. Хил хамгаалах бодлого, үйл ажиллагаа. УБ хот
9. Р.Ринчинбазар, 2004 он. Монголын бүс нутгийн тогтвортой хөгжлийн асуудал. УБ хот
10. С.Чулуун, Ю. К., 2013 он. Сангийн аж ахуй, УБ хот
11. ҮСХороо, 2019 он. Мал тооллогын урьдчилсан дүн 2019, УБ хот
12. ХААИС-МЭСургууль, 2017 он. Малын эмч эмхэтгэл, УБ хот
13. Ш.Мөнхцэрэн, П., 2019 он. Монгол Улсын төсвийн төвлөрлийг сааруулах үйл явц ба орон нутгийн эдийн засаг санхүүгийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх арга зам, УБ хот

**ЗОХИОГЧИД****Б.Энхбайгаль**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хот  
бүсчилсэн хөгжлийн бодлогын зөвлөх,  
доктор, дэд профессор

**Б.Баттөр**

ССХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн  
дарга

**Д.Батмөнх**

ССХ-ийн Эрдэм шинжилгээний  
ажилтан

**Ч.Цэцэгмаа**

ССХ-ийн Эдийн засгийн судалгааны  
секторын эрхлэгч

**Б.Пүрэвсүрэн**

ССХ-ийн Эрдэм шинжилгээний  
ажилтан

**Т.Энхзаяа**

ССХ-ийн Эрдэм шинжилгээний  
ажилтан

**Д.Уламбаяр**

ХИС-ийн Олон улсын харилцаа,  
нийгэм судлалын сургуулийн захирал,  
доктор, профессор

**Т.Батцэцэг**

МУИС-ийн Олон улсын харилцаа,  
нийтийн удирдлагын сургуулийн  
докторант

**Л.Дамдинсүрэн**

Техникийн шинжлэх ухааны доктор,  
профессор

**Э.Энхмаа**

ССХ-ийн Нийгэм төрийн судалгааны  
секторын эрхлэгч, доктор

**Э.Энхтайван**

ССХ-ийн Эрдэм шинжилгээний  
ажилтан

**AUTHORS****B.Enkhbaigali (Ph.D, Associate Professor)**

Advisor  
Urban and Regional Development Policy to  
the President of Mongolia

**B.Battur (M.A)**

Vice-Director  
Institute for Strategic Studies

**D.Batmunkh (M.A)**

Researcher  
Institute for Strategic Studies

**Ch.Tsetsegmaa (M.A)**

Head of Department for Economic Policy  
Institute for Strategic Studies

**B.Purevsuren**

Researcher  
Institute for Strategic Studies

**T.Enkhzaya**

Researcher  
Institute for Strategic Studies

**D.Ulambayar (Ph.D, Professor)**

Director, School of International  
Relations and Social Studies,  
University of Humanities

**T.Battsetseg (M.A)**

School of International  
Relations and Public Administration  
National University of Mongolia

**L.Damdinsuren (Sc.D, Professor)****E.Enkhmaa (Ph.D)**

Head of Department for Domestic Policy  
Institute for Strategic Studies

**E.Enkhtaiwan (M.A)**

Researcher  
Institute for Strategic Studies